



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>		<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>		<i>2-38</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>		<i>39-217</i>
1. Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох, чөлөөлөх тухай		<i>40-65</i>
2. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай		<i>65-79</i>
3. Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай		<i>79-100</i>
4. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай		<i>100-123</i>
5. Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай		<i>123-161</i>
6. Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүдийг томилох тухай		<i>161-169</i>
7. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/		<i>169-171</i>
8. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/		<i>171-176</i>
9. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/		<i>177-178</i>
10. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл		<i>178-179</i>
11. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл		<i>179-181</i>
12. “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл		<i>181-184</i>
13. Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/		<i>184-216</i>
14. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/		<i>216-217</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, Б.Бейсен, Д.Бум-Очир, Ш.Бямбасүрэн, С.Бямбацогт, Л.Гантөмөр, Б.Дэлгэрсайхан, С.Зулпхар, Т.Мөнхсайхан, П.Наранбаяр, Ч.Номин, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Х.Тэмүүжин, Ж.Энхбаяр, Л.Энхнасан, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: П.Батчимэг, Ж.Ганбаатар, Д.Жаргалсайхан, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, Л.Оюун-Эрдэнэ, Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батлут, С.Лүндэг, Ц.Мөнхтуяа, Б.Түвшин, Б.Энхбаяр;

Тасалсан: Х.Баттулга;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-15 минут, С.Амарсайхан-11 минут, Т.Аубакир-11 минут, Ц.Баатархүү-06 минут, М.Бадамсүрэн-14 минут, Н.Батсүмбэрэл-04 минут, Э.Батшугар-07 минут, Ж.Баясгалан-27 минут, Х.Булгантуяа-29 минут, Г.Ганбаатар-04 минут, С.Ганбаатар-21 минут, Д.Ганбат-36 минут, М.Ганхүлэг-14 минут, Т.Доржханд-4 цаг 43 минут, Б.Жавхлан-36 минут, Б.Жаргалан-03 минут, Б.Заяабал-02 минут, Н.Наранбаатар-4 цаг 34 минут, Б.Пунсалмаа-13 минут, Ц.Туваан-03 минут, Г.Тэмүүлэн-29 минут, А.Ундраа-18 минут, Н.Учрал-07 минут, Г.Уянгахишиг-03 минут, Ж.Чинбүрэн-51 минут, Б.Чойжилсүрэн-01 минут, Д.Энхтуяа-12 минут.

Нэг.Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох, чөлөөлөх тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргад нэр дэвшигч Т.Жамбаажамц оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, мөн албаны референт А.Хонгорзул нар байлцав.

Нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, нэр

дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан нар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Д.Пүрэвдаваа, О.Саранчулуун, Э.Бат-Амгалан, Ц.Даваасүрэн, Ч.Анар, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад нэр дэвшигч Т.Жамбаажамц, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, П.Сайнзориг, Х.Ганхуяг, Г.Очирбат, Да.Цогтбаатар, О.Номинчимэг нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Түндэвийн Жамбаажамцыг Санхүүгийн зохицуулах хорооны даргаар томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 30
Бүгд: 90
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Дэмбэрэлдашийн Баярсайханыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 31
Бүгд: 90
65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох, чөлөөлөх саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Уг асуудлыг 11 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнд нэр дэвшигч Б.Саруул, Л.Соноор, Ш.Хандсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг,

Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл танилцуулав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ө.Шижир, Д.Рэгдэл, Х.Ганхуяг, Д.Ганбат нарын тавьсан асуултад нэр дэвшигч Л.Сонор, Б.Саруул, Ш.Хандсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Булганы Саруулыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	55
Татгалзсан:	35
Бүгд:	90

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Лувсандоржийн Сонорыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	39
Татгалзсан:	51
Бүгд:	90

43.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан техникийн саатлын улмаас санал хураалтад оролцож чадаагүй тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргаж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	37
Татгалзсан:	53
Бүгд:	90

41.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

3.Байнгын хорооны саналаар Шагдаржавын Хандсүрэнг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 35
Бүгд: 90
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Баасанжавын Батхишиг, Нямдэлэгийн Мандуул, Баярсайханы Баярдаваа нарыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 35
Бүгд: 90
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүдийг томилох, чөлөөлөх саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүдийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Уг асуудлыг 12 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Д.Буяндэлгэр, О.Оч, Б.Энхбаяр, Ч.Сайнбилэг, С.Халиунаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ, Д.Пүрэвдаваа, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад нэр дэвшигч Д.Буяндэлгэр, О.Оч, Б.Энхбаяр, Ч.Сайнбилэг, С.Халиунаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ц.Идэрбат, Ө.Шижир, М.Мандхай, Э.Болормаа, О.Номинчимэг нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргаар томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 40
Бүгд: 90
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Оюунтөгсийн Очийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 34
Бүгд: 90
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Болдбаатарын Энхбаярыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 31
Бүгд: 90
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Чимидийн Сайнбилэгийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 39
Бүгд: 90
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Соронзонболдын Халиунааг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Равсалын Ренчинбазарыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас, Батболдын Амарсанаа, Дүгэрээгийн Цэрэнбадам, Жадамбаагийн Эрдэнэбилэг нарыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 31
Бүгд: 90
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Уг асуудлыг 13 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Н.Батнасан, Р.Даваадорж, Б.Мөнхзаяа, Б.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 13 цаг 48 минутаас хуралдааныг даргалав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Х.Ганхуяг, Да.Цогтбаатар, О.Номинчимэг, А.Ганбаатар, Э.Батшугар, С.Ганбаатар, Д.Ганбат нарын тавьсан асуултад нэр дэвшигч Д.Н.Батнасан, Р.Даваадорж, Б.Мөнхзаяа, Б.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 14 цаг 38 минутаас хуралдааныг даргалав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Намсрайн Батнасанг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 38
Бүгд: 93
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Раднаасэдийн Даваадоржийг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 46
Бүгд: 93
50.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Батбаатарын Мөнхзаяаг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Бямбажавын Энх-Амгаланг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 44

Бүгд: 93
52.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Бямбажавын Энх-Амгалан, Цэрэндоржийн Батсүх, Цэвэгсүрэнгийн Мөнхбаяр, Чулуундоржийн Хашчулуун нарыг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Уг асуудлыг 15 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Н.Ууганбаатар, С.Лхагвадорж, Г.Тэлмэн, Т.Тэлмэн, У.Хосжаргал, Д.Энхжаргал, Г.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, У.Отгонбаяр, Б.Хэрлэн, П.Сайнзориг, Х.Ганхуяг, Т.Очирбат, Д.Цогтбаатар, Ч.Анар, Э.Батшугар нарын тавьсан асуултад нэр дэвшигч Н.Ууганбаатар, С.Лхагвадорж, Г.Тэлмэн, Т.Тэлмэн, У.Хосжаргал, Д.Энхжаргал, Г.Эрдэнэбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Л.Соронзонболд, М.Мандхай, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Нинжбатын Ууганбаатарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргаар томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 37
Бүгд: 93
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Сугарын Лхагвадоржийг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Гэрэлтийн Тэлмэнг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 36
Бүгд: 93
61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Тунсагийн Тэлмэнг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Ундраагийн Хосжаргалыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Данзанбалжирын Энхжаргалыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Гомбын Эрдэнэбаярыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Далрайн Даваасамбууг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас, Лхагвадоржийн Ариунаа, Лувсан-Очирын Дондог, Баатаржавын Лхагважав, Бат-Очирын Цэрэнбалтав, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Мишигийн Энх-Амгалан нарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 28
Бүгд: 93
69.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Уг асуудлыг 17 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч И.Батхүү, Т.Гарамжүгдэр, А.Даваасүрэн, Д.Мягмарцэрэн, Д.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын

хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын тавьсан асуултад нэр дэвшигч И.Батхүү, Т.Гарамжүгдэр, А.Даваасүрэн, Д.Мягмарцэрэн, Д.Цолмон нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Хэрлэн нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Идэшийн Батхүүг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 47
Бүгд: 93
49.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан техникийн саатлын улмаас санал хураалтад оролцож чадаагүй тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 43
Бүгд: 90
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул Идэшийн Батхүүг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Төмөрбаатарын Гарамжүгдэрийг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 41
Бүгд: 93
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Авирмэдийн Даваасүрэнг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 43
Бүгд: 93
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Дамдиндоржийн Мягмарцэрэнг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 46
Бүгд: 93
50.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Дорждэрэмийн Цолмонг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 41
Бүгд: 93
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Ганболдын Золбоог Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 38
Бүгд: 93
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнийг томилох саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Уг асуудлыг 17 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж баталсан тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулах нь зүйтэй гэсэн санал гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжив.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан баталсан тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулав.

1.“Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:54/

2.“Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:54/

3.“Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:54/

4.“Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:54/

5.“Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:55/

6.“Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай

холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:55/

Уг асуудлыг 17 цаг 55 минутад танилцуулж дуусав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу товлосон асуудлыг ажлын цагт багтаан хэлэлцэж дуусаагүй тул хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хуралдааны цагийг сунгав./17:55/

Долоо. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Итгэлт, мөн газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Д.Мөнхбат, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, мөн хэлтсийн ахлах шинжээч Б.Цэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 47

Бүгд: 93
49.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 43
Бүгд: 93
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 42
Бүгд: 93
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар төлөгчтэй харилцах газрын дарга Б.Буяннэмэх, Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга Ц.Тогосмаа, Олон улсын татварын хэлтсийн дарга Л.Мөнхтуул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос гаргасан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 38

Бүгд: 83

54.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Ес. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 30

Бүгд: 81
54.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Арав. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 35
Бүгд: 79
55.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 33

Бүгд: 77

57.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр. *“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн ахлах эдийн засагч Т.Тэлмэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын тайланг Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар танилцуулав.

Тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 33

Бүгд: 77

57.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Арван гурав. *Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн С.Энхжаргал, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан газрын дарга Н.Нацагдорж, мөн захиргааны зөвлөх Б.Энхсайхан, Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарсанаа, Мэдээлэл, харилцаа холбооны инженер М.Отгонбат, мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 19 цаг 28 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, Г.Хосбаяр, Н.Алтаншагай, Ч.Анар, Н.Батсүмбэрэл, Ж.Алдаржавхлан, А.Ундраа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ, Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан газрын дарга Н.Нацагдорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 19 цаг 48 минутаас хуралдааныг даргалав.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар,

Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заяабал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн гарчгийн “ХОТЫН” гэсний дараа “ТӨЛӨВЛӨЛТ” гэж нэмж, үүнтэй холбогдуулан төслийн 6 дугаар бүлгийн 26 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 26.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот төлөвлөлт” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 35
Бүгд: 79
55.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь түүхэн нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулж, Монгол үндэстний түүх, язгуур өв, нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжих, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ж.Золжаргал, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 34
Бүгд: 79
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль” гэсний дараа “Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 31
Бүгд: 80
61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Г.Хосбаяр нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 30
Бүгд: 80
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим

4.1.Хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-д зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

4.1.1.монгол үндэстэн, угсаатны уламжлалт үнэт зүйл, түүх, соёлын, биет болон биет бус өвийг сэргээх, хадгалан хамгаалах;

4.1.2.түүх, соёлын дурсгалт газар, археологи, соёлын, биет болон биет бус өв, байгалийн онцлог, нүүдлийн соёл иргэншилд түшиглэн олон төрөлт, тогтвортой аялал жуулчлалыг дэмжих;

4.1.3.бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан, эдийн засгийн хувьд Хангайн бүсийн хөгжлийг дэмжиж, бие даан хөгжих боломжтой байх;

4.1.4.тогтвортой хөгжлийн зорилгыг хангах хөрөнгө оруулалтыг дэмжих;

4.1.5.хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, оршин суугчийн нийтлэг эрх, хууль, ёсны, ашиг сонирхолд нийцсэн, нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, хүмүүнлэг олон төвт хотын тогтолцоог хөгжүүлэх;

4.1.6 Дэвшилтэт технологи, инновацад суурилсан, ухаалаг дэд бүтцийг хөгжүүлэх;

4.1.7.эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийг дэмжих;

4.1.8.сэргээгдэх эрчим хүчний олон төрлийг дэмжих;

4.1.9.орчны аюулгүй байдлыг хангаж, гамшгаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.10.Улаанбаатар хот болон бусад бүс нутагтай холбогдох зорчигч болон ачаа тээврийн сүлжээг хөгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 30
Бүгд: 80
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хотын эрх зүйн үндэс

5.1.Хот нь улсын зэрэглэлтэй байна.

5.2.Хотын захирагч хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хотыг төлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 30
Бүгд: 80
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох, түүнийг өөрчлөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэх бөгөөд Газрын тухай хуульд заасан эдэлбэр газрын хэмжээ, заагийг баталж, тогтоохтой холбогдох зохицуулалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 31
Бүгд: 80
61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Хот нь” гэсний дараа “Хот байгуулалтын тухай хуулийн 11.1-д зааснаас гадна” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 31
Бүгд: 80
61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “асуудлыг” гэснийг “асуудал болон хэрэгжүүлэх дэд бүтцийн төслүүдийн жагсаалтыг” гэж өөрчилж, 7.4 дэх хэсгийг 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр хамт боловсруулах бөгөөд хотын Зөвлөл батална.

7.5.Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “зориулалтаас” гэснийг “зориулалт, хүн амын нягтаршлаас” гэж, 8.1.2 дахь заалтын “ногоон хот байгуулах зорилтын хүрээнд” гэснийг “хотын” гэж, 8.1.3 дахь заалтын “1 га” гэснийг “0.1 га” гэж, 8.1.5 дахь заалтын “нягтралыг” гэснийг “нягтаршлыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө барилгажилтын төслийн түвшинд” гэж, 8.1.6 дахь заалтын “төлөвлөгөөний шийдэл, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай” гэснийг “баримт бичигтэй” гэж, 8.1.8 дахь заалтын “байгууламжийн хамт цогцоор нь төлөвлөсөн” гэснийг “байгууламж, инженерийн дэд бүтцийн зурвасыг багтаасан цогц төлөвлөлтөөр шийдсэн” гэж, 8.2 дахь хэсгийн “ухаалаг шийдэл нэвтрүүлнэ” гэснийг “олон улсын ухаалаг хотын стандартад заасан ухаалаг шийдлийг нэвтрүүлж болно” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	44
Татгалзсан:	35
Бүгд:	79

55.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “орон сууцнаас” гэсний өмнө “нийтийн” гэж, 8.1.7 дахь заалтын “шийдэл нь” гэсний дараа “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан гудамжны нийтлэг өнгө, барилгын өндөржилт, загварын дагуу” гэж, 8.1.9 дэх заалтын “саарал усыг” гэсний өмнө “хотын олон нийтийн барилга байгууламж нь” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

Зөвшөөрсөн:	45
Татгалзсан:	34
Бүгд:	79

57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.15 дахь заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.18, 8.1.19 дэх заалт нэмэх:

“8.1.18.байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, соёл, нутгийн иргэдийн ахуй амьдралд түшиглэсэн, төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх;

8.1.19.түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээлд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээж, биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 32

Бүгд: 79

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмэх:

“8.3.Хотын ерөнхий төлөвлөгөөг 20 жил, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 5 жилийн хугацаатайгаар төлөвлөх бөгөөд оршин суугч болон аж ахуйн нэгжийн санал, барилгажилтын түвшин, хотын Зөвлөлийн олонхын шийдвэрийг үндэслэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 32

Бүгд: 79

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх саналыг дэмжсэнээр тооцож, 60.8 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хотын нутаг дэвсгэрийн бүсчлэл

9.1.Хотын нутаг дэвсгэр Хот байгуулалтын тухай хуулийн 13.1-д зааснаас гадна дараах бүсчлэлтэй байх бөгөөд эдгээр бүс нь тусгайлан баталсан бүсчлэлийн дүрэмтэй байна:

9.1.1.археологи судалгааны бүс ;

- 9.1.2.нийгмийн дэд бүтцийн бүс;
- 9.1.3.тээвэр логистикийн бүс;
- 9.1.4.инженерийн дэд бүтцийн бүс;
- 9.1.5.хамгаалалтын бүс;
- 9.1.6.холимог ашиглалтын бүс;
- 9.1.7.нөөц бүс /цагаан газар/

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан бүсчлэлийн дүрмийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр нарийвчлан тодорхойлно.

9.3.Бүсчлэлийн дүрэм тухайн бүсэд зөвшөөрөгдөх үйл ажиллагааны төрөл, барилга байгууламжийн хэмжээ, байршил, барьж болох барилгын зориулалтыг тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	47
Татгалзсан:	32
Бүгд:	79

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “төсөл сонгон шалгаруулах журмаар шийдвэрлэнэ.” гэснийг “дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	46
Татгалзсан:	33
Бүгд:	79

58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5.1 дэх хэсгийн “заасан бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээс” гэснийг “зааснаас” гэж, 10.5.2 дахь заалтын “бүтээн байгуулалтын төслийг” гэснийг “газар ашиглах” гэж, 10.7 дахь хэсгийн “төлөвлөгөөнд” гэснийг “төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	47
Татгалзсан:	32
Бүгд:	79

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар бүлгийн гарчгийг “ХОТЫН ЧИГ ҮҮРЭГ, УДИРДЛАГА” гэж өөрчилж, 12 дугаар зүйлийн 12.1.12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 32
Бүгд: 79
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 32
Бүгд: 79
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 35 дугаар зүйлийг хасах:

“14 дүгээр зүйл.Хотын удирдлага

14.1.Хотын удирдлагыг хотын Зөвлөл, Захирагч хэрэгжүүлнэ.

14.2.Хотын байнгын оршин суугчийн тоо 10000 хүрснээр хотын Зөвлөл, Захирагчийн сонгуулийг зохион байгуулна.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан Зөвлөл, Захирагчийн бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч, хотын удирдлагыг хэрэгжүүлнэ.

14.4.Энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.5.Зөвлөл нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах төлөөллөөс бүрдэнэ:

14.5.1.Засгийн газрын санал болгосон гурван төлөөлөл;

14.5.2.энэ хуулийн 14.7-д заасан Захирагч;

14.5.3.Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас санал болгосон гурван төлөөлөл;

14.5.4.хот байршиж байгаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;

14.5.5.барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон мэргэжлийн холбоодын хоёр төлөөлөл;

14.6.Энэ хуулийн 14.5.3-т заасан төлөөллийг нээлттэй нэр дэвшүүлж, тэдгээрээс сонгогдсон гишүүдийг энэ хуулийн 14.5-д заасан бусад гишүүдийн хамт Засгийн газар томилж, чөлөөлнө.

14.7 Энэ хуулийн 14.3-т заасан Захирагчийг Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 36
Бүгд: 79
54.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх саналыг дэмжсэнээр тооцож, 55.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3, 15.4, 15.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 29
Бүгд: 79
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 35
Бүгд: 79
55.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 33
Бүгд: 79
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.13 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 32
Бүгд: 79

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.4 дэх заалтын “батлах” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаа эсэхийг шалгах” гэж, 16.7.6 дахь заалтын “бүсчлэл” гэснийг “бүсчлэлийн дүрэм” гэж, 16.7.7 дахь заалтын “төлөвлөлтийн даалгаврыг батлах” гэснийг “төлөвлөлтийг хянан зөвшилцөх” гэж, 16.7.9 дэх заалтын “барилга байгууламжийн” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилга байгууламжийн” гэж, мөн заалтын “уялдуулан батлах” гэснийг “уялдаж байгаа эсэхийг хянах” гэж, 16.7.11 дэх хэсгийн “батлах” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагын дүгнэлтийн дагуу олгох” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 29

Бүгд: 79

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.3, 16.7.15 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 36

Бүгд: 79

54.4 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 29

Бүгд: 79

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх саналыг дэмжсэнээр тооцож, 64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “төлөвлөгөө” гэсний дараа “бүсчлэлийн дүрэм” гэж, 17.1.7 дахь заалтын “хот хөгжүүлэх” гэсний дараа “болон хотын дэд бүтцийн” гэж нэмж, 17.1.8 дахь заалтын “энэ хуулийн 29.1.2-т заасан” гэснийг “хотын өмчит болон хотын өмчийн оролцоотой” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 30
Бүгд: 79
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.6 дахь заалтын “бүтээн байгуулалтын” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Энэ хуулийн 18.2-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэлдүүлэхтэй холбоотой харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.2.5, 18.2.6, 18.2.14 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 32
Бүгд: 79
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “хот хөгжүүлэх” гэсний дараа “сан, хотын дэд бүтцийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 30
Бүгд: 79
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх саналыг дэмжсэнээр тооцож, 63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 32
Бүгд: 79
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 29
Бүгд: 79
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх саналыг дэмжсэнээр тооцож, 64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “паркийг” гэснийг “парк, гаалийн тусгай бүсийг” гэж, мөн хэсгийн “заасан журмын дагуу” гэснийг “заасны дагуу” гэж өөрчилж, 23.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 29
Бүгд: 79
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “Зөвлөлийн шийдвэрээр” гэснийг “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.8-д заасны дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 27
Бүгд: 79
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.1.3.хотын өмчит болон хотын өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хотод ноогдох ноогдол ашгийн 10 хүртэлх хувь;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 30
Бүгд: 79
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.4, 25.1.5, 25.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 30
Бүгд: 79
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.2.1 дэх заалтын “инженерийн болон” гэснийг хасаж, 25.2.2 дахь заалтын “түүх, соёлын” гэсний дараа “өвийг хадгалан хамгаалах” гэж, 25.3 дахь хэсгийн “санг бууруулах” гэсний дараа “түүний удирдлага, зохион байгуулалт” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “эх үүсвэрээр” гэсний дараа “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 29
Бүгд: 79
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.5 дахь хэсэг нэмэх:

“27.5.хөрөнгө оруулалтын хэлбэр татварын болон татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 26
Бүгд: 79
67.1 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийг “28.1.Хотод хэрэгжүүлэх төсөл нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан шалгуур хангасан тохиолдолд дараах хугацаагаар

тогтворжуулах гэрчилгээ олгоно.” гэж, 28.6 дахь хэсгийн “өөрөөр заагаагүй” гэснийг “заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 29

Бүгд: 79

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.7 дахь хэсэг нэмэх:

“28.7.Хотод үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээртэй хамтран ажиллах зорилгоор хөрөнгө оруулагч оруулагчдын төлөөллөөс бүрдсэн Хөрөнгө оруулагчдын зөвлөлийг хотын Захирагчийн дэргэд байгуулах ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хотын Зөвлөл батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 31

Бүгд: 79

60.8 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 32

Бүгд: 79

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 29

Бүгд: 79

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 29

Бүгд: 79

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн гарчгийн “этгээдийн” гэсний дараа “эрх,” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.1 дэх хэсэг нэмэх:

“33.1.Хот төлөвлөлтийн баримт бичгээр зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр бүсчлэлийн дүрмийн дагуу хэрэгжүүлэх эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 30
Бүгд: 79
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Иргэний хуульд” гэснийг, мөн зүйлийн 34.3, 34.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 27
Бүгд: 79
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.Энэ хуулийг 2025 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн энэ хуулийн 14.2-т заасан нөхцөл бүрдэж, хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 27
Бүгд: 79
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 27
Бүгд: 79
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “бүтээн байгуулах” гэсний өмнө “төлөвлөх” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалтын “нийтийн” гэсний өмнө “олон” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “бүтээн байгуулалт” гэсний өмнө “төлөвлөлт” гэж, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.6 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь хэсгийн “хөгжлийн” гэсний дараа “ерөнхий төлөвлөгөө” гэж, 10 дугаар зүйлийн 10.5.2 дахь заалтын “хэрэгжүүлж” гэсний өмнө “төслийг” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “чиг үүргээс” гэсний өмнө “нийтлэг” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Засгийн хуралдаанд” гэснийг “Засгийн газарт” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтын “нийтийн үйлчилгээний” гэснийг “олон нийтийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “гүйцэтгэнэ” гэснийг “хэрэгжүүлнэ” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “зөвлөл, түүний” гэснийг “зөвлөлийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “эрх, үүргийг” гэж, 18 дугаар зүйлийн 18.2.3, 18.2.4 дэх хэсгийн “байгууламж” гэснийг “байгууламжийн” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “үйлдвэр” гэснийг “үйлдвэрлэл” гэж, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “тогтворжуулалтын” гэснийг “тогтворжуулах” гэж, мөн хэсгийн “зохицуулаагүйгээс” гэснийг “зохицуулснаас” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 33
Бүгд: 79
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Р.Сэддорж, Г.Ганбаатар, Б.Хэрлэн, Д.Үүрийнтуяа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.5 дахь хэсгийн “эзэмших,” гэснийг тус тус, 10.3 дахь хэсгийн “ашиглуулахаас” гэсний өмнөх, мөн хэсгийн “ашиглуулах” гэсний өмнөх, 16 дугаар зүйлийн 16.7.6 дахь заалтын “эзэмшүүлэх,” гэснийг тус тус хасаж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Г.Хосбаяр, Б.Баярбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 55
Бүгд: 79
30.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг хасаж, 16.6 дахь хэсгийн “алба болон харьяа газрын” гэснийг “албаны” гэж өөрчлөх гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 51
Бүгд: 79
35.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Нэг.Улсын зэрэглэлтэй хот” гэсэн хэсгийн 4 дэх заалтыг бүхэлд нь хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 32
Бүгд: 79
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

““Хархорум” хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийг “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” гэж өөрчилж, тогтоолын төслийн тэмдэглэх хэсгийн “хэсэг, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг” гэснийг “хэсгийг” гэж өөрчилж, төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1.“Хархорум” хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн зохион байгуулах;

2.“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны төсөв, хөрөнгө, эрх, үүрэг, бүтэц бүрэлдэхүүнийг Хархорум хотын Захирагчийн ажлын албанд шилжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	50
Татгалзсан:	29
Бүгд:	79

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дэх заалтыг хасаж, үүнтэй холбогдуулан тус заалтын агуулгыг алдагдуулахгүйгээр “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	49
Татгалзсан:	30
Бүгд:	79

62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Итгэлт, мөн газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Д.Мөнхбат, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, мөн хэлтсийн ахлах шинжээч Б.Цэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 35

Бүгд: 79

55.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 20 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 14 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 10 цаг 48 минут үргэлжилж, 126 гишүүнээс 93 гишүүн хүрэлцэн ирж, 73.8 хувийн ирцтэйгээр 20 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН

ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 04 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн ирц 50,8 хувьд хүрсэн байна. 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 19 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

2 Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

3 Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

4 дүгээрт Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

5 дугаарт Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

6 дугаарт Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүдийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

7 дугаарт “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

8 дугаарт Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

9 дүгээрт “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

10 дугаарт “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

11 дүгээрт “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

12 дугаарт Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

13 дугаарт Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

14 дүгээрт “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

15 дугаарт “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэл хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

16 дугаарт Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

17 дугаарт “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

18 дугаарт “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

19 дүгээрт баталсан хууль, тогтоолын төслийн эцсийн найруулгыг сонсоно.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох тухай саналыг уншиж танилцуулна. Нэр дэвшигчийн талаар гаргасан Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай танилцуулна. Индэрт урьж байна.

М.Мандхай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.13 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан өөрийн бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргад Түндэвийн Жамбаажамцыг нэр дэвшүүлсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 3 дугаар тогтоолоор баталсан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн зааврын дагуу нэр дэвшигч Жамбаажамц өөрийн танилцуулга, холбогдох бусад баримт бичгээ бүрдүүлж, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай тогтоолыг баталж, 2024 оны 1 дүгээр сарын 14-

ний өдөр нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулахаар шийдвэрлэж, сонгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддоржийг томилсон.

Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан нэр дэвшигчийн сонголд Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батшугар, Ганхуяг, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг, Цогтбаатар, Эрдэнэбат нарын гишүүд оролцсон болно.

Байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Санхүүгийн зохицуулах хорооны даргад нэр дэвшигчийн сонголт явуулсан талаарх сонголын тайланг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гарган танилцуулж байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлээгүй бөгөөд Түндэвийн Жамбаажамцыг Санхүүгийн зохицуулах хорооны даргад томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Дэмбэрэлдашийн Баярсайханыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлүүлэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Түндэвийн Жамбаажамц хүрэлцэн ирсэн байна. Танилцуулгыг уншиж танилцуулъя.

Санхүүгийн зохицуулах хорооны даргад нэр дэвшигч Түндэвийн Жамбаажамцын танилцуулга.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт хорооны даргад Улсын Их Хурлын дарга нэр дэвшүүлж Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонголт хийж томилно гэж заасныг үндэслэн Түндэвийн Жамбаажамцыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж байна.

Т.Жамбаажамц нь 1982 онд Баянхонгор аймгийн Баянхонгор сумд төрсөн. Ам бүл 6, эхнэр 4 хүүхдийн хамт амьдардаг.

Нэр дэвшигч нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийг 2006 онд эрх зүйч мэргэжлээр бакалавр, 2017 онд СЭЗИС-ийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Жамбаажамц нь 2006-2007 онд Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, шалгалтын газрын мэргэжилтэн, ажилтан, 2007-2009 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт мэргэжилтэн, 2009-2011 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт хянан шалгагч, 2011-2013 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт ахлах хянан шалгагч, 2013-2014 онд Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгийн зах зээлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, 2014-2015 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, 2015-2016 онд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газрын орлогч дарга, 2016 оноос одоог хүртэл Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын албан тушаал эрхэлсэн ажлын туршлагатай.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгосон төрийн захиргааны тэргүүн зэрэг дэвтэй. Төрийн мэргэшсэн албан хаагч юм.

Нэр дэвшигчийн мэргэшсэн байдлын хувьд Япон Улс, Англи улс, Малайз улс, БНЭУ, Арабын Бүгд Найрамдах Египет Улс, БНСУ, БНХАУ, АНУ зэрэг санхүүгийн хөрөнгийн зах зээлийн чиглэлээр богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан. 2010-2012 онд Нью-Йоркийн хөрөнгийн бирж, Лондоны хөрөнгийн бирж, Хонг Конгийн хөрөнгийн бирж, АНУ-ын Хөрөнгө оруулалтын банк, Үнэт цаасны хороонд дадлагажигч суралцагчаар, 2011 онд БНСУ-ын Хөрөнгө оруулалтын банк болох leading investment and securities LLC-д 3 сарын хугацаанд дадлагажигч ажилтнаар тус тус ажиллаж, мэргэжил дээшлүүлсэн.

Мөн хөрөнгийн зах зээл, компанийн засаглал, бизнесийн эрх зүй сэдвээр санхүүгийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд эрх олгох болон мэргэшүүлэх сургалт, түүнчлэн СЭЗИС-ийн магистрын хөтөлбөрт сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд багшилж байна.

Жамбаажамц нь Үнэт цаасны зах зээлийн эрх зүй, компанийн эрх зүй, компанийн засаглалын чиглэлээр судалгаа хийж, хууль зүйн их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөр болон санхүүгийн зах зээлийн хуульчдад зориулсан үнэт цаасны зах зээлийн эрх зүй хичээлийн хөтөлбөрийг 2011 онд, Үнэт цаасны эрх зүй гарын авлагыг 2013 онд, Хувьцаа эзэмшигчийн эрх гарын авлагыг 2017 онд салбарын эрдэмтэн судлаачидтай хамтран тус тус бэлтгэн гаргаж хэвлүүлжээ.

Мөн 2013 онд Монгол Улсын компанийн засаглалын үндэсний тайлан, 2019 онд төрийн өмчит компаниудад хийсэн компанийн засаглалын үнэлгээний тайлан, 2020 онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулалтын үнэлгээний тайланг боловсруулахад тус тус оролцсон.

Түндэвийн Жамбаажамц нь Санхүүгийн зохицуулах хороонд ажиллах хугацаандаа Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Санхүүгийн зах зээлийн бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм, журам,

заавар, боловсруулах ажил зэрэгт гар бие оролцон, манлайлан өнөөгийн санхүүгийн зах зээлийн тогтолцоог хөгжүүлэх, боловсронгуй болгоход чухал үүрэгтэй оролцож ажилласан.

Жамбаажамцын санхүүгийн зах зээлийн чиглэлээр мэргэшсэн байдал, мэдлэг, боловсрол, Санхүүгийн зохицуулах хорооны төсөв, санхүү, хүний нөөцийн удирдлага, Монгол Улсын даатгал, бичил санхүү, хөрөнгийн зах зээл зэрэг санхүүгийн зах зээлийн бодлого, зохицуулалт, хяналт, хяналтын орчныг бүрдүүлэх, хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан туршлага, удирдан зохион байгуулах чадвар, энэ байгууллагадаа тасралтгүй, тогтвортой бүх түвшинд ажилласан байдлыг харгалзан төрийн албаны чадавхын зарчмыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Танилцуулгыг уншиж танилцууллаа.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

А.Ариунзаяа: Өглөөний мэнд. Жамбаажамц нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлэх гэсэн юм. Маш олон жил Санхүүгийн зохицуулах хороонд ажиллаж байгаа. Үнэхээрийн мэргэжлийн мерит томилгоо гэдэг бол яг л энийг хэлнэ.

Би тэгээд яг энэ завшааныг ашиглаад бас иргэддээ мэдээллийг хүргээсэй гэдэг үүднээс энэ албан журмын жолоочийн даатгалын талаар юу болчихоо гэж асуух өгөх гэсэн юм.

2011 онд Улсын Их Хурлаар албан журмын даатгалын хууль батлагдсан. 2011 онд би ч даатгалын компанид ажиллаж, яг энэ жолоочийн хариуцлагын даатгалыг зөндөө л хийдэг байлаа. Тэгээд 2011 оноос хойш 14 жилийн дараа өнгөрсөн оны 10 сард итгэлцүүрээ шинэчилжээ. Санхүүгийн зохицуулах хороо өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу, тогтоолоор энэ итгэлцүүрээ шинэчилсэн юм байна. Гэтэл нийгэмд жолоочийн хариуцлагын даатгал 700 мянган төгрөг боллоо гэдэг ийм шуугиан явсан. Тэгээд эргээд л нөгөө төр засаг руу дайрах ийм асуудал гарлаа л даа. Тэгээд үнэхээрийн 700 мянган төгрөг болчихсон юм уу, юу болчихов, юу болоод өнгөрчхөв. Тухайн үед тогтоолоо гаргачхаад итгэлцүүрээ 2-оор нэмэгдүүлээд, жолоочоо хариуцлагажуулах буюу осол их хийсэн бол 40 хувиар нэмэгдүүлэх ийм өөрчлөлтүүдийг хийсэн юм байна. Хариуцлагатай жолооч бол эсрэгээрээ хураамж нь буурах ийм өөрчлөлтүүдийг хийсэн юм байна гэж би ойлгосон. Тэгээд энэ журмаа Хууль зүйн яаманд хүргүүлээд.

Д.Амарбаясгалан: Ариунзаяа гишүүний асуулт томилгооны сонсголтой холбоогүй асуулт учраас хариулах боломжгүй. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Давхардчихлаа.

Д.Амарбаясгалан: Асуулт давхардсан. Өлзийхүүгийн Шижир гишүүн алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Жамбаажамцыг бас дэмжиж байна. Тэгээд 1 зүйл байна лээ. Бас сонсгол болон Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэхэд 1 байгууллагадаа бас их олон жил ажиллаж байгаа гэдэг бол бас тийм нэг их том шалгуур биш. Энэ байгууллагын өнгөрсөн хугацаан дахь сайн, муу бүх зүйлтэй холбоотой. Сайн муугаа дэнсэлбэл бас хаашаагаа явах вэ гэдэг дээр ч гэсэн бодоорой гэдэг зүйлийг бас хэлж байсан.

Тэгээд хоёулаа бол бас олон салбарт олон хуулийн прожектууд, хар саарал жагсаалтаас Монгол Улсыг гаргах гээд ажиллаж байсан хувьд өөрийг чинь мэднэ. Зарчмаа барьдаг гэдгийг чинь мэднэ. Тийм учраас бас зарчим барихаас гадна яг энэ санхүүгийн сектор дээр бас тулгамдаад байгаа асуудлуудаа шийдэхэд жоохон зоримог байгаарай л гэж хүсэж байгаа юм. Би ч бас ний нуугүй л хэлсэн. Манай Санхүүгийн зохицуулах хороо бас нэг жоохон тийм хойрго шүү. Хэтэрхий их мэргэжлийн оролцогчдынхоо үгээр явдаг шүү. Цаана нь нөгөө санхүүгийн хэрэглэгчдээ бас жоохон мартчихдаг юм шүү. Жоохон тэнцвэртэй эрх ашгуудыг хангахад бас анхаараарай гэдэг зүйлийг л хэлмээр байгаа юм.

Тэгээд би яах вэ, хэд хэдэн зүйлүүдийг анхааруулмаар байна. Энэ зах зээл дээр уг нь өрсөлдөөн гэдэг зүйл л явж баймаар байгаа юм. Банк бус санхүүгийн байгууллагын бас үйл ажиллагаа өрсөлдөж байж л тэдгээрээс олгож байгаа зээлийн хүртээмж болон хүү буурна. Гэтэл банк бус санхүүгийн байгууллагуудын дүрмийн санг өсгөөд байхаар цөөн тооны л хүмүүс зах зээл дээр үлдээд байгаа юм. Тэгээд энэ хэд чинь үндсэндээ манай дээр бол хэрэглээний зах зээлийг л дэмжиж байгаа шүү дээ. Тэгээд энд гадаад худалдааны тэнцэл дээр угаасаа асар их хувь нэмэр оруулж байгаа хүмүүс зөрүү дээр. Тэгэхээр ер нь зүгээр өрсөлдөөнийг дэмжээрэй гэдэг зүйлийг л би хүсэж байгаа юм.

2 дугаарт энэ зарим хуулиуд их хоцрогдчихсон. Зохицуулалтын хувьд. Тэгээд энэ зохицуулалттай салбарын хувьд хууль нь хоцрогдохоор байснаасаа илүү гай болдог юм байна лээ. Би энийг бас жоохон ойлгоод байгаа. Тэгээд та бас энэ дээр үнэхээр тэр даатгалын болоод зарим хууль, тогтоомжуудаа бас нэг жоохон тэнцвэрт байдлаар сайжруулах, зах зээлийн болон технологийн энэ цаг үе дээр бас жоохон сайжруулах талд нь анхаараарай. Тэгэхдээ зөвхөн энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллагуудын эрх ашгийг хамгаалж биш шүү. Иргэдийнхээ эрхийг тэнцвэртэй хамгаалж бас сайжруулахад анхаараарай гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт бид шинэ тутам зохицуулалтуудыг эрх шилжүүлэх замаар буюу журам дүрэм гаргадаг. Сая Ариунзаяа сайд асуугаад байгаа нь энэ шүү дээ. Болж өгвөл энэ дүрэм журмуудаа цаашдаа процессжуулаад хуульчлаарай. Хуулиа сайхан дэлгэрэнгүй хийхгүй бол хэн нэг дарга цэрэг гарч ирээд л өөрчлөөд байж болдоггүй юм. Энэ өөрөө зах зээлийг тогтворгүй, хэрэглэгчдэд ойлгомжгүй, дараа нь эрх ашиг нь иргэд л хохирдог ийм зүйл байгаа.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд бас бодитой оруулаарай. Ингэж байж наад хөрөнгийн болон үнэт цаасны зах зээл чинь жоохон итгэл төрнө шүү. Эд нарын шүүхэд хандах эрхийг хүртэл босго тавиад хохироочихсон байхгүй юу. Тэгчхээд та хувьцаа аваач гээд бид хэд ятгаад итгэж үнэмшүүлэх гээд байдаг. Эцсийн дүндээ эрх ашиг нь хохироход тодорхой квотод хүрээгүй байна гээд та шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй гээд л ингээд зогсоочихдог.

Тэгэхээр энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд анхаарна биз.

2 дугаарт тэгээд хамгийн сүүлд нь бас оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах буюу хөдлөх эд хөрөнгүүдийн үнэ цэнийг бас банк, банк санхүүгийн байгууллага, магадгүй ер нь зүгээр бас жоохон үнэ цэнтэй болгоход бас санхүүгийн секторыг удирдах гол байгууллагын нэг учраас та бас энэ дээр жоохон манлайлал үзүүлж ажиллаарай гэж хүсэж байна. Тэгээд хариултууд хэрэггүй байх. Би зүгээр захиас хэлж байгаа юм. Тэгээд ажлын амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэллээ. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Ганхуяг: Өглөөний мэнд хүргэе. Санхүүгийн зохицуулах хороо бол үндсэндээ Монгол Улсын санхүүгийн зах зээлийг бүхэлд нь зохицуулалт хийдэг болсон байгаа шүү. Хуучин бол зөвхөн банк бус, ХК, даатгал гээд явдаг байсан бол өнөөдөр арилжааны банкнууд хүртэл энэ хороонд харьяалдаг болсон. Тэгээд яах вэ Жамбаажамц даргыг бол дэмжиж байна. Ер нь бол бас олон жил ажилласан. Ер нь бол үнэт цаасны зах зээлийн ихэнх хууль дээр хамтарч ажилласан байгаа. Сая өнгөрсөн 4 жилийн хугацаанд.

Гэхдээ 3 зүйл дээр анхаарч ажиллахыг би бас Жамбаажамцад даалгах гэсэн юм. Өнөөдөр бид нар төрийн өмчит компаниудын асуудлыг ярихаар нээлттэй ХК болгох, хувьцааг нь хөрөнгийн бирж дээр гаргах асуудлыг ярьдаг. Гаргах асуудлыг ярьдаг. Яагаад энийг ингэж ярьдаг вэ гэхээр өнөөдөр бол компанийн засаглалын хамгийн жишиг бусад засаглал нь өөрөө эргээд нээлттэй ХК буюу засаглал нь ил тод байдаг, өгөөж нь ил тод байдаг болохоор тийшээ бид нар аль болох явуулах ийм бодлого бариад явж байгаа. Тэгээд энэ дээр нэг асуудал нь юу болж байна гэхээр жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд тавина шүү. Яагаад энийг хэлж байна гэхээр бид нар яг хөрөнгө оруулагчдын итгэлийг олж авъя гэх юм бол яалт ч үгүй жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах ёстой юм. Хөрөнгө оруулагчид хэзээ ч 51-ээс дээш хувийг авдаггүй юм. Дандаа л 5, 10, 30 гээд иймэрхүү хувь дээр л хөрөнгө оруулалт хийдэг. Яагаад гэхээр хөрөнгө оруулагч бол менежментийг нь хийх сонирхол байдаггүй юм. Тийм учраас энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн асуудлыг ялгаа байхгүй яг тэр хувьцааны олонхыг эзэмшиж байгаа иргэдтэй нь адилхан хэмжээнд хамгаалж байж, адилхан хэмжээнд эрхийг нь байлгаж байж л энэ хөрөнгө оруулалтын зах зээл, хөрөнгө оруулалтын орчин, хөрөнгийн зах зээлд итгэх итгэл нэмэгдэх юм байгаа юм шүү.

Өнөөдөр олон жил тэр Улсын Их Хурлын, УИД-ийн асуудлын хувьцаа эзэмшигчдийн асуудал яригддаг шүү. Санхүүгийн зохицуулах хороо сүүлийн миний санаж байгаагаар 26 жил, 28 жил энэ тал дээр дорвитой ямар ч арга хэмжээ аваагүй. Жижиг хувьцаа эзэмшигчдийн асуудлыг нь хамгаалахгүй байсаар байгаад хувьцааг нь үнэгүйдүүлээд авсаар байгаад өнөөдөр 1 том компани тэрийг нь бүхэлдээ эзэмшигчсэн сууж байна. Иймэрхүү байдлаар хандаж болохгүй шүү. Энийг та онцгой анхаарч ажиллах ёстой шүү.

2 дугаарт энэ койны асуудал гээд. Яг энэ койны асуудал яг энэ ковидын үеэр эрчээ авсан юм байгаа юм. Тэгээд энийг би Санхүүгийн зохицуулах хороо дээр нэг биш удаа очиж уулзалт хийсэн. Та нар энийгээ 1 бол зохицуулалттай болго. 1 бол хоригло. Тэгээд асуудал нэлээн хүндэрсний дараа бүртгэх үйл ажиллагаа явуулж

эхэлсэн. Өнөөдөр зарим нөхөд нь шүүх цагдаа болчихсон л явж байна. Тэгээд энэ асуудлуудыг урьдчилж харж, хууль, эрх зүйн орчныг нь шинэтгэж явж байхгүй бол дандаа хойноос нь хоцорч явж байна. Үүний үр дүнд юу болж байна гэхээр дандаа иргэд хохирч байна. Нээлттэй зар сурталчилгаа хийгээд, хүмүүсээс мөнгийг нь цуглуулаад ингээд яваад байхаар энэ зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа байна гэдэг итгэл үнэмшил иргэдэд төрсөн байхгүй юу. Тэр бүү хэл манай энэ хороонд ажиллаж байсан зарим хүмүүс ч гэсэн тэд нартай холбогдсон. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань онцгой анхаарч ажиллана шүү.

3 дугаарт өнөөдөр Зөвшөөрлийн хууль бол үндсэндээ бол батлагдаад 2 жил болж байна. 3 дахь жилийн нүүрийг үзэх гэж байна. Салбарын хамгийн олон зөвшөөрөлтэй салбар бол танайх байгаа шүү. Нийтдээ 33 тусгай зөвшөөрөл байна. 25 энгийн зөвшөөрөл байна.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье Ганхуяг гишүүнд.

Х.Ганхуяг: Тэгээд яг асуудал ярихаар гүйж очоод л зөвшөөрөлтэй болгоод хаячихдаг. Тэгэхээр энэ дээр анхаарна шүү. Аль болох зөвшөөрлийнхөө тоог багасгах тал дээр арга хэмжээ авч явна шүү.

Тэгээд ер нь цаашдаа яг энэ санхүүгийн зах зээл дээр шинэ үйлчилгээ, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх тал дээр илүү тэр бусад хөгжингүй орнуудын бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, илүү ардчилалтай болох, илүү өрсөлдөөнт зарчим руу шилжүүлэхгүй бол яг хуучин арга барилаар яваад байгаа шүү. Тэгээд тэр маань угаасаа энэ хөрөнгийн зах зээл дээр зохихгүй гэдгийг та өөрөө ч мэдэж байгаа байх. Энэ тал дээр онцгой анхаарч ажиллаарай гэж хүсэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Ганбатын Очирбат гишүүн үг хэлье. Асуулт асууя.

Г.Очирбат: Өглөөний мэнд хүргэе. Ер нь бол яг энэ тэгээд мерит зарчмаар явж байгаа залуучуудаа бас дэмжээд ажиллах ёстой гэдэг байр суурь дээр байгаа.1-д.

2-т гэх юм бол Санхүүгийн зохицуулах хороонд сүүлийн 19 жил тасралтгүй ажилласан байна. Энэ зохицуулах хороотой холбоотой муу, сайн янз бүрийн юм нийгэмд байдаг. Ялангуяа тэр банк бус санхүүгийн байгууллагуудтай холбоотой, түрүүн бас Ганхуяг гишүүн хэлж байна. Тэр койнтотой холбоотой асуудлууд, зөвшөөрөлтэй холбоотой асуудлууд. Ингээд нөгөө банк санхүүгийн салбар маань өөрөө энэ Санхүүгийн зохицуулах хороо маань хууль, эрх зүйн шинэтгэлүүдээ хийж чадахгүй дандаа үүнийхээ араас явдаг.

Тэгэхээр та 19 жилийн туршлагатай, олон даргын нүүр үзсэн, олон луйвар булхай дундуур явсан. Тэгэхээр энэ шинэчлэл хийх юмаа зоригтой хийгээрэй гэж хэлэх гэсэн юм. Тэгэхгүй бол иргэн бүр санхүүгийн харилцаанд орж байгаа. Тэгээд дандаа Санхүүгийн зохицуулах хороо дээр очоод асуудлууд ингээд гацдаг. Араас нь дандаа энэ шинэтгэлийн юмнууд нь явдаг шүү. Тэгэхээр та залуу хүн, мэргэжлийн хүн, дотор нь олон жил ажилласан, алдаа оноотой дарга нарын шийдвэрийг бас дагаад явж байсан. Заримдаа бол шүүмжлээд ч явж байсан цаг хугацаа байгаа байх. Тэгэхээр энэ туршлага дээрээ тулгуурлаад Санхүүгийн зохицуулах хороо гэдэг энэ байгууллагын даргаар очиж байгаа болохоор зоригтой, эрчтэй ажиллаарай гэж л хүсэх гэсэн юм. Тэгээд ажилд нь амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Баасанжаргал: Надад 3 асуулт байна. Тэгээд 1 дүгээрт энэ нөгөө цахим аппликэйшны асуудал, мөрийтэй тоглоомын асуудал дээр Санхүүгийн зохицуулах хорооны даргаар томилогдвол ер нь энэ тал дээр ямар төрлийн хяналт шалгалт, ямар хүрээнд ажиллах ёстой гэж харж байгаа вэ. Би бол Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс бол идэвхтэй үйлдэл гэхээс илүү эс үйлдэхүй гаргаж маш их алдаа хийдэг гэж хардаг. Олон хүн хохирсны дараа хөдөлдөг. Тэгэхээр ийм эс үйлдэхүйтэй холбоотой асуудал, эс үйлдэхүйтэй холбоотой зүйлийг энэ хууль тогтоомж дээрээ байгаа эсэхийг харсан уу. Ер нь бол Санхүүгийн зохицуулах хорооны эс үйлдэхүйн асуудал дээр бас ямар байр суурьтай байгаа вэ.

2 дугаар асуулт. Орон нутгийн иргэдийн энэ санхүүгийн боловсролыг дээшлүүлж, Санхүүгийн зохицуулах хороо энэ зохицуулалттай энэ зах зээлд нэг чухал оролцогч болгох тал дээр та ямар бодлого, ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ. Энэ хөрөнгийн зах зээл гэдэг чинь ганцхан Улаанбаатар хот, суурин соёл иргэншил Улаанбаатар хотын иргэдэд зориулсан ийм зах зээл ерөөсөө биш. Тэгэхээр бүх нийтэд яг энэ санхүүгийн боловсрол, ялангуяа орон нутгийн иргэдийг энэ чиглэлийн боловсрол дээр анхаарах хэрэгтэй байгаа. Дээрээс нь нэмээд орон нутаг дээр орон нутгийн иргэд өөрсдөө тухайн орон нутгийнхаа баялгийн хувь хүртэх нэг арга зам би бас яг энэ зохицуулалттай зах зээл гэж харж байгаа. Орон нутгийн компани байгуулах замаар, тухайн орон нутгийн иргэд өөрсдөө хувьцаа эзэмших замаар тухайн орон нутгийн удирдлагууд үүнд нь ажиллах замаар ийм зүйл рүү бид нар тэлмээр байна. Энэ дээр ямар санаа оноо байдаг вэ.

3 дугаарт ашиг сонирхлын зөрчлийн асуудал маш их гардаг. Маш их мэргэжлийн салбарынхан тоглодог ийм салбар учраас маш их хаалттай хүрээнд, явцуу хүрээнд хэдэн биеэ таньдаг, асар их ийм хуйвалдааны шинжтэй байж болзошгүй, зарим тохиолдолд болоод байх шиг байгаа юм. Тэгэхээр ер нь энэ ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг зохицуулах тийм бодлого танд магадгүй шинээр батлах хууль тогтоомж, шинээр батлах ямар бодлого байгаа гэж харж байгаа вэ гэсэн ийм 3 асуултыг асуух гэсэн юм.

Тэгээд дэмжиж байгаа. Үг хэлэх дахиж өөр боломж олдохгүй учраас бас дээрээс нь маш их итгэл найдвар байгаа. Санхүүгийн зохицуулах хорооны хөгжлийн дараагийн үе шатад гаргах болов уу гэсэн ийм итгэл найдвар байгаа шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч Жамбаажамц.

Т.Жамбаажамц: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Сүүлийн асуултаас нь эхлээд хариулчихъя. 3 тодорхой асуулт асуулаа.

Ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн ангид байх вэ, хэрхэн яаж зохицуулах вэ гэж байгаа. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг хамгаалах тухай хуулийн хүрээнд манай Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан, албан хаагчид, удирдлагууд бол үйл ажиллагаагаа явуулдаг. Нөгөө талаараа Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу бас тодорхой

хязгаарлалтууд, тодорхой дотоод мэдээлэл эзэмшигч зэрэг ийм хязгаарлалтуудын хүрээнд мэдээ тайлангаа өгч ажилладаг. Мэдээж сүүлийн жилүүдэд Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа, ялангуяа энэ аливаа авлига төрийн нийтийн албан тушаалтнууд бол авлига, албан тушаалын зөрчлөөс ангид байх энэ бодлогыг бол хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллах нь мэдээж.

Тэгээд энэ манай санхүүгийн салбар бол өөрөө онцлог салбар. Нээлттэй, ил тод, хариуцлагатай ийм санхүүгийн салбар. Тэгэхээр энэ салбарынхаа юун дээр бол энэ ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх дээр бол хэрэв би энэ байгууллагын удирдлагаар томилогдоод ажиллавал манлайлж ажиллана гэдгээ бол 1 дүгээрт хэлье.

2 дугаарт нь тэр цахим үйл ажиллагаа, цахим луйвар, цахим залилан гэдэг дээр та бас их тодорхой онцолж хэлж байна. Ерөнхийдөө бол цахим орчинд үйлдэгддэг гэмт хэрэг сүүлийн 3 жилийн хугацаанд асар ихээр нэмэгдсэн байна. Тоо баримт ингээд харахаар 4 дахин, 5 дахин нэмэгдсэн ийм тоо баримтууд бол цагдаагийн байгууллагаас гаргасан тоо баримтаар гарч байгаа. Тэгээд энд бол би таны нөгөө 2 дахь асуулттай холбож хариулах гээд байгаа. Ерөнхийдөө бол энд цахим луйвар, цахим залиланд өртөөд байгаа энэ хандлага бол иргэдийн санхүүгийн боловсролтой бол шууд холбоотой. Иргэдийн санхүүгийн боловсролтой шууд холбоотой. Тэгэхээр бидний хувьд бол 1 дүгээрт Санхүүгийн зохицуулах хороо бол илүү яг тодорхой салбарын 30 орчим хуулийн хүрээнд зохицуулалт, хяналт тавьж ажилладаг ийм тодорхой ажлууд нь тодорхой ийм салбарт ажилладаг байгууллага байгаа. Тэгээд яг энэ манай зохицуулалтын салбар дээр бол цахим залилан гэдэг юм уу, залилан луйврууд бол мэдээж энэ дээр бол байдаггүй. Ялангуяа энэ иргэдийн хялбар аргаар мөнгө олох гэсэн гэдэг юм уу, энэ сонирхол дээр дөрөөлж, цахим луйврын ажиллагаанууд бол бас хийгддэг. Энэ дээр би тодорхой 2 санал хэлэхэд 1 дүгээрт нь энэ кроуд фандинг гэж хэлбэр байгаа. Кроуд фандингийн хэлбэрээр юу гэдэг юм олон нийтэд тэр хандив цуглуулдаг гэдэг юм уу, тодорхой төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, бизнест орлого олох эсвэл зээлийн үйл ажиллагаа явуулах гээд энэ үйл ажиллагаанууд дээр бол тодорхой энэ хуулийн зохицуулалттай болох ёстой юм билээ гэж би бодож байгаа. Өөрөөр хэлбэл сая Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 5 сард Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад, үнэт цаасны хамтын санхүүжилтийн харилцааг зохицуулсан. Гэтэл цаад талын 3 үндсэн төрөл болохоор хандивт суурилсан, бусад тэр зээлд суурилсан зэрэг тэр төрлүүдийг бол өнөөдөр зохицуулалтгүй байгаа.

Тэгэхээр бид нар бол тэр тодорхой платформууд буюу яг хуулийн хүрээнд бүртгэлтэй хяналттай явдаг тодорхой хэмжээний санхүүжилт босгодог тэр платформыг нь бол үүсгэж өгөх нь зүйтэй юм байна. Зохицуулалтынх нь орчныг бий болгох ёстой гэж бол бодож байгаа. Тэгээд тэр дээр бол тодорхой тэр хуулийн төсөл боловсруулах ажил дээр бол манлайлж ажиллана. Энэ дээр бол Их Хурлын гишүүдтэйгээ энэ чиглэлээр хамтарч ажиллана гэж бодож байгаа.

Эцэст нь санхүүгийн боловсрол бол энэ бол зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажил биш. Бүх нийтийн ажил. Ялангуяа бага, дунд боловсрол гэдэг юм уу багаас нь санхүүгийн боловсролтой иргэн болгох, ирээдүйд санхүүгийн боловсролтой иргэн болгоход бол энэ бол туйлын чухал. Энэ дээр бол холбогдох .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигчийн микрофоныг чангалж өгөхгүй бол сул байгаад байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд хүргэе. Нэр дэвшигчийн мэдээлэлтэй танилцлаа. Олон жил тууштай ажиллаж байгаа, мерит зарчмаараа явж байгаа. 16 оноос хойш гэхээр 9 жил тасралтгүй дарга хийсэн хүн байна. Тэгээд ажлын албаны даргаар 9 жил ажилласан, гадаадад сургууль төгссөн. Санхүүгийн чиглэлээр мэргэшсэн этгээд байна гэж уншигдаж байна. Тэгээд 1 асуулт байна.

Энэ ажлын албаны дарга гэдэг чинь бас нэлээн хариуцлагатай дарга биз дээ?. Тэгээд жинхэнэ дарга болоход танд ямар эрх мэдэл дутав. Энэ Санхүүгийн зохицуулах хорооны даргаар томилогдвол би ийм ажил хийнэ гээд нэг юм бичсэн байна шүү дээ. Тэгээд энэ ажлын албаны дарга байхад чинь та жишээ болгоод 3 эрх мэдэл дутлаа гэдгээ хэлээч.

Тэгээд энэ дээр чинь бичсэн байна л даа. Хадгаламж зээлийн хоршоо, банк бус гээд эдгээрийг би цэгцэлнэ гээд. 500 гаруй банк бус, хэчнээн ч хадгаламж зээлийн хоршоо, ломбард байдаг юм. Сонгуулийн үеэр энэ 2 нам маань энэ ломбардын тоог багасгана гэж мөрийн хөтөлбөртөө болон сурталчилгаандаа нэлээн их түлхүү ярьсан. Тэгээд энэ улс төрд хамаарал бүхий этгээдүүдийн хэчнээн нь банк бустай байдаг юм. Хэчнээн нь Хадгаламж зээлийн хоршоотой байдаг юм.

Би бол ингэж хардаг юм. Танай Санхүүгийн зохицуулах хороо бол ил тодын байдлаараа маш муу ажилладаг. Ил тод байдал нь бол маш муу гэж хардаг. Тэгэхээр та танай Санхүүгийн зохицуулах хороо ямар байгууллагатай дүйцэхүйц ил тод ажилладаг юм бэ. Тэр дээр мониторинг хийсэн зүйл байна уу. Судалгаа хийсэн зүйл байна уу. Тэгээд та дарга болсноороо ард түмнээ хялбар аргаар гээд та түрүүн хэлсэн шүү дээ. Өндөр хүүгээр хүүлдэг энэ асуудлыг хэдий хугацаанд ямар дорвитой, үр дүн өгөхүйц ажил нийгэмд мэдрэгдэхүйц үйл ажиллагаа хийгдэх юм бэ. Тэрийгээ энэ ард түмний өмнө бас тодорхой хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвдаваа гишүүний асуултад би хариулчихъя даа. Нэр дэвшүүлсэн хүний хувьд. Жамбаажамц нэр дэвшигчийн талаар ер нь яагаад нэр дэвшүүлсэн шалтгаан бол энэ салбартаа олон жил ажиллаж, туршлагажсан албан хаагч учраас нэр дэвшүүлсэн. Өөрөөс нь миний хувьд уулзаж санал бол сонсоогүй.

Энэ салбар өөрөө шинэ тутамд хөгжиж байгаа салбар учраас эхнээсээ энэ хууль, эрх зүйн орчныг нь улам бүүр чамбайруулж, сайжруулах шаардлага байгаа учраас гаднаас шинэ хүн томилж, салбартайгаа танилцаж, туршлагажих хугацаа алдахгүйгээр эрх зүйн орчны томоохон өөрчлөлт шинэчлэлтийг хийх зорилгоор энэ хүнийг нэр дэвшүүлсэн байгаа. Тэгээд өнөөдөр Улсын Их Хурлаар томилогдчихвол бас Улсын Их Хурлын даргын хувьд хүлээж авч уулзаж, үндсэн чиглэл өгнө гэж бодож байгаа. Чиглэл бол яг гишүүдийн хүсээд байгаа 1 асуудал байна.

Энэ Банк бус санхүүгийн байгууллага болон мөнгө зээлдэг энэ салбар өөрөө эрх зүйн зохицуулалт маш сул байгаад байна. Арилжааны банкнаас илүү хөнгөхөн нөхцөлөөр иргэдэд зээл олгодог байдал нь өндөр хүүгээр мөнгө хүүлэх боломжийг бий болгоод байдаг сул тал байна гэж ингэж харж байгаа юм. Тэгэхээр бид бол энэ арилжааны банкнаас мэдээж тодорхой хэмжээнд хөнгөлөлттэй байх ёстой байх. Гэхдээ хэт хөнгөлөлттэй байгаа нөхцөл нь өөрөө банкнаас зээл авч банк бус

санхүүгийн байгууллагуудаар мөнгө угаах хэлбэрүүдийг үүсгэх нөхцөлүүд бүрдэж байна гэдэг нэг дэх асуудал явж байна.

2 дугаарт энэ Санхүүгийн зохицуулах хорооны хариуцдаг нэг чухал зүйл даатгалын тогтолцоо. Монголын даатгалын тогтолцоог шинэ түвшинд гаргахгүй бол даатгалын байгууллагуудаар төрийн зарим чиг үүрэг, хяналтын чиг үүргүүдийг гүйцэтгүүлдэг болгохгүй бол төр өнөөдөр иргэн, аж ахуйн нэгжээ хянадаг энэ байдал бас болохгүй байна гэдэг олон нийтийн шүүмжлэл дагуулсаар байгаа юм. Тэгэхээр энэ даатгалын салбарын хөгжлийг бодитой болгох чиглэл дээр бас энэ эрх зүйн орчны томоохон шинэчлэлүүдийг хийх шаардлагатай. Тэгээд энэ нь яг салбартаа 15, 16 жил ажилласан туршлагатай юм байна лээ. Үндсэн мэргэжил нь хуульч юм байна лээ. Тэгэхээр энэ салбар дээр энэ эрх зүйн орчны томоохон өөрчлөлт шинэчлэлтийг хийхэд хийхэд анхаарна гэсэн ийм зорилгоор энэ хүнийг нэр дэвшүүлсэн байгаа гэдгийг бас Пүрэвдаваа гишүүнд хариулж хэлье. Тодруулж асууя. Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Ингээд байгаа юм л даа. Энэ сонгууль чинь саяхан болоод өнгөрлөө шүү дээ. 6 сарын өмнө. Орон нутгийн сонгууль ч боллоо. Тэр үеэр бие биеийгээ харлуулах, бохир Пи Ар хийхдээ дандаа яаж ийж байгаад л нэг санхүүгийн банк бустай, энэ нь ингээд нэг улс төрчийн хамаарал бүхий этгээд байдаг гээд л ингээд л хэвлэлээр гардаг шүү дээ. Тэгээд энэ үндсэн үүрэг нь бол эрх зүйн орчныг сайжруулах асуудал, хяналт шалгалт хийх гэж ойлгож байгаа. Тэгээд яг энэ ажлын албаны даргаар ажиллаж байсан хүн маань бол 2 өгүүлбэрт багтаагаад, яг энэ үе дээрээ өөрөө хариулах нь зүйтэй байх гэж л бодож байна. Энэ бас нийтэд ингээд зөв, үнэн бодит мэдээллийг өгөх нь зүйтэй шүү дээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч хариулт өгье.

Т.Жамбаажамц: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг бол тодорхой салбарын зохицуулалтуудаар хэрэгждэг. Тэгээд та бол яг ямар өөрчлөлтүүд гаргах вэ гэж асууж байна.

Ерөнхийдөө хөрөнгийн зах зээл, даатгалын салбар бол санхүүгийн зах зээлийн тулганы 3 чулуу байж байгаа. Тэгэхээр энэ тулганы 3 чулууны 2 даатгалын салбар хөрөнгийн зах зээл дээр бол томоохон эрх зүйн шинэчлэл, өөрчлөлт гаргана. Энэ хүрээнд бол тэр ил тод, нээлттэй цахим даатгал, цахим хөрөнгийн арилжаа, ялангуяа энэ үндэсний томоохон аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн болгох, ингэснээрээ эх үүсвэрийн зардал буурдаг, өргөжилт үүсдэг энэ зах зээлийг бол бий болгоно. Тэгээд ялангуяа олон нийт энэ зах зээл рүү орж хөрөнгө оруулалт хийдэг, хөрөнгө оруулалт татдаг. Ялангуяа жижиг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Жамбаажамцдаа хандаж хэдэн үг хэлэх гэсэн юм. Манай Жамбаажамц нэр дэвшигчид залуу хүн байгаа. Тэгээд үр дүнд хүрэх нь чухал байгаа. Хуучин ах нар шигээ хуучин дүрэм журмынх нь хүрээнд ажиллаад энэ хүрчихлээ гээд хэсэг хугацааны дараа сууж байж болохгүй.

Тэгээд Санхүүгийн зохицуулах хорооны өнгөрсөн 2024 оны төсөв бол 14 тэрбум төгрөг байсан. 2025 оны төсөв 21 тэрбум төгрөг төсөвлөгдөж байгаа. Тэгээд ямар нэгэн асуудал ажлыг хийхэд төсөв мөнгө байхгүй байсан гэдэг ийм зовлон

үүсэхээргүй байгаа. Зориг дутаж болохгүй гэдгийг л маш сайн хэлэх гээд байна. Яг өнөөдрийн байдал энэ нийгэмд гараад харахад бол Даашинхүүгийн пүүсийн мөнгө угаалтын 2 дугаар анги бол яг сонгодог утгаараа хэрэгжиж байгаа. Аппликэйшний зээлгүй хүн олдохгүй. Бүгд нэг ийм өрийн гинжин хэлхээнд аваад л нэг зээлээ дардаг, аваад л нэг зээлээ дардаг энэ системд орчихсон. Энийг бас нэг тодорхой хэмжээнд хязгаарлаж, цэгцлэх ажил таныг хүлээж байгаа.

Цахим мөрийтэй тоглоом, аппликэйшний зээлтэй холбоотой зөвхөн мөнгөн дүнг нь сонсоход бол 6 орчим их наяд төгрөгийн асуудал явж байгаа. Энийг бас тодорхой мэдээллийг нь тодорхой болгоод, ард иргэддээ бас нэг ил тод мэдээлэл өгөөрэй гэж ийм хүсэлт байгаа. Тэгээд бүх мэдээллүүдээ ил тод болгоод явъя гэхээр өмнөх дарга нарын чинь яг өмнөх дарга нарын чинь энэ ББСБ-тай холбоотой асуудлууд бас гарч ирэх байх. Мэдээллүүдийг нь ил болгоод, нийтэд бас мэдээлээд яваадхаарай. Зориг битгий дутаарай гэж.

Тэгээд энэ Санхүүгийн зохицуулах хороонд ажиллаж байгаа дотоод боловсон хүчнийх нь асуудлуудыг бас шилэн, ил тод болгоод ажиллаарай. Тэгэхгүй бол тэр дотор чинь ер нь удам дамжсан хунтайж нар, тэгээд энэ улс төрд нөлөө бүхий хүмүүсийн ах дүү, амраг садан хүмүүс бас нэлээн гарч ирнэ. Энэ хүний нөөцийнхөө бодлогыг та ил тод, шилэн болгож байгаад нээлттэй ажиллаадхаарай гэж бас хүсэж байгаа юм.

Тэгээд өмнө нь сонсгол дээр та өөрөө бас хэлсэн. Амарбаясгалан даргатай уулзаж үзээгүй. Намайг шаардлага хангасан учраас нэр дэвшүүлсэн байх гээд. Сая Амарбаясгалан дарга бас хэлж байна. Хэрвээ томилогдох юм бол би уулзаж эрх зүйн шинэчлэлийн асуудлуудыг ярина гээд. Тэгэхээр миний хэлээд байгаа үгтэй яг ингээд энэ их тохирч ирээд байгаа юм. Байгаа дүрэм журмынх нь хүрээнд ажиллаад гээд нэг ийм цаг хугацааны дараа ороод ирэв. Банк бус санхүүгийн байгууллагууд, аппликэйшний зээлүүд, цахим мөрийтэй тоглоомууд, даатгалын даатгуулагчдын эрх ашгууд гээд ингээд зөрчигдөж байгаа эрх ашиг маш их байгаа.

Даатгуулагчдын эрх ашиг зөрчигдөж байгаа хамгийн сүүлийн нэг жишээ нь бол нэг жилийн өмнө газ ачиж явсан машин дэлбэрчихсэн. Өмнө нь байсан орон сууц шатчихсан. Одоо болтол 1 ч даатгуулагч даатгалаас нөхөн төлбөрөө аваагүй. Хэн нэгнийг гэм буруутайг хүлээгээд сууж байгаа юм. Даатгалын байгууллага тэрнээс үл хамаараад даатгалынхаа нөхөн төлбөрийг олгоод байж байх ёстой газар одоо болтол ингээд ажлаа хийхгүй сууж байгаа энэ мэт асуудлуудыг бас нэг цэгцлээрэй гэж хэлэх гээд байгаа юм.

Тэгээд тэр нөгөө Хөрөнгийн бирж дээр байгаа хувьцаат компаниудынхаа листийг шинэчлэх, цэгцэд нь оруулах, хөрөнгийн бирж дээр маш олон ажлууд бас таныг хүлээж байгаа. Үүний тод жишээ нь Төрийн банк байгаа. Төр өөрөө банктай байх, тэгээд тэр Төрийн банкны өр авлын асуудал цэгцлэгдээгүй байгаа. Тэгээд энийг Төрийн банк учраас та цэгцлэх ёстой байх. ХК учраас бас тэр талаас нь харж ажиллаарай гэж байгаа юм.

Тэгээд ер нь өнөөдөр ингээд харахад бол энэ санхүүгийн салбар чинь бараг нэг хүнээс хамааралтай болчихоод байгаа юм. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Аадгаламжийн даатгалын корпорац , Хөрөнгийн бирж өөр юу байдаг юм. Тэгэхээр энийг задлаад аль болох ийм олон хүний хамааралтай нийтэд ил тод байлгах талаас нь бас нэг ажиллаарай. Та яг түүний эхлэл болгоод 126 гишүүнтэй

парламентаас томилогдох гэж байгаа анхны Санхүүгийн зохицуулах хорооны дарга шүү гэдгээ бас их анхаарч ажиллаарай.

Тэгээд эцэст нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Да.Цогтбаатар: Их Хуралд та бас ажлаа дүрэм журмынх нь хүрээнд байдаггүй ч гэсэндээ Их Хуралд эсвэл олон нийтэд нээлттэй, хийсэн ажлаа сар тутамдаа мэдээлээд яваад байгаарай гэж ийм эцсийн танд хандаж үг хэлэх гэсэн юм.

Тэгээд эцэст нь Их хурлын даргад хандаж нэг үг хэлэх гэсэн юм. Өмнөх Санхүүгийн зохицуулах хорооны дарга Их Хурлаас томилогдоод тодорхой ажлуудыг хийгээд, хугацаа нь дуусаад, ажлаа өгөөд явж байгаа. Тэгээд хугацаа нь дуусаад явсан хүмүүсийг дахиад өөр газар томилно гэж битгий оруулж ирээсэй. Та тэр тал дээр бас нэг анхаарч ажиллаарай гэж хүсэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн үг хэлье, асуулт асууя.

О.Номинчимэг: Баярлалаа. Нэр дэвшигч Жамбаажамцыг бол дэмжиж байна. Бас хуульч хүн. Гэхдээ яг хууль зүй, эрх зүйн эдийн засгийн дүн шинжилгээ гэдэг сэдвээр бас өөрөө судалдаг, багшилдаг, хууль зүйн зохицуулалтууд, дүрэм журмууд чинь эдийн засгийн ямар үр дагавар гаргадаг юм бэ гэдгийг бас анхаарч ажилладаг хүн гэдгийг нь мэднэ. Тэгэхээр энэ чиглэл рүүгээ бас Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэгт байгаа зах зээлийг бас тэлэх, сайжруулах, гажуудыг нь засах чиглэл рүү бас маш санаачилгатай, зөв эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар идэвхтэй ажиллаасай гэж хүсэж байгаа.

Тэгээд яах вэ, гишүүдийн хэлж байгаа зарим юмтай давхцаж байна. Гэхдээ би 2 юман дээр бас маш сайн анхаарч ажиллаасай гэж бодож байна.

1 дүгээрт бол энэ аппликэйшний зээл гэдэг юм бол ерөөсөө бидний хувьд, иргэдийн хувьд маш том боловсон мөнгө хүүлэлтийн арга руу шилжчихсэн. Тэгээд аппликэйшний зээлгүй хүн байхгүй. Сард 4-5 хувийн хүү төлнө. Хүүгээ төлж чадахгүй болохоороо дараагийн аппликэйшн руу орно. Ямар нэгэн зөв зохистой зохицуулалт байхгүй болохоор иргэд маань ингээд өрөөс өр лүү болдог. Нөгөө талдаа мөнгө хүүлэлтийн боловсон систем ингээд гаараад явж байна. Тэгэхээр энийг цэгцлэх тал дээр бас анхаараач ээ. Тэгээд яах вэ, үүний нөгөө гол гогцоо хуульч хүний хувьд харж байгаа 2 юм байгаа гэж үзэж байгаа юм. Бид нар бас Иргэний хууль дээрээ дүн шинжилгээ хийгээд явж байгаа. Нэгд нь бол бид цахим гэрээний асуудлыг бол Иргэний хууль дээрээ яг зарчмыг хуульчилж өгөөгүй бол энэ шинэ тутам тулгамдаж байгаа асуудал болж байгаа юм. Тэгээд цахим гэрээний нөгөө тал гэхээрээ энэ яалт ч үгүй хэрэглэгчийн эрх ашиг хөндөгддөг. Бид цахимаар гэрээ хийхдээ ялангуяа хэрэглэгч болон санхүүгийн эрхлэгчийн хувьд ямар хамгаалалтуудыг хийх ёстой юм бэ гэдэг юмыг бид нар Иргэний хуулийн энэ хэрэгжилтийн ажлын хэсгийн хүрээнд бас хийнэ. Энэ дээр Санхүүгийн зохицуулах хороо бас идэвхтэй ажиллаж, энэ талын хууль, эрх зүйн шинэчлэлийг хамтдаа хийгээд яваасай гэж харж байгаа.

2 дугаарт энэ иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал эргээд банк болон ББСБ-ын зээлийн хүүд нөлөөлдөг. Өр төлбөрөө авч чадахгүй болохоор энэ эрсдэлээ тооцоод, өндөр зээлтэй, зээлийн хүүтэй байдаг. Тэгээд бид нар дүн шинжилгээ хийгээд үзэхээр энэ иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн системийн гажуудлын засаад энэ ажилладаг систем болчих юм бол зээлийн хүү маань 2 хувь автоматаар буурах боломжтой. Эрсдэлийн сангаа банкнууд буулгах боломжтой гэсэн дүн гарсан. Энэ маань ч гэсэн дахиад ББСБ-ын зээлийн харилцаанд нөлөөлнө. Тэгэхээр энэ дээр бас идэвхтэй Санхүүгийн зохицуулах хорооны хувьд энэ салбарыг бас хариуцах хүний хувьд бас маш санал санаачилгатай ажиллаасай гэж бас хүсэж байна. Бас даалгаж байна. Улсын Их Хурлын гишүүн, ард түмний төлөөллийн хувьд.

2 дугаар асуудал бол энэ цахим бооцоот тоглоомын асуудал байгаа. Спортын бооцоо гээд One ехрест гээд нэг ийм компани ороод ирчихсэн. Энэ компани бол Кипр улсад бүртгэлтэй ер нь Орост байсан компани байгаа шүү дээ. Англи улсад энэ өөрөө хууль бус сурталчилгаа явуулдаг. Порнографыг дэмждэг гээд ингээд бүр хориглолтод орчихсон компани. Нидерланд улсад дампуурлаа зарлачихсан компани. Тэгээд манай Монгол Улсаас хамгийн их ашгаа олдог юм шиг байна лээ. Хүмүүс нь ирээд ийм эдийн засагтай улсаас бид нар жилдээ тэдэн тэрбумын ийм доллар ашиг олж байгаадаа өөрсдөө бүр гайхсан гэсэн. Тэгээд энэ ямар ч зохицуулалтгүй явсаар ирж байгаа. Тэгээд энэ цахим тоглоомыг зохиодог энэ компани маань өөрөө монголын залуучуудын ирээдүйгээр өөрөө тоглож дуусаж байгаа. Бид нар харсаар байж энэ дээр ямар нэгэн зохицуулалт хийхгүй, алдаад дуусаж байна. Тэгээд энэ дээр бас Хууль зүйн сайдтай хамтраад Хууль зүйн сайдын хувьд бас эрхлэх асуудал нь байгаа байх. Мөн санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах гэдэг утгаараа Санхүүгийн зохицуулах хороо энэ дээр бас идэвхтэй, хурдан шуурхай ажиллаж, энэ хууль тогтоомжийн зохицуулалтын асуудлыг хурдан Улсын Их Хуралд оруулж ирээсэй гэж ингэж захимаар байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Саранчулуун: Монгол Улсад ТББ-ын тоог үзэхээр бараг ингээд 20 мянга гаруй гээд тоотой. Тоо нь ярихаар тэгж харагддаг. Яг улсын бүртгэлд тайлангаа өгдгийг нь тоолоод үзэхээр тэр тооноосоо бараг 5, 6 дахин цөөхөн ийм болчихоод байгаа. Тэгээд төрийн бус байгууллагуудад тулгамддаг ямар асуудлууд байна вэ гээд судалгаа хийгээд үзсэн. 2019 оны судалгаагаар үзэхэд ТББ бол ашгийн бус, нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулдаг ТББ. Тэгэхээр тулгамддаг тэр ажлаа хийхэд нь хандив босгох асуудал байгаад байгаа. Тэгэхээр хандивыг яг зөв босгоод, зөв зохион байгуулах энэ эрх зүйн орчин манайд их сул байгаад байгаа. Тэгэхээр олон улсад болохоор энэ санхүүгийн байгууллагууд нь хандивын харилцаанд зохицуулагч үүрэгтэй оролцдог. Тэгээд жишээлэх юм бол Америк ч юм уу, барууны орнуудад бол иргэн, аж ахуйн нэгж өөрөө сайн дураараа жил болгон өөрийнхөө орлогын тодорхой хувийг хандив өгдөг ийм жишиг байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ер нь Санхүүгийн зохицуулах хороо мэдээж өнгөрсөн 4 жилийг харахад бол маш өсөлттэй ийм хурдтай явж байгаа үр дүнтэй байгууллага юм байна гэж харсан тайлангаас нь. Тэгэхээр энэ хурдаараа яваад энэ олон асуудлыг зохицуулангаа энэ хандивын харилцааг хэрхэн сайн зохицуулах юм бэ. Энэ хурдаараа явж байгаад зохион байгуулчихвал нөгөө жинхэнэ ЖДҮ гэдэг шиг жинхэнэ ТББ нь ялгараад ирнэ. ТББ-ын чадавх бий болно. Тэгээд хандивын харилцаанд зохицуулагчийн үүрэгтэй оролцож байгаа ямар олон улсын хувилбар

байгаа вэ гэхээр ядаж л нөгөө краудфаундинг тогтолцоонууд байгаа шүү дээ. Би жишээлбэл банканд жишээлбэл хүн хадгаламждаа мөнгө хийхдээ ч юм уу, банкны карт үүсгэхдээ тодорхой хувь нь хандив өгч болж байна. Аж ахуйн нэгж өөрөө ажилтнахаа өмнөөс хандив өгч болж байна. Жишээлэх юм бол миний ажилладаг байсан хуучин ТББ-д бол Америкт яаж хандив өгдөг вэ гэхээр тодорхой хэмжээний сайн дурын ажлыг хийгээд, тэрэндээ дүйцэхүйц цалингаа хандив хэлбэрээр олгодог. Тодорхой байгууллага сонгодог. Тэр байгууллагууд нь тухайн байгууллагын нийгмийн хариуцлагын цэсээс сонгож байгаад хандив өгдөг ийм сайхан тогтолцоонууд байгаад байгаа. Энэ нь өөрөө иргэдийн нийгмийн сайн сайхан байдалд оролцох оролцоог дэмжиж өгсөн ийм зөв тогтолцоо байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ер нь та ямар бодолтой байдаг вэ. Ер нь цаашдаа түрүүн бас дурдсан. Тэгэхдээ би илүү дэлгэрэнгүй тайлбарыг хүсэж байгаа. Яагаад гэхээр энэ Санхүүгийн зохицуулах хороноос хэрвээ амжилттай зохион байгуулчих юм бол маш олон ТББ-ын жинхэнэ үйл ажиллагаа ялгарч гарч ирнэ. Нийгэмд. Энэ нь нөгөө жинхэнэ үйл ажиллагаа нь. Дээрээс нь чадавх бий болно. Нийгэмд маш олон иргэдийн хариуцлага бас нэмэгдэх байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ямар бодолтой байна вэ. Ямар төлөвлөгөө байгаа вэ гэдэг дээр та мэдээлэл өгөөч.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Жамбаажамц хариулт өгье.

Т.Жамбаажамц: Саранчулуун гишүүний асуултад 2 чиглэлээр хариулъя. Тодорхой асуулт асуулаа.

1 дүгээрт нь энэ олон улсад бол краудфандингийн зохицуулалт байдаг. Үүний гол бас нэг хэрэгждэг хэлбэр нь бол энэ хандивт суурилсан буюу сайн үйлсэд зориулсан краудфандингийн платформууд байгаа. Тэгэхээр манайд бол яг ийм албан ёсны бүртгэлтэй ийм краудфандингийн платформууд 1 дүгээрт алга. 2 дугаарт хууль, эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа. Энийг бол та маш сайн мэдэж байгаа. Тэгэхээр энэ краудфандингийн зохицуулалтыг бол ер нь Их Хурлаас бий болгох ёстой юм болов уу гэж би бодож байгаа. Тэгээд энэ чиглэлээр бас Санхүүгийн зохицуулах хороо дээр боловсруулчихсан хуулийн төсөл байгаа. Өөрөөр хэлбэл түрүүний ярьсан энэ хандивт суурилсан, хувьцаанд суурилсан, зээлд суурилсан, урамшуулалд суурилсан гэсэн ийм 4 төрлийн краудфандингийн төрлийг зохицуулсан анхдагч хуулийн төслийг бол манайхаас боловсруулчихсан байгаа. Тэр дээр энэ хууль, эрх зүйн зохицуулалт нь бий болох юм бол ялангуяа энэ хандив тусламж, ялангуяа төрийн бус байгууллагууд тэгээд өөр олон төрлийн хандивууд энэ нийгмийн орчинд үүсдэг. Энийг бол нэгдсэн платформоор бүртгээд явах юм бол энэ нь ямар нэгэн байдлаар луйвар, залилан үүсгэхгүйгээр яг очих ёстой тэр хүндрэлтэй хүмүүст очдог ийм нэгдсэн платформуудыг тодорхой хуулийн этгээдүүд үүсгээд явдаг нэг ийм хэлбэр бол байгаад байгаа юм.

2-т нь манай бас зохицуулалтын нэг салбар дээр хадгаламж зээлийн хоршооны салбар байдаг. Тэгээд хадгаламж, зээлийн хоршоо бол өөрөө манай энэ зохицуулалтын салбаруудаас нэг онцлог нь ашгийн төлөө биш хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Тэгээд анх бол хадгаламж зээлийн хоршоо нөгөө маш олон дампуурлууд үүсээд, өөр хэлбэрээр үүсээд нийгэмд маш ийм сөрөг юутай болчихсон болохоос биш, яг нөгөө гишүүддээ үйлчилдэг, гишүүддээ санхүүгийн тусламж үйлчилгээг нь үзүүлдэг, хадгаламж зөвхөн гишүүдээсээ тодорхой хэмжээний тусламж дэмжлэг, хураамж, гишүүнчлэлийн хураамж болон бусад илүүдэл санхүүгийн эх үүсвэрүүдийг нь цуглуулаад, энэ цуглуулсан эх үүсвэрээ гишүүддээ өөрөөр хэлбэл яг ТББ шиг гишүүддээ санхүүгийн хүрэлцээтэй

хүндрэлтэй байдалд нь дэмжлэг үзүүлдэг зохицуулалтын ийм салбар байдаг. Энэ дээр бол нийтдээ 185 орчим хадгаламж зээлийн хоршоо Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа. Үүний 50 орчим хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр орон нутгийн ялангуяа иргэдэд тэр санхүүгийн үйлчилгээ хүртээмж хол байдаг ийм хэрэглэгч нарт бол санхүүгийн энэ хоршоо хамтарч яадаг энэ хадгаламж зээлийн хоршоо энэ хоршооны үйл ажиллагаа бол илүү санхүүгийн дэмжлэг туслалцаа, энэ бол 1 төрлийн санхүүгийн тусламж дэмжлэг болно шүү дээ. Гишүүд нь тодорхой хэмжээгээр санхүүгийн дэмжлэг туслалцаа шаардлагатай бол түүнд нь санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг энэ хоршооны хэлбэрийг бол яг энэ хэлбэр лүү нь илүү сайжруулах чиглэлээр хадгаламж зээлийн хоршооны тэр институтийг илүү санхүүгийн зөвхөн хадгаламж зээлийн хоршоо биш бусад тэр санхүүгийн шаардлагатай бүтээгдэхүүн үйлчилгээг нь үзүүлдэг, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг энэ хэлбэр лүү нь бол Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг АХБ-тай бас хамтраад боловсруулчихсан байгаа юм. Тэгэхээр тэр хуулийг илүү тодорхой болгоод Улсын Их Хуралдаа өргөн барина гэж бол бодож байгаа. Тэр дээр бас Саранчулуун гишүүнтэй бас хамтарч ажиллахыг хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өглөө. Энхтайвангийн Бат-Амгалан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Э.Бат-Амгалан: Санхүүгийн зохицуулах хорооны даргад нэр дэвшигч Жамбаажамцын материалтай намтартай танилцлаа.

Ер нь харьцангуй бас залуу хүн байна. Мөн энэ салбартаа 20-иод жил ажиллачихсан юм байна. 2006 оноос хойш тогтвор суурьшилтай. Ер нь бол дэмжиж байгаа. Бас мэдээж энэ салбартаа олон жил ажилласан, туршлага хуримтлуулсан, гэхдээ харьцангуй залуу хүний хувьд эрчтэй хүчтэй, хурдан шуурхай ажиллах ёстой гэж ингэж бодож байна.

Миний сонссоноор 2020-2024 оны хооронд Санхүүгийн зохицуулах хорооны хариуцдаг, энэ хариуцаж байгаа зах зээл 4,5 дахин тэлсэн ийм үзүүлэлттэй гарсан. Тэгэхээр энийгээ бас хадгалаад, цаашдаа эрч хүчтэй ажиллах ийм л шаардлагатай байгаа юм.

2 гол тодорхой асуулт байна. 1 дүгээрт хөрөнгийн зах зээлийг ер нь юу гэж харж байгаа вэ. Энэ хөрөнгийн зах зээл бол зүгээр миний харж байгаагаар өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улсад хөрөнгийн зах зээл бол үнэхээр чамлалттай, удаан, урагшгүй гэж хэлдэг юм уу ажилласан. Ерөөсөө бид нар улс орноороо, ард иргэдээрээ, аж ахуйн нэгж компаниудаараа бүгдээрээ энэ банкны салбарын ерөөсөө хараанд орсон байгаа. Иргэд хөрөнгийн зах зээл дээр гарч, тэндээс итгэл үнэмшил авч, хөрөнгө санхүү, эдийн засгийн боломж бололцоогоо нэмэгдүүлэх энэ чиглэл дээр яг ямар тодорхой ажлууд хийх вэ. Ерөөсөө иргэд гар дээр байгаа бэлэн мөнгөө зөвхөн банканд хадгалуулдаг. Банк нь хадгаламж аваад эргээд аж ахуйн нэгжүүдэд нь хадгаламжаасаа давсан зээл өгдөг. Энэ л ерөөсөө Монголын эмгэнэл болчихоод байгаа юм шүү дээ. Хөгжлийн гол саад бол ердөө л энэ байгаа юм. Тэгэхээр иргэдийн карманд мөнгөтэй байх, итгэл үнэмшилтэй байх, ирээдүйдээ тэр хөрөнгийн зах зээл дээр томоохон компаниудад итгэл үзүүлэх энэ чиглэл дээр та ер нь бас туршлагатай хүн. Тэгээд харьцангуй залуу хүн. Тэгээд сая харьцангуй бас энэ хөрөнгийн энэ танай Санхүүгийн зохицуулах хорооны хариуцаж байгаа энэ зах зээл 4,5 дахин өсчихсөн энэ үед яг ямар төлөвлөлтүүд хийж байгаа вэ гэж. Энэ

чиглэл дээр ажиллаж байж бас өнөөдрийн энэ нөхцөл байдлаас энэ банкны системийн өндөр хүү, зээл энэ асуудлаас бол гарах ёстой гэж ингэж ойлгож байгаа.

2 дугаар гол асуудал бас даатгалын энэ компаниуд байгаа. Үнэндээ бол даатгалын компаниуд иргэдийн даатгуулагч нарт эргэн нөхөн төлөгдөх энэ боломж процесс их удаашралтай явагддаг. Энэ агуу зүйл энгийн зүйлээс эхэлдэг гэж нэг үг байдаг. Тийм учраас жишээ хэлье. Өнөөдөр Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөлт Улсын Их Хурлаар яг энэ цаг дор орж байна. Улаанбаатар хотын иргэдийн эхний байранд яригдаж байгаа нэг асуудал бол түгжрэлийн асуудал шүү дээ. Зам дээр 2 машин мөргөлдөөд 30-40 минут цагдаа, даатгалын компани иртэл хүлээдэг. Энэ асуудлыг цахим үндэстэн, цахим монгол болно гэсэнтэй холбож хийх. Харахад нэг энгийн ажил юм шиг яригдаж байгаа юм. Үндсэндээ тэнд хүний амь нас эрсдээгүй, хөнгөн зэргийн зам тээврийн осол гарсан үед энэ аппликэйшн онлайнгаар энэ даатгалын компани, цагдаа, тэр тээврийнх нь хоорондоо ойлголцоод, тэгээд тэр дээрээ тэр бүх хүмүүс судалгаа гарсан байна лээ шүү дээ. Монгол Улсын бараг нийт иргэд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхтайвангийн Бат-Амгалан гишүүнд нэмэлт нэг минут өгье.

Э.Бат-Амгалан: Монгол Улсын нийт насанд хүрсэн иргэдийн бараг 90 гаруй хувь нь ухаалаг гар утастай байгаа. Тийм учраас хоорондоо энэ гар утсаараа, тэр аппликэйшнаараа, тэр даатгалын компанитай янз бүрийн программуудын хөгжүүлэлт үүсчихсэн байна шүү дээ гэх жишээний. Энэ зүгээр даатгалын компанитай ярьж байгаа ганцхан жишээ. Ингээд шүргэлцсэн, мөргөлдсөн тэр хүмүүс томоохон хэмжээний хүн амины ноцтой гэмт хэрэг гараагүй тохиолдолд энэ асуудлыг ингээд шийдчих ийм боломж бололцоотой харагдаж байгаа юм гэх мэтчилний. Ний нуугүй хэлэхэд даатгалын компаниуд бол одоо бараг хөрөнгө оруулалтын сан байгуулаад, хөрөнгө оруулалтын компаниуд маягийн болоод ажиллаж байгаа. Тэгээд энэ чиглэл дээр та бас олон жил энэ салбартаа ажиллачихсан туршлагатай, тэгээд харьцангуй залуу хүний хувьд, тэгээд дээрээс нь энэ боломж бололцоотой 4,5 дахин өссөн үед яг ямар ямар төлөвлөлтүүд бодож байгаа вэ гэдэг 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн. Тодруулж, нэмэлт хариулт өгье. Нэр дэвшигч Жамбаажамц.

Т.Жамбаажамц: Бат-Амгалан гишүүний асуултад хариулъя. 2 тодорхой асуулт асуулаа. Даатгалын яг тодорхой жишээн дээр хэлэхэд даатгалын компани зам тээврийн осол болоход даатгалын компаниудыг дууддаг, асар их юу үүсдэг гэдгийг та хэлж байна. Яг ийм асуудлууд бол болдог байсан. Тэрийг бол Санхүүгийн зохицуулах хорооноос тодорхой шаардлагууд өгөөд, хүний амь бие, эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулаагүй тохиолдолд тодорхой тэр осол аваарынхаа зургийг баталгаажуулаад, даатгалын компанид өгөөд ингээд явдаг чиглэл рүү бол ороод чиглүүлж ажиллаж байгаа. Би танд маш тодорхой хэлэхэд цаашид ийм асуудлууд зам дээр үүсгэдэггүй байхад би онцгой анхаарна. Энийг бол засна 1 дүгээрт.

2 дугаарт ерөнхийдөө даатгалын салбар дээр товчхон хэлэхэд Даатгалын тухай хууль 2004 онд батлагдсан. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль 2004 онд батлагдсан. Өөрөөр хэлбэл Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдахаас өмнө энэ 2 салбарын суурь хуулиуд нь батлагдчихсан. 2011 онд

Жолоочийн даатгалын хууль батлагдаад, 14 жил болж байгаа. Тэгэхээр энэ хуулиуд дээр бол яалт ч үгүй даатгуулагч нарт түргэн шуурхай олгодог, цахим даатгалыг дэмждэг, даатгалын хохирлын үнэлгээг түргэн шуурхай гаргадаг, даатгуулагчийн эрх ашигт нийцсэн ийм хэлбэрийн өөрчлөлт зохицуулалтуудыг бол зайлшгүй оруулах шаардлагатай. Тэрийг бол Сангийн яам, Засгийн газартай бол хамтарч ажиллаад, хуулийн төслөө бол боловсруулчихсан. Ойрын үед Улсын Их Хуралд өргөн барих ажлыг бол Засгийн газартай хамтарч ажиллаад оруулж ирнэ. Энэ хүрээнд энэ асуудлыг бол маш шуурхай шийдээд явагдана. Тэр хүртэл бол ямар ч байсан зам дээр түрүүний ярьдаг ийм түгжрэл үүсэхгүй байхад бол анхаарч ажиллана.

2 дугаарт нь хөрөнгийн зах зээл бол үнэхээрийн улс орны хөгжилд чухал салбар. Улс орны хөгжил төрөөс бол хөрөнгийн зах зээлийг онцгой анхаарч ажиллах шаардлагатай ийм салбар гэж үздэг. Тэр ч утгаараа сүүлийн 4 жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас бол хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр бүр үе шаттай бодлого хэрэгжүүлсэн. Энэ бодлогын үр дүнгүүд бол таны хэлсэн тэр 4,5 хувийн өсөлт бол энэ бодлогын тодорхой үнэхээр чухал үр дүн болсон гэж би бол боддог. Ялангуяа Улсын Их Хурлаас банкны салбарын системийн шинэчлэл, банкны реформ, төрийн өмчийн компанийн хувьчлал олон нийтийн болгох процесс, нэмээд зах зээл дээр тодорхой татварын хөнгөлөлт, урамшууллын асуудлууд. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахад зориулсан нэлээн томоохон өөрчлөлтүүд бол оруулж өгсөн. Тэгээд энэ хүрээнд бол өөрчлөлтүүд 1 дүгээрт гарсан.

2 дугаарт нь сүүлийн 4 жилийн хугацаанд бол Санхүүгийн зохицуулах хорооноос энэ салбарын оролцогч, мэргэжлийн байгууллагууд, салбарын дэд бүтцийн байгууллагууд, ялангуяа салбарын мэргэжлийн холбоодтойгоо бол маш нягт хамтарч ажилласан. Үүний үр дүнд сүүлийн 20 жил хийгдээгүй үнэт цаасны арилжаа эрхлэх томоохон хэлбэр болох Өү Ти Си маркет гэж нэрлэдэг. Биржийн бус зах зээлийн арилжааг үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо буюу мэргэжлийн холбоодтойгоо хамтраад Санхүүгийн зохицуулах хороо 2021 оны 9 сард анхны санал цохиж, нээлтийг хийсэн. Тэгээд энэ бол Монгол Улсад төрийн байгууллага, зохицуулагч байгууллага, хувийн хэвшлийн холбоотой хамтарч ажилласан элээн том тийм амжилттай хэрэгжүүлсэн төслийн 1 гэж бол би боддог. Тэгээд энэ платформ эхлээд үндсэндээ 3 жил орчим ажиллах хугацаандаа 150 гаруй компанийн дандаа үндэсний компаниуд байгаа. 150 гаруй компанийн 3,7 их наяд төгрөгийн санхүүжилтийг тэнд тусгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл үндэсний 150 гаруй компани жилийн 16-18 хувийн хүүтэй, тэр дээр бондоо мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт Өү Ти Си маркетаар дамжуулж арилжаалдаг. Тэндээсээ санхүүжилт, өөрөөр хэлбэл банкнаас өөр санхүүжилтийн эх үүсвэрийг үндэсний компаниуд гаргадаг тэр боломжийг нь бол бүрдүүлж өгсөн. Тэгэхээр энэ ажлуудыг бол цааш нь маш шуурхай ингэж үргэлжлүүлж, илүү энэ өсөлтийг хангаж, цаашид улам сайжруулна гэж бодож байна. Баярлалаа танд.

Д.Амарбаясгалан: Энхтайвангийн Бат-Амгалан гишүүн дахин тодруулж асууя.

Э.Бат-Амгалан: Нэг зүйл дээр анхаарч ажиллаасай гэж ингэж бодож байгаа юм. Энэ хөрөнгийн зах зээл дээр байгаа, одоо яг Монголд явагдаж байгаа томоохон компаниуд ер нь зүгээр хувьцаагаа арилжаалж байгаа. Гэхдээ энэ хувийн асуудал хувь байна шүү дээ. Борлуулж байгаа энэ хувийн асуудал дээр нь та хэд маань бас

нэг анхаарал хандуулаарай. Ний нуугүй хэлэхэд бас нэг хэсэг бүлэг эрх ашиг нэгтэй хүмүүсийн сонирхлоор 80-90 хувь нь үлдчихдэг. Ердөө зүгээр Санхүүгийн зохицуулах хороонд гэдэг юм уу, хуульд заасны дагуу бас 5-10 хувийг нь борлуулаад, тэгээд нээлттэй компани болчихсон мэтээр ингээд яваад байдаг. Тэгэхэд чинь Европын орнуудад, барууны орнуудад 30-40 хувийг нь хүртэл борлуулдаг нээлттэй хувьцаагаа ард иргэддээ борлуулдаг энэ чиглэл байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр бас цаашдаа та Улсын Их Хурлын олон гишүүд дэмжиж байгаа юм байна. Даргаар сонгогдвол энэ чиглэл дээр бас анхаарч ажиллаасай гэж.

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өдрийн амгаланг эрье. Тэгэхээр энэ Санхүүгийн зохицуулах хороо гэдэг бол төсвөөс бусад бүх санхүүгийн салбарын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй, маш хариуцлагатай ийм алба. Энэ албаны дарга бол маш сайн бэлтгэчихсэн хүн байх ёстой. Ялангуяа шийдвэр гаргах түвшинд бэлтгэчихсэн хүн байх ёстой. Тэгж байж л энэ албыг авч явна. Тэрнээс биш залуу хүн гэдэг тийм гол шалгуур нь биш байх. Ямар спортын салбарт очих гэж байгаа биш. Чи төрийн салбарт очих гэж байна. Тэр талаасаа харах юм би чиний энэ анкетыг харахад тун боломжийн бэлтгэгдсэн байдал бол харагдаж байна. Нэлээн судалгаа шинжилгээнд л үндэслэж байж шийдвэр гаргадаг ийм л байх санхүүгийн салбар бол. Өнөөдрийн залуусыг хараад байхад судалгаа, шинжилгээ, мэдээлэл гэдэг юмыг ерөөсөө их тийм ойшоохгүй хандлага бол бий болчихсон харагдаад байгаа юм. Сая манай Их Хурал дээр гэхэд 2 том гэрээ ороод ирэхэд ТЭЗҮ-г нь нэхэхгүй байгаа байхгүй юу. ТЭЗҮ-ийг нь хараагүй байж байж сайн гэрээ гээд л зөвшөөрөөд явчхаж байгаа байхгүй юу. Тэгээд тэр шиг тийм хандлага ерөөсөө гаргаж болохгүй. Чи маш сайн тооцоо судалгаа дээр үндэслэж байж, хөгжлийн чиг хандлагыг нь үнэлж байж, ингэж шийдвэр гаргах хэмжээнд л бэлтгэгдсэн байх ёстой. Тэр талаасаа чи бусад энэ өөрийнхөө бас дутуу байж болзошгүй гэсэн салбаруудынхаа чиглэлээр өөрийгөө сайн бэлдэх хэрэгтэй. Би зүгээр чамайг бас энэ Хөрөнгийн зах зээлийн бодлогын газрын дарга хийж байсан хүний хувьд бас зүгээр сайшаагаад байгаа юм. Яагаад гэвэл өнөөдөр Монголд энэ зээлийн хүүг бууруулах чиглэлд бол хамгийн чухал юм бол шууд зээллэгийн систем. Хөрөнгийн биржийг хөгжүүлэх асуудал байхгүй юу. Тэгэхээр энэ чиглэлд ер нь чи ямар алхам хийх вэ гэж.

Нөгөө талаар энэ стратегийн ордуудын 10 хувийг Хөрөнгийн биржээр арилжих ёстой. Жишээлбэл Оюутолгой байна. Эд нарыг ингээд чи арилжаад эхлэх юм бол бас хөрөнгийн зах зээл хөдөлгөөнд орж, сэргэж магадгүй. Тэгэхээр энэ чиглэлээр чи жишээлбэл стратегийн ордуудын хувьцааг арилжаалах чиглэлд ямар бодолтой байна. Тэгээд энэ салбар дээр бол маш их луйвар явдаг. Олон гишүүн хэлээд байна шүү дээ. Манай Хөвсгөл гэхэд Бэлтэс Мөрөн гээд л иргэдийн мөнгийг луйвардаад л явчихсан. Тэгэхээр иргэдэд энийг сайн ойлгуулж байхгүй бол, мэргэжлийн байгууллага нь анхааруулж авахгүй бол болохгүй юм байна лээ. Мань мэт нь очоод хэлэхээр үгүй ээ, чи биднийг тэжээхгүй байхад энэ тэжээж байна гэж уурлаад, тэгээд хамаг мөнгөө өгчхөж байгаа юм. Тэгээд луйвардуулсныхаа дараа болохоор та нар хэлж байхад яасан юм гээд биднийг буцаагаад загнаад унаж байгаа байхгүй юу. Хэлж байхад тоохгүй байсан мөртөө. Тийм учраас энэ дээр нэг ажиглагдсан юм бол энэ мэргэжлийн салбарууд нь харин яг иймэрхүү үйл ажиллагаа явж байхад тухайн үед нь таслан зогсох арга хэмжээг авч байх ёстой юм байна гэдгийг бол бас ойлгосон. Тийм учраас та бүгд бас нэг иймэрхүү юм болох юм бол, санхүүгийн луйврууд явагдах юм бол энэ зах зээл дээр тэр даруй нь зогсоох, иргэдэд мэдээлэл

өгөх ийм арга хэмжээнүүдийг авч байхгүй бол иргэд чинь хөөрхий мэдээлэлгүйгээсээ болоод ингээд луйвардуулах юм бол их гарч байна.

Тэгээд эцэст нь тэр валютын зохицуулалтын хууль дээр бол Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа бол нэлээн дутмаг байдаг юм. Тэгээд сая орж ирсэн шинэчилсэн найруулга дээр би ажлын хэсгийг ахлаад нэлээн өөрчлөлтүүдийг хийсэн боловч сая буцчихсан юм байна. Тэгэхээр чи энэ Валютын зохицуулалтын хуулийг оруулах, тэр валютын зохицуулалтын хууль дээр Санхүүгийн зохицуулах хорооны бас энэ үйл ажиллагааг уялдуулах, энэ чиглэл дээр бас нэлээн анхаарч энэ хуулийн төслийг бас өргөн барьж оруулж ирэхэд бас нэлээн анхаараарай. Монголбанк танайх 2 оруулж ирэх ёстой. Тэгээд энэ хуулийг оруулж ирэх ийм шаардлага байгаа. Тэгээд би .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Нэр дэвшигч Жамбаажамц.

Т.Жамбаажамц: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд 2 чиглэл дээр бүр маш тодорхой ажиллана гэж төлөвлөж байгаа.

1 дүгээрт нь бол энэ хөрөнгийн зах зээл дээрх үндэсний томоохон компаниудыг олон нийтийн болгох. Энэ дээр бол анхаарна. Ялангуяа манай хөрөнгийн зах зээл дээр бол бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл хязгаарлагдмал байдаг. Хувьцаа, бонд гээд ийм цөөн төрлийн бүтээгдэхүүнүүд байгаа. Үүнийг бол илүү олон төрлийн бүтээгдэхүүнүүд болгох, ялангуяа тэр шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд гаргах энэ чиглэл дээр онцгой анхаарна. Өөрөөр хэлбэл тэр олон нийтэд гаргах компаниуд бололцоотой санхүүжилт татах энэ бололцоотой компаниудтай л үндсэндээ ажиллана гэсэн үг.

Энэ хүрээндээ бол нөгөө талд нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бэлтгэх чиглэл дээр бол анхаарна. Сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол улс дахь үнэт цаасны арилжаа бол нэлээдгүй өссөн. 4 дахин зах зээлийн үнэлгээ бол 4,5 дахин өссөн. ДНБ-ий 17 хувь орчимд бол хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ очсон гээд ийм маш сайн үзүүлэлтүүдтэй байгаа. Тэгэхээр энэ сайн үзүүлэлтүүдийг бол улам цааш нь тогтвортой хангахын тулд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо бол энэ дээр үнэхээрийн чухал байгаа. Тэгэхээр мэргэжлийн хөрөнгө оруулагч талд нь бол сүүлийн өнгөрсөн 2024 оны нийт хөрөнгийн зах зээл дээр арилжаанд оролцсон оролцогчдыг харахад бол 60 орчим хувь нь аж ахуйн нэгж буюу мэргэжлийн хөрөнгө оруулагч, байгууллагын хөрөнгө оруулагч болж нэмэгдсэн байж байгаа. Энэ бол бас их сайн тоо. Үүн дээр нэмээд энэ гадаадын хөрөнгө оруулагч нарыг оруулж ирэх. Гадаадын хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээлээр дамжиж оруулж ирэх чиглэл дээр бол бүтээгдэхүүний чанарт ингэж анхаарч ажиллах юм гэдгийг бол танд хэлье.

Тэгээд хөрөнгийн зах зээлийг бол та юу гэж хардаг вэ гэж асуусан. Энэ бол ерөөсөө олон нийтийн зах зээл. Хөрөнгийн зах зээл хөгжиж байж санхүүжилтийн өртөг буурна. Аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээл дээрээс хямд, урт хугацааны өртөгтэй санхүүжилтүүд татна. Эргээд иргэд тодорхой хувийн хуримтлалаараа иргэд мэргэжлийн байгууллагаар дамжаад энэ хөрөнгийн зах зээл дээрээс хөрөнгө оруулна, хуримтлал үүсгэнэ. Эндээсээ өгөөж хүртдэг ийм хамтын зах зээл. Тэгээд эргээд энэ дотоодын компаниудын хөрөнгийн зах зээл дээр олон нийтийн болсон компаниудын засаглал сайжирна. Ил тод байдал сайжирна. Ингэснээр ашигт ажиллагаа өснө. Зах зээлийн үнэлгээ нэмэгдэнэ гээд ийм олон сайн талуудтай

байдаг. Тэгэхээр энэ чиглэл дээр бол бүтээгдэхүүн үйлчилгээний чанарт анхаарах, нөгөө талаас мэргэжлийн хөрөнгө оруулагч бэлтгэх чиглэл дээр анхаарна.

Зүгээр сүүлийн үед бол энэ олон нийтэд санал болгох хувь дээр бол үнэхээрийн онцгой анхаарч ажиллах ёстой гэж бол харж байгаа. Ялангуяа анх удаа олон нийтийн болж байгаа, паблик болж байгаа компаниуд бол олон нийтэд нөгөө Фриплөүт гэж нэрлэдэг. Ялангуяа анх удаа болж байгаа компаниуд бол хамгийн багадаа юу гэдэг юм 30 хувь, 40 хувийг олон нийтэд арилжаалдаг, санал болгодог ийм байдалтай байгаа. Манай хөрөнгийн зах зээлийн бас чадавх чансаа бол тэр хэмжээгээр нэмэгдэж байгаа гэж бол хариулмаар байна.

2 дугаарт нь бол тэр валютын зохицуулалтын хуулийг бол манай хорооны валют арилжааны цэгүүд дээр бас энэ хуулийн зохицуулалт ажилладаг. Банк бус санхүүгийн байгууллагууд бас гадаад валютын арилжааны чиглэлээр ажилладаг. Тэгэх энэ хуулийн төсөл дээр Монголбанк болон холбогдох байгууллагатай идэвхтэй хамтарч ажиллаж бас саналаа танилцуулъя гэж хэлэх байна. Баярлалаа танд.

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

Ц.Даваасүрэн: Тэр стратегийн ордын 10 хувийг арилжаалах дээр чи яагаад хариулт өгөхгүй байгаад байна. Тэр чинь бас нэг боломж шүү дээ. Оюутолгойн 10 хувийг арилжаална гэдэг чинь бол том л зүйл шүү дээ. Олон улсын зах зээл дээр. Нөгөө талаар олон нийтэд нээлттэй компани болгоно гэж байгаа сайхан үг л дээ. Тэгэхдээ бас мөнгө муутай иргэд яаж оролцох вэ гэдэг чинь асуудал. Ялангуяа стратегийн хөрөнгө оруулагч гэж ингэж тодорхой хэсэг хүмүүст гол хувьцааг нь өгчхөөд байна шүү дээ. Манайхан чинь. Нээлттэй компани болгож байна гээд. Тэгээд энэ тэрийг анхаарахгүй бол юун нээлттэй компани болгох. Стратегийн хөрөнгө оруулагч гээд хэдэн нөхдөд л нөгөө компани чинь оччихоод байгаа шүү дээ. Энэ ядуу иргэд чинь юугаараа авах юм бэ. Тийм учраас нийтэд нээлттэй байх, нийт оролцох боломжоор хангах чиглэлд нь зохицуулалт хийж өгөхгүй бол стратегийн хөрөнгө оруулагч гээд л ингээд яваад байх юм бол олон нийтэд нээлттэй компани ерөөсөө болж чадахгүй.

Тэгээд тэр миний асуусан зүйл дээр хариулъя. Стратегийн ордын 10 хувийг яах юм бэ.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье. Нэр дэвшигч Жамбаажамц.

Т.Жамбаажамц: Ашигт малтмалын тухай хуулиар ашигт малтмалын стратегийн орд эзэмшигч хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжаална гэсэн ийм хуулийн зохицуулалттай. Тэр хүрээнд бол Санхүүгийн зохицуулах хорооны хувьд бол уул уурхайн бизнес давамгайлсан манайд уул уурхайн дээр түшиглэсэн ийм бизнес давамгайлсан компаниуд ялангуяа хувьцаагаа олон нийтэд гаргахад бол үнэхээрийн сонирхол татсан бүтээгдэхүүн байдаг. Тэгээд Санхүүгийн зохицуулах хорооны хувьд бол ялангуяа стратегийн томоохон ордуудыг эзэмшигч компаниуд бол хувьцаагаа олон нийтийн болгох, энэ хуулийн шаардлагыг хангах дээр бол хорооны зүгээс холбогдох байгууллагуудтай нь хамтарч ажилласаар ирсэн. Энд бол төрийн өмчийн тодорхой компаниуд ч байдаг. Хувийн өмчтэй компаниуд ч байдаг юм байна лээ. Тэгээд олон нийтийн болгох бол энэ хуулийн шаардлагыг хангаад олон нийтийн болгох бол компанийн

өөрийнх нь шийдвэр. Энэ дээр бол бүх техник технологи, хууль, эрх зүй, зохицуулалт бүх юм нь бол бэлэн байгаа. Дэмжинэ.

Д.Амарбаясгалан: Чинбаатарын Анар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ч.Анар: Сайн байна уу. Жамбаажамц нэр дэвшигчийг мэднэ. Насаараа Санхүүгийн зохицуулах хороонд ажилласан. Зовлон, жаргалыг нь мэддэг. Тийм учраас дэмжиж байгаа. Тэгээд 2 захиас, тэрэнтэйгээ уялдсан 2 асуулт байна.

Урьд урьдын Санхүүгийн зохицуулах хорооныхон бусад зохицуулах байгууллагыг бодвол хамгийн нээлттэй либерал ажиллаж ирсэн. Жишээ нь Сенд боксын орчныг үүсгэсэн. Финтекийн орчинд нээлттэй байсан. Бүс нутагтаа бол энэ хамгийн зохицуулалттай байгууллагыг нээлттэйгээр авч явсан. Тэгэхээр энэ тэргүүлэх төрийн зохицуулагч байгууллага мөртөө илүү инновацлаг байдаг, нээлттэй байдаг бодлогоо авч яваасай, үргэлжлүүлэн авч яваасай гэж Танаас хүсэж байна.

2 дугаарт энэ Их Хурлын гишүүд их яриад байгаа. Банк, төрийн өмчит компаниуд гээд, сая Даваасүрэн дарга ярьж байна. Бас Оюутолгойн 10 хувийг хувьчлах. Энд хөрөнгийн зах зээл өнөөдөр хөгжиж байгаа ч гэсэн гаднын институционал хөрөнгө оруулагч байхгүй байгаа. Тэгэхээрээ Төрийн банкиг 34 хувь хувьчиллаа, банкнуудыг 34 хувьчиллаа. Эрдэнэс Тавантолгойг эргэлтэд орууллаа. Энэ хөрвөх чадвар хөрөнгийн зах зээлд байхгүй. Тэгэхээр энэ гаднын хөрөнгө оруулагчдыг оруулж ирэх хууль, эрх зүйн орчин, нөхцөлийг нь бүрдүүлж ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд энэ 2 захиас дээр та ер нь цаашдаа ямар бодлоготой ажиллах вэ. Илүү Санхүүгийн зохицуулах хороог бусад зохицуулах хорооноос илүү нээлттэй ажилладаг зарчмаа баримтлах уу.

2 дугаарт энэ том төрийн өмчит компаниуд хөрөнгийн зах зээл рүү гарах гэж байна. Хөрвөх чадвар байхгүй учраас нэмж чадахгүй байгаа. Энийг та яаж зохицуулж ажиллах вэ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Жамбаажамц хариулт өгье.

Т.Жамбаажамц: Анар гишүүний асуултад хариулъя. Дэлхийн санхүүгийн зах зээл маш хурдацтай өсөж байгаа. Ялангуяа технологид суурилсан энэ санхүүгийн зах зээлийг бол зохицуулах байгууллагууд бол гүйцэхээ байчихсан ийм байдалтай байгаа. Тэгээд энэ орчинд бол дэлхийн санхүүгийн зохицуулагч байгууллагууд хамгийн гол хэрэгсэл нь бол таны түрүүний хэлдэг Сенд боксын орчин байж байгаа. Тэгээд Монгол улс, түүний дотор Санхүүгийн зохицуулах хороо 2 жилийн өмнө Сенд боксын орчноо үүсгээд, Сенд боксын зөвлөлөө байгуулаад, энд бол өнөөдрийн байдлаар 8 бүтээгдэхүүн амжилттай туршигдаад явж байгаа. Энэ бол маш үр дүнгээ өгч байгаа гэж бид нар үзэж байгаа. Ялангуяа хууль, эрх зүйн зохицуулалт дутмаг шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ зах зээл дээр гарах хэрэгцээ шаардлага байдаг. Энэ хэрэгцээ шаардлагыг нь хангах гэхээр хууль, эрх зүйн зохицуулалт дутмаг учраас гарах бололцоогүй гэж үздэг. Тэгэхээр Сенд боксын орчинд бодит орчинд хязгаарлагдмал хүрээнд, тодорхой хугацаанд 1 жилээс 1 жил хагасын хугацаанд туршаад, амьдрах чадвартай үгүй юу гэдгийн тэр туршилтын хугацаанд тогтоогоод, цаашаа гаргаад ингээд явахад бол маш их тодорхой ийм үр дүнгүүд бол гарч байгаа.

2-т нь манайх энэ юуны хүрээнд таны тэр хэлдэг энэ шинэ технологийг суурилуулах, ялангуяа энэ виртуал хөрөнгө технологид суурилсан бизнес энэ чиглэл дээр бол энэ үнэхээр нээлттэй байгаа. Энийг бол бид бүхэн ялангуяа хууль, эрх зүйн зохицуулалтын дутмаг байдал гэдэг юм уу, хязгаарлагдмал байдлаас хамаараад ийм бүтээгдэхүүн гаргах, эсэх юм дээр бол маш нээлттэй ажиллаж байгаа. Ялангуяа энэ хөрөнгийн зах зээл дээр бол бүтээгдэхүүн дээр ялангуяа миний түрүүний хэлсэн Өү Ти Си маркет дээр тухайлбал сая 2014 оны 11 сараас блокчэйн технологийг бас туршаад эхэлчихсэн байгаа. Тэгэхээр ингээд блокчэйн технологийг арилжааны платформ дээр туршиж эхэлснээрээ байнгын 24/7 арилжаалдаг. Илүү найдвартай хамгаалалттай болдог. Хөрөнгө оруулагч тэр дээр бүтээгдэхүүнээ зарж байгаа үнэт цаас гаргагчийн хувьд маш хурдан шуурхай оролцдог гээд ийм олон давуу талууд үүсэж байгаа.

Тэгээд миний хувьд хэрвээ Улсын Их Хурал дэмжээд, цаашаа Санхүүгийн зохицуулах хорооны даргаар томилогдоод ажиллавал өнөөдрийн хүрсэн энэ амжилт, ялангуяа технологи инновац шингэсэн энэ амжилтыг бол улам цааш нь хөгжүүлж, энийгээ бол улам баримталж явна гэж бодож байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Ганбаатар: Нэр дэвшигчийн хувьд бол Санхүүгийн зохицуулах хороог анхнаас, анх байгуулагдсан цагаас нь хойш энэ байгууллагад мерит зарчмаар ажиллаж яваа хүн юм байна. Мерит зарчим дээр сайн тал ч бий, сул тал ч бий. Сайн тал нь туршлагатай. Сул тал нь өмнөх элдэв юмныхаа талаар их мэдээлэлтэй байдаг сул тал байдаг. Тэгэхээр санхүүгийн зах зээлийн тулганы 3 чулуу нь бол банк, даатгал, хөрөнгийн зах зээл 3. Өнөөдөр яах вэ банкны систем бол харьцангуй гайгүй Монгол улсад хөгжиж байна. Даатгалын систем бас хөгжөөд явж байна. Хөрөнгийн зах зээл маш дутмаг байна. Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт босгох, түрүүн та бас хэлж байгаа харагдана. Хөрөнгийн үндэсний хөрөнгө оруулагчид мэргэжлийн хөрөнгө оруулалтын компаниудыг бэлтгэх, дээрээс нь энэ зах зээлээс үндэсний томоохон компаниудыг олон нийтэд бонд гаргах, хувьцаа гаргах тал дээр нь мэргэжлийн болох тал дээр нь сайн тусална гэж. Мөн гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж оруулна гэж.

Өнөөдөр энэ хүүгийн хамгийн өндөр байгаа шалтгаан чинь зөвхөн банкнуудаас гадна, гаднын хөрөнгийн зах зээлээс их хэмжээний эх үүсвэр татаж хүү буулгах ёстой юм шүү дээ. Энэ тал дээр юу хийх вэ гэдэг 1 дүгээр асуулт.

2 дахь нь манай улсын санхүүгийн зах зээл дээр хадгаламж зээлийн хоршоодын хэрэг гээд хүү өндөр байх үед нь улс төрчид мөнгөө оруулаад угаагаад авчихсан. Мөн ихээхэн хэмжээний зээл авч байгаад, дараа нь банкнуудыг дампууруулчихсан. Мөн хамгийн сүүлийнх нь бол нөгөө крипто валют буюу койны хэрэг. Та бол энэ үед бас ажиллаж л байсан юм байна. Энэ крипто зах зээл буюу эрх зүйн орчныг нь сайжруулах тал дээр яг хууль, эрх зүйн орчныг нь сайжруулах тал дээр яг юу хийхээр төлөвлөж байгаа вэ гэж 2 дахь асуулт.

3 дахь асуулт нь үндсэндээ 2023 онд манай улс мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль гэж гаргасан. 2023 оны 3 сарын 1-ээс хэрэгжсэн шиг санаж байна. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль яг үндсэндээ амьдрал дээр хэрэгжиж байгаа нь их тааруухан байна. 2023 онд АН мөрийн хөтөлбөрөө боловсруулах гээд Монгол орон даяар өрийн дарамтгүй Монгол гээд

улс төрийн томоохон үйл ажиллагаа явуулсан. Энэ үеэр бид нар бас бүх орон нутгаар явж иргэдтэй уулзаж, үнийн өсөлт, өрийн дарамтын талаар судалж явсан юм. Өнөөдөр Монгол Улсад 555 ББСБ, 1 мянга гаруй ломбард ажиллаж байна. Уг нь энэ мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль амьдрал дээр сайн хэрэгжих юм бол эдгээрийн үйл ажиллагааны зохицуулалт арай өөр болох ёстой юм. Тэгээд энэ чиглэлээр яг ямар ажлууд хийгдэх вэ гэдэг 3 дахь асуулт байна.

Ялангуяа тэр мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн хөдөө амьдрал дээр хэрэгжихгүй байгаа зүйл нь тэр олгох зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ нь үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй гэдэг асуудал үндсэндээ иргэдийн санхүүгийн мэдлэг дутуу байгааг далимдуулаад, орон нутагт хэрэгжихгүй байна. Ийм учраас эдгээр 3 асуулт дээр хариулт авъя гэж бодож байна.

Дараа нь бас тодруулах зүйл бий.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Жамбаажамц хариулт өгье.

Т.Жамбаажамц: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 3 асуулт асуулаа. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас баталж, үндсэндээ 2 дахь жилдээ хэрэгжээд явж байгаа ийм хууль байгаа. 2021 онд баталсан. 2022 оны 9 сараас үндсэндээ бүрэн утгаараа хэрэгжиж явж байгаа ийм хууль байгаа. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хуулиар ерөнхийдөө, өнөөдөр дэлхийн санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллагууд бол виртуал хөрөнгийн зах зээлийг бол зохицуулсан зохицуулалтгүй байгаа. Ер нь зах зээлийг нь зохицуулсан. Одоо ямар хэлбэрээр зохицуулж байна гэхээр Монгол Улс ч энэ хэлбэрийг бас сонгосон. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нөгөө платформууд арилжааны платформуудын өөрөөр хэлбэл арилжаа эрхлэгч этгээдийг нь бүртгэж байгаа. Бүртгэхдээ бол тодорхой технологийн, хүний нөөцийн, санхүүгийн гэсэн ийм шаардлагууд дээр шаардлагуудыг тавиад, тэгээд бүртгэж байгаа, энэ бүртгэсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нар бол цаашид тэр койн, токен гарч гарах тэр процесс дээр нь хяналт тавиад өөр дээрээ үнэт цаас гаргагчид нь хяналтаа тавиад ингээд явдаг ийм хэлбэрийн л зохицуулалтыг бол хэрэглээд явж байгаа. Монгол Улсын хувьд ч гэсэн яг энэ энэ хэлбэрийн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн арилжаа эрхлэгчийг бүртгэж, арилжаа эрхлэгч нь ч цаашаа зах зээл дээрээ хяналт тавьдаг. Энэ хэлбэрийг бол одоогийн хэлбэрээр бол яг энэ дэлхий нийтийн жишгийн дагуу зохицуулаад явж байгаа. Ер нь бол цаашид дэлхийн яг энэ виртуал хөрөнгөтэй холбоотой зохицуулалтын орчин нөхцөлийг судална. Энэ хүрээндээ бол ямар хэлбэрээр энэ зохицуулалтыг цаашид явах юм гэдэг нь бол тодорхой болох байх гэж бол үзэж байгаа. Энэ хүрээнд бол зохицуулалт нь явна.

2-т нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль бол Монгол Улсын Их Хурлаас батлагдсан. Энэ хуулийн онцлог бол зөвхөн Санхүүгийн зохицуулах хороо бол хариуцахааргүй байгаа. Өөрөөр хэлбэл хэмжээ, хүрээнээс нь хамаараад 2 үндсэндээ бүртгэлийн буюу хяналт тавих субъекттэй байгаа. 300 сая төгрөгөөс дээш дүрмийн сантай юм уу, 2-оос дээш орон нутагт салбартай мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг нь бол Санхүүгийн зохицуулах хороо бүртгэж байгаа. 300 сая хүртэлх нийслэл 300 сая хүртэлх, аймагт бол 100 сая хүртэлх дүнтэй компани хувь хүний бүртгэлийг бол орон нутаг, нийслэл, дүүрэг, аймгийн ЗДТГ дээр бол бүртгээд явж байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс бол мөнгөн зээлийн үйл ажиллагааны энэ хуулийг хэрэгжүүлэх чиглэл дээр 2 тодорхой зүйл хийсэн. 1 дүгээрт нь бол тэр бүртгэлийн цахим программыг бол нэвтрүүлсэн байж байгаа. Энэ цахим программыг өнөөдөр Санхүүгийн зохицуулах хороо ч бүртгэлдээ ашиглаж байгаа. Орон нутгийн засаг захиргааны нэгжүүд ч бүртгэлдээ манай энэ мөнгөн зээлийн программыг бол ашиглаж байгаа. Одоо он гараад 1 сараас эхлээд мөнгөн зээлийн иж бүрэн программ ашиглалтад орж байгаа. Программ ашиглалтад орж байгаа. Мэдээлэл авдаг санхүүгийн үзүүлэлтүүдийг нь ирүүлдэг. Дээрээс нь гол нь нөгөө мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн барьцаа хөрөнгийг нэгдсэн сангаар бүртгэдэг. Тэр нь өөрөө цагдаагийн байгууллагын мэдээллийн сантай холбогддог ийм программыг бол Санхүүгийн зохицуулах хороо захиалж хийлгээд , энэ оны оноос эхлээд энэ юу бол ажиллаад эхэлж байгаа. Тэгэхээр энэ ажиллаад эхлэх юм бол мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд, ялангуяа бид нарын нэрлэж заншсанаар ломбардуудын үйл ажиллагаа бол нэлээн цэгцдээ орно гэж бол харж байгаа. Ийм байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажилд томилох санал хураалт явуулна. Асуулт, үг хамт байсан. Санал хураалт явуулна. Өнөөдрийн нэр дэвшигчийн сонголт хийгдсэнтэй холбоотой нэр дэвшигчийг дэмжье гэсэн ийм саналын томъёоллын санал хураалтууд. Санал хураалт нь нууцаар явагддаг. Нууцаар гэдэг нь хурууныхаа хээгээр саналаа өгнө. Гэхдээ нөгөө нэрийн жагсаалт гарахгүй. Дэмжсэн тоо, хувь нь гарна гэсэн үг. Энэ нөгөө шинэ дэгийн тухай хуулийн зохицуулалтаараа аливаа нэр дэвшигчтэй холбоотой санал хураалтыг ийм хэлбэрээр зохион байгуулдаг болсон байна лээ. Тэгэхээр эхний санал хураалт учраас туршилтын санал хураалтыг явуулаад үзээдэлье. Туршилтын санал хураалт. Нийт 59 гишүүн санал хураалтад орж, дэмжсэн байна. Бүртгүүлсэн байна. Ингээд Түндэвийн Жамбаажамцыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажилд томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулья. Санал хураалт. 60 гишүүн дэмжиж, Санхүүгийн зохицуулах хорооны даргаар дэмжигдлээ.

Одоо Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх санал хураалтыг явуулна.

Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Дашдэмбэрэлийн Баярсайханыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 59 гишүүн буюу 65,6 хувиар санал дэмжигдлээ.

Томилж, чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Дэмжигдсэн Жамбаажамцад ажлын өндөр амжилтыг хүсье. Энэ Улсын Их Хурлын зорилго банк болон ББСБ-аас олгогдож байгаа зээлийн хүүг бодитой зах зээл, амьдралд нийцсэн тэр түвшинд аваачихын төлөө томоохон зорилго тавьж ажиллаж байгаа. Энэ ажил ирэх хаврын чуулганд ажил хэрэг болох ёстой. Тэгэхээр шинээр ажил аваад эрчтэй ажилдаа орохыг хүсье. Амжилт хүсье.

11.32 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Нэр дэвшигчдийн талаарх талаар гаргасан Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Батсүмбэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилуулахаар саналаа ирүүлсэн болон Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн нэр дэвшигчийг бүртгэх тухай 5 дугаар тогтоолын дагуу зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд Булганы Саруул, Лувсандоржийн Сонор, Шагдаржавын Хандсүрэн нарыг нэр дэвшүүлсэн болно

Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 3 дугаар тогтоолоор баталсан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу нэр дэвшигчид өөрийн танилцуулга, холбогдох баримт бичгээ бүрдүүлж, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчдийн Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай тогтоолыг баталж, 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддоржийг томилсон.

Эдийн засгийн байнгын хорооноос 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан нэр дэвшигчийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батшугар, Ганхуяг, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг, Цогтбаатар, Эрдэнэбат нарын гишүүд оролцсон болно.

Байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаар сонсголын тайланг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гарган танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд нэр дэвшигчээс асуулт асуугаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Шижир улс төрийн өндөр албан тушаал хашдаг этгээдүүдтэй

харилцан хамаарал бүхий садан төрлийн холбоотой, эсвэл ашиг сонирхлын зөрчил үүсгэх бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдүүдийг аливаа албан тушаалд нэр дэвшүүлэн томилдог асуудлыг зохиох талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл мерит зарчмаа хангаж, мэдлэг боловсрол, ур чадвар, ажлын туршлагаар тэмцсэн нэр дэвшигчийн хувьд харилцан хамаарал бүхий гэсэн үндэслэлээр нэр дэвшигчийг томилох асуудалд хэт ерөнхий байдлаар хандахгүй байх талаар санал хэлсэн болно.

Булганы Саруул, Лувсандоржийн Сонор, Шагдаржавын Хандсүрэн нарыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүн тухай бүрийг дэмжсэн болно.

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Баасанжавын Батхишиг, Нямдэлэгийн Мандуул, Баярсайханы Баярдаваа нарыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээс чөлөөлүүлэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Булганы Саруул, Лувсандоржийн Сонор, Шагдаржавын Хандсүрэн нар хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны санал, дүгнэлт болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 5 гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Нэр дэвшигчдэдээ амжилт хүсье. Тэгээд Санхүүгийн зохицуулах хороо. Яах вэ, манайхан энэ санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой асуудлуудыг бас нэлээн сайн авч үзэж харж байх ёстой. Ингээд орон тооны бус гишүүдээс нийтэд нь бас асуучихъя гэж бодож байна.

Энэ жижиг дунд бизнесийн санхүүжилтэд тулгардаг саад бэрхшээлүүдийг та бүхэн маань арилгах тал дээр ямар бодолтой байдаг вэ. Энийг 1 дүгээрт асууя.

2 дугаарт Монгол Улсын санхүүгийн тогтолцоог илүү тогтвортой болгохын тулд ямар бодлогын өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай гэж үздэг вэ. Энэ дээр та бүхний бодлыг сонсмоор байна.

3 дугаар асуулт бол уламжлалт банк даатгалын салбараас гадна финтек блокчэйн зэрэг шинэ салбаруудад зохицуулалт хийхэд таны байр суурь ямар байдалтай байдаг вэ. Ямар бодолтой байдаг вэ гэдгийг асууя.

4 дүгээрт энэ санхүүгийн зах зээлийн хяналтыг ер нь яаж хийх ёстой юм бэ. Өнөөдөр монополын эсрэг газар ломбардын хяналтыг хийгээд явж байгаа. Хуучин ШӨХТГ гэсэн үг. Энэ санхүүгийн хяналт ер нь нэг газраа төвлөрөх ёстой юм уу эсвэл

ийм байдлаар салангид явах ёстой юм уу гэдгийг та бүхэн хариулж өгөөч ээ гээд нэр дэвшигч гурваасаа гурвуулаагаас нь зэрэг асуучихъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Сонор хариулт өгье. Ажлын хэсгийн хэддүгээр микрофон байна. 19 дүгээр микрофон.

Л.Сонор: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тодорхой 4 асуулт асуулаа. Жижиг, дунд үйлдвэрийг хэрхэн дэмжих вэ. Санхүүжилтийг олгоход бэрхшээлийг арилгах уу гэдэг талаар асуулаа. Яг одоо Монгол Улсад хэрэгжиж байгаа хууль журмын хүрээнд яг энэ ЖДҮ-ийг дэмжих талаар Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоо ажиллаж байгаа. Энэхүү тогтолцоо бүрдээд сүүлийн 10 гаруй жил болж байна. Энэхүү тогтолцооны гол зорилго нь бол барьцаа хөрөнгийн шаардлага хангалтгүй байдаг. Тэрнийх нь барьцаа хөрөнгө дээр нь батлан даалт гаргаж, ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилтийн боломжийг нээх талаар зохицуулалттай.

Нөгөө талдаа мөн санхүүжилтийн илүү урт хугацааны механизм бол өөрөө хөрөнгийн зах зээл байдаг. Банкны хувьд бол богино хугацаат депо, хадгаламж байршуулаад илүү богино хугацааны санхүүжилт авдаг бол хөрөнгийн зах зээлээс бонд, үнэт цаас хэлбэрээр илүү урт хугацааны санхүүжилтийг татах боломж үүсэж байдаг.

Тийм учраас хөрөнгийн зах зээл талдаа бас энэхүү зохицуулалтын уян хатан байдлыг сайжруулж, мөн ялангуяа хөрөнгийн бирж дээр байгаа индексүүд дээр топ 20, тэрнээсээ гадна А, Б гээд самбарууд дээр, тэрнээс гадна ингэж ... иймэрхүү бас зохицуулалтын уян хатан орчныг бас бий болгох боломжтой. Тэгж байж бас ЖДҮ-ээ дэмжих нь бас боломж байгаа гэж.

2 дугаарт нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах гэдэг тал дээр асуулт асуулаа. Миний хувьд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2-т заасны дагуу санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дэвшүүлсэн санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гэдэг механизм Монгол Улсад ажилладаг. Энэ нь Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, ХДК-ийн захирлуудаас бүрдсэн. Энэхүү механизмаараа дамжуулаад санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой төсөв мөнгөний бодлогын уялдаатай, мөн санхүүгийн салбарын уялдаа холбоог хангаж ажилладаг. Цаашдаа энэхүү механизм нь Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилогдох, ингээд нэр дэвшүүлэх процесс нь өөрөө бас санхүүгийн салбар дээрээ энэхүү тогтвортой байдлыг хангахад бас ингээд нөлөөлөх уялдаа холбоог хангахад бас чухал юм.

Финтекийн салбартай шинэ технологитой холбоотой гэх юм бол Монгол Улсад Сенд боксын орчинд шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэхээсээ өмнө ингээд туршилт хийдэг механизм ажиллаж байгаа. Олон улсад маш олон ийм финтекийн болон шинэ технологиуд бий болж байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдахад тухайн үед бас ажлын хэсэгт нь орж ажиллаж байхад ямар ньюанс гарч байсан бэ гэвэл нэг талдаа энэ бол дэлхий даяараа байгаа асуудал. Нэг талдаа инновац болон финтек шинэ технологийг дэмжих хэрэгтэй байдаг. Энэ нь өөрөө цаашдаа ингээд санхүүгийн салбарын хэрэглэгчдийг бас боловсролыг сайжруулах хүртээмжийг нэмэгдүүлэхэд их том ач холбогдолтой.

Нөгөө талдаа гэхдээ бас мөнгө угаах болон бусад залилан, гэмт хэргийн шинж чанараар бас ашиглагдах эрсдэл байгаад байгаа. Дэлхийн бүх улс орнуудын хувьд үүний хэрхэн балансыг олох вэ гэдэг маш чухал байгаа. Тийм учраас эхний ээлжид хэт их зохицуулалт оруулах юм бол энэ нь өөрөө финтек болон шинэ технологийг өөрөө салбарыг бас унагах эрсдэлтэй байдаг учраас одоогийн байдлаар зохицуулалтын орчин бол эхний ээлжид бүртгэл хийх, тэгээд сэнд боксын орчинд буюу ингээд инкубатор үүсгээд туршилтаа хийгээд, үүний дараагаас үнэхээр боломжтой цаашаа зах зээл рүү нэвтрүүлдэг энэ тогтолцоогоор явж байгаа. Энэ бас одоогийн байдлаар .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Булганы Саруул хариулт өгье. Аль болох товч хариулахыг хүсье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Саруул: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Үндсэндээ дийлэнх саналууд бол эхний хариултад бол тусгагдчихлаа.

1 дүгээрт нь жижиг, дунд бизнесийн саад бэрхшээлийг хэрхэн бууруулах вэ гэхээр ил тод байдлыг дэмжих хэрэгтэй. Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээ бол бас хүнд суртал багатай байх ёстой. Мэдээлэл боломжуудыг бүгдэд бол нээлттэй, хүртээмжтэй хүргэх шаардлага бол байгаа гэж үзэж байна.

2 дугаарт санхүүгийн тогтвортой байдлын тухай асуулаа. Энэ дээр бол Тогтвортой байдлын зөвлөлийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо бол гишүүнээр нь оролцдог. Тэгэхээр одоогоор 80 хувь банк давамгайлсан, 15 хувь дээр хөрөнгийн зах зээл давамгайлсан байдалтай байгаа. Үүнийгээ нэмэгдүүлэх буюу томоохон төрийн өмчит компаниудыг бас нээлттэй хувьцаа гаргах тал дээр бол ил тод байдлыг хангах тал дээр бас нэлээн анхааран ажиллах шаардлага бол байгаа гэж үзэж байгаа. Гэхдээ үүн дээр хөрөнгө оруулагч талдаа бол маш чухал. Ингэхийн тулд бас гадаадын хөрөнгө оруулалтыг бидний зүгээс бол дэмжих нь маш зүйтэй. Энэ дээр том утгаараа бол бас улсынхаа зээлжих зэрэглэлийн асуудлыг бас нэлээн анхаарах шаардлага бол байгаа. Одоогоор фиж болон эс эн пи зэрэглэл тогтоох агентлагуудаас бид нар бол В1 буюу бас тодорхой түвшин ахисан байдалтай байгаа. 2024 онд. Тэгэхээр энийгээ бас улам батжуулах, нэмэгдүүлэх тал дээр бас холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах зүйтэй гэсэн бас бодолтой явдаг.

Хяналт шалгалтын тухай бол хорооны зүгээс ер нь төрийн байгууллагуудын зүгээс сүүлийн жилүүдэд эрсдэлд суурилсан хяналт шалгалт буюу хяналт шалгалтын дарамтыг багасгая. Харин их хэмжээний хөрөнгө эргэлдэж буй их хэмжээний арилжаа хийж буй аж ахуйн нэгжүүдэд бас хяналт шалгалтыг тодорхой давтамжтайгаар хэрэгжүүлье гэсэн хууль журам гараад, энэ тал дээр бас харьцангуй нэг чигт хараад явж байгаа гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Шагдаржавын Хандсүрэн хариулт өгье. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Ш.Хандсүрэн: Эрхэм гишүүний асуултад хариулъя. 2 нэр дэвшигчийн хэлсэн дээр нэмээд хэлэхэд хяналт шалгалтын ажиллагааг тодорхой болгох шаардлагатай. Үндсэндээ бол энэ сая яригдаагүй зүйл бол Зөвшөөрлийн тухай, Мөнгөний эх үүсвэрийн тухай бол яригдсангүй. Хамгийн чухал асуудал нь санхүүгийн зах зээл дээр оролцогчдын хөрөнгө оруулагчдын оруулах мөнгөн хөрөнгийн эх үүсвэр хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого байх тухай

хуулийн зохицуулалттай байгаа. Энийгээ тодорхой болгосон тохиолдолд нөгөө цахимжуулах асуудлуудыг бүрэн шийдвэрлэх, бүх төрлийн зөвшөөрлүүдийг цахимжуулснаар саяын яригдаж байгаа асуудлуудыг бүрэн дэмжих боломжтой гэж үзэж байгаа гэж харж байгаа.

Энэ хүүгийн тухай асуудлууд яригдаж байгаа. Ялангуяа банк бус санхүүгийн байгууллагууд зах зээл дээрээс мөнгө татахдаа асар өндөр хувийн хүүтэй эх үүсвэрийг татсантай холбоотой энэ хүүгийн асуудлууд өндөр байгаа дээр хяналт шалгалтын аргаар энийг зохицуулах боломжтой гэж үзэж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ө.Шижир: Өглөөний мэнд. Надад 2, 3 асуулт байна. Асуултын өмнө нэг үг байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу банк бустай болон даатгалын бизнес эрхэлдэг Улсын Их Хурлын гишүүд энэ томилгоо дээр өөрсдийн сайн дураараа санал өгөхөд оролцохгүй байхыг хүсэж байна.

Яагаад гэхээр өөрөө тэр салбарт нь бизнес хийдэг байж өөрийнх нь бизнесийн үйлчилгээ явдаг газарт өөрийн хамаатнаа томилж байгаа ийм тохиолдол болж байна. Тийм учраас даатгалтай болон банк бустай, энэ төрлийн бизнес үйлчилгээ эрхэлдэг хүмүүс энэ хуулийн дагуу санал хураалтад сайн дураараа оролцохгүй байхыг хүсэж байна.

Санхүүгийн зохицуулах хороо дээр байгаа энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн асуудлыг түрүүн Их Хурлын гишүүд маш ихээр хөндөж байна. Үүн дээр нэр дэвшигч нар маань ямар байр суурьтай байдаг вэ. Жижиг хувьцаа эзэмшигчдийн гомдлыг Санхүүгийн зохицуулах хороо хэрхэн шийддэг вэ. Энэ дээр яаж шийдэх вэ гэдэг асуулт байна.

2 дугаарт нь Санхүүгийн зохицуулах хорооны гаргасан дүрэм журмыг хэрэгжүүлдэггүй компаниуд, хувьцаат компаниуд бас байдаг. Шүүхээр заргалддаг, шүүхэд нөлөөлдөг. Тэгээд үүн дээр хороо нь яаж ч чаддаггүй ийм бас жишээнүүд байгаа. Үүн дээр ямар байр суурьтай, яаж шийдвэрлэх вэ гэдэг. Одоо 555 банк бус байгууллага 5,2 их наяд төгрөгийн зээл иргэдийн гар дээр гарчихсан байна. Үүн дээр бас цаашид ямар бодлого барих вэ.

Мөн бид нарын хамгийн сайн ярьдаг койн гэж байдаг. Маш олон залуучууд энэ койноос болоод хохирсон. Тэгсэн мөртөө хохирлын асуудал одоо болтол шийдэгдээгүй. Тэгэхээр энэ дээр койны татвартай холбоотой, койны үйл ажиллагааны хураамжтай холбоотой юм дээр Санхүү зохицуулах хороо ямар байр суурьтай ажиллах вэ. Жишээ нь арилжааны орлого дээр нь татвар төлөх үү гэдэг ийм хэдэн асуултууд байна. Энэ дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Шижир гишүүн асуулт асуулаа. Шижир гишүүний асуултад 3 нэр дэвшигч тус бүрдээ хариулна. Хариултыг товч тодорхой өгөхийг хүсье.

Өнөөдөр хэлэлцэх асуудал маш олон байгаа учраас үдийн завсарлагагүй чуулган үргэлжилнэ. Гишүүдэд эртхэн мэдээлэл хүргэе. Үдийн завсарлагагүй. Нэр дэвшигч Сонор хариулт өгье.

Л.Сонор: Шижир гишүүний асуултад хариулъя. Жижиг хувьцаа эзэмшигчтэй холбоотой гомдол бол сүүлийн 30 жил яах аргагүй явж байгаа асуудал мөн. Шүүхээр маргаан нь явдаг. Хамгийн гол нь энэ нөгөө Корпрет Акшн гээд сүүлд бас 2024 онд батлагдсан үнэт цаасны зах зээлийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Корпрет акшны асуудлыг сайжруулах хэрэгтэй байгаа. Хууль зүйн хувьд бол зохицуулалтын орчин бүрдсэн. Цаашдаа Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнээр ажилласан тохиолдолд тусгайлсан зохицуулалтын орчныг дахиж нарийвчилж сайжруулах дээр ажиллана гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Мөн энэ асуудал дээр технологийн дэвшлийг бас нэвтрүүлэх боломжтой гэж хардаг. Жишээ нь гэвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан жижиг хувьцаа эзэмшигчид жил болгоны үнэт цаасан дээр хувьцаа эзэмшигчдийн хуралдаа саналаа бүрэн өгөх, ирэх, шинэ технологийг ашиглах, энэ нөхцөл байдлыг бүрдүүлэх тал дээр ажиллах нь зүйтэй гэж бодож байна.

Банк бус санхүүгийн зээлийн хувьд бол яах аргагүй үнэн. Өнөөдрийн байдлаар бол 555 ББСБ зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнтэй холбоотойгоор банкны салбар дээр өр орлогын харьцаа. Жишээ нь гэвэл өр орлогын харьцаа тавиад, энэхүү хэрэглээний зээлүүд дээр тодорхой хязгаарлалт хийсэн боловч өнгөрсөн жилүүдэд банк бусын салбар дээр иймэрхүү харьцаанууд байгаагүйн улмаас бас хэрэглээний зээл нэмэгдэх иймэрхүү асуудлууд байгаа. Тэгэхээр өнгөрсөн жилээс эхлүүлээд банк бус санхүүгийн зээл дээр өр орлогын харьцаан дээр бас 70/30 хувийн зохицуулалтыг оруулж, энэ дээр бас цаашдаа зохицуулалтын орчин дээр нь бас ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Мөн Шижир гишүүний хэлсэн койны тал дээр бол энэ дээр бас миний өмнөх хариулттай бас давхцаж байгаа юм. Яагаад гэхээр койн маань өөрөө бас блокчэйн технологи буюу дилти технологийг ашигласан ингээд шинэ бүтээгдэхүүн байгаад байгаа. Шинэ технологи. Олон улсад жишээ нь биткойн, бусад стэйбл койн зэрэг олон койнууд сүүлийн 10-аад жил гарлаа. Үүнтэй холбоотойгоор дэлхий дээр хаа сайгүй л зохицуулалтын орчин бол шаардлагатай байна. Хэрвээ хэт их зохицуулалтыг хийсэн тохиолдолд энэ нь өөрөө инновацыг бас үгүй хийх аюултай байдаг.

Нөгөө талдаа хэт зохицуулалтгүй явсан тохиолдолд яг таны хэлсэнтэй адилхан гэмт хэргийн үйлдлүүд ихэсдэг учраас Сэнд боксын орчноор дамжуулж энэ койны асуудлуудыг бас оруулж ирэх нь зүйтэй гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Булганы Саруул хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Саруул: Шижир гишүүний асуултад хариулъя. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудал бол маш зөв зүйтэй асуудал байгаа. Миний бие нэр дэвшихдээ бас жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг бүрэн хамгаалах шаардлага бол байгаа. Ингэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.2, 61.1.16-д заасны дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хороо бол хувьцаа эзэмшигчдийг эрх ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах

бүрэн эрх байдаг. Одоогоор энэ эрхээ хэрэгжүүлээгүй байгаа. Миний бие 2014, 2015 онуудад хорооноосоо томилогдон Хонг Конгийн үнэт цаас фючерсийн хороонд бас ажилласан. Энэ хугацаанд бол тухайн орны хорооны хянан шалгалтын газар бол шүүхэд хандаад, энэ маргаан маш хурдан шийдэгддэг ийм туршлага байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ дээр бол бид ч гэсэн үнэт цаасны маргаан шийдвэрлэх чиглэлээр холбогдох байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх шаардлага бол байгаа. Ингэснээр бол цаашид өмчлөх эрхийн зөрчлөөс сэргийлэх бүрэн боломжтой гэж үзэж, энэ талаар сонгогдох юм бас нэлээн анхаарал хандуулан ажиллана гэж хэлэх байна.

Бүртгэлийн шаардлага хангадаггүй хувьцаат компаниудын тухай бол 10-аад жилийн өмнө 330 компани хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байсан. Одоогоор 100 гаруй компани бүртгэлтэй байдалтай байна. Тэгэхээр шаардлага хангадаггүй компаниуд хэт төвлөрсөн буюу хөрвөх чадварыг хангаж чадахгүй компаниудыг бол ди лист хийх зохицуулалт бол байгаа. Өөрөөр хэлбэл бүртгэлээс хасах. Тэгэхээр энэ чиглэл рүү бас л төвлөрлийг задлах, шаардлага хангахгүй бол бүртгэлээс хасах зэрэг зохицуулалтууд бол байгаа. Тэгэхээр энэ хэрэгслүүдээ хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

Койны харилцаа дээр бол бас их анхаарал татсан асуудал байгаа. Энэ дээр нэлээн бас түлхүү зохицуулалт талаас хэрэглэгчдийг хохироохгүй байх талаас зээлийн хүүгийн талаас гэх мэтчилэн олон асуудал дээр анхааруулж ажиллана. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ээр дэвшигч Хандсүрэн хариулт өгье. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Ш.Хандсүрэн: Шижир гишүүний асуулт дотор энэ асуудал яригдлаа. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах тухай, тэд нарын гомдлын тухай асуулт байсан.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн гол гаргадаг гомдол бол ноогдол ашиг хуваарилах тухай асуудал байдаг. Үндсэндээ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад гол асуудал нь юу вэ гэхээр тухайн байгууллагын гаргасан аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланд хяналт тавих. Ашгийг үнэн зөв бодитой мэдээлж байна уу гэдэг асуудал дээр анхаарах шаардлагатай байгаад байгаа юм. Энийг Санхүүгийн зохицуулах хорооноос хийх ёстой. Хяналтыг бүрэн тавиад ажиллах нь зүйтэй гэж харж байгаа юм.

Койны тухай асуудал дээр бол нэн тэргүүнд энэ дээр хийгдэх хамгийн чухал асуудал нь сургалтын асуудлуудыг хийх нь зөв байх гэж бодож байгаа юм. Тэгэхгүй болохоор иргэд маань буруу ойлголтоор, өндөр ашиг хүртэнэ гэсэн ойлголтоор ийшээ орж хохирол амссан тохиолдлууд гарсан гэж харж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулга.

Ө.Шижир: Манай 3 нэр дэвшигч миний 1 асуултад ерөөсөө огт хариулсангүй. Тэр нь юу вэ гэхээр койны орлого дээр татвар тооцдог болох юм уу, болохгүй юм уу. Жишээ нь Америк 37 хувь, Франц 45 хувь, Сингапур 22 хувь байна. Дараа нь Монголд 1 ч койн байхгүй. Блокчэйн технологи дээр суурилсан 1 ч койн байхгүй. Бүгдээрээ цахим залилан. Бүгд залилан. Тэгэхээр энэ дээр та хэд ямар байр

суурьтай байгаа юм бэ. Сая тэр асуултад хариулж байхдаа нэр дурдсан койнууд чинь бол блокчэйн технологи дээр суурилсан шүү дээ. Монголд гарсан 60 хэдэн койн 1 нь ч блокчэйн технологи дээр суурилагдаагүй. Тийм болохоор энэ бол цахим залилан. Тэгэхээр эд нарын орлого дээр татвар тооцох юм уу. Энэ асуудал ерөөсөө хаана ч байхгүй. 2021 онд батлагдсан хуульд ч ийм заалт байхгүй. Энэ асуултад хариулаач. Хэн ч хариулсангүй.

Д.Амарбаясгалан: Хууль тогтоогчид Их Хурлын зүгээс бол энэ хуулийг санаачилж, өргөн барьж, батлах ёстой. Тэр батлагдсан хуулийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

Улсын Их Хурлын даргын захирамжаар бас энэ цахим койн, крипто валюттай холбоотой эрх зүйн орчныг бодитой болгох ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Тэгэхээр Шижир гишүүн тэр ажлын хэсэгт орж өргөн барих ажлыг санаачилж хийхийг бас хүсье. Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнд нэр дэвшигчдийн талаарх сонсголын тайлан, нэр дэвшигчдийн холбоотой материалтай танилцлаа. Тэгээд ингээд харахад бол эрх бүхий байгууллага нь манай төрийн албанд барилдах ёстой мерит зарчим дээр үндэслэж энэ 3 хүний нэрийг дэвшүүлсэн юм байна гэдэг ойлголт төрж байна. 1 дүгээрт.

2 дугаарт нэр дэвшигчдийн товч материалтай танилцахад эдгээр хүмүүс бол ажил эрхлэх хугацаандаа Санхүүгийн зохицуулах хорооны гишүүний үүргийг гүйцэтгэхэд хангалттай хэмжээний туршлага хуримтлуулсан. Тэгээд ч бас их потенциал сайтай хүмүүс юм шиг харагдаж байна. Тэгэхээр энэ 3 хүнийг бол сонгохыг бол дэмжиж байгаа юм.

Тэгэхээр үүнтэй холбогдуулаад хэлэхэд энэ нэр дэвшигчдийн анкет гэнэ үү нэг товч танилцуулга байгаа юм. Тэгэхээр гадаадын байгууллагууд, гадаад орнуудад төрийн албанд томилогдох гэж байгаа, сонгогдох гэж байгаа хүмүүс энэ анкетыг таглахдаа ажил эрхэлсэн байдал, мэргэжлийн сургалтад хамрагдсанаас хойш өнөөдрийг хүртэл ажил эрхэлсэн байдлыг ямар ч зайгүй нөхөж байх тийм хариу үүрэг хүлээдэг. Тэгэхээр манайд бол тийм юм байдаггүй юм шиг байгаа юм. Ингээд нэр дэвшиж байгаа хүмүүсийн ажил эрхэлсэн байдал дунд хараад байхад 2 3 жил ерөөсөө оргүй хоосон үлдчихдэг. Юу хийж явсан нь мэдэгддэггүй. Тэгэхээр манайх цаашдаа энэ асуудалд төрөөс хандахдаа нэр дэвшигчдийн танилцуулгыг бол ямар ч ажил эрхлэлтэд зайгүй бөглөж өгөхийг бол шаардаж байвал зүгээр юм шиг байгаа юм. Зүгээр энэ 3 хүний хувьд аваад үзэхэд жишээлбэл нэр дэвшигч Сонорын хувьд бол ажил эрхлэлтийн байдлаа онтой, сартай нь бүр нарийн сайн зайгүй хийчихсэн. Хандсүрэн нэр дэвшигчийн хувьд бол бас оноор нь зайгүй хийчихсэн. Атал нэр дэвшигч Саруул бол зайтай юм хийгээд байгаа юм. Жишээлбэл 2015 онд Төрийн банкны гүйцэтгэх захирлын орон тооны зөвлөхөөр ажиллаж байгаад, 2019 оноос Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын ЕНБД-аар ажиллачихсан. Энэ хооронд үндсэндээ 5 жил юу хийж явсан нь эндээс бол харагдахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр манайх нэгэнт анкетаа ингэж тагла гэдэг шаардлага тавьдаггүй учраас би бол та энэ хооронд юу хийж байсан юм бэ гэж асуулт тавина. Тавихдаа бол манайх энэ шаардлага тавигддаггүй учраас та бас хариулахгүй байж болно. Тэгэхээр энэ 5 жилд та ямар ажил эрхэлж байсан юм бол. Хариулж болно. Хариулахгүй байж болно. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Булганы Саруул. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Саруул: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Анкет дээрээ 2018 оны 12 сар, 2019 оны 3 сар гэсэн ийм зай гарсан байгааг асууж байх шиг байна. Тэгэхээр тухайн үед бас миний бие эмчлүүлэх гэсэн бас заалтаар тодорхой хугацаанд бас биеийн байдлыг анхаарсан. 1 дүгээрт. 2 дугаарт эмэгтэй хүний хувьд бол мөн бас тодорхой 2 жилийн, 3 жилийн чөлөө авах тохиолдол байдаг. Энэ нь хуулийн дагуу амаржсан болон хүүхэд асрах чөлөөтэй он жилүүд бас таарсан байгаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Ганхуяг: Санхүүгийн зохицуулах хорооны энэ гишүүдийн хийх үндсэн ажил бол ер нь зөвшөөрөл өгөх ажил байдаг юм даа. Тэгээд энд тэндгүй банк бусын зөвшөөрөл, янз янзын зөвшөөрлийн наймаа ер нь их явдаг шүү. Авлигаар зөвшөөрөл өгдөг асуудал байдаг шүү. Тэгээд энэ асуудал дээр онцгой анхаараарай гэдгийг бас хэлэх гэсэн юм.

Би яагаад энийг яриад байна гэхээр 1 дүгээрт би энэ Сонор гээд залуугаас асуух гээд байгаа юм л даа. Энэ ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ёстой юм. Хэвлэлээр яваад байх юм. Таныг энэ төрийн өндөр албан тушаалтан, хувьдаа банк бустай, хувьдаа даатгалын бизнестэй ийм хүнтэй хамаатан, ураг садны холбоотой гэсэн юм яваад байх юм. Энэ үнэн үү. Үнэн эсэхийг би тодруулчихмаар байна. Хэрэвзээ үнэн байвал банк бусын зөвшөөрөл өгөх хорооны шийдвэрт, даатгалын компанийн зөвшөөрөл өгөх хорооны шийдвэрт та хуулиар оролцох эрхгүй болно гэдгийг та мэдэж байгаа юу, үгүй юу гэдгийг асуух гэсэн юм.

2 дугаарт энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудлаар та бүхний байр суурийг сайн анхааралтай сонслоо. Би яг та 3-аас бол Саруул гэдэг бүсгүйгээр илүүтэй дэмжмээр санагдаад байна. Ерөөсөө яг хувийн хэвшлээс орж байгаа ганцхан хүн байна шүү дээ. Жижиг хувьцаа эзэмшигчдийн энэ эрх ашгийг хамгаална гэдэг маань үндсэндээ бол нээлттэй ХК-д бол 3 хороо байдаг юм. жишээлбэл Аудитын хороо, нэр дэвшигчийн хороо, цалин урамшууллын хороо гээд. Жижиг хувьцаа ажилчдыг яаж хамгаалдаг вэ гэхээр энэ үнэ хороонуудыг нь жижиг хувьцаа эзэмшигчдээр ахлуулах ёстой байдаг юм. Тэгж байж тэд нарын эрх ашиг хамгаалагддаг байхгүй юу. Аудитын хороог нь жижиг хувьцаа эзэмшигч ахалж, аль аудитаар компанийн үйл ажиллагааны тайланг нь шалгадаг болох вэ. Тэр тухайн захирлыг хэн сонгох вэ гэдэг дээр жижиг хувьцаа эзэмшигчид оролцдог байж байж жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагддаг юм. Цалин урамшууллын хороо дээр яагаад жижиг хувьцаа эзэмшигчид байх ёстой байдаг вэ гэхээр ТУЗ-ийнхөө даргад эсвэл гүйцэтгэх захиралдаа өнөөдөр бол асар их хэмжээний өндөр цалин тавьж, амлаж явж байж бас нэг буруу жишиг тогтоочих гээд байдаг асуудал бий. Яагаад би энийг яриад байна гэхээр өнөөдөр бид нар төрийн өмчит компаниудыг нээлттэй ХК болгох асуудал яриад байгаа юм. Өнөөдөр төрийн өмчит компаниудын захирлуудын цалин урамшуулал асар өндөр байна гэдэг асуудлыг яриад байдаг. Тэгээд тэр цалин урамшууллын уг нь нээлттэй ХК байвал жижиг хувьцаа эзэмшигчид тавьдаг байх ёстой. Шалгаруулдаг байх ёстой. Энэ асуудал дээр нь анхаарал хандуулаарай гэж. Тэгээд энэ асуултууд дээрээ хариу авчхаад, тэгээд эргээд тодруулъя.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Сонор хариулт өгье.

Л.Сонор: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хороонд нийт 6 гишүүн байдаг. Үүнийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2-оор зохицуулсан. Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Эдийн засгийн байнгын хороо 2 хүн, Хууль зүй болон Төсвийн байнгын хороо 1 хүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Сангийн сайд 1 хүн, Монголбанкны ерөнхийлөгч 1 хүнийг дэвшүүлж Их Хурлаар сонголт хийж томилно гэсэн заалттай.

Өнгөрсөн оны 12 сард Эдийн засгийн байнгын хорооноос энэхүү хуулийн заалтын дагуу нэр дэвшүүлэх албан бичиг ирсэн. Сангийн яам дотор миний эрхэлдэг ажил бол Санхүүгийн бодлогын газрын дарга. Сангийн яаманд сүүлийн 10 жил ажиллаж байгаа. Гэрээт ажилтан, мэргэжилтэн, хэлтсийн дарга өнгөрсөн жилээс Санхүүгийн бодлогын газрын даргаар. Тухай бүр нь сонгон шалгаруулалтад орж, ТАЗ дээр шалгалт өгч, дэвшиж ажилласан. Үүнтэй холбоотойгоор Сангийн яамны зүгээс яг энэ санхүүгийн салбарын асуудал нь өөрөө Санхүүгийн бодлогын газрын харьяанд байдаг тул эрхлэх ажлынхаа чиг үүргийн дагуу миний нэрийг нэр дэвшүүлсэн байгаа юм.

Таны асуултад хариулахад мөн улс төрийн хамаарал бүхий хүнтэй хамаатан садан холбоотой юу гэсэн. Үүн дээр бол үнэн. Миний хувьд Доржханд сайд бол миний аавын дүү, авга ах.

Гэхдээ би энэ дээр бас нэг хариуцлагатай мэдэгдэл хийх нь зөв байх. Яагаад гэвэл намайг энэ албан тушаалд нэр дэвшүүлэхэд ямарваа нэгэн хувь хүн улс төрийн намын квот, аливаа бүлэглэл бол ямар нэгэн байдлаар нөлөөлөөгүй гэдгийг би хариуцлагатайгаар бас хэлэхийг хүсэж байна.

Тэгээд Санхүүгийн зохицуулах хорооны хурлаар аливаа тусгай зөвшөөрөл өгөх асуудал дээр ББСБ, даатгалын асуудал орж ирсэн тохиолдолд би өөрийн саналаар татгалзаж, хорооны хуралд оролцохгүй гэдгээ бас мэдэгдэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төрд бас олон жил ажиллаж байгаа туршлагатай залуучуудаа төр бас чиг үүргийнх нь дагуу салбарын яамны бодлогоор байх ёстой томилгоонууд хийгдэж явдаг. Тэгэхээр ийм залуучуудаа бас бохир улс төртэй хутгаж, явцуу улс төр хийх 1 дүгээрт шаардлага байхгүй. Ер нь энэ төрд итгэх ард түмний итгэл гэдэг зүйл ийм зүйлээс эхэлдэг. Тэгэхээр гишүүд маань бас энэ дээр наанатай цаанатай бодох ёстой. Хуулиараа ер нь хамаарал бүхий этгээд гэдгийг эцэг эх, төрсөн ах дүү, хамтран амьдрагч, үр хүүхэд гэдэг агуулгаараа байдгийг манай гишүүд мэдэхийн дээдээр мэдэж байгаа байх. Тэгэхээр энэ хэвлэлээр явж байгаачлан шууд хамаарал бүхий этгээд юм уу, нэгдмэл сонирхолтой этгээд нь биш учраас Сангийн сайд Сангийн яамны квот дээр нэр дэвшүүлж ирсэн байгаа гэдгийг бас анхаарах нь зүйтэй гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Ганбат: Ингээд Санхүүгийн зохицуулах хорооны гишүүдийн нэрс орж ирж байна. Яах вэ би хэн нэг хүнийг нэр зааж, янз бүрийн юм яриад яах вэ. Гэхдээ энэ улс орон бизнесийн орчин ямар байна вэ л гэдэг нь харагдаад байна л даа. Энэ

Санхүүгийн зохицуулах хороо нь энэ 3 нөхрийн анкетыг нь харлаа. Үгүй ээ, тэгээд энэ хувийн хэвшилд ажиллаж байсан тийм хүмүүс байхгүй л юм байна шүү дээ энэ дотор чинь. Би лав олж харахгүй байна. Өөрсдөө хариулна биз. Ямар юманд ажиллаж байсан юм. Яаж щ байсан гэдгээ. Тэгээд олигтой компаниуд гарч ирэхгүй, ард түмний амьдрал дээшлэхгүй энэ тэр байгаа юм л даа. Тэр тусмаа төрийн албаараа дамжиж бариад л ах дүүгээрээ орчихоор жишээлбэл хөдөө орон нутагт бол малчид бол хамгийн өндөр хүүтэй зээл авч байна шүү дээ. Тэгээд мал нь төрийн хамгаалалтад байдаг гэсэн. Тэр нь яг тэр зээлийн юу хангадаггүй гэдэг утгаараа олон жил өндөр хүүтэй зээл авч, амьдрал нь маш муудаж байна. Энийг та нар мэдэх юм уу, мэдэхгүй юм уу. Ингэж ажиллаж чадах юм уу, үгүй юм уу. Тэгээд ярихаараа бол шал өөр юм. Бид нарыг гадаадад бараг 200, 300 мянган доллароор ажиллуулах гээд байна. Бид нар ийм сайхан эх орончид болохоор цалин хөлсгүй ажиллах гээд байна гэсэн юм яриад байдаг. Энийг нь харахаар цэргийн алба хаасан хүн ерөөсөө алга. Тэгээд ярьж байгаа юмтайгаа нийцэхгүй байна л даа. Тэгээд та нар маань цалинтай ажилладаг юм уу, цалингүй ажилладаг юм уу. Өчигдөр би тэр Хууль зүйн байнгын хороо дээр суусан чинь зарим хүмүүс би цалингүй ажиллах гэж байгаа гэж ярина лээ. Тэгээд энэ чинь ийм юм чинь нийцэхгүй шүү дээ.

Нөгөө талаараа энэ чуулган дээр үг хэлэх ховорхон боломж тохиолдох юм. Тэгээд энэ Засгийн газар маань хамгийн эрх мэдэлтэй, хамгийн удаан жил ажиллаж байгаа ийм Засгийн газар л даа. Үгүй ээ, энэ гадаа гарахаар хүмүүсийн амьдрал энэ тэр бол хүнд байна. Энэ хэдэн Засгийн газрын гишүүд ч юм уу, дарга нарыг тойрсон хүмүүсийн амьдрал сайжраад байх шиг байна. Тэгээд тэрийг нь хэлээд Үндсэн хуульд заасныхаа дагуу жагсаж байгаа тэр эмэгтэй хүнийг ямар их гутаан доромжилж байна.

Ийм байвал энэ Засгийн газартай би хариуцлага тооцно шүү. Ямар ч байсан нэг жил хүлээе гэж бодсон байхгүй юу. Тэгсэн чинь энэ Чингис хааныхаа ард талд бид нар нуугдаад суугаад байдаг. 126-уулаа болчихсон мөртөө. Эзэн хааны өмнө Эзэн хааны талбай дээр энэ Монгол хүний чинь энэ эрүүгийн элементүүдтэй нийлчихсэн фашистууд, нацистууд. Гитлер ингэж л гарч ирсэн байхгүй юу даа. Хэдхэн жилийн өмнө 5, 6 жилийн өмнө Сүхбаатарын талбай дээр одоо бол Чингисийн талбай дээр хэчнээн ч гэр бариад, тэр Эрдэнэс Тавантолгойн тэр захирал нь би санхүүжүүлж байсан гэж яриад байгаа. Тэгж жагсаж байсан шүү дээ. Өнөөдөр иргэн хүн гарч ирээд талбай дээр яагаад энэ утаа агаар чинь ийм байна. Би ээж болох гэж байгаа хүн. Хүүхэд гарахад олигтойхон газар төрж болохгүй юу гэсэн ийм юм хэлж яагаад болдоггүй юм бэ. Энийг яагаад ингээд хаагаад боогоод байдаг юм бэ. Яг үүнээс эхлээд л бид нар дарангуйлал руу явж байгаа байхгүй юу.

Улсын Их Хурлын чуулган магадгүй маргааш нөгөөдрөөс завсарлах байх. Битгий хэд хоноод ирэхэд энэ талбайг Монгол хүний цусаар бялдчихсан байгаарай даа. Бид нар ардчилсан хувьсгалаа хийхдээ бол оготнын хамраас цус гаргаагүй хийсэн ийм Монголын ард түмэн шүү. Ийм ард түмэн байгаа. Энийг одоо энэ засаг төрийн үед ийм болгочхов. Эцсийн эцэст энэ ардчилал, энэ Үндсэн хууль, хууль дээдлэх бол энэ улс орны баталгаа, тусгаар тогтнолын баталгаа ийм л зүйл шүү дээ. Үүний эсрэг яваад байна шүү.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигчид хариулт өгье. Лувсандоржийн Сонор нэр дэвшигч хариулт өгье. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

Л.Сонор: Ганбат гишүүний асуултад хариулъя. Миний хувьд сүүлийн 10 жил Сангийн яаманд Өрийн удирдлагын хэлтэст мэргэжилтэн, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, ингээд Санхүүгийн бодлогын газрын даргаар ажиллаж байгаа.

Хийсэн ажлын туршлагын хувьд бол Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн банкны олон улсын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татах, санхүүжилт татах бондын арилжаанууд дээр бас зохион байгуулалтыг хийж ажилласан туршлагатай. Нэн ялангуяа хугацаа тулсан томоохон өр төлбөрүүд дээр мөн төлбөрийн тэнцэл дээр томоохон дарамт ирэх үеүд дээр өрийн зохицуулалтыг хийх ажлыг бас ахлан ажиллаж байсан. Мөн Монгол Улс саарал жагсаалтад ороход 2019 онд саарал жагсаалтаас гарах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, ФАТФ-ын хууль дүрэм журмын хэрэгжилтийг сайжруулах, мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай болон ЭХХШТХ зэрэг багц хуулиудыг төслийг боловсруулж, Их Хурлаар өргөн барьж батлуулж байсан. Улмаар ФАТФ-ын шалгалтаар тодорхой бас хамгаалах ажлуудыг тайлан бэлтгэлийг хангаж, хамгийн богино хугацаанд бусад улс орнуудын түүхэнд бол хамгийн богино хугацаанд тус жагсаалтаас гаргаж байсан.

Мөн сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хариуцаж ажилласан. Үүн дээр 2020 оноос ковид болон дайны хүнд нөхцөл байдалд ороход зээлжих зэрэглэлийг бол маш олон улс орнууд унаж байсан. Тэр үед яг үндсэн метрикээрээ Монгол Улсын зээлжих зэрэглэл бас унах өндөр эрсдэлтэй байсан. Тухайн үед бас тайлан дээр маш их тулж ажилласны үр дүнд бол амжилттай хамгаалж, өнгөрсөн жил Мүүдиз агентлагийн В3 байсан зэрэглэлийг В2, фюч агентлагийн В тогтвортой байсан зэрэглэлийг В+, Эс Эм Пи агентлагийн В байсан зэрэглэлийг В эерэг болгож сайжруулахад бас ажилласан юм.

Мөн холбогдох салбарын гол хуулиуд дээр ажилласан. Үүнд бол Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль зэрэг хуулиудын ажлын хэсэгт орж заримыг нь ахалж ажилласан туршлагатай.

Мөн олон улсын байгууллагуудтай гэрээ хэлцэл хийх, олон улсын зээл авахад чип нэго шэйтерийн түвшинд бас ажилласан туршлагатай байгаа юм.

Та бас зээлийн хүүг бууруулахад бас анхаарал хандуулах хэрэгтэй гэдэг дээр хэлж байна. Би бас 100 хувь санал нэг байна. Үүн дээр хамгийн гол нь бас макро тогтвортой орчин макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Мөн урт хугацаат бонд болон өрийн хэрэгслийн зээлийн хүүг бууруулахад суурь хүүгийн асуудал бас хөндөгддөг. Монголбанкны бодлогын хүү бол өөрөө банкны салбарын богино хугацаат мөнгөний захын суурь хүү болж байдаг бол Засгийн газрын дотоод болон гадаад бондууд нь урт хугацаат хөрөнгийн зах зээлийн хэрэгслүүдийн суурь, хүү, хүүгийн түвшнийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Булганы Саруул хариулт өгье.

Б.Саруул: Гишүүний асуултад хариулъя. Бизнесийн орчны талаар мэдлэг мэдээлэлтэй байна уу гэдэг талаар асуулаа. Тэгэхлээр миний бие брокер дилерийн компанид ажиллаж байсан туршлагатай. Энэ утгаараа бол хорооны зүгээс бас мэргэжлийн компаниудад хэрхэн хандаж байдаг вэ, ямар шаардлага тавьдаг тал

дээр бол маш сайн мэднэ. Тэгэхээр энэ дээр бас цаашдаа түрүүний гишүүдийн хэлсэнчлэн элдэв хяналт шалгалт, дарамт, хүнд суртлын бууруулах тал дээр илүү анхааран ажиллана.

Мөн бодлогын өмгөөллийн түвшинд МҮХАҮТ-д ажиллаж байсны хувьд бол энэ дээр бас харин их зүй зохистой синержи буюу бидний ажилд их нийцэл гарах юм байна гэж харж байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр бас анхааран ажиллана.

Ажлын хөлсний тухай бас 2 дугаар асуулт тавигдлаа. Тэгэхээр энэ бол хууль журмын дагуу юу гэж заасан түрүүгээрээ явна гэж харж байгаа. Баярлала.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон. Нэр дэвшигч Хандсүрэн хариулна.

Ш.Хандсүрэн: Миний бие Монголбанкны хяналт шалгалтын чиг үүрэг бүхий ажлыг Монголбанканд сүүлийн 15 жилийн турш хийж байгаа. Энэ хугацаандаа Хянан шалгагч, ахлах хянан шалгагч, хэлтсийн захирал, албаны даргаар дэвшиж ажилласан байгаа. Цалин урамшууллын тухай асуудлыг нарийн зохицуулалтыг нь сайн мэдэхгүй байна. Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм дээр энэ тухай журмыг хороо баталж, мөрдүүлэх тухай заалтад заасан байсан. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Ийм л болчихоод байгаа юм даа. Тэгээд асууна. Хариулж байгаа нь ийм л байна. Ер нь тэгээд хэн ч олигтой хариулт хэлж чаддаггүй шүү дээ. Энэ Улсын Их Хурал дээр ийм л байгаа байхгүй юу. Тов тодорхой асуулт асуусан. Тэр малчид яагаад өндөр хүүтэй зээл авдаг юм бэ гэж. Тэгээд Үндсэн хууль дээрээ мал төрийн хамгаалалтад байна гэхихсэн. Тэр талаар асуугаад хариулж байгаа нь энэ. Энэ орон тооны бус гишүүн гээд байгаа байхгүй юу. Тэгээд баахан төрийн албанд тэгж тэгж ингэж ажиллаж байсан гээд түрүүгээрээ л гайхуулаад байх юм. Энэ хувийн хэвшил гэж байхгүй юм уу. Энд оччихоод тэгээд хувийн хэвшлийнхнийг дарамтлаад, бизнесийг хаагаад, тэгээд энэ залуучууд ч гэсэн ингэж орж ирж байгаа нь ерөөсөө хувийн хэвшилд ажиллах орон зай байхгүй болчихсоны л илэрхийлэл байхгүй юу. Бид нар эндээс ийм дүгнэлт хийх ёстой. Энэ Улсын Их Хурал бол ийм... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбат гишүүнтэй санал нэг байна. Банкны хүү, ББСБ-аас бас олгогдож байгаа зээлийн хүү зэрэг бол иргэдийн орлого, иргэдийн хийж байгаа бизнест бол нийцэхгүй өндөр хүүтэй байгаа гэдэгтэй санал нэг байгаа. Энийг Улсын Их Хурал хууль, эрх зүйн орчинд нь сайжруулалт хийх замаар зээлийн хүүг бууруулах алхмуудыг хийнэ. Энэ дээр шинээр сонгогдож байгаа Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүд, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүд, Монголбанкны мөнгөний бодлогын хорооны гишүүд, өнөөдөр энэ томилогдож байгаа орон тооны болон орон тооны бус сонгогдсон нөхдүүд бүгд идэвхийлэн ажиллах ёстой. Яагаад идэвхийлэн гэж хэлж байгаагийн учрыг бас та бүхэн зөв тунгаагаарай.

Өмнөх гишүүдийн хугацаа дуусаад хэд хэдэн жил болсон мөртөө Их Хурал өөрчилж шинэчлээгүй. Сонгогдсон орон тооны бус гишүүд ажилтай, ажил хариуцаж байгаа, хариуцахгүй байгаа нь тодорхойгүйгээр асуудал ужгирсан байгаа учраас өнөөдөр эдгээр орон тооны бус гишүүдийг томилох ажлыг цогцоор нь нэг мөр хийж

байгаа юм. Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнадаг эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа идэвхтэй ажиллах ёстой. Хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэдэг байх ёстой. Улсын Их Хурлын гишүүд амаа хаттал энэ асуудлыг ярьдаг. Харамсалтай нь гүйцэтгэж байгаа байгууллагууд дээр очихоороо шийдэгддэггүй уддаг. Тэгээд цаана нь хуулиар зохицуулалт хийсэн нэрийн доор иргэдийн эрх ашгийг маш ихээр зөрчиж байна. Их Хурал мэдээж хүний эрх, эрх чөлөө, бизнесийн эрх, эрх чөлөөг дэмжих чиглэл дээр ажиллаж байна.

Нөгөө талдаа өнөөдөр энэ хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэл дээр бас онцгой анхаарч ажиллана. Яагаад өндөр хүүтэй зээл авч амьдраад байгаа юм. Яагаад бизнесийн зориулалттай зээл нь 18 хувьтай байхад, хэрэглээний зориулалттай малчны зээл, тэтгэврийн зээл, цалингийн зээл 24 хүртэл хувьтай олгогдоод байгаа юм. Яагаад арилжааны банкнууд урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл өгөхөөсөө татгалзаж, богино хугацаатай, өндөр хүүтэй хэрэглээний зээл дээр төвлөрч ажиллаад байгаа зэрэг асуудал дээр Улсын Их Хурал онцгой анхаарч ажиллана гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох санал хураалт явуулна. Хүн нэг бүрээр санал хураалт явагдана. Ирц бүртгэлийн санал хураалт явуулах шаардлагатай юу. Гайгүй байна.

Булганы Саруулыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт 55 гишүүн буюу 61,1 хувиар дэмжигдлээ.

Лувсандоржийн Сонорыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 39 гишүүн буюу 43,3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Тамгын газар энэ яах билээ. Сангийн сайд.

Б.Жавхлан: Би тайлбар хэлчихэд би хариуцлагагүй өөрөө хариуцлагагүй яачихлаа. Санал өгч чадсангүй. Санал хураалтад оролцож чадсангүй. Тэгээд энийг дахин санал хурааж өгөөч. Болох уу.

Д.Амарбаясгалан: Тамгын газраас энэ дээр тайлбар өгөөч. Санал хураалт дээр горимын санал гаргах боломжтой эсэх талаар тайлбар авъя. Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ариунхур дарга тайлбар өгье. Ариунхур дарга. Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон.

Ч.Ариунхур: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан горимын санал гаргаж болно. Энэ асуудлаар хуралдаан даргалагч санал хураалгах эрхтэй. Нууц санал хураалт явуулсан тохиолдолд тухайн гишүүний яг санал хураалтад оролцсон эсэх асуудал бас нууцлалтай байгаа учраас Улсын Их Хурлын гишүүн өөрөө энэ талаар горимын саналдаа дурдаад, энэ асуудлаа өөрөө батлах үүрэг хүлээх байх.

Д.Амарбаясгалан: Яах вэ, энэ юу л даа. Нөгөө горимын санал гаргах нь өөрөө Улсын Их Хурлын гишүүн дэгийн тухай хуулиар хүлээж байгаа эрхийн асуудал байдаг. Энийг харин дэмжих эсэх нь гишүүдийн өөрсдийн асуудал. Тийм учраас горимын санал гаргалаа гэж буруутгаж бол болохгүй байх.

Зүгээр Жавхлан сайд өөрөө учир шалтгаанаа түрүүн дурдсан учраас Жавхлан сайдын горимын саналаар санал хураалгая. Жавхлан сайдын гаргасан горимын саналаар дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 41,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Шагдаржавын Хандсүрэнг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн. Саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 гишүүн буюу 61,1 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээс чөлөөлөх санал хураалт явуулна.

Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Баасанжавын Батхишиг, Нямдэлэгийн Мандуул, Баярсайханы Баярдаваа нарыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя. Нууц санал хураалт. 55 гишүүн буюу 61,1 хувиар санал дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх асуудлыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул” Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

12.25 цаг.

Дараагийн асуудалд оръё. **Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Нэр дэвшигчдийн талаар гаргасан Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн танилцуулна. Индэрт урьж байна.

С.Цэнгүүн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн нэр дэвшигчийг бүртгэх тухай 5 дугаар тогтоолын дагуу зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргад Мягмарсүрэнгийн Буяндэлгэр, гишүүнд Оюунтөгсийн Оч, Болдбаатарын Энхбаяр нарын нэрийг дэвшүүлсэн болно.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 3 дугаар тогтоолыг баталсан Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу нэр дэвшигчид нь өөрийн

танилцуулга, холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлж, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу Эдийн засгийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай тогтоолыг баталж, 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддоржийг томилсон.

Эдийн засгийн байнгын хорооноос 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан нэр дэвшигчийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батшугар, Ганхуяг, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг, Цогтбаатар, Эрдэнэбат нарын гишүүд оролцсон болно.

Байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх сонсголын тайланг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гарган танилцуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргаар Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг, тус зөвлөлийн гишүүнээр Оюунтөгсийн Оч, Болдбаатарын Энхбаяр нарыг томилуулах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Равсалын Ренчинбазарыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас, Батболдын Амарсанаа, Дүгэрээгийн Цэрэнбадам нарыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэнгүүн гишүүнд баярлалаа. Нэр дэвшигчдийн талаар гаргасан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

У.Отгонбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүдэд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос 2 хүний нэр дэвшүүлнэ гэж 29.2-т

Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө гэж, 29.4-д Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр Эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэшсэн ажлын туршлагатай эрх зүйн хувьд төлөвшсөн Монгол Улсын иргэнийг томилно гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчидтэй холбогдуулан Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол явуулна. 30.1.1 Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол гэж, 30.3-д нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо явуулна гэж, 30.4-д нэр дэвшигчийн сонсгол явуулахад хууль, Монгол, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтална гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй байдлаар мэдээлж, хүсэлт материалыг 2024 оны 12 сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаанд хүлээн авсан бөгөөд тус хуралдаанд 4 хүн материалаа ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хүсэлт материалыг хүн тус бүрээр хэлэлцэж, Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар Чимэдийн Сайнбилэг, Соронзонболдын Халиунаа нарыг нэр дэвшигчийн сонсголд оролцуулахаар сонгож, нэр дэвшигчдийн сонсголыг 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан болно.

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа нэр дэвшигчийн сонсголын тайлан болон Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тус асуудлыг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар ББСБ-д иргэдийн хэрэглээг дэмжсэн зээл олгох олголт биш, бизнесийн үйл ажиллагааг дэмждэг болгоход хэрхэн анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшсэн үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нэр дэвшигчийн урд ажиллаж байсан байгууллагын талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг нээлттэй болгож иргэд, аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах чиглэлд санаачилгатай ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал хорооны зүгээс хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар ББСБ-ууд аппликэйшн ашиглаж, иргэдэд өндөр хүүтэй, барьцаагүй зээл олгож байгааг анхаарч ажиллах болон Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Заяабал өмч хувьчлалын цэнхэр, ягаан тасалбар, крипто валютын асуудлаас болж Монголын хөрөнгийн зах зээлд итгэх иргэдийн итгэл буурсан бөгөөд энэ тал дээр анхаарч ажиллах мөн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулах, цаг үеийн шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлаас томилогдон очиж байгаа албан тушаалтнууд хуулийн хүрээнд далайцтай ажиллах бүрэн боломжтой

бөгөөд идэвх санаачилгатай ажиллаж, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг цаг үеийн шаардлагад нийцүүлж ажиллах талаар үг хэлэв.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулсан бөгөөд нэр дэвшигч Чимэдийн Сайнбилэг, Соронзонболдын Халиунаа нарыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилуулах нь зүйтэй гэж үзсэн.

Нэр дэвшигчид дэмжигдсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь дууссан Жадамбаагийн Эрдэнэбилэгийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Отгонбаяр гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Мягмарсүрэнгийн Баяндэлгэр, Отгонтөгсийн Оч, Болдбаатарын Энхбаяр, Чимэдийн Сайнбилэг, Соронзонболдын Халиунаа нар хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хороодын санал, дүгнэлт болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 7 гишүүн, 11 гишүүнээр тасаллаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд энэ санхүүгийн сектор бол бас эрүүл байж байж, хяналттай байж байж бас олон ажлын байр буюу ер нь эдийн засгийг солонгоруулах чиглэл маань энэ чиглэлдээ л явж байгаа. Тэгээд өнөөдөр бас Улсын Их Хурлынхаа гаргаж байгаа шийдвэрт хүндэтгэлтэй байна. Олонхоороо шийдэж байгаа. Тэгэхдээ 1 зүйлийг бас бодмоор байна. Ер нь зүгээр ашиг сонирхлоо бас ил тод ярьж байгаа, энэ дээрээ ашиг сонирхол гаргахгүй байхад л анхаарах ёстой.

Тэгээд Монгол Улсыг бас олон удаагийн томоохон арга хэмжээ дээр жишээ нь авч явж байсан залуу байхгүй юу. Энэ өмнө нь үүсгэсэн энэ бүх өрийн бонд өрнүүдийг бондуудыг чинь хямд эх үүсвэрээр солих, энэ хэлэлцээрийг олон улсын зах зээл дээрээс хямд эх үүсвэр олж ирэх, дээрээс нь энэ төсөвт дарамт учруулахгүйгээр энэ бондын өрнүүдийг чинь цэгцлэх ажил дээр Монгол Улсыг ФАТФ-ын хар саарал жагсаалтаас гаргах ажлыг яг энэ хэлэлцээр дээр нь олон улсын байгууллага дээр төлөөлж очоод, Монгол Улсынхаа эрх ашгийн төлөө явж байсан ийм залуучуудыг жишээ нь ийм зүйлээр ингээд мухарлаж сая ингээд л

гаргаж л байна л даа. Тэгээд яах вэ, зүгээр би гишүүдийнхээ олонхын саналд хүндэтгэлтэй байна. Бодох л ёстой. Энэ бодож байгаа шиг харин энэ дотор орж ирж байгаа зарим хүмүүс дээр бодоорой. Би ялангуяа Хууль зүйн байнгын хороо дээр хэлсэн. Одоо хэлмээр санагдчихлаа. Уг нь дуугүй байж бай гэж бодсон юм.

Өнөөдөр өөрийнхөө намтар дээр ажилласан байгууллагаа бичиж чадахгүй байгаа хүмүүс энэ дотор орж ирчихсэн байгаа шүү дээ. Би асуусан. Энэ Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр дэвшиж байгаа хүн өөрийнхөө ажилласан юун дээр Би Би Эс Вэлт ББСБ дээр ажиллаж байснаа бичиж чадахгүй, Төрийн банк дээр ажиллаж байснаа бичиж чадахгүй. Та яагаад энийгээ бичдэггүй юм гэхээр маягт нь угаасаа гуравхан нүдтэй юм байна лээ. Багтахгүй байхаар нь бичээгүй. Ингэж хариулт өгөөд бодлогын хэдэн асуулт асуухад, асууж чадахгүй, хүний асууж байгаа асуултыг тэмдэглээд авчаж чадахгүй ийм хүмүүсийг бид нар томилж явуулах гэж байж, чадвартай залуучуудаа ингэж шоглож янз янзын байдлаар ингэдгээ болих хэрэгтэй. Тэгээд бодно биз. Энэ дээр тэр Ч.Сайнбилэг та хариул. Яагаад намтар дээрээ та ажилласан байгууллагаа бичиж чадахгүй байгаа юм бэ. Танд ямар эрх ашиг байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Аль микрофон байна.

Ч.Сайнбилэг: Миний хувьд Би Би Эс Вэлт ББСБ-ыг 2009 онд үүсгэн байгуулаад, 2012 он хүртэл ажиллаж байгаад, худалдах, худалдан авах гэрээгээр өөр өмчлөгчид шилжүүлж өгсөн байгаа. Тэгээд гол асуудал яагаад бичээгүй орхигдсон бэ гэхээр үнэхээр гараараа анкетыг бичих тухайн үед бол нөхцөл байдалтай байсан юм. Компьютер дээр нээгээд нэг таб доошоо явуулаад оруулах боломж байсан боловч цаг хугацааны хувьд бол үнэхээр амжаагүй.

Тэгээд миний хувьд юу гэж бодож, зорьсон бэ гэхээр энэ нээлттэй сонгон шалгаруулалтад өөрийгөө нэр дэвшүүлэхдээ гол нь урт хугацаанд ажиллаж байсан гол төвлөрч ажиллаж байсан ажлуудаа бичиж тэмдэглэж оруулсан байгаа.

Төрийн банк банкны хувьд бол би 6 сарын хугацаатай ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байсан юм. Тэрнээс миний хувьд бол энэ нэр дэвшилтэд ороод хэрвээ энэ албан тушаалд сонгогдож ажиллалаа гэхэд ямар нэгэн сонирхлын зөрчилгүйгээр, бусдын нөлөөнд автахгүйгээр, өөрийн итгэл үнэмшлээрээ ажиллах болно.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Ийм л зүйл дээр хандаж байгаа хүний хандлагыг нь та нар харж байгаа байх. Тэгчхээд бид нар үнэхээр боловсролтой, Монгол Улсын төлөө зүтгэж явсан залуучуудыг тал талаас нь бөөрөлхөж, шоглочхоод ингэж цаг хугацаа байгаагүй. Юу яриад байгаа юм бэ. Хэнийг доромжлоод байгаа юм. Улсын Их Хурлын босго тийм намхан болчихсоныг та нар илтгээд байгаа юм уу. Өөрийгөө ийм чухал албан тушаал дээр бэлтгэж орж ирж чадахгүй байгаа хүн бусдын төлөө ажиллаж чадахгүй. Харин энэ удаагийн яах вэ юман дээр ний нуугүй хэлэхэд бас нэг ойлголцлын юмнууд явж байгаа учраас чимээгүй байя гэсэн ийм зүйлүүдийг харин хандаж байгаа бол бас энэ залуучуудынхаа өмнөөс дуугарна. Чаддаг залуучуудыг нь тавихын төлөө би дуугарна. Та зүгээр боль за юу. Би гишүүдэд ийм хүмүүс дээр дэмжиж битгий саналаа өгөөрэй гэж хүсэж байна. Энэ өөрийнхөө

ажилласан юмаа нуудаг, тэгээд ийм хариулт өгдөг. Бодлогын 2, 3 хууль, эрх зүйн юман дээр ямар байр суурьтай гэхээр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Нэр дэвшигч нартаа амжилт хүсье. Тэгээд бас чадварлаг залуучууд орж ирж байна. Сайнзориг гишүүний хэлж байгаа бас үнэн. Сонортой холбоотой асуудал ч гэсэн. Тэгээд Мягмардоржийн Баяндэлгэр Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшигч байна.

Монгол Улс бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал бодлогоо баталсан. Энэ бүсчилсэн хөгжлийн бодлого үзэл баримтлалын хүрээнд бас өнөөгийн парламент бүрдээд Монгол Улсын Засгийн газар энэ чиглэл дээр бол 14 мега төсөл хэрэгжүүлэхээр бас ингээд томоохон арга хэмжээг аваад ажиллаж байгаа. Санхүүгийн зохицуулах хороо хэдийгээр Хяналтын Зөвлөлийн дарга боловч Буяндэлгэр маань бас энэ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бодлого дээр маш өргөн цар хүрээтэй сууж ажиллаж байсан одоо би тухайн үед бас сайдаар ажиллаж байсан хүний хувьд энийг цохон тэмдэглэж хэлэх нь зөв болов уу гэж бодож байна. Маш сайн ажиллаж байсан. Одоо бид нар энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал маань 2024 оны Улсын Их Хурлын 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдаад явж байгаа. Бид нар энийг хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангахад тулгамдаж байгаа санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянах чиглэл дээр хорооноос хийж хэрэгжүүлж байгаа ажлыг бас чиглүүлэх шаардлагатай үйл ажиллагаанд нь хяналт тавих шаардлагатай байгаа гэж харж байгаа. Тэгээд энэ Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшиж байгаа гишүүдийг бол дэмжиж байна. Буяндэлгэр даргаас бол Хяналтын зөвлөлийн энэ хараат бус байдлыг хэрхэн цаашид авч явж ажиллуулах вэ гэдэг нэг ийм асуултыг асуух гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Буяндэлгэр хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Д.Буяндэлгэр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлд нэр дэвшигч Буяндэлгэр Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Санхүүгийн зохицуулах хороо маань Улсын Их Хурлаас баталсан бодлогыг хэрэгжүүлдэг ийм байгууллага байгаа. Тэгэхээр энэ бодлогын хэрэгжилтэд нь Хяналтын зөвлөлийн хувьд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс хяналт тавьж ажилладаг. Ингэхдээ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагаагаа хараат бусаар гишүүдийнхээ олонхоор хуралдаан хэлбэртэйгээр үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг ийм байгууллага. Тэгэхээр манай зөвлөлийн хувьд Улсын Их Хурлаас баталсан бодлогын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн хувьд хуралдаан хэлбэрээр гишүүд өөрсдийнхөө хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хяналт тавьж, хуралдаан дээр саналаа өгч олонхоороо шийдэж явна. Тэгээд энэ байдлыг хангаж ажиллана.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

А.Ариунзаяа: Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлд удирдлага, гишүүдээр дэвшиж байгаа бүх залуучуудыг дэмжиж байна. Сая мэргэжлийн Байнгын хороо ажиллаад маш олон асуулт хариултад суурилж дүгнэлтээ гаргаж, та

хэд маань чуулганд орж ирж байна. Тэгэхээр мэргэжлийн Байнгын хороодоо итгэж, мөн анкетуудыг нь харж, өмнөх түүх, туршлагыг нь харж, бүгдийг нь дэмжиж байгаагаа илэрхийлье.

Санхүүгийн зах зээлийн 3 тулгууртай байгаагийн 2 тулгуурыг нь хариуцдаг. Банкны салбар, даатгалын салбар, хөрөнгийн зах зээл гээд 3 тулгууртай гэж үзэх юм бол 2 нь Санхүүгийн зохицуулах хороо хариуцдаг. Банк бусууд бас Санхүүгийн зохицуулах хороонд ордог. Санхүүгийн зах зээл маань 95 хувь нь банкны салбар эзэлсэн байгаа нь өнөөдөр Санхүүгийн зохицуулах хорооны ажил хэчнээн сайжрах ёстойг илтгэж байгаа юм. Хяналтын зөвлөл маань Санхүүгийн зохицуулах хорооны зөвхөн хянах бус харин зөвлөн туслах үйлчилгээг, зөвлөн туслах үйл ажиллагааг бас сайн явуулах ёстой шүү гэдгийг захиж хэлье.

Хамтын ажиллагаа ямар түвшинд бас энэ Улсын Их Хурлын гишүүдтэй байх ёстой вэ гэхээр Эдийн засгийн байнгын хороонд харьяалагддаг учраас Эдийн засгийн байнгын хорооны гишүүдээ байнга мэдээлэлжүүлж, яг энэ хяналтын чиг үүргээ зөв зөвлөн туслах чиг үүргээ маш сайн хэрэгжүүлээрэй гэж захъя. Би түрүүн нэг асуулт асууж байгаад хамааралгүй гэж хэлүүлсэн учраас энэ даатгалын салбартаа анхаараарай гэж захъя. Тухайн дүрэм журам гарахаас өмнө хуульд нийцэж байгаа юм уу, үгүй юу. Хуульд нийцсэн байгаа ямар нэгэн улс төрийн нөлөөллөөр өөрчлөхгүй байхыг анхаарах, хамгийн гол нь иргэдийгээ бас мэдээлэлжүүлэх, мэргэжлийн оролцогчдын саналыг авч, яг энэ салбараа зах зээлийнх нь журмаар нь хөгжүүлэх тал дээр бас анхаараарай гэж хүсье.

Тэгээд хамтран ажиллахад бас бэлэн байгаа шүү гэдгийгээ илэрхийлье. Амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд шинээр сонгогдох гэж байгаа хүмүүсээс бас үг хэлэх ийм зүйл байна. Би ялангуяа энэ Санхүүгийн зохицуулах хорооны гол бодлогын салбарын олон гол асуудлуудыг бас манай гишүүд хэлсэн учраас давхардахгүй байдлаар ганц зүйлийг хэлье гэж ингэж бодож байгаа юм. Энэ юу гэвэл Санхүүгийн зохицуулах хорооноос 10 сард нөгөө жолоочийн албан даатгалын итгэлцүүрийг нэмэгдүүлэх асуудлаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд нөгөө нийтээр дагаж мөрдөх журмын жагсаалтад оруулахаар санал хүргүүлсэн юм билээ. Тэгээд Хууль зүйн сайдын эрх, үүргийн хүрээнд энийг хянаж үзээд, бүртгүүлээгүй л дээ. Бүртгэж аваагүй. Бүртгэж аваагүй шалтгаанаа хэлэхдээ 1 дүгээрт Үндсэн хууль зөрчсөн байна. 2 дугаарт бичиг баримтын бүрдэл дутуу. 3 дугаарт нөхцөл байдлын нөлөөллийн мэдүүлгийг бодит байдалд нийцүүлээгүй гэдэг. Үндсэндээ ийм 3 шалтгаанаар Хууль зүйн сайд бүртгээгүй юм байна лээ.

Тэгээд яагаад энийг ингээд албан журмын даатгал гэдэг бол тухайн хүн сонголтоороо биш зайлшгүй даатгуулах ёстой болчихдог. Тэгээд зайлшгүй даатгуулах ёстой энэ даатгалын хөдөлгөөнийг хийхдээ Хууль зүйн яаманд бүртгүүлэхгүйгээр нийтэд мэдээлж, нийтийн бухимдлыг бүр төрүүлж ийм зүйл хийв. Энэ дээр би шинээр томилогдож очих Хяналтын зөвлөлийн дарга энэ хүмүүс бас би анхаарч ажиллаасай билээ гэж ингэж бодож байгаа юм. Нэг дэх асуудал.

2 дахь асуудал яах вэ би энэ албан журмын даатгалтай холбоотой асуудал дээр ер нь Их Хурал бол ингээд нэг томилоод явуулдаг. Тэгэхээр энэ Санхүүгийн зохицуулах хороо энэ албан журмын даатгал буюу иргэд зайлшгүй даатгуулж байгаа энэ автын даатгалын асуудлууд гээд энэ асуудлууд дээр бас онцгой анхаарч, нийтийн эрх ашиг хаана хөндөгдөх гээд байна. Үнэхээр бодитой юм уу, бодит бус юм уу гэдгийг бас нэг ялгаж салгадаг тэр талаарх мэдээллийг холбогдох Байнгын хороонууддаа өгдөг. Байнгын хороогоор дамжиж Их Хуралд бас мэдэгддэг байхгүй бол энэ олон даатгалын компаниуд албан журмын даатгал руу гол анхаарлаа хандуулдаг, бусад даатгал руу бас төдийлөн даатгалын шинэ үйлчилгээнүүд нээдэггүй ийм бодит зүйл бол бас байгаа шүү гэдгийг бас би хэлье.

Ер нь энэ албан журмын даатгалтай холбоотой асуудал өнгөрсөн 2020-2024 оны парламентад бас нэг бөөн асуудал болж байсан. Ингээд одоо сая бас бөөн асуудал болж байна. Яагаад албан журмын даатгалын асуудал ингэж үе үе босож ирдэг юм бэ. Үнэхээр тийм зайлшгүй .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Идэрбат гишүүн үг хэллээ. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ө.Шижир: Санхүү зохицуулах хорооны Хяналтын зөвлөлд нэр дэвшиж байгаа хүмүүст амжилт хүсье. Ер нь бол санхүүгийн боловсрол олгох тал дээр та хэд маш сайн анхаарч ажиллахгүй бол уг нь бол энэ санхүүгийн боловсрол олгох чиг үүрэг чинь бол Монголбанканд байгаа. Хадгаламжийн даатгалын корпорацад байгаа. Санхүүгийн зохицуулах хороонд байгаа. Тэгсэн мөртөө энэ санхүүгийн боловсрол олгох тал дээр нь маш их учир дутагдалтай. Яагаад учир дутагдалтай вэ гэхээр 2024 оны 3 дугаар сарын байдлаар жилийн дундаж хүү нь, сарын дундаж хүү нь 3,5, хувийн хүүтэй зээл 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 5,2 их наяд. Зөвхөн банк бус болон аппликэйшнууд дээр. Оны эцсээр 7 их наяд болчихсон. Өндөр хүүтэй. Тэгэхээр энэ юмнууд дээр бас та хэд анхаараарай.

2024 оны эхний 6 сарын байдлаар гэхэд зөвхөн аппликэйшний зээлд 1 тэрбум төгрөг үгүй ээ, 1 их наяд төгрөг ингээд гарчихсан. Орлого барьцаалаад хөрөнгө барьц барьцаалдаггүй болохоор 1 хүн 2-3 аппликэйшнээр давхардуулж зээл авах боломжтой болчихсон. Тэгэхээр ийм зүйлүүд дээр та хэд маань маш сайн анхаараарай. Тэгээд санхүүгийн боловсролыг энэ тал дээр нь анхаарч ажиллахгүй бол залуучууд маш их бэт-д мөнгөө алдаж байна. Манайх хуулиараа хориотой мөртөө гаднын сайтууд Монголд ажиллаж болдог. Тэгээд дансаа холбоод онлайн бооцоотой тоглоомууд дээр маш их хөрөнгөө алдаж байна. Үүний ард хүн хувь хүний амьдрал яригдаж байна. Мөн өндөр хүүтэй зээлүүдийг давхардуулж авснаасаа болоод бас ахуй амьдрал нь хэцүүдэж байна. Тийм учраас санхүүгийн боловсрол олгох тал дээр та хэд сайн анхаараарай. Энэ бол яг өөрөө үнэхээр чухал асуудал болчихоод байгаа. Санхүүгийн боловсрол муутай, тэр талын мэдлэг хомс учраас тухайн үед олдож байгаа зээлийг нь маш хурдан хугацаанд үрэн таран хийгээд, ингээд буцаад төлөх чадвар дээр асуудал үүсдэг. Энэ нь өөрөө юу гэхээр ганцхан эргээд эргэн төлөгдөх чадваргүй болоод ирлээ гэх юм бол ганцхан банк бусын асуудал биш, ганцхан Санхүү зохицуулах хорооны асуудал биш. Энэ чинь Монгол Улсын асуудал болчихож байгаа байхгүй юу. Яг энэ койн шиг. Тэгэхээр ийм юмнуудыг урьдчилан сэргийлж ажиллаарай л гэж хэлэх гэсэн юм. Тэгээд бүгдэд нь амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Шижир гишүүн үг хэллээ. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууж, үг хэлье.

М.Мандхай: Эдийн засгийн байнгын хороо дээр Хяналтын зөвлөлийн гишүүдийг бид нар бүтэн 13 цаг сууж олон талаас нь асууж, ер нь юу хийх гэж байгаа, яаж ажиллах гэж байгаа талаар бас санал солилцож, ажилласан байгаа. Энд олон цаг ажилласан олон гишүүд бол байсан. Тэгтэл хуралдаа суудаггүй мөртөө орж ирж зөвхөн хүнээ танихгүй байж байж улс төржиж орж ирж, чадвартай залуучуудыг үндсэндээ сонгуулахгүй байх ийм шийдвэрт нөлөөлж байгаа нь маш харамсалтай байна. Саяын бол Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүн бол яг өөрийнхөө албан нөгөө хуульд заасан квотоор орж ирэх байсан. Тэгээд энэ чадвартай залуучуудыг ийм улс төржсөн байдлаар сонгуулахгүй байгаа дээр бол харамсаж байгаагаа бүр давхар хэлмээр байна.

2 дугаарт энэ Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд бас амжилт хүсье. Бид нар бол бас олон талаас нь асууж юу хийхээр зорьж байгаа мэдээлэл бол авсан. Тэгээд хамгийн чухал юм бол Хяналтын хороо бол өөрөө маш хатуу хяналттай, хараат бус нөлөөнд автахгүй ийм баг бүрэлдэхүүн бол байх ёстой. Тэгээд 1 чухал юм бол компанийн хувьцаат компаниудын санхүүгийн тайлан. Асуудал нь юу гэхээр энэ нягтлан бодох бүртгэлийн хуурамч үйлдлүүд тайланд тусгагдсан асуудлууд байдаг. Ялангуяа энэ хувьцаат компаниудын дотор. Тэгэхээр энэ санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн тэр хуурамч үйлдлүүдийн эсрэг маш сайн дүн шинжилгээ хийдэг байх, дээрээс нь энэ дүрэм журмыг нь чангатгах бол шаардлагатай гэж үзэж байгаа.

Мөн балансын гадуурх байгууллагууд байгаа. Санхүүгийн нарийн бүтэцтэй холбоотой тэр зохицуулалтуудыг бас нэлээн сайн чангатгах хэрэгтэй байгаа. Зөвхөн үндэсний дотоодын аудитын компани биш, гуравдагч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын компаниудаар бас яг энэ хувьцаат компаниудын тайлан мэдээг аудит хийлгэж, тэрийг нь ил тод танилцуулдаг баймаар байгаа юм. Яагаад би ингэж хэлж байна гэхээр үндсэндээ нөгөө хамаарал бүхий нийт хувьцаат компаниудын бараг 90 гаруй хувь нь зөвхөн 1 эзэнтэй, тэгсэн мөртөө 10-аас доош хувь нь олон нийтэд гаргачихсан ийм компаниуд маш их байгаа.

Тэгээд энийгээ бол олон нийтийн хувьцаат компани гэж ярьдаг. Яг үндсэн үйл ажиллагаа нь болохоор тийм биш зүгээр л яг л ХХК шиг л үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр энэ компаниудын тэр санхүүгийн тайлагналыг бас шалгамаар байна. Яагаад гэхээр жижиг хувьцаа эзэмшигчдийг луйвардах хууран мэхлэх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

М.Мандхай: Тухайн компанид өөрийнхөө хөрөнгө оруулалт хийгээд, хувьцаагаа нэмэгдүүлж, урт хугацааны ийм тогтвортой хөрөнгө оруулалт хийе гээд зориод ирчихсэн байгаа жижиг хувьцаа эзэмшигчдийг хууран мэхлэх асуудлууд бас энэ санхүүгийн тайлангийн луйвраас гарч ирдэг. Тэгэхээр энийг олж илрүүлдэг байх, нарийвчилсан тэр анализ дүн шинжилгээнүүдийг компанийн тайлангуудаар хийдэг байх. Ингэхийн тулд олон улсын тэр аудитаар шалгуулж, тэр мэдээллүүдийг ил тод болгодог ийм нөхцөл бол бид нарт зайлшгүй шаардлагатай байгаа. Яагаад гэхээр би нөгөө Америкийн Энороны бас алдартай кэйс байдаг. Тэгээд энэ жижиг хувьцаа эзэмшигч яг энэ Энороны кэйс шиг асуудлууд үүсэх вий гэдгээс урьдчилан

сэргийлэх үүднээс одоо бүрдэж байгаа энэ Хяналтын зөвлөлийн гишүүд бол энэ дээр маш сайн анхааралтай ажиллаасай гэдгийг бас захиж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Пүрэвдаваа: Би үг хэлж байгаад, цөөн асуулт асууя гэж бодож байна.

1 дүгээрт энэ хэлэлцэж байгаа асуудал маань бол энэ албан тушаал томилох асуудал өнөөдөр орж ирлээ. Миний сонссоноор МАН, АН, ХҮН нам нийлсэн 3 нам ажлын хэсэг байгуулаад, тэгээд энэ хуваарилдаг албан тушаалуудаа ингээд хувааж авч хуваарилдаг юм шиг байгаа юм. Тэгээд энэ улс орны хувьд энэ тулгамдсан асуудал маш их байгаа. Энэ намынхаа асуудлуудыг яаралтай, бодвол хүмүүсээ томилох нь аргагүй л байх. Тэгээд энэ Их Хурлаараа уван цуван биш, нэг мөр нэн яаралтай гэдгээрээ бол маш хурдан юмаа шийдчихдэг л юм байна лээ шүү дээ. Тийм учраас бүх томилгоогоо яаралтай хийгээд дуусчихмаар байгаа юм. Тэгээд энэ улс эх оронд тулгамдаад байгаа агаарын бохирдол, түгжрэл, тэгээд энэ үнийн өсөлт энэ бүх юмыгаа шийдчихвэл яасан юм бэ гэдэг энэ асуудлыг яг энэ мөчид бол хэлчихмээр санагдаж байна.

2 дугаарт сая бодвол энэ нууцаар ингээд санал хураахаар чинь бас гоё байдаг юм байна шүү дээ. Нам нам нь тохирч байгаад бодвол хүмүүсээ явуулсан юм байлгүй. Нэгнийгээ унагаачихдаг юм байна. Тэгээд бужигнаад явчихдаг. Тэгээд бүх юмаа хэлэлцээд тохирчихсон юм бол тэгээд юмнууд нь дэмжигдэх байлгүй дээ.

Би асуулт асуумаар байгаа юм. Энэ Санхүүгийн зохицуулах хороо гэдэг бол Монгол Улсын хэмжээнд энэ санхүүтэй холбоотой, ялангуяа энэ мөнгө хүүлэх хуулиар эрх эдэлж байгаа нөхдүүдийг л сайн хянадаг, зохицуулдаг ийм л субъект гэж харж байгаа юм. Энэ нэр дэвшиж байгаа хүмүүсээс өнөөгийн манай бүх л том жижиг худалдан авалт болгоныг л нэг банк бусаар, аппликэйшнээр зээл авч худалдан авалт хийдэг, зээл өгдөг. Тэгсэн мөртөөсөө 12 арилжааны банк нь зээл авъя гэхээр зэрэг маш өндөр босготой байдаг. Энэ үйл явдал чинь өөрөө энэ иргэдийн кредит скор буюу энэ зээлийн түүхийг нэмэгдүүлэхгүй, эерэг үзүүлэлт бага байдаг. Энэ дээр та бүхэн ямар өөрчлөлт хийх юм бэ. 1 дүгээрт.

2 дугаарт энэ өмнөх ажилласан нөхдүүд нь хэдэн жил болоод халагдчихав. Тэр ажлаа өгч байгаа нөхдүүд нь ямар үр дүн гаргасан юм. Бид нар томилохоо л яриад байдаг. Чөлөөлсөн хүмүүс нь яагаад үргэлжлүүлээгүй юм. Эсвэл 1 удаагийн байдаг юм уу. Тэгээд тэр хүмүүсийн ажлын дүгнэлтийг бас товч сонсмоор байна. 1, 2 өгүүлбэрээр. Тэгээд ер нь Санхүүгийн зохицуулах хороо бол ил тод байдал маш муу байгаа шүү. Энийг хэрхэн сайжруулах вэ гэдгийг асуумаар байна. Тэгээд хариулсны дараа дахиад асуулт асууна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигчийн сонсгол нээлттэй явагдсан Пүрэвдаваа гишүүн ээ. Энд тэр Засгийн газрын хамтарсан, хамтраагүй асуудал огт хамаагүй. Бүгдээрээ бас ажилдаа хариуцлагатай хандаад, бас зарим зүйлийг улс төрийн өнцгөөр харж мушгихаа ч бас болих хэрэгтэй.

Нээлттэй сонсгол явагдаад нийтдээ 40 гаруй хүн бүртгэгдээд, 2 Байнгын хороо дээр ажлын хэсэг байгуулагдаад, томилгооны сонсгол хийгдээд, ороод ирж байгаа. Ер нь Улсын Их Хурлаар томилогдож байгаа томилгоо бол Улсын Их Хурлын нийт гишүүдэд нээлттэй мэдээлэл өгч, асуултад хариулж, Байнгын хорооны санал,

дүгнэлт нь гарсны үндсэн дээр өнөөдөр Улсын Их Хурлаар орж ирж томилогдож байгаа.

Ер нь нэг зүйлийг бид их тийм хариуцлагатай бодохгүй бол болохгүй байгаад байна. Материалаа дутуу уншсан, хуулиа дутуу судалсан, мэдээллээ дутуу авснаас болоод зарим зүйлүүдийг Улсын Их Хурлын гишүүд маань бас мушгин гуйвуулаад яваад байх юм. Энэ нь ингээд төрийн албандаа, төрийн албан хаагчдадаа төрд зүтгэж байгаа залуучуудад бас урам зоригийг нь мохоох, худлаа үнэн мэдээллийг олон нийтэд түгээж улс төр хийх ийм байдлууд гарч байна. Сая бол тэр Сангийн яамны чадварлаг боловсон хүчин Сангийн сайдын санал болгосон квотоороо санал болгож байгаа нэр дэвшигчийг бас ингээд л янз янзаар улс төртэй хутгаж байгаад л өнөөдөр Улсын Их Хурал дэмжихгүй гээд л гарч байгаа. Яах вэ Улсын Их Хурал дэмжээгүй. Тэр нэгэнт шийдэгдчихсэн асуудал. Гэхдээ цаашдаа энэ төрд ажиллаж байгаа чадварлаг боловсон хүчнүүдийг ийм байдлаар урам зоригийг нь мохоох байдал бол Улсын Их Хурлын хийх ажил огт биш байдаг юм шүү.

Мэдээж өнөөдөр Улсын Их Хурлаар орж томилогдохоор явж байгаа нэр дэвшигчид бол дийлэнх нь 1-ээс бусад нь үндсэндээ бүгд орон тооны бус гишүүд. Иргэдийн, аж ахуйн нэгжийн, салбарын, төрийн байгууллагын нэрийн өмнөөс орон тооны бус гишүүнээр ажиллаж, хяналт тавих чиг үүрэг бүхий хүмүүс явж байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн байдлаар нэг их намын эрх ашиг яриад байхгүй. Энэ хүмүүс чинь бараг зарим нь цалинтай, цалингүй, хурал суусан оролцсон байдлаараа цагаараа үнэлэгдэж цалин авдаг энэ тэр гээд саяхан сонсож байхад тийм айхтар өндөр цалин мөнгөтэй зүйл биш юм байна лээ. Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүд бол айхтар айхтар өндөр дүнтэй цалин аваад байдаг бол энэ Улсын Их Хурлаас томилогдож, орон тооны бусаар хяналт тавьж ажиллах гэж байгаа нөхдүүд бол тийм цалин мөнгөтэй асуудал биш юм байна лээ.

Гэхдээ нөгөө талдаа бас энэ гишүүдийн хэлээд байгаа зөв. Ямар нэгэн байдлаар цөөнхийн хувийн эрх ашгийг хангахын төлөө огт ажиллаж болохгүй. Харин Их Хурал энд нь байнгын хяналт тавьж байх болно гэдгийг бас сайн анхаарч ажиллаж байх ёстой. Хуулиа ягштал биелүүлж ажилладаг байх хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүдийн иргэдийг төлөөлж хэлж байгаа болох бүтэхгүй байгаа зүйлүүдийг засаж залруулах дээр сэтгэл зүтгэл гаргаж ажиллаж байх ёстой гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Ингээд Пүрэвдаваа гишүүний асуултад хэн хариулах билээ. Үндсэндээ үг хэлснээр авах юм уу. Пүрэвдаваа гишүүн 5-аас нь асуух уу.

Халагдах биш өмнөх нэр дэвшигчид чинь Пүрэвдаваа гишүүн 2016 онд томилогдсон. 6 жилийн хугацаатай. 2022 онд солих байсан ажил хийгдээгүй, өнөөдрийг хүртэл эзэнтэй, эзэнгүй байдлаар яваад байгаа учраас Улсын Их Хурал энэ удаа бүхлээр нь нэр дэвшүүлэх ажлыг хийж байгаа юм. Нэг ч хүний хугацаа дуусаагүй байхад нь чөлөөлсөн асуудал байхгүй. Үр дүнг харин тийм. Ерөөсөө энэ томилогдож ажилласан хүмүүсийн үр дүнг эргээд Улсын Их Хурал тайлан сонсдог баймаар байна гэдэг энэ гишүүдийн саналыг дэмжээд байгаа. Тэгэхээр энэ дээр энэ дэгийн хуульд зохицуулалт хийнэ. Дэгийн хууль болон Улсын Их Хурлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсгүүдийг байгуулж эхэлж байгаа. Эдгээр ажлын хэсгүүд дээр энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг хийгээд хүн нэг бүрээр үр дүнг сонсдог болох ёстой гэдэгтэй санал нэг байна. Ажлын хэсэгт Пүрэвдаваа

гишүүнийг оруулж ажиллуулна. Баярлалаа. Энхбатын Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн энэ сонсгол дээр Хяналтын зөвлөлийн гишүүн, мөн орон тооны бус гишүүдийн ер нь энэ сонсголын бэлтгэл хангах хүрээнд би бас Эдийн засгийн байнгын хороонд саналаа хэлье гэж бодож байна.

Энэ дээр сонсголын тов, хугацаа, ер нь нэр дэвшигчдийн нээлттэй зарласан гэж байгаа юм. Нээлттэй зарласан нэрийдлийн доор яг хэр олон нийтэд хүрсэн бэ гэдэг асуудлыг бас бид нар хөндөх ёстой юм шиг. Сонсголын тов хугацааг энэ parliament.mn дээр байрлуулсан. Улсын Их Хурлын цахим хуудас. see.mn, soronznews.mn, shogch.mn, ubn.mn, ulsturch.mn, МҮОНРТ, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн гэж байгаа юм. Одоо ийм мэргэжлийн салбар буюу Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөл энд оролцох мэргэжлийн хүмүүсийг бид нар бүртгэхдээ арай жоохон мэргэжлийн баймаар байна. Орчин үе linkedin ч юм уу, энэ бүртгэх гишүүдийнхээ оролцуулах байдлаа нээлттэй гэдэг томъёоллоо илүү өөрөөр цаашид хандаач гэж хүсмээр байна.

Ингэснээр яг бид нарын хүсээд байгаа үнэхээр бид нар улсынхаа шилдэг боловсон хүчнийг энэ шаардлагатай газар байршуулж чадаж байна уу гэдэг асуултдаа ийм байдлаар хариулах болов уу гэж бодож байна. Мөн өнөөдрийн энэ Хяналтын зөвлөлд нэр дэвшиж байгаа нэр дэвшигчид асуулт, санал хамт явж байгаа учир би нэг зүйлийг онцгойлон хэлье. Ер нь энэ ББСБ болон даатгалын энэ хамаарал бүхий асуудлуудыг л хүмүүс онцолж байна шүү дээ. Тэгэхээр зөвхөн энэ ББСБ, даатгалын хамаарал гэхгүй та бүхэн өнөөдөр өмнө нь сая орон тооны бус гишүүд дээр 1 нь шууд хэллээ шүү дээ. Би ийм хамааралтай учир хуралд цаашдаа орохгүй гэдэг шиг энийг нэлээн ил тод, нээлттэй тавимаар байна.

Хяналтын гишүүд та бүхэн биднийг төлөөлөөд болон олон нийтийг төлөөлөөд Санхүүгийн зохицуулах хорооны маш том цар хүрээнд хяналт тавьж байгаа. Энэ ББСБ-аар мөнгө хүүлдэг асуудал, төрийн ямар нэгэн сангаас мөнгө аваад цаашаа зээлдэг энэ онлэндингийн асуудал дээр нэлээн хяналт тавих дээр анхаараач гэж хүсмээр байна. Бүх гишүүн л үүнийг хэлж байна. Үүнээс гадна орон тооны бус, гишүүд болон та бүхэнд нэг зүйлийг онцлоод хэлэхэд Санхүүгийн зохицуулах хорооны маш том үндсэн чиг үүрэг бол өөрөө хөрөнгийн зах зээлийг бэхжүүлэх байгаа. Тэгэхээр иргэдийн хуримтлалтай байх энэ Засаг талд явж байгаа энэ Үндэсний баялгийн сан бид нар энэ дундаж давхаргаа тэлэх асуудалд бид нар Их Хурлын харьяа байгууллага гээд нэг тийм гараа хумьсан байдалтай хандахгүйгээр нийтдээ бид нар яг иргэдийнхээ энэ дундаж давхаргыг тэлэх, хөрөнгийн зах зээлийг бэхжүүлэх, хадгаламжтай болох энэ асуудал дээр бас онцгойлон анхаарч ажиллаарай гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Номинчимэг: Баярлалаа. Өнөөдөр энэ Хяналтын зөвлөлд нэр дэвшиж байгаа 3 нэр дэвшигчийн 2 нь Хууль зүйн байнгын хороогоор орсон. Тэр дээр сонсгол дээр хангалттай бас байр суурийг нь сонссон. Юу хиймээр байгааг нь сонссон. Харилцан адилгүй яах вэ, идэвх санаачилгын хувьд ийм байсан. Гэхдээ яах вэ би энэ чуулган дээр бас энэ 5 нэр дэвшиж байгаа хүмүүстээ амлалтыг нь

авмаар байгаа юм. Яагаад вэ гэхээр өмнө нь Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөл ерөөсөө функц хийхгүй, ерөөсөө ажилладаггүй. Иргэд, аж ахуйн нэгж гомдол гаргаад, Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол дээр гомдол гаргаад ирэхээр тэр нь ажилладаггүй болохоор энэ одоо бид нарын зорьж, Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа шийдвэрт нь хяналт тавих энэ бүтэц ерөөсөө ажиллаагүй байхгүй юу. Тэгээд янз бүрийн л шалтгаан байсан байх. Гэхдээ ерөөсөө тэнд гишүүнээр томилогдсон хүмүүс өөрийн энэ томилгооны үүрэг, ач холбогдлыг сайн ойлгоогүй. Эсвэл мэдэхгүй одоо эсвэл дургүй байхад нь хэн нэгэн дэвшүүлээд томилчихсон байдаг юм уу дуртай, дургүй нэг тийм хүмүүс байсан юм уу, энэ ажлаа хийдэггүй байсан юм байна лээ.

Тэгэхээр одоо бид энэ санхүүгийн зах зээл тэлж байгаа, сая гишүүдийн хэлж байгаа олон асуудлууд байгаа. Санхүүгийн хэрэглэгчийн эрх хохирч байгаа. Хохироод эхэлчихсэн, шинэ тутам үүсэж байгаа харилцаанууд дээр өмнө нь ч байсан энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн асуудал гээд олон асуудлууд дээр та бүхэн маань бас идэвхтэй ажиллаач. Идэвхтэй ажиллахын тулд та бүхэн орон тооны бус зарим нь гишүүн ч гэсэн сардаа 1 удаа хуралдана. Ирсэн гомдол асуудлыг маш нухацтай авч хэлэлцэнэ. Дээр нь үүнтэй холбоотой юун дээрээ гажуудаад байна гэдэг саналуудыг та бүхэн бас гаргах ёстой байгаа. Тэгэхээр би энэ 5 нэр дэвшигчээсээ амлалтыг нь авмаар байна. Энэ бүрэн эрхийнхээ хугацааг хэрвээ томилогдвол энэ 6 жилийн хугацаатай яг хуралдаа биечилж өөрсдөө оролцоно, идэвхтэй оролцоно. Яг энэ чиг үүргийнхээ дагуу бүх хүчин чадлаа дайчилна гэдэг үгийг энэ Улсын Их Хурлын чуулган дээр та бүхний амнаас энэ протоколд үлдээхээр авмаар байна.

Д.Амарбаясгалан: Энэ ч асуултад хариул даа. Амлалт өгдөг дэг байхгүй дээ. Хуулиараа хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэх ёстой. Хангалтгүй гүйцэтгэж байгаа тохиолдолд чөлөөлөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэх ёстой. Тэгэхдээ Номинчимэг гишүүний хэлж байгаа маш зөв зарчмын асуудал шүү. Орон тооны бусаар сонгогдчихсон гээд, нэг ийм сэтэртэй, ажилд оролцдоггүй энэ ард томилсон Улсын Их Хурал, Байнгын хороо бүх итгэлийг нь алдсан ийм байдал бол байж болохгүй.

Ер нь дахин дахин л хариуцлагатай хэлье. Улсын Их Хурал батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ гүйцэтгэхийн тулд энэ Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Төрийн албаны зөвлөл, Аудитын байгууллага гэх мэт байгууллагуудыг ажиллуулж, хэрэгжилтийг хангахад чиглэж ажилладаг. Тэгээд энийг нь цаашлаад байгуулагдсан, томилогдсон албан тушаалтнууд нь эрх мэдэл албан тушаал гэдэг талаас нь хараад хувийн явцуу эрх ашгийн төлөө ажиллаад эхлэх л юм бол энэ ард иргэд олон нийтийн чинь итгэл алдарч байдаг. Сая ч гэсэн энэ гадаа гудамж талбайд болж байгаа жагсаал цуглааныг бид зөв өнцгөөс нь харах ёстой. Төрөөс батлагдсан хууль нь хэрэгжиж чадахгүй байна. Хуулиа давчихсан журам, хэм хэмжээ тогтоож байгаа актууд нь иргэдийн эрхийг их хэмжээгээр зөрчиж байна. Эрх мэдлээ хэтрүүлсэн албан тушаалтан, албан байгууллагын гаргасан шийдвэрийг эсэргүүцэж байгаа иргэд жагсаж цуглаж байна. Аливаа төрлийн стандарт, хэм хэмжээ мөрдөгдөхгүй байгаа. Энэ нь өөрөө ард иргэдийн уур бухимдлыг амар тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байгаа нь бухимдлыг төрүүлж байна гэдэгтэй бид санал нэг байх ёстой. Тэгэхийн тулд энэ томилогдож байгаа орон тооны болон орон тооны бус албан тушаалтнууд бүх түвшиндээ л хариуцлагатай ажилладаг байх ёстой. Тэгж байж энэ итгэл сэргэж, дэмжлэг авдаг болно гэдгийг бас давхар нэмж хэлье. Тэгээд Номинчимэг гишүүний

хэлсэн саналыг бүрэн дэмжиж байна. Та бүхэн өнөөдөр томилогдож байна гэдэг амлалт өгөөд томилогдож байна гэж өөрсдөө ойлгож байх ёстой. Болохгүй байгаа тохиолдолд шаардлагатай шийдвэрүүдийг Улсын Их Хурал гаргаж ажиллана.

Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Галбадрах: Баярлалаа. Нэр дэвшиж байгаа бүх залуусыг дэмжиж байна. Анкеттай нь, ажилласан байдал, сурсан байдал, бүх юмтай нь танилцаад, ер нь шалгарч орж ирсэн их зөв залуучууд байна гэж харж байна. Тэгээд санхүүгийн манай энэ зөвлөл маань болохоор Монголын эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход маш их чухал үүрэгтэй ийм нэгж байгууллага. Маш их чухал зөвлөл гэдгийг бол та бүхэн маш сайн ойлгож байгаа байх. Тэгээд сая яг адилхан Номинчимэг гишүүнтэй би бас адилхан л гишүүн бүрээр нь дэвшиж байгаа дэвшигч болгоноор бас дуу хоолойг нь сонсож, бас өөрсдөөр нь хэлүүлэх ийм санал байна.

Би өөрөө Байнгын хорооны хурал дээр бол байдаггүй, оролцоогүй. Тэгэхээр нэр дэвшиж буй үндэслэлээ хүн болгон хэлээч ээ. Саш товчхон. Ер нь бол ингээд биччихсэн байж байна. Тэгэхдээ энэ чуулганы танхимд бас хэлбэл зүгээр байна. Томилогдоод очсон тохиолдолд ямар зорилт тавьж байгаа, ямар шинэчлэл хийхийг зорьж байгаа, өөрөөр хэлбэл юунд фокуслаж ажиллах вэ гэдгийгээ энэ 5 залуус бас хэлж өгвөл их зүгээр байна гэж бодож байна.

Тэгээд Хяналтын зөвлөлийн гишүүн гэдэг бол хараат бус хүн байх ёстой, зарчимч байх ёстой, шударга байх ёстой гэдэг энэ тал дээрээ хувь хүнийхээ хувьд бол өөрсдийнхөө үзэл бодол, тэр зүйлийг бол би итгэж байгаа. Энийг бол байнга бодож яваарай гэж бодож байна.

Тэгээд Буяндэлгэр дарга бол өөрөө инженер суурьтай хүн байна. Тэгэхээр Монгол Улсад үйлдвэрлэлийг дэмжих энэ зээл яриад байна шүү дээ. ББСБ-аас эхлээд зээлүүд нь өндөр байна гээд байна. Тэгэхээр ЖДҮ-ээс эхлээд энэ үйлдвэрлэлийг дэмжих юман дээр л бид нар энэ зээлийн бодлогыг маш сайн чиглүүлж ажиллах тал дээр их анхаараарай гэдгийг та бүхэндээ бас хэлье. Тэгээд тэрнээс гадна би өөрөө бас боловсролын салбарын хүн. Тэгээд бид нар энэ салбаруудаа ингээд тэргүүлэх салбар, жишээлбэл боловсрол бол тэргүүлэх салбар. Тэр дотроо багш нар нь гол ажилладаг. Багш нарыг дэмжих энэ санхүүгийн дэмжлэг ер нь юу байж болох вэ. Энэ тал дээр сайн бодож ажиллахыг хүсэж байна. Ипотекийн зээлээс нь эхлээд орон нутагт ажиллаж байгаа багш нарыг дэмжих, сурах, багш мэргэжлийг сонгох тал дээр өөрөөр хэлбэл ер нь хүний хөгжлийг дэмжих санхүүгийн ямар механизм байж болох вэ гэдэг тал дээр та бүхнийгээ их фокуслаж ингэж ажиллахыг захиж хэлэхийг хүсэж байна.

Тэгээд орон тооны бус гишүүн гэдэг утгаараа зарим хүмүүс сардаа байдаг юм уу, ямар зарчмаар та бүхэн маань хуралдаж уулзаж явах юм. Энэ тал дээрээ их хариуцлагатай, идэвх зүтгэлтэй, сэтгэлтэй ажиллаж байж та бүхэн бол өөрсдөө ингээд мэргэжлээр нь үзсэн сурсан. Японд ч сурсан хүн байна. Хятадад ч сурсан хүн байна. Тэгэхээр энэ чиглэл дээрээ та бүхэн маань өөрсдийн тэр сурсан мэдсэн тухайн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Галбадрах гишүүн үг хэллээ. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Булгантуяа: Шийдэл хүсэж байна гэж байх шиг байна шүү дээ. Тэгвэл асуултад хариулчих уу дарга. Тэгвэл миний микрофон явчихлаа. Хяналтын зөвлөлийн гишүүдэд би бүгдийнх нь анкетыг нь харсан. Бүр Хяналтын зөвлөлийн даргад газар зохион байгуулагчаар бакалавр, магистраа хамгаалсан, энэ чиглэлээр 23 жил ажиллахдаа нийтдээ 20 жилд нь бараг энэ чиглэлээр ажилласан хүн Хяналтын зөвлөлийн дарга болох гэж байгаа юм байна. Миний ойлгож байгаагаар Хөрөнгийн биржээр эсвэл газрыг худалдаалах ажлыг зохион байгуулах гэж байгаа юм болов уу. Яагаад бид нар газар зохион байгуулагч хүнийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргаар тавих гэж байгаа юм бол гэдгийг би бол ерөөсөө ойлгохгүй байна 1 дүгээрт.

Бусад нь Оч, Энхбаяр, Халиунаа, Сайнбилэг гээд энэ хүмүүс бүгдээрээ бизнесийн удирдлагын чиглэлээр, эсвэл эдийн засагчаар төгссөн хүмүүс байна. Та бүхэн энэ Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийнхөө чиг үүргийг мэдэж байна уу. Энэ чинь гаргасан шийдвэртэй холбогдсон гомдлыг хянах, хорооны үйл ажиллагааны талаар хөндлөнгийн аудитаас гаргасан санал, зөвлөмжийн хэрэглэгчдэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ гэсэн байгаа. Энэ хүмүүс дотор 1 ч аудитор байхгүй. Тэгэхээр аудитын дүгнэлт гаргахаар тэрүүнтэй чинь хэн танилцах юм. Нөгөөдөх дотор нь бодвол хууль зөрчсөн гэж гаргаж байгаа дүгнэлтүүдтэй танилцах байх. Тэгэхээр хуульч хүн ерөөсөө байхгүй. Та бүгдээр бол эдийн засгийн тооцоолол бол хийлгэхгүй байх. Хэрвээ эдийн засгийн тооцоолол хийлгэнэ гэж бодож байгаа бол хийх гэж ийшээ орж байгаа бол Монголбанкны Мөнгөний зөвлөлд нэрээ дэвшүүлэх нь зүйтэй байх. Тэгэхээр би яг энэ чиг үүргийг харахаар үнэхээр гайхаж байна. 1 дүгээрт.

2 дугаарт нь Эдийн засгийн байнгын хороо маань бас Хөрөнгийн бирж, Санхүү зохицуулах хорооны энэ удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл энэ тэр дээр нэг чиг үүрэг дээр нь та бүхэн маань жоохон хараач. Энэ дэлхий даяараа 1 дүгээрт бүртгэлтэй компаниудын хувьд, гарах гэж байгаа компаниудын хувьд засаглал нь сайн байна уу гэдэг их чухал байгаад байгаа байхгүй юу. Бид нар өнөөдөр ард түмнийг Санхүүгийн зохицуулах хороогоор та бүгдээс зөвшөөрөл авхуулаад, Хөрөнгийн бирж дээр гаргаад, наадах чинь гэр бүлийн компаниудын хувьцаануудыг бид нар авхуулаад сууж байна шүү дээ. Бид нар ер нь засаглал нь хэр сайн байгааг мэдэж байгаа юм алга. Тэгэхээр И Эс Жи гээд байгаль орчин, нийгэм, засаглалын хувьд хэр сайн байна гэдгийг компаниудыг үнэлдэг дүгнэдэг, түүн дээр хянадаг ийм хүмүүсийг оруулж ирж байна. Хяналтын зөвлөл дээрээ, удирдах зөвлөл дээрээ. Дээрээс нь нэмээд тэр чигээрээ энэ ай ти цахимжилт болчихсон. Та бүхэн Лондоны хөрөнгийн биржийн удирдах зөвлөлд нь хороонд нь хэн байгааг та бүхэн ороод хараарай. Ай би Эм компанид 30 жил ажилласан Ай Ти-ийн спесиалист хүн орж ирж байна. Яагаад гэвэл энэ сайбер секьюрити аюулгүй байдал нэн чухал байдаг. Тэн дээр манай Тетха гээд л Клерин хаус энэ тэр гэж байхад Монгол Улсын бүх иргэдийн мэдээлэл байгаа. Дансны мэдээлэлтэй нь хамтдаа байгаа. Энэ бүхэн аюулгүй байна уу, үгүй юү гэдэг ийм мэдээллүүдийг шалгадаг Ай Ти-ийн хүмүүсийг авч байна. Гэтэл өнөөдөр бид нар дандаа бүгдээрээ эдийн засагч нар аваад ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Булгантуяа гишүүн нэмж 1 минут авъя.

Х.Булгантуяа: Тэгээд би бол яг энэ хүмүүсийн анкетаас хараад, Санхүүгийн зохицуулах хорооны дараагийн чиг хандлагыг, хөгжлийг энэ хүмүүс чинь 4, 5 жилээр томилогдож байгаа шүү дээ. Яг олж харахгүй л байна л даа. 1 дүгээрт.

2 дугаарт та бүхэн орон тооны бус гишүүд юм байна. Тэгэхээр энэ бол цалин мөнгө багатай, тэгээд бүгдээрээ хувийн хэвшилд яг үүнтэй харилцан хамааралтай компаниуд ажилладаг юм байна. Тэгээд та бүхэн маань яаж амьдаръя гэж бодож байгаа юм бэ. Цалин мөнгөө хаанаас авах вэ. Яг харилцан хамааралтай компанидаа үргэлжлүүлээд ажиллах юм уу. Тэр чинь бас нөгөө талдаа юу үүсгэнэ шүү дээ. Тэгэхээр та бүхэн маань түүн дээрээ яая гэж бодож байгаа юм бэ гээд 1 дүгээрт энэ дарга дээр нэр дэвшиж байгаа хүнээс, 2 дугаарт бусад нэр дэвшигчдээс үргэлжлүүлээд яаж ямар ажил хийж орлогоо энэ чинь мэдээж та бүхэн маань амьдарч амьдрах орлогоо бол хаанаас олно гэж бодож байгаа юм бэ гэдэг нэг ийм 2 асуултыг асуух гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигчид 5-уулаа товчхон хариултууд өгье. Буяндэлгэр нэр дэвшигч.

Д.Буяндэлгэр: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр миний эзэмшсэн мэргэжил бол 3 төрлийн мэргэжил байгаа. Анхны мэргэжил маань бол газар зохион байгуулагч. СЭЗДС-ийг санхүүгийн шинжээч мэргэжлээр 2016 онд төгссөн. Хуульч мэргэжлийг бол 2022 онд бол төгсөж, эзэмшсэн байгаа. Гэхдээ намтар дээрээс харахаар миний ажилласан жилийн туршлага илүү инженерийнхээ чиглэл рүү байгаа учраас Эдийн засгийн байнгын хороо дээр ч Улсын Их Хурлын эрхэм гишүүдээс бол энэ асуултууд бол гарч ирж байсан. Тэгэхээр таны хэлж байгаачлан миний инженерийн чиглэлийн туршлага бол илүү. Гэхдээ санхүүгийн чиглэлээр бас ажилласан туршлага маань инженерийн чиглэлтэй харьцуулахад бол харьцангуй бага гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн хийх ажил маань Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд бол тодорхой заачихсан байдаг. Энэ талаар. Булгантуяа гишүүн маань сая тодорхой хэлчихлээ.

Гэхдээ манай хяналтын зөвлөл бол аливаа бодлого гаргадаг байгууллага биш. Бодлого бол Улсын Их Хурал дээрээ гараад, энийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг арга хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлнэ. Үүний хэрэгжилтэд хяналт тавих, эргээд энэ бодлого маань хэрэгжилт нь сайн уу, муу юу эсвэл энэ дээр ямар асуудал гарч байна вэ гэдгээр Улсын Их Хурлын эрхэм гишүүдийг мэдээллээр, үнэн зөв мэдээллээр, хараат бусаар хангах ийм чиг үүрэгтэй байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээрээ төвлөрч ажиллана.

Д.Амарбаясгалан: Оюунтөгсийн Оч нэр дэвшигч. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

О.Оч: Сайн байцгаана уу. 2 гишүүний асуултад хариулъя. Миний бие санхүүгийн зах зээлд оролцогч зохицуулалттай байгууллагад ажиллаж байсан. Тухайн ажиллаж байх хугацаандаа үргэлж шинэлэг, зах зээлийг хөгжүүлэх шинэ төсөл хөтөлбөрүүд санаачилж, заримд нь оролцож явсан. Тэгэхээр ер нь бол энэ зах зээлийн зовлон жаргалыг гадарлана гэж би өөрийгөө боддог. Тэр утгаараа бас энэ орон тоог зарлагдмагц нь бас сонирхоод, өөрийгөө дэвшүүлье гэж бодсон.

Зохицуулалт ер нь сонгогдсон тохиолдолд бол хийж, санаачлан ажиллая гэж бодож байгаа хэд хэдэн ажлууд байгаа. Яагаад гэхээр би нөгөө салбарт нь ажиллаж байсан учраас юуг сайжруулах, юуг улам зохицуулалтыг нь сайжруулах, юуг шинээр хөгжүүлэх талаар бас өөрийн гэсэн бодолтой явдаг. Юуны түрүүнд зохицуулалтын

энэ процессыг нээлттэй хялбар болгох дээр эн тэргүүнд анхаарч ажиллана гэж бодож байгаа. Дээрээс нь санхүүгийн зах зээлд оролцогчдын хүртээмжийг нэмэгдүүлэх дээр бас анхаарч ажиллана гэж бодож байгаа. Түрүүн гишүүдийн санал дээр бас нэлээдгүй дурдагдсан. Санхүүгийн зохицуулах хорооноос өмнө нь хийгдсэн судалгаанууд дээр бол маш тодорхой харагддаг. Хүмүүс үнэт цаасны зах зээлийн компаниудад 30 хэдэн хувь нь л итгэж байхад үйлчилгээг нь авдаг, итгэдэг гэж байхад ББСБ, ломбардуудад 89 хувь, 86 хувь итгэдэг, үйлчилгээг нь авдаг гэж судалгаанууд гарсан байдаг. Тэгэхээр энийг бас сайжруулах чиглэл дээр санал санаачилгууд гаргана гэж бодож байгаа. Хүний нөөцийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо маань 1 мянга гаруй аж ахуй нэгжүүдийг 30 хэдэн тусгай зөвшөөрлөөр, 10 хэдэн салбарт ингэж зохицуулалт хийж ажилладаг байгаа. Тэгэхээр 160 гаруй, 150 гаруй мэргэжилтнээр энэ ажлыг хийхэд бол үнэхээр хэцүү байдаг байх гэж би бас боддог. Тэгэхээр энэ одоо байгаа мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах чиглэл дээр бас санал санаачилга гаргаж ажиллана гэж бодож байгаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Болдбаатарын Энхбаяр. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон. Урд талд чинь дугаар байгаа тэрийг өргөнө шүү

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгээд Булгантуяа гишүүний асуултад маш тодорхой хариулъя. Миний хувьд бол 10-аад жил яг Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай байгууллага, мөн банк, ББСБ-д ажиллаж байсан туршлагатай. Сүүлийн 10 жил бол хэрэглэгч тал буюу худалдан авагч талд ажилласан. Хувийн хэвшилд ажилласан. Хөрөнгө мөнгө босгох тал дээр бол ажилласан. Тэгэхээр энэ Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлд нэрээ дэвшүүлсэн гол шалтгаан бол аль аль талд нь ажилласан надад туршлага байгаа учраас аль алиныхаа асуудлыг мэднэ. Тэр агуулгаараа энэ Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг илүү шуурхай болгох, илүү уян хатан болгох боломжтой юм байна гэдэг ийм итгэл үнэмшилтэйгээр нэрээ дэвшүүлсэн.

Миний хувьд бол үндсэн мэргэжил эдийн засагч. 2 дахь мэргэжил бол эрх зүйч мэргэжилтэй ийм хүн байгаа. Үндсэн 4 зорилго яг өөртөө, хувьдаа дэвшүүлсэн байгаа. Мэдээж Хяналтын зөвлөлийн эрх, үүрэг бол маш хязгаарлагдмал. Зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны гаргасан тогтоол шийдвэртэй холбоотой асуудал. Хэрэглэгчдээс ирсэн санал, гомдолтой холбоотой асуудлыг хэлэлцэх байгаа боловч өөрийнх нь идэвх санаачилгын хүрээнд хөрөнгийн зах зээлд олон нийтийн хөрөнгийн зах зээлд оролцогчид болоод олон нийтийн итгэлийг 1 дүгээрт сэргээх шаардлагатай байгаа. Энэ итгэлийг сэргээхийн тулд бид нар олон нийтийн болоод яг энэ сонирхогч этгээдүүдийн боловсрол, ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж харж байгаа. Энэ дээр бол Санхүүгийн зохицуулах хороо болоод мэргэжлийн экспертүүд, аж ахуй нэгжүүдтэй хамтарч ажиллана гэж бодож байгаа. Дэмжлэг үзүүлж.

2 дугаарт бол манай Санхүүгийн зохицуулах хороо яг мэргэжлийн байгууллагууд, мэргэжлийн оролцогчидтой байдаг учраас ер нь их хаалттай, мэдээлэл их хомс байдаг. Тэгэхээр энэ ил тод байдлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Гишүүдийн заримд нь бас саналууд гарч байна. Хувьцаат компаниуд ерөөсөө тайлангаа ил тод мэдээлдэггүй гэж байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын эзэд, даатгалын компанийн үйл ажиллагааны тайлангууд ил тод байдаггүй. Үүнээс болоод энэ санхүүгийн зах зээл, хөрөнгийн зах зээлтэй холбоотой

итгэлцэл бий болж өгдөггүй. Санхүүгийн зах зээл бол яг цэвэр итгэлцэл дээр тогтож явдаг салбар. Тэгэхээр энэ ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд Хяналтын зөвлөл бол өөрийнх нь эрх үүргийн хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагуудтай хамтарч ажиллана. Дээр нь нэмээд энэ дээр олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэхийн тулд олон нийтдээ нэлээн нягтарч ажиллана. Мөн салбарын мэргэжлийн экспертүүдтэй илүү хамтарч ажиллана гэсэн ийм яг хувийн амбицтай байна.

Эцэст нь бол хөрөнгийн зах зээл бол Монгол улсын эдийн засгийн тулгуур 2 баганын 1. Тэгэхээр өнөөдөртөө бол яах вэ, ихэнх хувийн хэвшлийнхэн болоод бизнесүүд хөрөнгө оруулалт, санхүүжилтийг арилжааны банкнуудаас маш их өндөр зардалтайгаар татаж авч байгаа. Тэгэхээр хөрөнгийн зах зээл өнөөдөр хамгийн сүүлийн мэдээллээр бол 10 хувийг эзэлж байгаа. Нийт зах зээлийн. Тэгэхээр энэ 10 хувийг бол бид нар ажиллах хугацаандаа ядаж бид нар олон улсын жишигт хүрдэггүй юм гэхэд 20-30 хувьд хүрэхийн төлөө ажиллана гэж ийм амбицтай, зорилго тавиад ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Чимэдийн Сайнбилэг нэр дэвшигч хариулъя. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Ч.Сайнбилэг: Миний хувьд банкны салбарт анхан шатаас нь эхлээд Санхүү эрхэлсэн гүйцэтгэх захирлын орлогч хүртэл нийтдээ 20 орчим жил ажилласан байдаг. Үүн дотроо миний хамгийн их удаан хугацаанд ажилласан, мэргэшсэн салбар бол хөрөнгө зохицуулалтын газар. Энэ нь өөрөө банкны актив хөрөнгийн байршил болон хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулах ийм үндсэн үйл ажиллагаа байсан.

2-т гэвэл би Монгол Улсад Хадгаламжийн даатгалын тогтолцоо нэвтэрсэнтэй холбогдуулан Хадгаламжийн даатгалын корпорацад анх үүсгэн байгуулахад нь орж ажиллаад, 3 жил орчим ажиллахдаа тухайн үеийн Анод банк, Зоос банк гэх мэт банкнуудын дараалсан дампуурлаас үүдэлтэй банкны хадгаламж эзэмшигчдийн банканд итгэхгүй байх, энэ үл итгэх итгэл алдагдсан нөхцөл байдалд энэ маш хэрэгтэй хууль батлагдаж, энэ тогтолцоог Монгол улсад нэвтрүүлэх талаар бол ажилласан байдаг.

Тэгээд хамт олныхоо хүчээр мөн арилжааны банкнуудын тогтолцоог хүлээж авах дэмжсэн дэмжлэг, дээрээс нь бид нар банкны системтэй болон төрийн бусад санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн холбогдох байгууллагуудтай хамтраад олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх тал дээр бол нэлээдгүй ажил зохион байгуулсны хүчинд дэлхийн хуримтлалын өдөр гэх мэт энэ онцлох ажлууд бол өнөөдрийг хүртэл тогтвортой, байнга явагдаж ирж байгаа. Ер нь миний хувьд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүний нээлттэй сонгон шалгаруулалтыг олж хараад, энэ бол миний хүсэж мөрөөдөж явж байдаг зүйлийг дөхүүлэхэд би өөрийнхөө оролцоог оруулах боломжтой юм байна гэж үзсэн.

Яагаад гэвэл манай Монгол Улсын санхүүгийн зах зээл хөгжиж, гадна дотнын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан ийм боломж, бололцоог бол бий болгоё гэвэл бий болох боломж байдаг. Тэгээд энийг өнөөдөр маш олон гишүүд бол энийг ярьж байна.

Тэгэхээр энэ санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд дутагдаад байгаа зүйлсийг оруулахад бол өөрийнхөө хувь нэмрийг оруулж ажиллах болно. Яг онцолж хэлэх юм бол хөрөнгийн зах зээл үнэхээр манай санхүүгийн зах зээл дээр бол ийм бага оролцоотой байдаг. Үүнийг хөгжүүлэхийн тулд бид нар анхаарч ажиллах ёстой. Ганцхан хөрөнгийн биржийн асуудал биш, Санхүүгийн зохицуулах хорооны ч асуудал биш. Энэ бол нөгөө санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл буюу Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорац, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад төрийн байгууллагуудын хамтын оролцоо, хамтын дэмжлэгтэйгээр энэ бүхнийг бий болгоно гэдэгт бол би итгэдэг.

Тийм учраас би энд хэрвээ сонгогдож цааш ажиллах юм бол энэ Хөрөнгийн зах зээлийн оролцоог нэмэгдүүлэх, түүнд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд ард иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх тал дээр бол санал санаачилга гаргаж ажиллах болно.

Мөн түрүүн Булгантуяа гишүүний асуултад дурдагдаж байсан цалин, урамшууллын асуудал болон хувийн зохион байгуулалттай асуудлуудыг яаж шийдэх гэж байгаа юм бэ гэдэг дээр бол миний хувьд ямар нэгэн байдлаар энэ албан тушаалыг хашиж, эрхэлж байх хугацаандаа бол цөөнхийн ч гэдэг юм уу бусдын нөлөөнд автаж ашиг сонирхлын зөрчил үүсгэж, хараат бусаар ажиллахгүй байх гэх мэт ийм зүйлүүдийг бол... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Соронзонболдын Халиунаа хариулт өгье. Битгий дараарай цаанаас нь асна. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

С.Халиунаа: Та бүхний өдрийн мэндийг эрье. Би хуульч Соронзонболдын Халиунаа байна. Хуульч мэргэжилтэй. 2011 онд Уэльсийн их сургуульд бизнесийн удирдлагаар хамгаалсан байгаа. Ирснээс хойш Ард, Апу ХК-аас 130 сая долларын Кредит Свисс бол болон И Би Ар Ди Эс ЕСБХБ-ны санхүүжилтээр ажиллах ажиллаж байсан. Мөн Ард санхүү нэгдэл дээр 2016-2019 онуудад бүх Ай Пи Өү болон 3 нэгдэл дээр хариуцаж ажиллаж байсан ийм туршлагатай байгаа. Хуульч мэргэжилтэй. Миний хувьд бол яг тодорхой яг аженда гэх юм уу яг тодорхой алсын хараатай орж ажиллая гэсэн бодолтой байгаа. Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын журмын 2.1.4 дээр Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд нь санал өгөх ийм зохицуулалт байж байгаа. Үүний хүрээнд 1 дүгээрт зөвхөн санхүүгийн тайлангаас гадна Дэлхийн банкнаас ерөөсөө манай банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн хэмжээнд бол маш шүүмжтэй хандаж байгаа. Гагцхүү өнөөдөр бол Дампуурлын тухай хуулийг бол ерөөсөө манай Монгол Улс бол ерөөсөө авч хэлэлцээгүй байгаа. Тэгэхээр банк бус санхүүгийн байгууллагууд нь чанаргүй зээл өсөөд байгаа. Тухайн зээлүүд нь дандаа иргэдийн хэрэглээний зээлийг хангаж байгаатай холбогдуулаад хамгийн 1 дүгээрт энгийн шийдэл бол банк бус санхүүгийн байгууллагуудын хяналт тавихаас илүү Дампуурлын тухай хуулийг батлах болчихсон.

Өнөөдөр манай Монгол Улсын Дампуурлын тухай хууль зөвхөн иргэн төдийгүй аж ахуйн нэгжүүдийн бас дампуурлын тухай хууль нь ерөөсөө огт зохицуулалт байхгүй байгаад байгаа. Өнөөдөр хэдийгээр 160 мянган арга буюу 210 мянган аж ахуйн нэгжүүдээс Сангийн яам 2 жилийн өмнө 50 мянган аж ахуйн нэгжүүдийг өргүй болон өр төлбөргүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр татварт өргүй гэсэн учраас татан буугдсан байгаа. Өөрөөр хэлбэл Дампуурлын тухай хууль нь ямар ч ажлаа хийхгүй байгаад байгаа учраас ингээд Төр нь оролцож энэ дээр явж байгаа. Тийм

учраас хамгийн 1 дүгээрт хэрвээ Хувь хүний дампуур хүний дампуурлын тухай хуулийг батлаад, хамгийн бага үнийн дүнгээр ингээд туршилтаар явуулах юм бол банк бус санхүүгийн байгууллагууд нь чанаргүй зээлийнхээ хэмжээг иргэдэд олгодог. Тэгээд дээрээс нь зөвхөн зохицуулалттай зах зээлээс гадна, зохицуулалтгүй зах зээлээс гадуур олгож байгаа сторпэй нь ямар нэгэн шалгуур үзүүлэлт байхгүй. Санхүүгийн зохицуулах хорооноос тавьж байгаа шалгуурыг 70/30-ийг хангахгүйгээр зээл олгож байгаа бас асуудлыг бол өөрөө энэ Дампуурлын тухай хуулиар зохицуулах боломжтой байгаа.

2 дугаарт Монголчууд төдийгүй ер нь эрх баригчид маань ерөөсөө бас зээлийн хүү дээр маш их төвлөрдөг юм байна. Санхүүжилт бол ерөнхийдөө үндсэн 2 санхүүжилтийн үндсэн арга хэрэгсэл байгаа юм. Нэг нь дебит финанс буюу зээлийн санхүүжилт, нөгөөх нь экюти финанс буюу зээлийн санхүүжилт. Тэгэхээр бас нэг талаасаа манай Монгол Улсын бизнес эрхлэгчид маань төдийгүй бодлого тодорхойлогч маань хүртэл ерөөсөө энэ зээлийн хүүгийнхээ хооронд л эргэлдээд байдаг юм байна. Хувьцааны санхүүжилтийг ерөөсөө Хөрөнгийн биржээр хардаг. Тэгээд Хөрөнгийн биржийн ерөөсөө топ 20 аж ахуйн нэгжээр төлөвлөдөг учраас хувьцааны санхүүжилт гэдгийн жижиг дунд компаниудын хувьцааны санхүүжилтийг ерөөсөө тэр болгон авч хэлэлцдэггүй юм байна. Тухайлах юм бол Компанийн тухай хууль дээр Компанийн тухай хууль маань өөрөө бид нарын хамгийн шүүмжлэлтэй ханддаг ОХУ-аас хоцорч явж байгаа. Өнөөдөр манай компанийн тухай хууль нь хувиараа бизнес эрхлэгч, ХХК, ХК гээд 3 бие даасан хуулийг зөвхөн ганцхан хуулиар зохицуулдаг. Өнөөдөр 163 мянган компаниудын хувьцаанд ямар нэгэн хөрвөх чадвар байхгүй. Компанид хөрөнгө оруулаад 20-30 хувийн хувьцаа эзэмшсэн тохиолдолд тухайн хувьцаагаа эргүүлэн худалдах зохицуулалт дээр маш туйлын хязгаарлагдмал. Өөрөөр хэлбэл 160 мянган аж ахуйн нэгжүүд нь хөрвөх чадвар байхгүй байгаад байгаа юм. Тийм учраас хэрвээ бид нар зээлийн санхүүжилтийн өөр алтернативыг хөгжүүлбэ гэж байх юм бол зөвхөн зээлийн хүү дээрээ анхаарлаа төвлөрүүлээд байхгүй. Эсрэгээрээ хувьцааны санхүүжилт, тэр дундаа хаалттай ХК-ийг бид нар бид илүү эргэлтэд оруулах боломжтой юм. Харамсалтай нь хаалттай ХК-ийн хувьцаа нь илүү яагаад ингээд хөрвөгддөг вэ гэхээр өнөөдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв гэдэг компанийн маш өндөр шимтгэлтэй бүртгэлийн ажиллагаа дээрээс өнөөдөр шимтгэл авдаг учраас өнөөдөр хүн жишээлбэл 100 сая төгрөгийн хувьцаа авлаа гэхэд тухайн шимтгэл нь 2,5 гэх мэтчилэн маш өндөр шимтгэлтэй байдаг учраас ХХК-удын цааш нь дараагийн шатад бол ерөөсөө гарах ийм хөгжил нь .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн 1 минут тодруулж асууна. Улсын Их Хурлын гишүүдийг чуулганы танхимд цугларахыг хүсье. Санал хураалт явагдана.

Х.Булгантуяа: Нэр дэвшиж байгаа Оч, Энхбаяр, Халиунаа, Сайнбилэг нар бол угаасаа ажилласан туршлагаараа, мэдлэг туршлагаараа бол асуудалгүй хүмүүс байна лээ. Зүгээр манай Эдийн засгийн байнгын хороо бас энэ дээр анхаармаар байна. Тэгсэн мөртөө Газар зохион байгуулагч хүнээр, тэрүүгээр 20 жил ажилласан, тэгээд түрүүн Сайнзориг гишүүний асуултад тэгж хариулж л дээ. Би ББСБ-д 6 сар ажилласан гээд тийм хүнээ болохоороо Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлж оруулж ирж бас арай л болохгүй байх. Энэ Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн салбар гэдгийг бас арай ч ингэж хөнгөн харж бас арай болохгүй байх энэ чинь. Тэгээд энд гарч байгаа бүх өргөдөл гомдлын асуудлуудыг шийдвэрлэх газар нь шүү дээ 1 дүгээрт.

2 дугаарт яах вэ, би зүгээр тэгж л асуусан юм. Та бүхэн маань ингээд орон тооны бус гишүүд болоод цалинтай, цалингүй байхаар хажуугаар нь өөр яг үүнтэй харилцан хамааралтай ашиг сонирхолтой ажил хийхгүйгээр гайгүй биз дээ. Ашиг сонирхлын зөрчилд өртөхгүй биз дээ. Гайгүй биз дээ гэдэг асуултыг тавьсан юм. Тэрнээс та бүхэн маань бүгдээрээ хийх ажлаа бол мэдэж байгаа юм байна. Туршлагатай юм байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явагдана. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэл. Санал хураалтад орж амжаагүй гишүүд байна уу. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд орсон гишүүд орж ирж байгаа юм байна. Аюулгүй байдлын байнгын хорооны гишүүдийг орж ирэхийг урья. Өнөөдөр олон асуудал байгаа учраас асуудлаа цаг тухай бүрд нь шийдвэрлээд явна. Гишүүд өнөөдөр бүтэн суугаад, идэвхтэй сайн оролцоод асуудлаа түргэн шуурхай шийдвэрлээд явъя. Намрын чуулган завсарлах хугацаа дөхсөнтэй холбогдуулан хэлэлцэх асуудлуудыг эцэслэн шийдвэрлэх чухал байгаа.

Байнгын хорооны саналаар Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр томилох санал хураалт явуулна.

Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажилд томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 50 гишүүн буюу 55,6 хувиар санал дэмжигдлээ.

Оюунтөгсийн Очийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 56 гишүүн буюу 62,2 хувиар санал дэмжигдлээ.

Болдбаатарын Энхбаярыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 59 гишүүн буюу 65,6 хувиар санал дэмжигдлээ.

Чимэдийн Сайнбилэгийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 51 гишүүн буюу 56,7 хувиар санал дэмжигдлээ.

Соронзонболдын Халиунааг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 54 гишүүн буюу 60 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналаар Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээс чөлөөлөх санал хураалтыг явуулна.

Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Равсалын Ренчинбазарыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас, Батболдын Амарсанаа, Дүгэрээгийн Цэрэнбадам, Жадамбаагийн Эрдэнэбилэг нарыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт

ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 59 гишүүн буюу 65,6 хувиар дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Дэмжигдсэн дарга, Хяналтын зөвлөлийн гишүүдэд ажлын амжилт хүсье. Улсын Их Хурлын гишүүдийн хэлсэн үгийг маш сайн анхаарч ажиллана. Энэ бол та бүхэнд өгсөн шагнал биш. Улсын Их Хурлын хяналт тавих чиг үүргээ гүйцэтгэж байгаа гэдгийг та бүхэн анхаарч ажиллаарай. Ажлын амжилт хүсье.

13.40 цаг.

Дараагийн асуудалд оръё. **Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Нэр дэвшигчийн талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Энхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн нэр дэвшигчийг бүртгэх тухай 5 дугаар тогтоолын дагуу зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд Намсрайн Батнасан, Раднаасэдийн Даваадорж, Батбаатарын Мөнхзаяа, Бямбажавын Энх-Амгалан нарын нэрийг дэвшүүлсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 3 дугаар тогтоолоор баталсан Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу нэр дэвшигчид нь өөрийн танилцуулга, холбогдох бусад баримт бичгээ бүрдүүлж, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1-д заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг товыг тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай тогтоолыг баталж, 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддоржийг томилсон.

Эдийн засгийн байнгын хорооноос 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан нэр дэвшигчийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батшугар, Ганхуяг, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд,

Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг, Цогтбаатар, Эрдэнэбат нарын гишүүд оролцсон болно.

Байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонгол явуулсан талаарх сонголын тайланг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гарган танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Төрөөс малчдад олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах тухай хуулийн төслийг санаачилсан этгээд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшиж байгаа нь зүйд нийцэж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Намсрайн Батнасан, Раднаасэдийн Даваадорж, Батбаатарын Мөнхзаяа, Бямбажавын Энх-Амгалан нарыг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь тухай бүр дэмжсэн болно.

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Цэрэндоржийн Батсүх, Цэдэвсүрэнгийн Мөнхбаяр, Чулуундоржийн Хашчулуун нарыг Монголбанкны Мөнгөний бодлогын орон тооны бус гишүүдээс чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн сонголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энхцэцэг гишүүнд талархал дэвшүүлье.

Чуулганы хуралдааны танхимд нэр дэвшигч Намсрайн Батнасан, Раднаасэдийн Даваадорж, Батбаатарын Мөнхзаяа, Бямбажавын Энх-Амгалан нар хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны санал, дүгнэлт болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 7 гишүүнээр, 8 гишүүнээр тасаллаа.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууж, үг хэлье.

Л.Соронзонболд: Тэгэхээр энэ ирэх 2025-2028 онд Монгол Улс эдийн засгаа тэлж, 1 хүнд ноогдох ДНБ-ээ 2 дахин нэмэгдүүлэх ийм зорилт тавьсан байгаа. Нөгөө талдаа Монголбанкны мөнгөний бодлого бас төсвийн бодлогоос хараат бусаар ажиллах ийм шаардлага байгаад байгаа юм. Тийм учраас энэ Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшиж байгаа хүмүүсийн үүрэг роль маш их чухал байгаа. Хамтарсан шийдвэр гаргах ёстой. Дээрээс нь хараат бус, хариуцлагатай байх ёстой байгаад байгаа юм. Тийм учраас

орон тооны бус гишүүнээр хэрвээ та бүхэн сонгогдох юм бол бас энэ зарчмаа маш сайн баримталж ажиллаарай гэж 1 дүгээрт захимаар байгаа юм.

2 дугаарт болохоор бол Монголбанкны мөнгөний бодлого дээр ялангуяа уламжлалт бус мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг яаж энэ Монгол Улсынхаа эдийн засгийн нөхцөл байдалд тохируулж хэрэгжүүлэх вэ гэдэг дээр бас нэлээн сайн судалж, бас санал онолоо хэлж байгаарай гэж захимаар байгаад байгаа юм. Ялангуяа өнөөдрийн та бүхэн Улсын Их Хурлын чуулган дээр гишүүдийн хэлж байгаа саналыг сайн харж байгаа байх. Зээлийн хүүг бууруулах шаардлагатай байна. Ялангуяа бизнес эрхэлж байгаа, ажлын байр бий болгож байгаа, ДНБ-ийг нэмэгдүүлэх талаар ажиллаж байгаа энэ хэсэг рүү чиглэсэн бодлого дээр нэлээн сайн анхаараарай гэдэг дээр үгээ хэлж байгаа. Тийм учраас энэ дээр та бүхэн бас сайн анхаарч ажиллаарай гэж хэлмээр байгаа юм.

Нөгөө талдаа бол энд бүтээмж Монгол Улсын хувьд бол энэ бүтээмжийг нэмэгдүүлэх тал дээр бол их анхаарах шаардлагатай байгаа. Тийм учраас энэ технологийн дэвшлийг ашигласан энэ төлбөр тооцоонд энэ бүх бизнесийн үйл ажиллагаанд энэ технологийн дэвшлийг ашиглах дээр нэлээн сайн анхаарах ёстой. Ялангуяа энэ олон улсын төв банкууд Төв банкны тоон валютыг бол нэвтрүүлж байна. Жижиглэнгийн хэлбэрээр нэвтрүүлж байна. Бөөний хэлбэрээр нэвтрүүлж байна. Монгол Улсын одоогийн нөхцөл байдалд хараад үзэхэд аль нь зөв бэ гэдэг дээр та бүхэн бас нэлээн сайн дэнсэлж байж, шийдвэр гаргаж энэ талын бодлогыг хэрэгжүүлээрэй гэж хэлмээр байгаа юм. Тэгээд өнөөдөр саяхан болж өнгөрсөн Монголбанкны Мөнгөний бодлогын хороогоор төгрөгийн болоод гадаад валютын заавал байлгах нөөцийг бол 2 хувь нэгжээр нэмэгдүүллээ. Энэ талаар та бүхний өөрсдийн чинь хувь эдийн засагчдын байр суурь ямар байна вэ гэж асууя.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Хэнээс нь асуух юм. 4 нэр дэвшигч хариулт өгье. Ажлын хэсгийн 16 дугаар микрофон нэр дэвшигч Бямбажавын Энх-Амгалан.

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын дарга болон Улсын Их Хурлын гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгэхээр эдийн засгийн нөхцөл байдал маань ер нь бол харьцангуй бас сайжирч байгаа. Гэхдээ бас тодорхой хугацаанд бас мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор Монголбанкнаас мөнгөний бодлогыг 10 хувьд хэвээр байлгах, дээрээс нь арилжааны банкны заавал байлгах нөөц болон зохистой харьцааг бол нэмэгдүүлэх ийм шийдвэр гаргасан. Тэгэхээр энэ маань бол яах вэ, тодорхой түвшинд бол зах зээл дээр хэт их мөнгөний нийлүүлэлтийг бий болгохоос бол сэргийлсэн арга хэмжээ гэж ингэж үзэж байгаа. Тийм болохоор энэ маань бас тодорхой хугацаанд өөрчлөлтүүд хийгдээд явчих боломжтой учраас энэ хязгаарлалтыг бас тодорхой хугацаанд хэрэгжүүлээд явах нь зөв болов уу гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн дараагийн микрофоныг өгье. Асчихсан байна.

Н.Батнасан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд та бүхний өнөөдрийн амгаланг айлтгая. Гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө бол ямар нэгэн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд гарч ирж байгаа үр дүн нь ямархуу байгаа вэ гэдгийг макро эдийн засагт гарч байгаа тэр өөрчлөлтүүд дээрээ бид нар харж дүгнэх ёстой. Тэгээд сая мөнгөний бодлогын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дараа ханш болоод макро эдийн засгийн томхон өөрчлөлтүүд бол 1 дүгээрт гараагүй байна.

2 дугаарт бол би энэ бодлогыг холбож үзэхдээ ерөнхийдөө зах зээл дэх сүүлийн үед бол бас энэ төсөв нэлээн тэлэгдэж байгаа учраас тэр зах зээл дээр гарч байгаа мөнгөний нийлүүлэлтийг тодорхой хэмжээнд хязгаарлах үүднээс энэ арга хэмжээг авлаа гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд энэ нь бол зөв зохистой арга хэмжээ байжээ гэж харж байгаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн дараагийн микрофоныг өгье.

Б.Мөнхзаяа: Улсын Их Хурлын гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгээд Соронзонболд гишүүний асуултад 2024 оны 11 сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт 41,5 тэрбум төгрөг байна. Их наяд төгрөг байна. Өнгөрсөн оноос бол 10 гаруй хувиар өссөн. Тэгэхээр энэ мөнгөний нийлүүлэлтийн өсөлт маань өөрөө инфляцыг тэлэх, нэмэгдүүлэх ийм сөрөг нөлөөллийг авчирч байгаа учраас төв банкны мөнгөний бодлого бол өөрөө эрсдэлээс хамгаалах, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг барих зорилготой учраас урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ зүй ёсны арга хэмжээ гэж ингэж үзэж байгаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн дараагийн микрофоныг өгье.

Р.Даваадорж: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд саяын зөвлөлийнхөө гишүүнд нэр дэвшиж байгаа, миний өмнө хэлсэн 3 хүний хэлсэн зүйл нь бол бас зөв зүйтэй. Тухайлах юм бол мөнгөний масс М2-оор хэмжигддэг хэмжүүр бол зөвхөн 2, 3 сарын дотор 2 их наядаар нэмэгдсэн тийм статистик харагдаж байна лээ. Дээр нь сонгууль болж байгаатай холбоотойгоор бол бас нэлээн хэдэн ийм арга хэмжээ авсан гэдгийг бид нар бүгд мэдэж байгаа. Цалинг 2, 3 удаа нэмлээ. Тэтгэвэр нэмсэн. Ойрын үед цахилгааны үнэ өсөж байгаатай холбоотойгоор энэ бэлэн мөнгөний эргэлт, бэлэн мөнгөний масс нэлээн нэмэгдэж байгаа. Дээр нь бол төсөв тэлэлттэй батлагдсан гэдгийг манайхан бас сая манай энэ хүмүүс хэллээ.

Гадаад худалдааны статистикийг харах юм бол экспорт хэдийгээр 6 хувиар нэмэгдэж байгаа ч импорт асар өндөр 26 хувийн өсөлттэй гэх мэтийн ийм нэлээн хэд хэдэн ийм шалтгаануудтай холбоотойгоор зайлшгүй байх нөөцийг бол 2 хувьд өсгөсөн байна гэж би хувьдаа бол харж байгаа. Энэ бол зөв шийдвэр байна гэсэн ийм дүгнэлтийг бол хувьдаа хийсэн.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Яах вэ 2 хоног үндсэндээ сонсгол хийгээд, нэлээн бас шүүсийг нь шахсан. Тэгээд яах вэ, би Даваадорж нэр дэвшигчид хандаж өмнө нь бас хэлсэн. Өнөөдөр бас протоколд оруулъя гэж бодоод өнөөдөр бас хэлж байгаа юм шүү хандаж. Та бол Улсын Их Хурлын дэд даргын ахлах зөвлөх. Монголбанк дээр ямар нэгэн улс төржилтийн аль нэг улс төрийн намын бодлого хэрэгжүүлэх ийм зүйлийг огтоос хэрэгжүүлж болохгүй шүү гэдгийг танд сануулж хэлэх гэсэн юм.

Бусад нэр дэвшигчид нь анхааруулаад хэлэхэд бол өнөөдөр Дэлхийн банкны хийсэн судалгаа, ОУВС-ийн хийсэн судалгаа дээр Зомби аж ахуйн нэгж гэдэг нэр томьёо байдаг. Тэр нь ямар аж ахуйн нэгжийг хэлдэг вэ гэхээр нөгөө татаасаар, хүүгийн татаасаар амьдардаг аж ахуйн нэгжүүдийг энэ олон улсын хөрөнгийн зах зээл дээр бол зомби аж ахуйн нэгж гэж хэлдэг. Өнөөдөр манайх үндсэндээ 5,5 их наяд төгрөгийг зээлийг хүүгийн татаасны санхүүжилтээр ийм хэмжээний зээлийг

олгосон байдаг. Тэгэхээр зомби аж ахуйн гэж яг юу гэж хэлээд байна гэхээр үндсэндээ бол бага хүүтэйгээр ингээд зээл авдаг, тэгээд тухайн компанийнхаа амьдрах чадвар нь ерөөсөө бага хүүтэй зээл дээр л оршин тогтнодог компаниудыг хэлдэг. Манайх бол үндсэндээ бол ийшийгээ маш их эрчтэй орж байгаа. Манай хөдөө аж ахуйн салбар, мал аж ахуй, ингээд явсаар байгаад л бүгдээрээ хүүгийн татаас өгдөг болсон. Тэгээд тэрний үр дүнд юу болж байна гэхээр ерөөсөө өрсөлдөх чадваргүй баахан компаниуд бий болж байгаа. Тэгэхээр энэ дээр бол та бүхэн маань бас анхааралтай ажиглаж, энэ Засгийн газарт бодлогын зөвлөмжөө хүргүүлдэг бүх ажлын хэсэг дээр төв банкнаас угаасаа хүн ордог. Тэгээд тийм учраас энэ татаас, хүүгийн татаас гэсэн энэ асуудал дээр жоохон багасгамаар байгаа юм. Тийшийгээ зээл нь олгогдоод эхлэхээр энгийн аж ахуйн нэгжүүд нь зээл олгогдохоо больдог. Хэн нэгэн даргын татаастай компаниудтай өрсөлдөх болдог. Тэгээд энэ дээр бол маш их энэ хянуур хандмаар байна.

Мөн энэ ипотекийн зээл гээд манайх чинь ингээд 6 хувьтай, орон нутагт 3 хувьтай зээл олгоод эхэлснээс хойш бол ипотекийн зээл нь олдохоо больсон. Мөн орон сууцын үнэ ч талийгаад, хүмүүс худалдан авах чадвар нь ч байхгүй болж байна. Тэгээд энэ хүүгийн татаас юм уу, ипотекийн зээл байна уу бүгдийг нь бодлогынхоо хүүтэй уя. Бодлогын хүүтэй нь уячих юм бол ядаж тэр арилжааны банкнууд чинь төв банканд байршуулах уу, ипотекийн зээлд байршуулах уу гэдэг шийдвэрээ гаргах боломжтой болно гэсэн үг. Тэгж байж бид нар арилжааны банкнуудыг энэ ипотекийн зээл рүү илүү сонирхох энэ юуг нь оруулах боломжтой болно. Эргээгээд тэр зээлээ дараад нь дамжуулан худалдах боломжууд нэмэгдэх юм байгаа юм. Энэ тал дээр онцгой анхаарч ажилламаар байгаа юм. Тэгээд энэ дээр та бүхний байр суурийг бас сонсчихмоор байна. Би энэ хүүгийн татаастай холбоотой асуудлыг дараа нь дахиад нэг тодруулж бас та бүхэнд дахиад хэлнэ.

Х.Булгантуяа: Нэр дэвшигчдээс хамгийн баруун талын микрофон юм байна. Тохойгоо өргөөдхөөрэй. Микрофон нь асчихлаа.

Р.Даваадорж: Гишүүний асуултад хариулъя. Эхлээд миний нэр дурдагдсан учраас би бас энэ дээр нь тайлбар өгье гэж бодлоо. Би өнгөрсөн 2 парламент дараалан Улсын Их Хурлын Ардчилсан намын бүлгийн зөвлөхөөр ажиллаж байхдаа бол мэдээж бас улс төрийн тийм өнцгөөс бол аливаа асуудалд хандаж байсныг би хүлээн зөвшөөрч байгаа. Одоо энэ парламентын хувьд бол би бүлгээсээ гараад Их хурлын даргын зөвлөхөөр ажиллаж байгаа. Тэгээд ер нь судалгаандаа голчлон анхаарч байгаа учраас би таны тэр болгоомжлолыг бол ойлгож байгаа. Энэ дээр би бас анхаарч ажиллана. Тийм улс төржсөн асуудал гарахгүй гэдгийг хэлэхийг хүсэж байна.

2 дугаарт зомби компаниудын талаар та дурдлаа. Энэ бол бас их сонирхолтой ийм зүйл байдаг. Зомби компаниуд гээд ковидтой холбоотойгоор энэ дэлхийн улс орнуудад төсвийн тэлэлт их яваад, маш их хэмжээний хөнгөлөлттэй зээлүүд олгогдсон. Тэрний дараа энэ 2022 оны сүүлээр Массачусе их сургуулийн нэлээн олон эрдэмтэд оролцсон ийм том судалгаа хийсэн. Энэ ковидтой холбоотой хөнгөлөлттэй арга хэмжээнүүдийн алдаа нь юу байсан бэ гэдэг дээр энэ зомби компани гэдэг зүйл орж ирсэн. Асар их хэмжээний зомби компаниуд бий болсон. 2 доллар тутмын бараг 1 доллар нь ямар ч үр дүнгүй явсан гэсэн ийм үр дүн гарсан. Тэгэхээр энэ талын судалгаа бол Монголд байхгүй. Саяын гишүүн бол ярьж байна. Тэгэхээр энэ дээр бас тодорхой хэмжээний Монголбанкны тэр судалгааны байгууллагууд, бусад их дээд сургууль, санхүүгийн их дээд сургуулиудыг хамарсан

ийм судалгаа хийж байж ингээд бас тодорхой тоонуудыг энэ Их Хурал дээр бодлогоор бас ярих нь зөв байх гэж бодож байна. Тэгэхээр тантай бас санал нэг байна.

Ипотекийн зээлийн хувьд бол 8, 9 их наяд төгрөгийн зээл байгаа. Мэдээж бас их хүндрэлтэй. Сүүлийн үед бол хүссэн хүндээ олдохгүй ийм зүйл байгаа. Гэхдээ бодлогоор бол ипотекийн зээлийг цааш нь явуулах шийдвэр гарч байгаа. Гэхдээ Засгийн газар байх уу, Монголбанк дээр байх уу гэдэг ийм маргаан бол сүүлийн 4 жил явлаа шүү дээ. Тэгээд Монголбанк дээрээ л одоохондоо байж байх шиг байна. Ер нь бол Монголбанк дээр байх ёсгүй л гэж үздэг юм билээ. Тэгэхээр энэ дээр бол мэдээж тэр бодлогын хүүтэй уяна гэдэг бол их зөв зүйл, зөв санаа байна. Энийг бид нар цаашдаа бас хэрвээ ийм төрлийн асуудал гарах юм бол хэлэлцэж ярилцаж, таны саналыг бас авч хэрэгжүүлэх тал дээр ажиллана гэдгийг хэлэхийг хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Нэр дэвшигч нартаа амжилт хүсье. Бас нэлээн сайн ярилцсан болохоор нэмэлт асуулт байхгүй. Саяын анхааруулгаас гадна, ер нь бол та бүхнээс хамааралтайгаар бодлогын хүү тодорхойлогддог болно. Төгрөгийн ханшны асуудал та бүхнээс тодорхойлогддог болно. Инфляцын түвшин дээр та бүхэн бас оролцдог болно гэсэн үг. Тэгээд тийм учраас та бүхнийгээ ямар ч байсан Засгийн газрын түрийвч байж болохгүй шүү төв банк. Түрийвч байж болохгүй шүү. Аль нэг арилжааны банкны түрийвч байж болохгүй шүү. Тэгээд энэ дээр л та бүхэндээ анхааруулж хэлэх гэсэн юм. Та бүхэндээ амжилт хүсье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Баярлалаа та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Мөнгөний бодлогын хороонд томилогдох гэж байгаа хүмүүст бүгдэд нь амжилт хүсье.

Тэгээд мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах нь Монголбанкны үндсэн зорилго. Тэгээд энэ зорилгын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлууд ерөөсөө орхигдсоор байгаад өдий хүрээд, өнөөдөр 1 доллар 3420 төгрөгтэй тэнцэж байна. Тэгээд энэ чиглэлд түлхүү анхаарч ажиллаж, тодорхой хугацааны дараа Монгол төгрөг чинь долларын эсрэг аливаа валютын эсрэг чангардаг үр дүнд хүргэж ажиллах тал дээр та бүгдийн бодлыг сонсьё гэж байгаа юм. 1 дүгээрт.

2 дугаарт бол энэ мөнгөн тэмдэгт чинь аливаа улсын валют өөрөө алтаар баталгаажсан мөнгөн тэмдэгтийг чинь л бид нар валют гэж ойлгоод байгаа шүү дээ. Гэтэл Монгол Улсад энэ алт байтугай бүх байгалийн баялаг байна. Алт нь байна. Мөнгө нь байна. Зэс нь байна. Молибдин нь байна. Хүдэр нь байна. Нүүрс нь байна. Сая бид нар бүр стратегийн бүтээгдэхүүн ураныг олборлоод, борлуулах гэрээг нь Улсын Их Хурал батлаад өгчихлөө. Тэгээд эд нар дээр бид нар яг энэ своп хэлцэл гэдгийг мэргэжлийн түвшинд хийж, амь оруулж, нүүрс аваад байгаа Хятадтай своп хэлцэл хийх, уран аваад байгаа Францтай своп хэлцэл хийх, бусад манай энэ алтыг аваад байгаа Швейцартай ч гэдэг юм уу, бусад улс орнуудтай бид нар ингээд своп хэлцэл хийгээд, энэ төгрөгийн худалдан авах чадвар, төгрөгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх тал дээр маш сайн анхаарч ажиллаасай гэж бид та бүхнээс бүр хичээнгүйлэн хүсэж байгаа шүү. Энийг бас нэг сайн анхаарч ажиллаарай гээд, тэгээд энэ дээр хариулт авчихъя. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс аль микрофон хариулах вэ. Ажлын хэсгийн микрофон өгье.

Н.Батнасан: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр инфляц өндөр байна. Энийг яаж бууруулах вэ, энэ дээр ямар зүйл хийх вэ гэж асуусан гэж ойлгосон зөв үү. Мөнгөн тэмдэгт. Тэгэхээр мөнгөн тэмдэгтийн ханш бол ерөнхийдөө инфляц, мөн валютын ханш гэсэн 2 зүйлтэй бид нар мөнгөн тэмдэгтийнхээ тогтвортой байдлыг бол авч үзэж байгаа. Тэгэхээр 1 нь болохоор зэрэг дотоодын зах зээл дэх бараа таваарын үнийн өсөлттэй холбоотой ойлголт, нөгөөх нь бол гадаад тэнцэл буюу Монгол Улсын экспорт, импортын зөрүүтэй холбоотой ийм зүйлүүдээр бол Монгол төгрөгийн тогтвортой байдал бол хэмжигдэж байгаа юм. Тийм учраас бол яах вэ, бид нарын хувьд бол төгрөгийн ханшийг дотооддоо инфляцын түвшнийг бага барихын тулд бол бид нар тодорхой зүйл дээр бас анхаарах ёстой. Энэ дээр бол юу гэж харж байгаа вэ гэхээр зэрэг бид нар бас төсвийн бодлого дээр ялангуяа хэрэглээний чиглэлийн зарцуулалтыг багасгах, ер нь хэрэглээний чиглэлийн зарцуулалтыг багасгах, хөрөнгө оруулалтыг бол аль болох их нэмэгдүүлэх чиглэл дээр бол бодлогоо чиглүүлэх ёстой гэсэн ийм зүйлийг бол харж байна.

2 дугаарт бол ханшны тухайд бид нар бас энэ гадаад валютынхаа нөөцийн асуудал дээр бол анхаарах ёстой. Үүнээс гадна экспортоо нэмэгдүүлэх, импортын хэрэглээг бол бас тодорхой хэмжээнд хязгаарлах, импортдоо бол бас хэрэглээний гэхээсээ илүү хөрөнгө оруулалтын чиглэлтэй импортыг тэр давамгайлах тэр тал дээр нь бол бас анхаарах ёстой гэж ингэж харж байна.

Х.Булгантуяа: Даваагийн Цогтбаатар гишүүн нэмж тодруулах уу. Бүгдээс нь. Ажлын хэсгийн гишүүний микрофоныг 1, 1-ээр нь өгчхөөрэй.

Б.Энх-Амгалан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь бол мэдээж төгрөгийн тогтвортой байдлыг хадгалахын тулд гол хийх зүйл маань болохлоороо мэдээж инфляцыг бага түвшинд барих асуудал байгаа. Энэ инфляцыг бага түвшинд барихад гол нөлөөлөх зүйл маань болохлоороо импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнийг аль болох бага байлгах, өөрөөр хэлбэл дотооддоо бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх чиглэл рүү илүү түлхүү анхаарах ийм шаардлага байгаад байгаа гэж ингэж харагдаж байгаа. Тэгэхээр ер нь бол цаашдаа зүгээр бодлогын хорооны гишүүнээр сонгогдсон тохиолдолд ер нь импортын бараа бүтээгдэхүүнийг орлуулах чиглэлийн бүтээгдэхүүнүүдэд илүү анхаарах тал дээр бол ажиллана.

Мөн төгрөгийн ханшийн асуудал дээр буюу гадаад ам.доллартой харьцаж байгаа харьцааны хувьд аваад үзэх юм бол энэ маань мэдээж экспортыг дэмжих чиглэл дээр бол илүү анхаарах ёстой. Тэгэхээр энэ чиглэл дээр бол мэдээж эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, манай улс зөвхөн уур уурхайн бүтээгдэхүүнээс хамаарах хамааралтай байдлыг багасгаж, илүү импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнийг орлох чадвартай, мөн гадагшийгаа дижитал болон технологийн чиглэлийн бүтээгдэхүүнийг экспортлох боломжтой энэ чиглэл рүү илүү түлхүү анхаарч ажилласан тохиолдолд энэ төгрөгийн ам.доллартой харьцах ханш маань чангарах боломж бүрдэнэ. Дээрээс нь инфляц буурах ийм нөхцөл үүснэ гэж миний зүгээс үзэж байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн дараагийн микрофоныг өгье.

Б.Мөнхзаяа: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Эхний асуултыг төгрөгийн ханш чангарах нөхцөл юу байх вэ, тэгээд энэ дээр ямар ажлууд хийгдвэл зүгээр вэ гэсэн асуулт гэж ойлгосон. Валютын ханш гэдэг бол төгрөгийн үнэ байдаг. Тэгэхээр төгрөгийн үнэ бол гадаад валют нэмэгдэж орж ирж байгаа тохиолдолд бол өснө. Тэгэхээр гадаад валют орж ирэх боломжууд гэхээр экспорт нэмэгдэх, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх, гадаад өр нэмэгдэх гэсэн ийм мөнгөн урсгалууд байгаа. Тэгээд энэ дундаасаа бол экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад валютыг оруулах чиглэлээр мөн энэ хөрөнгө оруулалтын орчин дээр бас тодорхой ажлууд хийгдэж байж Монгол улсад бас төгрөг урт хугацаандаа ингэж байх боломж бүрдэнэ гэж ингэж ойлгож байгаа. Мэдээжийн хэрэг импорт дээр тодорхой асуудлууд бол яригдах байх. Гэхдээ энэ уул уурхайн бүтээгдэхүүн олон улсын зах зээл дээр гарч арилжигдахдаа яг зах зээлийн үнээр арилжаалагдаж байна уу, дээрээс нь хил боомт дээр бас гацалт үүсэж байна уу гэдэг нь бол бас борлуулалтыг хязгаарлах ийм асуудлууд байдаг гэж ингэж ойлгодог.

2 дахь асуулт нь бол энэ своп хэлцлийг үр дүнтэй хийх замаар төгрөгийн ханшийг сайн байлгах тал дээр бол илүү нарийвчилж ажиллаарай гэдэгтэй санал нэг байна. Тэгэхээр хийгдсэн арилжаануудтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хэрвээ яг томилогдоод ажиллавал авах боломжтой. Тэгэхээр энэ дээр бол анхаарч ажиллана гэж хэлэх гэсэн юм.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн дараагийн микрофоныг өгье.

Р.Даваадорж: Манай нэр дэвшиж байгаа хүмүүс ерөнхийдөө онолынх нь талаас нь гишүүний асуултад ерөнхийдөө хариулчихлаа. Би яах вэ, энэ дээр хэд хэдэн тоо хэлье гэж бодож байгаа. Монгол Улсын гадаад худалдаа 25 тэрбум долларт эргэлдэж байгаа энэ 2024 оны байдлаа. Эндээс 14 тэрбум долларын экспорт, 11 тэрбум долларын импорт хийсэн. Өөрөөр хэлэх юм бол 3 тэрбум доллар бид нар илүү байна. Энэ гадаад худалдаанаасаа. Тэгээд яагаад валютын ханш өсдөггүй вэ. Валютын ханш нь буурахгүй өсөөд байна гэдэг ийм асуулт ер нь их олон хүн тавьдаг л даа. Яагаад энэ Монголбанк чинь энэ валютынхаа ханшаа барихгүй байна. Үндэсний мөнгөн тэмдэг чинь ингээд үнэгүйдээд байна гэдэг ийм асуулт тавьдаг. Тэгэхээр хэдийгээр энэ гадаад худалдааныхаа энэ статистикийг харах юм бол их боломжийн харагдаж байгаа боловч бид нар бас экспорт, импортоо харах юм бол экспорт нь өнгөрсөн жилийнхтэйгээ харьцуулахаар 6 хувиар өссөн, импорт нь 26 хувиар өссөн ийм асуудал байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол бодлогын дүн шинжилгээ хийж бид нар ажиллах ёстой гэж ингэж харж байгаа. Зөвхөн Монголбанк биш, Улсын Их Хурал дээр байгаа манай гишүүд, манай Улсын Их Хурлаас гол шийдвэр гаргадаг та бүхэн бас энэ дээр бас анхаарч ажиллах байх гэж бодож байгаа.

Өнгөрсөн жил согтууруулах ундаа, тамхи гэхэд л 1 тэрбум доллароор импортолчихсон байна. Энэ бол урьд нь ийм их хэмжээгээр импортолж байгаагүй. Ямар учраас ийм их хэмжээний согтууруулах ундаа, тамхи импортолсон бэ гэдэг дээр бас бид нар эргэж харах ёстой байх гэж бодож байна.

Автомашин гэхэд 60-70 мянгыг импортоор авдаг байсан бол 120 мянган машин болж ингэж өссөн байна. Энэ чухам юутай холбоотой байна вэ гэдгийг бас бид нар авч үзэх ёстой байх.

Нүүрсний хувьд бол оны эхнээс 100-120, манай голлох гадаад худалдааны 60, 70 хувийг дангаараа даадаг нүүрсний салбар гэхэд 100-120 долларын тонн ханштай байсан нүүрс маань 70, 80 руу унаж ирлээ шүү дээ. Тэгэхээр цаашид бас энэ байдал хэрвээ үргэлжлэх юм бол эдийн засаг дээр бол хүндрэл үүсэх нь ээ. Валютын ханш дээр хүндрэл үүсэх нь ээ. Тийм учраас бид нар ямар төсвийнхөө хувьд ч гэсэн, энэ Улсын Их Хурал дээр гаргаж шийдвэрийнхээ хувьд ч гэсэн зөв зүйтэй бодлого харахгүй бол энэ статистик тооцооллоо харах юм бол бас байдал хүндэрч байна шүү гэдэг ийм дохио өгч байгаа. Тийм учраас бас энэ дээр Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн хараат бус гишүүдээс шалтгаалах зүйл энэ дээр бол нэг их байхгүй байх. Гэхдээ бид нар бол аль болохоор өөр өөрсдийнхөө хэмжээнд энэ асуудалд бас анхаарлыг хандуулж, ингэж ажиллана гэж бодож байна.

2 дугаар асуулт своп хэлцлийн хувьд бол Монгол Улсын хувьд бол их гунигтай түүхтэй байдаг. 2010 онд бид нар Хятадын Ардын Банкнаас 2 тэрбум орчим, эхлээд 10 тэрбум, дараа нь 5 тэрбум, ойролцоогоор 2 тэрбум долларын своп хэлцлийг хийж авсан. Харамсалтай нь энэ өнөөдрийг хүртэл өнгөрсөн жилийг хүртэл ингээд явлаа шүү дээ. Тэгэхэд 3 байна уу 4 дахин сунгагдсан. Энэ бол бас хариуцлагагүй, нөгөө талдаа своп хэлцэл хийсэн талдаа их эвгүй харагдаж байсан байх. Би энэ дээр бас эдийн засагчийнхаа хувьд их санаа зовж явдаг байсан.

Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрэн бол энэ дээр маш зөв зүйтэй шийдвэр гаргаад, ингээд бараг талаас дээш хувийг нь төлчихсэн ийм статистик харагдаж байгааг би бас энийг тэмдэглэн хэлэхийг хүсэж байгаа юм. Тэгэхээр бид нар своп хэлцэл авч болно. Гэхдээ бас хариуцлагатай байх ёстой шүү гэдгийг мартажгүйгээр явах ёстой гэсэн ийм богинохон хариултыг хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Мөнгөний бодлогын гишүүдийн энэ томилгоотой холбоотой мэдээж ажлын туршлага, мэдлэг боловсрол, мөнгөний бодлогоо тодорхойлох, энэ удирдлагын албан тушаал энэ чиглэлээр ажиллаж байсан шалгууруудыг нь бас Эдийн засгийн байнгын хороо нягт нямбай шалгаж үзсэн байлгүй дээ гэж найдаж байна. Зүгээр миний хувьд 2 асуулт байна. Та бүхнээс.

1 дүгээрт яах вэ, бид нар мөнгөний бодлого гэхээр ер нь дандаа л инфляц, эсвэл валютын ханш гээд ингээд ярьдаг. Дэлхийн улс орнуудад Төв банкны мөнгөний бодлогын хамгийн том бас нэг зорилт бол ажилгүйдлийг багасгах явдал байдаг. Эдийн засгийг тэлж, ажилгүйдлийг багасгах. Ажилгүйдлийг хэр багасгасан, ажил олголт хэр сайжирч байгаагаар мөнгөний бодлого бас оновчтой явж байна уу, үгүй юу гэдгийг дүгнэдэг. Тэгэхээр энэ тал дээр манай Мөнгөний бодлогын зөвлөлд нэр дэвшиж байгаа гишүүд энэ инфляцыг хянах, тэгээд энэ ажилгүйдлийн түвшнийг бууруулах, ажил олголтыг дэмжих энэ бодлогын тэнцвэрийг хэр авч явах ёстой, яаж авч явах ёстой гэж бодож байна гэдэг дээр та бүхнээс хариулт авмаар байна.

2 дугаарт дэлхий дахинд бас нэлээн томоохон эдийн засгууд Төв банкнууд нь гаргаад эхэлчихлээ л дээ. Си Би Ди Си буюу Төв банкны дижитал валютын асуудал нэлээн яригдаж байна. Дижитал ар эн би Хятад гаргачихлаа. Дижитал рү пи Энэтхэг гаргачихлаа. Томоохон улсууд бас гаргахаа зарлачихлаа. Англи гэх мэт. Тэгэхээр та бүхний хувьд мөнгөний бодлогыг тодорхойлох гэж байгаа энэ нэр дэвшигчдийн хувьд ер нь энэ Төв банкны дижитал валютыг гаргах асуудал дээр ямар байр

суурьтай байдаг вэ юу. Төв банк өөрөө энэ цахим технологийг ашигласан мөнгөний бодлогыг бас явуулна гэдэг дээр ямар байр суут суурьтай байдаг вэ. Ялангуяа тэр Си Би Ди Си буюу Төв банкны дижитал валют дээр та бүхний байр суурийг бас сонсмоор байна.

Х.Булгантуяа: Бүх нэр дэвшигчдээс асуух шиг боллоо. Тэгвэл ажлын хэсгийн микрофоныг 1, 1-ээр нь өгье. Манай ажлын хэсгийн гишүүд маш товчхон хариулаарай.

Б.Энх-Амгалан: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь бол олон улсын болон онолын хүрээнд ч гэсэндээ ер нь бол ажилгүйдэл, инфляц 2 маань хоорондоо уялдаатай явж байдаг. Энэ чиглэлийн асуудлууд бол онолын хүрээнд судалгааны хүрээнд ч нэлээн яригддаг асуудлууд л даа. Тэгээд одоогоор бол манай Монголбанк дээр бол ажилгүйдлийн асуудлыг бол бүрэн хариуцсан зүйл байхгүй байгаа. Тэгэхээр энийг бол бас мэдээж олон улсынх нь жишиг рүү оруулах шаардлагатай. Тэгж байж бид нар энэ ажилгүйдэл, инфляцын хоорондын уялдааг нарийн харах шаардлагатай гэж бодож байгаа учраас гишүүнээр сонгогдсон тохиолдолд бол энэ ажилгүйдлийн асуудлыг бас Монголбанк дээр тооцож, энэ инфляцтайгаа уялдуулж, цаашаагаа бас судалгаа тооцоондоо прогнозууддаа ашиглах ийм шаардлага байгаа гэж миний зүгээс бас үзэж байгаа.

2 дугаар асуултын хувьд бол дижитал валют бол нэгэнт олон улсад бол хэрэглэгдээд эхэлж байна. Ер нь бол бас аль болох бэлэн мөнгө дээрээс гэдэг юм уу татгалзах, аль болох дижитал хэлбэр лүү шилжүүлэх, төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх, иргэдэд аль болох хүндрэл чирэгдэл учруулахгүй байх энэ асуудлууд яригдаад явж байгаа учраас бол Монгол Улсын хувьд ч гэсэндээ ер нь энэ технологийн салбарт бол хоцрох ёсгүй. Тэгэхээр миний хувийн байр суурь бол Төв банкны зүгээс бас энэ дижитал валют буюу дижитал төгрөг гэж хэлж болох энэ хэлбэр лүү бол явахыг бол дэмжинэ гэж ингэж бодож байна.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн дараагийн микрофон.

Н.Батнасан: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх гол арга зам бол ерөнхийдөө хөрөнгө оруулалтыг дэмжих асуудал. Тэгэхээр хөрөнгө оруулалт маань хэдийд их хийгдэх вэ гэхээр зээлийн хүү бага байж байж л хийгдэнэ. Зээлийн хүүд ямар хүчин зүйлүүд нөлөөлөөд байна гээд харахаар манай олгож байгаа арилжааны банкнуудын зээлийн хүү 18 хувь орчим гэж үзэхэд, үүний 8 хувь нь бол ойролцоогоор инфляцтай холбоотой. 4-5 хувь нь болохоор нөгөө хадгаламж эзэмшигчийн ашгийн асуудал байна. Дахиад 4 орчим хувь нь бол банкны үйл ажиллагааны зардал, тэгээд банкны ашиг гэсэн ийм бүтэцтэй байгаа юм. Тэгэхээр бид нарын хувьд энэ зээлийн хүүг бууруулахын тулд бол яах ёстой вэ гэхээр инфляцыг бууруулах тал дээр нэлээд ажиллах ёстой байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт бол арилжааны банкны зардлыг бууруулах асуудал. Энэ дээр бол би 2 гол зүйлийг бол их чухалчилж үзэж байгаа.

1 дүгээрт бол энэ арилжааны банкнуудын зардалд бол нөгөө арилжааны банкнаас авсан зээл авсан хүмүүсийн эрсдэлийн асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ эрсдэлийг бууруулахын тулд бид нар энэ хамгийн түрүүнд хийх асуудал бол зээлийн мэдээллийн санг үүсгэж, энэ хариуцлагатай зээлийг бий болгох асуудал дээр бол хамгийн түрүүнд анхаарах ёстой гэж харж байгаа.

Дараагийн нэг асуудал бол энэ цахим шийдлүүдийг нэвтрүүлэх замаар арилжааны банкнуудын өөрсдийнх нь үйл ажиллагааны зардлыг бууруулах. Ялангуяа тэр фронт оффис биш, байк, оффис дээр голцуу төвлөрсөн тийм. сүүлийн үеийн хандлага руу бас орж байж зардлыг бууруулна гэж харж байгаа.

Тэр дижитал валютын тухайд би бас 2, 3 жилийн өмнө манай нэртэй дэлхийн тэрбумтнуудын нэг Уоррен Бабетын Си Эн Энд өгсөн ярилцлагыг сонсож байсан. Тэгээд тэр хүн бол юу гэж хэлсэн бэ гэхээр бид нар бол ялангуяа энэ дижитал валют, криптой валют гээд энэ зүйлүүд дээр бол маш их хэмжээний ийм мөнгөний нийлүүлэлтийг нэмж байгаагаас болоод эдийн засагт тэнцвэрийг бол бид маш их хэмжээгээр алдагдуулж байна гэсэн нэг тийм санаа хэлсэн. Тийм учраас бол энэ асуудал дээр би юу гэж бодож байгаа вэ гэхээр энэ дээр нэлээн сайтар тооцоо судалгааны асуудал байна. 2 дугаарт бол энэ чинь цаанаа бас нөгөө банкны аюулгүй систем, найдвартай ажиллагаа гээд юмнуудтай холбоотой учраас энэ дээр бас анхаарах ёстой гэж ингэж харж байгаа. Баярлалаа.

Б.Мөнхзаяа: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өөрийнхөө сонгогдвол хийх ажлынхаа жагсаалтад эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр бас санал санаачилга гаргана гэсэн ажлыг төлөвлөж бичсэн байсан. Тэгээд Алсын хараа 2050 бодлогын бичиг баримтад бол 2030 он гэхэд дундаж орлогыг 12 мянган долларт хүргэнэ гэсэн ийм зорилт тавьсан байсан. Одоогоор бол энэ 5300 орчим доллартой байгаа. Тэгэхээр яаж энэ зорилтод энэ богино хугацаанд хүрэх вэ гэхээр ажлын байр, цалин орлого, ажилгүйдлийг бууруулах замаар хүргэнэ гэж ингэж харж байгаа. Тэгэхээр хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтыг дэмжих, ажлын байрыг дэмжих, ялангуяа энэ дээр эдийн засгийн төрөлжилтийн асуудлуудыг бол нэлээн анхаарч үзэх ёстой гэж ингэж бодож байгаа.

Дижитал валютын хувьд бас өнгөрсөн онд Европын холбооны улсууд дээр нэлээд олон тооны судалгаанууд гараад, манай сургууль дээр бас энэ судалгааны ажлууд бас хийж, хэлэлцэгдэж байсан. Тэгэхээр нэлээд олон эрсдэлүүд байгаа учраас зах зээлээ тэлэх, бэлдэх замаар ийшээ бол бид нар хүссэн, хүсээгүй шилжих байх гэж ингэж бодож байна. Тэгэхээр шилжих шийдвэр нь бол зах зээлээ бэлдэж, эрсдэлээ бууруулсны дараа хийх нь зөв гэж ингэж хардаг. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн дараагийн микрофон.

Р.Даваадорж: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Тэр Төв банкны хувьд энэ ажилгүйдлийн талаар бид нар бас яг харж үзэх нь зүйтэй. Яагаад гэхээр энэ Холбооны нөөцийн сангийн Ерөнхийлөгч гарч ирж, улирал тутам тайлангаа тавихдаа ажилгүйдлийн түвшнийг зарладаг. Манай Монголбанкны хувьд бол энэ ажилгүйдлийн түвшний талаар бас зөвхөн Үндэсний статистикийн хороо л гаргаад байх шиг байгаа юм. Тэгэхээр энийгээ бас уяж өгөх нь зөв зүйтэй гэдэг дээр би санал нэгтэй байна.

Монгол Улсын арилжааны банкнуудын нийт зээл 35,7 их наяд байгаа юм. Зах зээлд гаргасан зээл. Түний 21,8 их наяд нь иргэд авсан зээл. Хувийн хэвшлийнх нь авсан нь 13,4 их наяд төгрөг байгаа юм. Тэгэхээр энэ дүнгээс харахаар бас нөгөө ажилгүйдэлтэй холбоотой зүйлүүд чинь харагдана л даа. Энэ 20 их наяд гэдэг бол Монгол Улсын 3,5 сая иргэд бол ойролцоогоор 1 сая өрхтэй байна гэж тооцоход нэг өрхөд 22 сая төгрөг оногдохоор ийм өртэй байна гэсэн үг. Тэгэхээр энийг бид нар

маш сайн анзаарч харах ёстой юм. Тэгэхээр иргэд маань өнөөдөр ний нуугүй хэлэхэд миний энэ хэлж байгаа тоо болохоор зөвхөн арилжааны банкны хувьд би ярьж байна шүү дээ. Нэг өрхөд бараг 22, 23 сая төгрөгийн зээл зөвхөн арилжааны банкнаас оногдож байна. Банк бус санхүүгийн байгууллага, ломбардыг мэдээлэл нь байхгүй учраас хэлж мэдэхгүй байна. Тэгэхээр ажилгүйдлийг ярихын өмнө бид нар арилжааны банкныхаа зээлийг харах юм бол энэ бол бас толгой нь буруу тийшээ эргэчихсэн юм харагдаж байгаа. Арилжааны банк бол аж ахуйн нэгж дээр очоод иргэд дээр биш, аж ахуйн нэгж дээр очоод ажлын байрыг бий болгож байх ёстой зээл маань эсрэгээрээ эргэчихсэн явж байна гэдгийг бид нар бас хаана хаана харж ажиллах ёстой юм гэдгийг би ингэж анзаарч хардаг. Хэрвээ Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүнээр сонгогдвол би энэ тал дээр нь мэдээж анхаарч ажиллах болно гэдгээ хэлье.

2 дугаар асуултын хувьд мэдээж бусад улсаасаа хоцрох ийм шаардлага байхгүй байх. Дижитал төгрөгийг бол гаргах нь зөв гэдгийг дэмжиж явдаг хүний нэг байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар.

А.Ганбаатар: Нэр дэвшиж байгаа 4 нэр дэвшигчдэдээ амжилт хүсье. Сайн нэр дэвшигчид гэж ойлгож байгаа. Ялангуяа манай Даваадорж бол чансаатай нэр дэвшигч. Бас харьцангуй мэдэхийн хувьд энэ бүгдээс нь асуух шаардлагагүй байх. Даваадоржоос 2, 3 зүйл асуугаадахъя.

Хэрвээ бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилогдох юм бол энэ Монголбанк, Засгийн газар хоорондын төсөв мөнгөний уялдаа алдагдсанаас болж гарч байгаа доголдлууд гэх юм уу, энийгээ засаж ажиллана гэж хэлсэн байна. Тухайлбал Монгол төгрөгийн ханш унаж байгаа, ядуурал нэмэгдэж байгаа, ажилгүйдэл багасаж байна гэсэн үг. Аж ахуйн нэгжүүд хаалгаа барьж байгаа гэх мэт. Нэр дэвшигчид бас энэ дээр дурдаж байсан. Монголбанкны гол үүрэг бол Монгол төгрөгийн ханшийг барьж, импортын барааг багасгаад, импортыг орлох болон экспортын барааг дэмжих, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, гаднаас хөрөнгө оруулалт татах, гадаадын тусламж, зээлийн хөрөнгө мөнгө орж ирснээр монгол төгрөг чангарна гээд. Хамгийн түрүүнд энэ компаниудад олгож байгаа, аж ахуйг нэгжүүдэд олгох зээлийн хүү Монголбанк бусад банктайгаа уялдаж энэ зээлийн хүүгийн бодлогыг хийх ёстой. Тэгээд зээлийн хүү бол бодитой дорвитой, аж ахуйн нэгжид ашигтай ийм бол байхгүй л байна л даа өнөөдрийг хүртэл. Тэгэхээр манай Даваадорж маань энэ дээр өөрөө бас шүүмжлэлтэй талаас нь ханддагаар хэдийгээр улс төржихгүй гэж амлаж байгаа ч гэсэн мэргэжлийн хүний хувьд хамгийн түрүүнд аль алхмыг нь хийж эхлэх вэ. Та 4 маань Монголбанкны толь бас нэг тийм өөр өнцөг нь байгаарай. Тэгээд олон нийт, аж ахуйн нэгжүүд энэ Монголбанкны бодлогоос хамаарч дээшээ, доошоо явж байгаа иргэд болон аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл та бүхнийг харж байгаа. Тэгээд амжилт хүсье. Энэ дээр нэг хариулт авчихъя.

Х.Булгантуяа: Нэмж тодруулъя.

А.Ганбаатар: Бүгдэд нь амжилт хүссэн тэгээд яах вэ, арай мэдэх энэ бодлогод шүүмжлэлтэй хандаж байсан. Тухайлбал энэ мөнгөний бодлого буруу явснаас болж төв банк Засгийн газартай төсөв мөнгөний бодлогын уялдаа муугаас болж гарч байгаа доголдлуудыг яаж арилгах вэ, яаж шахаж ажиллах вэ, хамгийн түрүүнд аль алхмаа хийх вэ л гэж асуугаад байгаа юм. Даваадоржоос л асуусан.

Х.Булгантуяа: 21 номерын микрофонд Даваадорж нэр дэвшигч.

Р.Даваадорж: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Би өнгөрсөн 8 жилд 2 парламент дамжаад, Улсын Их Хуралд АН-ын бүлгийн эдийн засгийн зөвлөхөөр ажиллаж байхдаа жил бүр орж ирдэг төсөв болон мөнгөний бодлого дээр дүгнэлт бичиж байсан. Тэгэхээр энэ дүгнэлт дээр би ерөөсөө маш тодорхой хэд хэдэн тоог л ер нь хэлдэг байсан. Тэрийгээ бас давтаад хэлэхийг хүсэж байна. 2 жил тутам Дэлхийн банк, Үндэсний статистикийн хороо Монгол Улсын иргэдийн нэн ядуу байгаа иргэдийн тоог гаргадаг. Энэ бол сүүлийн 10-аад жил 30-27-ийн хооронд, өөрөөр хэлэх юм бол 3 хүн тутмын 1 нь нэн ядуу гэсэн ийм үзүүлэлтийг Дэлхийн банкнаас гаргаж ингэж зарладаг. Тэгэхээр төсөв, мөнгөний бодлого бол эцсийн дүндээ бол ард иргэдийгээ ажилтай байлгах, өрх нь орлоготой байх ийшээ чиглэх ёстой гэж ингэж хардаг. Мэдээж намын сөрөг хүчний бүлэгт байхдаа мэдээж шүүмжлэлтэй ханддаг зүйлүүд олон байсан. Энэ дээр бол юу хэлэхийг хүсээд байна гэхээр энэ төсвийн бодлого, мөнгөний бодлого 2 хоёулаа 10 сард орж ирдэг. Төсөв батлагдсаных нь дараа нь мөнгөний бодлого явчихдаг нь жаахан надад анхаарах ёстой юм уу гэж харагддаг. Яагаад гэхээр хэрвээ төсвийн бодлого маань хэт тэлчих юм бол нөгөө мөнгөний бодлого нь урьдчилаад батлагдчихаар энэ нь жаахан тийм худлаа зүйл болчхоод харагдаад байгаа юм. Тухайлах юм бол энэ жилийн төсөв, ирэх жилийн төсвийг нэлээн тэлсэн гэж эдийн засагч шүүмжлээд байна шүү дээ. Гэтэл нөгөө мөнгөний бодлого дээрээ 5-аас +2 ийм интервалд инфляцаа барина гэж ярьж байгаа. Гэтэл хэрвээ хэт ийм тэлэлттэй байх юм бол хүндрэлтэй байна гэдэг ингэж зүйлийг ярьж байна. Тэгэхээр энэ дээр чинь нөгөө төсөв мөнгөний бодлогын чинь энэ зөрүү харагдаад байгаа юм гэж би яах вэ шүүмжилдэг л дээ. Тэгэхээр төсвийг оруулж ирэхдээ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтээс гадна Монголбанкны Ерөнхийлөгч заавал сууж байх ёстой. Энэ хүн бол төсөвтэй холбоотойгоор тэр мөнгөний бодлогодоо ямар өөрчлөлт хийхийг бас энэ Их Хурлынхаа гишүүдэд бас таниулж, ойлгуулж байвал их зөв зүйтэй юм уу гэж би хардаг хүн юм байгаа юм.

Бусад улсын жишгийг харах юм бол зайлшгүй энэ Төв банкныхаа бодлоготой уялдуулж төсвийг өргөн барьдаг. Гэтэл манайд сүүлийн жилүүдэд төсвөө дураараа тэлдэг ийм асуудал ингээд харагдаад байдаг. Энэ дээр нь бас би гэхээсээ илүүтэй манай Улсын Их Хурлын гишүүд сүүлийн энэ сонгогдсон 126 гишүүд дотор их мундаг мундаг эдийн засгийн ийм хүмүүс сонгогдсон байна. Саяын 2025 оны төсөв дээрээс харахад анх удаа бид нар төсвийн алдагдалгүй баталлаа шүү дээ. гэх мэтчилнээр хэрвээ ингээд засаад явчих юм бол 126 гишүүн бол дор нь засах юм байна гэсэн ийм итгэл найдварыг төрүүлж байгаа юм. Тэгэхээр би бол мэдээж юу гэдэг юм мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүнээр оччих юм бол элдэв тийм төсөвтэй холбоотой шүүмжлэл хэлэлцээрийг бол ярихгүй нь бол мэдээж. Яах вэ мөнгөний бодлоготой холбоотой зүгээр өөрийнхөө санал бодлоо хэлээд, мэдээж тэрийг нь мөнгөний бодлогод тодорхой хэмжээгээр тусах юм бол энэ ажлын байрыг шийдэх, зээлийн хүүг бууруулах ийм боломжууд бол зөндөө бий. Зөндөө бий. Тийм учраас энэ дээр нь би анхаарч ажиллана гэдгээ гишүүнд амлаж байна. Хэрвээ сонгогдох юм бол шүү.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар.

Э.Батшугар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо бол маш нөлөө бүхий нийгэм, эдийн засагт шууд болон шууд бус нөлөөлж болох тийм институц юм. Монголбанкны бодлогын хүү өсгөх,

бууруулах, банкнуудын төгрөг, валютын заавал байлгах ёстой нөөцийг нэмэх, хасах гэх мэтчилэн маш том бодлогын том шийдвэрүүдийг гаргадаг. Энэ нь өөрөө хараат бус байх ёстой. Монголбанк өөрөө хараат бус байх ёстой. Төв банк энэ бол яг эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг үндсэндээ хангаж байдаг үндсэн институт. Тэгэхээр хэд хэдэн асуух зүйл байна.

1 дүгээрт Монголбанкны үндсэн зорилго та бүхэн яг яаж харж байна.

2-т нь та бүхэн өнөөдрийн байдлаар яг өөрсдийнхөө сурсан, мэдсэн болон ажигласан байдлаас харахад Монголбанк яг ямар мөнгөний бодлогын онолоор явж байна. Та бүхэн мэдэж байгаа байх. Хэд хэдэн онол. Шинэ Кенсийн онол, шинэ классикал онол, зүгээр Кенсийн, эм эм, ти гээд яг аль байдал аль школоор явж байна гэж та бүхэн дүгнэж байна. Та бүхний өөрсдийн чинь итгэл, үнэмшил чинь яг аль талдаа байдаг юм бэ гэж асууя.

2-т нь Даваадорж нэр дэвшигчээс асуусан. Уржигдар танаас асуусан. Монголбанкны бодлогын хүү гэж юу вэ. Ямар сувгаар бодит эдийн засагт нөлөөлдөг вэ гэж. Тэгэхэд та бол мэдэхгүй байсан тухайн үед. Буруу хариулсан. Монголбанкны бодлогын хүү бол банк хоорондын зээлийн дундаж хүү гэж. Тийм биш. Тэгэхээр энэ дээр бас сайн судлаарай. Бодлогын хэрэгслүүд гэж ямар ямар хэрэгслүүд байдгийг нь бас ахиж үзээрэй. Яагаад гэвэл та бол бодлогын хүү дээр бас тодорхой хэмжээний дуу хоолойгоо өгөх хүн. Тэгэхээр яг мөнгөний бодлогын онол, Монголбанк болон төв банкны онол, цаашдаа ямар каналаар яаж эдийн засагт нөлөөлдгийг нь судлаарай гэж хэлмээр байна.

Дахиад нэг анхаарах зүйл байгаа юм. Энэ юу вэ гэвэл Төв банкны итгэл үнэмшил нь өөрөө Төв банкны бодлогын шийдвэрийн үр дүнгийн хэмжүүр яг байдаг. Трансперенси сентрал банк коммуникэйшн гэдэг. Энэ дээр бас өөрсдөө анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна.

Уржигдар Монголбанкны бодлогын хороо хуралдаад, тэгээд заавал байлгах ёстой төгрөг, валютын нөөцийг 2 хувиар нэмсэн. Тэгээд та бүхэн удахгүй магадгүй томилогдох гэж байгаа хүмүүсийн хувьд энэ нь бодит эдийн засагт яаж нөлөөлөх вэ гэдэг энэ асуултыг асууя. Ер нь яг очих гэж байгаа ажил .../минут дуусав/

Х.Булгантуяа: Микрофонухоо дугаарыг өргөөдхөөрэй. Эндээс харагдахгүй байгаад байна шүү. 21 номерын микрофон.

Р.Даваадорж: Батшугар гишүүний асуултад хариулъя. Эхлээд надад хандсан тэр асуултад нь хариулъя гэж бодож байна. Монголбанкны бодлогын хүүг мэдэхгүй байсан гэж. Яах вэ, энэ дээр би буруу хариулсан байж магадгүй. Тэгэхдээ бол Монголбанкны бодлогын хүү бол Монголбанкны Үнэт цаасны өөрөөр хэлэх юм бол арилжааны банкнууд худалдаж авдаг тэр хүүг хэлж байгаа шүү дээ. Тухайлах юм бол өнөөдөр 10 их наяд Төв банкны үнэт цаасан дээр төвлөрчихсөн байна. Дөрвөн 7 хоногтоо Төв банкны үнэт цаас бол 7 их наяд гаруйтай байна. Хорин дөрвөн 7 хоногийн хугацаатай үнэт цаасны Төв банкны үнэт цаасны бол 1,2, 1,3 их наяд байх шиг байна. Нийтдээ 10 их наяд төгрөг байна. Тэгэхээр Монголбанкны бодлогын хүү гэдэг бол бодлогын хүүг өнөөдөр 10 хувьтай байна шүү дээ. Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэхээр арилжааны банкнууд зээл өөр дээрээ байгаа активаа зээлээ гаргах уу эсвэл Монголбанкны үнэт цаасыг худалдаж авах уу гэдэг дээр шийд гаргана. Хэрвээ 10 хувийн тэр өнөөдрийн тоог хэлж байна шүү дээ. Өнөөдрийнхөөр 10 хувиар бид

нар ингээд ямар ч эрсдэлгүй Төв банкны цаас худалдаад авчих юм бол ашигтай байна гэдгийг энэ манай 12 банк бол хараад 10 их наядыг төвлөрүүлчихсэн байна шүү дээ. Гэтэл энэ 10 их наяд төгрөг чинь аж ахуйн нэгж дээр очих ёстой. Аж ахуйн нэгж нь ажлын байрыг бий болгох ёстой. Өрхүүд нь ажилтай орлоготой байна. Иргэд ажилтай орлоготой байна гэдэг чинь өрх нь орлоготой байна гэсэн ийм утга санаа юм байгаа юм л даа.

Тэгээд 2 дугаар асуулт дээр нь бас товч хариулахад тэр нөгөө заавал байлгах нөөц нь 2-оор нэмэгдүүлсэн. Энэ нь яаж нөлөөлөх вэ гээд. Яах вэ, зах зээл дээр байгаа M2 бол зах зээл дээр байгаа мөнгөний чинь хэмжээ их байгаа учраас ингээд Төв банк нь үнэт цаасаа гаргаад, өндөр хүүтэйгээр худалдаж авч байна. Нэг талаас. Нөгөө талдаа заавал байлгах нөөцөө ингээд нэмээд Монгол төгрөг нь 11 хувь хүрчих үү, валют нь 16 хувь хүрчхээд ингээд явж байна. Өөрөөр хэлэх юм бол нэлээн ийм хатуу бодлого явуулж байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр зах зээл дээр асар их хэмжээний мөнгө байна. Энэ нь юугаараа илэрхийлэгдэж байна гэхээр M2 чинь 41,7 их наядтай байгаа байх. Тэгэхээр зөвхөн 1 жилийн дотор бараг 5-6 их наядаар нэмэгдэж байна лээ шүү дээ. Тэгэхээр чинь мэдээж энэ бодлогын хүү нь өндөр байж таарна. Зайлшгүй байх нөөц нь өндөр байгаа ийм зүйлүүд харагдаж байна гэдгийг л хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн бусад гишүүдийнх нь микрофоныг өгөөрэй. 18, 19, 20 гээд ар араас нь.

Б.Энх-Амгалан: Батшугар гишүүний асуултад хариулъя. Мэдээж Монголбанкны үндсэн зорилго бол юу байгаа. Монгол төгрөгийн тогтвортой байдлыг хадгалах гэсэн энэ асуудлын хүрээнд явж байгаа. Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад, ялангуяа яах вэ ковидын эхэн үед бол бид нар Монголбанкны зүгээс бол бодлогын хүүг бол нэлээн бага байлгасан. Тэгээд сүүлд бол нийлүүлэлтийн гаралтай шокуудын нөлөөллөөс шалтгаалаад гэдэг юм уу экспортын хувьд бол Монгол Улс бараа бүтээгдэхүүний экспортлох боломж гол нэрийн бүтээгдэхүүн болох нөгөө уул уурхайн бүтээгдэхүүний экспорт маань БНХАУ руу экспортлох боломж хомсодсон. Дээрээс нь нэмээд тээврийн зардлууд өссөн зэрэг нь эргээд инфляцад хүчтэй нөлөөлж эхэлсэнтэй холбоотойгоор бол бодлогын хүүг үргэлжлүүлэн өсгөсөөр ирсэн байж байгаа. Тэгээд яах вэ, тэрнээс хойш эдийн засаг тогтворжоод 2024 он гарсаар бол мэдээж бодлогын хүүг бол харьцангуй багасгасаар бол одоо 10 хувьд бол барьж байгаа. Тэгэхээр энэ маань бол ер нь хатуу бодлого бол эдийн засаг дээр инфляцын дарамт хүчтэй байгаа тохиолдолд хэсэг хугацаанд бол ямар ч байсан үргэлжлээд явах байх гэж ингэж бодож байгаа.

Тэр бодит эдийн засаг дээр заавал байлгах нөөцийн хэмжээг нэмэгдүүлснээр ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг асуулт асуусан. Энэ дээр бол мэдээж төсөв тэлэлттэй байгаа их хэмжээний мөнгө гүйлгээнд орж ирж байгаа, мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж байгаа ийм тохиолдолд бол заавал байлгах нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх нь эргээд арилжааны банкнууд гэдэг юм уу банкнуудаас гаргах зах зээл рүү нийлүүлэх мөнгөний хэмжээг багасгахад нөлөө үзүүлж байгаа ийм үзүүлэлт болдог. Энэ утгаараа аваад үзэх юм бол заавал байлгах нөөцийн хэмжээ нэмэгдсэн нь эргээд мөнгөний нийлүүлэлтийг багасгах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Х.Булгантуяа: Дараагийн ажлын хэсэг.

Н.Батнасан: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монголбанкны, Төв банкны үндсэн үйл ажиллагааны үндсэн гол зорилго бол 1 дүгээрт төгрөгийн худалдан авах чадвар, ханшийн тогтвортой байдлыг хангах. 2 дугаар гол асуудал бол эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах гэсэн ийм хүрээнд бол ойлгож байгаа. Тэгээд тэр заавал байлгах нөөцийн хэмжээг 2 хувиар бууруулсан нь ямар нөлөө үзүүлэх вэ гэж.

Тэгэхээр мөнгөний зах зээл дэх нийлүүлэлтийг бол багасгаж байгаа. Тэгэхдээ тэр нийлүүлэлтэд 2 зүйл зарцуулагддаг. Нэг хэсэг нь бол хэрэглээ рүү явдаг. Нөгөө хэсэг нь бол хөрөнгө оруулалт руу явдаг. Тэгэхээр хэрэглээ нэг талдаа буурна. Нөгөө талд бол бас тэр багасгасан заавал байлгах нөөцийн хэмжээг 2 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор бас хөрөнгө оруулалтын хэмжээ ч гэсэн тэр харьцаагаараа бол буурна гэж ингэж харж байна.

Өөр асуулт нь болохоор зэрэг нөгөө ямар онолоор явж байгаа вэ гэж. Тэгэхээр бидэнд бол ерөнхийдөө энэ Монголбанкны бодлогын арга хэрэгслүүдийг харахад бол ерөнхийдөө Монголбанкны мөнгөний нийлүүлэлт, эрэлт нийлүүлэлтийг яаж мөнгөний арга хэрэгслүүдээр удирдах вэ гэдэг л ийм зарчим дээр явж байгаа. Тэгэхээр би бол энэ Шинэ Кенсийн онол дээр явж байна гэж ингэж үзэж байна.

Ил тод байдлыг хангах гэдэг асуудал дээр бол энэ бол үнэхээр чухал. Ер нь бол банкны салбар бол өөрөө итгэл дээр суурилсан бизнес байдаг учраас энд ил тод байдал нь хамгийн сайн байж байж л хүмүүс тэнд итгэл үүснэ гэж ингэж үзэж байгаа юм.

Б.Мөнхзаяа: Батшугар гишүүний асуултад хариулъя. Төв банкны үндсэн зорилгыг төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах гэж ойлгож байгаа. Энэ дээр бол сая бас Батнасан доктор маань хэллээ. Шинэ Кенсийн онолоор явдаг. Таны хувьд ямар онолыг баримталбал зүгээр вэ гэсэн асуулт асуусан. 2013 онд би Хямралын үе дэх арилжааны банкны эрсдэлийн удирдлага гэсэн ийм докторын судалгааны ажил хийж байсан. Тухайн үед яг санхүүгийн хямралын дараа энэ сэдвийг судалсан учраас ер нь онолын шинжийг нь чиг хандлага буюу мөчлөгийн онол Минскийн онол гэдэг зүйлийг бол тухайн үед бол судалж гаргаж ирж байсан. Тэгээд хямралыг төрүүлэх индикаторууд юу байж болох вэ гээд. Тэгэхээр Төв банкны үндсэн зорилго бол эдийн засгийн мөчлөгийн тодорхойлох, үүндээ мөчлөг сөрсөн бодлогыг баримталбал зүгээр гэж боддог. Тэгэхээр энэ Минскийн онолыг бас энэ мөнгөний бодлого тодорхойлохдоо хэрэглэвэл зөв байх гэж хардаг. Тухайн үеийн судалгаагаар бол Монгол Улсын эдийн засгийн мөчлөг нь 10 жил, үүнээс 5 орчим жилд нь эдийн засаг өсдөг, тэлдэг. Үүнээс хойш бол тогтворжоод уналтын үе шат руугаа ордог гээд. Тэгэхээр яг энэ мөчлөгийн дагуу мөнгөний бодлого бол бас ажиллах хэрэгтэй гэж ингэж хардаг.

Дараагийнх нь зав заавал байлгах нөөцийн өөрчлөлт ямар нөлөөллийг үзүүлэх вэ гээд. Тэгэхээр арилжааны банкнууд бол заавал байлгах нөөцийн өсөлттэй холбоотойгоор бол тодорхой ойролцоогоор 1 их наяд гаруй төгрөгийг дансандаа байршуулах ийм хэрэгцээ бол үүсэж байгаа. Тэгэхээр энэ хэрээрээ зээл олголт бол хумигдана гэж ойлгож байгаа. Энэ нь гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээг бас бууруулна. Мөнгөний нийлүүлэлтийн ойролцоогоор 70 орчим хувь нь бол хадгаламж хэлбэрээр, үлдсэн хэсэг нь бол гүйлгээнд байгаа бэлэн мөнгө болон харилцах данс хэлбэрээр арилжаа ингээд явагддаг. Тэгэхээр энд бол гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээг бол тэр хэмжээгээр бууруулах нөлөөллийг үзүүлнэ.

Тэгэхээр мөнгөний хомсдол нь бас мөнгөний нийлүүлэлтийн энэ агшилт нь инфляцыг тодорхой хэмжээнд барих нөлөөллийг үзүүлнэ гэж харж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Батшугар гишүүн тодруулъя.

Э.Батшугар: Баярлалаа. Монголбанкны үндсэн зорилго бол үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг нь хангана гэж байгаа юм. Энэ нь бол том онолоороо болон өнөөдрийн бодит амьдрал дээрээ инфляцын үнийн өсөлттэй. Зарим хүмүүс ханш гэж ярьдаг юм. Гэхдээ ханш чинь өөрөө үнийн өсөлт дотор орчихсон байдаг. Монгол Улсын импортын инфляц болон үнийн өсөлт бол 40-50 хувьтай явдаг. Хэрэглэгч орны хувьд бол. Тэгэхээр хамгийн чухал зүйл Монголбанк юу анхаарах ёстой вэ гэхээр нэгд инфляц, үнийн өсөлт. 2-т нь Засгийн газар нь тодорхой хэмжээгээр бас хөгжих гээд, том том төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх гээд, мега төслүүдээ бас эхлүүлэх гээд төсвөө тэлдэг. Тэгэхдээ нөгөө талдаа бол Монголбанк чөдөрлөөд байж болохгүй. Яг энэ нарийн балансыг нь яаж барих вэ, яаж хэт мөнгөний өсөлтийг өсгөхгүйн тулд өсгөхгүй тэгсэн мөртөө хөгжлөө чөдөрлөхгүй байх балансыг нь барьж авдаг шүү. Тэгээд та бүхэндээ бүгдэд нь амжилт хүсье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар. Батшугар гишүүн сая үг хэллээ. Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Би бол энэ өглөөнөөс хойш орж ирж байгаа бүх хүмүүсийг бүр алга ташиж, бөөн баяртайгаар дэмжиж байгаа. Ямар гоё юм бэ. Амарбаясгалан дарга, Булгантуяа дарга хоёртоо баярлалаа. Яагаад их баярлаад, бүгдийг нь дэмжиж байгаа вэ гэвэл өмнө нь та нарын оронд байсан хүмүүс бол лаг шавар шиг 10 жил энэ дээр улс төрчдийн бүлэглэлүүдийн тохироогоор очсон, амралтын газар байгаа юм шиг жаргасан хэдэн хүмүүс байсан. Тэдний буянаар Монгол орон мөнгө хүүлэгчдийн диваажин болчихлоо. Та нар ингэж ард түмний зүхэл хараалыг идэв дээ. Та нар энийг яг хариуцаарай. Энэ Их Хурлаас сонгогдож байгаа шүү, томилогдож байгаа. Та нар яг Монгол төрийн мөнгөний бодлогыг барина шүү.

Тэгэхээр 1 дүгээрт Германы 1 эдийн засагчийн хэлсэн үг байдаг л даа. Банк санхүүгийн байгууллагад төрөөс ямар нэгэн зохицуулалт хийхгүй бол банкнууд бол яг вампир болдог юм гэж үг байдаг. Вампир гэж юу гэсэн юм бэ гэсэн юу ч өөрсдөө хөдөлмөрлөхгүй мөртөө бусдын цус хөлсийг сорж амьдардаг хүмүүсийг хэлдэг. Манай банкны салбарт сайн ажиллаж байгаа хүмүүс бий. Бүгдийг нь харлуулахгүй. Тэгэхдээ л энэ ядууралтай энэ их дампууралтай ковидын үед ч байна уу бүгдийг нь жилд 987 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байгаа. 1 их наяд. Энэ бол Манжийн үеийн мөнгө хүүлэлтээс ч бид 7 дор байдалтай болчихсон байгаа. Энийгээ засаж залруулахыг хичээгээрэй. Монгол оронд мөнгө их үнэтэй шүү дээ. 100 төгрөгийг Монголбанк 110 төгрөгөөр арилжааны банкнууддаа шахдаг. Арилжааны банкнууд нь Монголбанкнаасаа 100 төгрөгийг 110-аар аваад, 117-130 төгрөгөөр зардаг. Үгүй ээ, дунджаар 100 төгрөгийг 127 төгрөгөөр худалдаад авчихсан хүн яаж инфляц 10 хувиас доош буух вэ. Ямар мөнгөний бодлого байх вэ энд.

Тэгэхээр та бүхнээс ЖДҮ-лэгчдийг өрхийн амьжиргаа эрхэлж байгаа улсуудыг битгий алагчлаарай гэдгийг л банкны салбар мөнгөний бодлогод хэлье. Одоо манай банкны салбар бол хэдэн том аж ахуйн нэгжүүд, хэдэн уул уурхайн компаниудад мөнгө зээлчхээд л тэгээд л ЖДҮ-лэгчид бол Хадгаламж зээлийн хоршоо байна уу,

тэр цагийн зээл рүүгээ явдаг. Ард иргэдийг ингэж ялгаж болохгүй. Үндсэн хуулийн 5.4-д заасан байгаа. Би тодруулга дээрээ асууя. Тэгэхээр асуулт байхгүй. Юугаа ч хариулах вэ дээ. Тэгээд зүгээр би 1 минут тодруулаад үг хэлчихье дээ дарга аа.

Тэгэхээр хагалгаа амжилттай боллоо. Харамсалтай нь өвчтөн үхчихлээ гэдэг шиг та нар маань мөнгөний бодлого гэж ухаантай сайхан юм ярьчихаад, дараа нь ард иргэд өнөөдөр ингээд гуйлгачин мөнгө хүүлэлтийн барьцаанд орно гэдэг л аюул шүү. Гуйж байна шүү.

Үндсэн хуулийн 5.4-т төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал аж ахуйн бүх хэвшлийг ялгалгүйгээр эдийн засгийг зохицуулна гэж заасан. Яг энэ заалтыг та нар хэрэгжүүлж байгаа шүү. 5.4-ийг. Тэгээд Амарбаясгалан даргад хандаж хэлэхэд Их Хурлаар аж ахуйн нэгжүүдийг, аж үйлдвэрлэгч нарыг ялгасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал гэсэн нэг ийм луйврын хууль орж ирж байгааг та нар харин зогсоогоорой. Болиорой. Төрийн өмч, хувийн өмч гэж ялгаж Улсын Их Хурал нь Засгийн газраас өргөн барьсан төрийн өмчийн тухай тусгай хууль батална гэж ямар аймшигтай юм бэ. Энийг бас би протоколд бас тусгаж үлдээе. Өнөөдөр энэ орж ирнэ гэсэн орж ирсэнгүй. Маргааш ч гэсэндээ битгий орж ирээсэй. Ингээд аж ахуйн нэгжүүдийг хувийн хэвшил .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбаатар гишүүн үг хэллээ. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ.

Д.Ганбат: Ер нь бол нартай дулаахан өдрүүд бол ингээд удахгүй дуусна. Монголбанкийг бол ийм байгаа шүү. Бүлэглэлийн бэлэн мөнгөний машин шиг л ажиллаж байгаа шүү. АТМ шиг л ажиллаж байгаа. Өнөөдөр бодлогын хүү 10 хувьтай гэж байгаа. Үгүй ээ, ер нь энэ зах зээл дээр хэчнээн олон янзын хүү байдаг юм бэ. Уг нь нэг л хүү байх ёстой шүү дээ. Хамгийн өндөр хүүтэй зээлийг манай ядарсан малчид л авч байна. Яагаад ийм байдаг юм б. Өөр тэр мэдээлэлд ойр энэ тэр гээд л өөрсдийгөө янз бүрийн яриад байх юм. Тэд нар нь 3 хувийн хүүтэй, 6 хувийн хүүтэй ийм зээлүүд авч байна. Ийм байж болдог юм уу. Тэгээд гаднын банк яагаад орж ирдэггүй юм бэ. Одоо энэ хэдэн банкнууд чинь ломбард нэртэй шахуу л ийм юм байна шүү дээ. Олигтой том ч санхүүжүүлж чадахгүй. Хувийн хэвшлүүд бүгд хаалгаа хааж байна. Барьж байна. Одоо 2 их наядын өртөгтэй хэдхэн компани байгаа байх. 2, 3 л компани байгаа биз дээ. Нэг архины үйлдвэр байгаа. 2, 3 банк л байгаа. Тэгээд Эрдэнэс Тавантолгой байгаа байх. Үгүй ээ, энэ хувийн аж ахуйн нэгжүүдээ дэмжээд, өөдөө гараад энэ том компаниуд нь өсөөд томроод, иргэдийг ажлын байртай болгоод, араасаа ингээд Монгол Улсыг чирээд явах ёстой шүү дээ. Гэтэл яаж байна. Төр дээр л хамаг юмыг овоолоод байна. Ганц нэг Монголбанкны хяналтын зөвлөлд бас нэг эрүүл саруул зах зээлийн эдийн засаг мэддэг ганц нэг хүн байх шиг байна. Манай Даваадорж доктор. Бусдыг нь би мэдэхгүй юм чинь юуг нь мэдэх вэ. Ярьж байгаа, хэлж байгаа юмыг нь хараад байхад бол бас нэг хагас социалист юм яриад байх юм.

Нөгөө талаар ийм байна. Өдөр болгон 1 төгрөг нэмэгдэж байна. Валютын ханш чинь валют 2 янзын үнэтэй болсон байна. 8 шарга дээр 1 үнэ байна. Монголбанкны 1 үнэ байна. Ханш. Яагаад ийм байдаг юм. Ийм байдаг юм уу. Яагаад ийм байна. Энийг бас асуумаар байна. Тэнд очих гэж байгаа хүмүүс юу гэж бодож байна. Зээлүүд яагаад ийм өндөр янз янзын ялгаа хүүтэй байна. Зах зээл дээр 1 л хүүтэй байх ёстой. Яагаад гаднын банк орж ирэхгүй байна. Энэ бүхнийг та бүхнээс тодруулмаар байна л даа.

Тэгээд энэ улс орон бол хүнд болох нь ээ. Цаашдаа бол. Үндсэндээ энэ мөнгөний бодлого, эдийн засгийн бодлого бол сууриараа буруу явж байна шүү Монгол банк одоо.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч Намсрайн Батнасан. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Н.Батнасан: Гишүүний асуултад хариулт өгье. Тэгэхээр яах вэ гаднын банкны асуудлаас эхлээд ярья гэж бодож байна. Ер нь бол яах вэ гадаадын банкнийг оруулахад сайн тал байгаа. Бас муу тал байгаа. Бид нарын одоо ингээд хэрэгжүүлэх гэж байгаа том төсөл хөтөлбөрүүд байна. Энэ төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ёстой юу гэвэл хэрэгтэй. Гэхдээ энийг Монголын банкнууд бол санхүүжүүлэх тийм хүчин чадал бараг байхгүй. Томоохон 4, 5 үйлдвэр барихад бараг 30, 40 тэрбум долларын хэрэгцээ гарч ирнэ. Энийг санхүүжүүлэх тийм чадалтай банк бол Монголд байхгүй. Тэгэхээр бид гаднын банкнийг оруулах зайлшгүй шаардлага бол байна уу гэвэл байгаа.

Нөгөө талдаа гаднын банк оруулчихсан орнууд бас ямар асуудалтай тулсан бэ гэдгийг бас Европын хуучин орнуудын жишээнээс үзэхэд тэнд гаднын банкнийг оруулаад Үндэсний банктай бараг тийм улс ер нь ховорхон үлдсэн. Тэгэхээр зэрэг банкны олсон тэр ашиг орлого нь бол гадагшаа явдаг нэг ийм байдал руу орчих эрсдэл байгаа юм. Тэгэхээр бид нарын хувьд банкны салбарт гадаадын банкнийг оруулахдаа ямар үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох юм, ямар хэмжээнд ажиллуулах вэ гэдэг дээр нэлээн сайн цензур тавьж, ялангуяа хөрөнгө оруулалтын чиглэлээр нь гаднын банкнийг. Тэгэхдээ төрийн оролцоогүй гэх мэтийн шаардлагуудаа тавьж байж оруулах ёстой байх гэж ийм юм бодогдож байгаа юм.

2 дугаарт бол тэр зээлийн хүү яагаад өндөр байгаад байна вэ гэж. Энэ бол зах зээлийн өрсөлдөөнтэй холбоотой асуудал. Бид нар банкны сектор давамгайлсан эдийн засагтай байгаа учраас энэ хүү бол буурахгүй байна. Тэгэхээр санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх асуудал бол бас чухал байгаа юм гэж ингэж харж байгаа юм.

Ялгаатай хүүнүүдийн тухайд бол бид нар ер нь бол нэг тийм энэ зээлийг бас арилжааны зарчим руу нь шилжүүлэх асуудал их чухал. Би бол ингэж харж байгаа. Жишээ нь бид нар ипотекийн зээл 6 хувь, 8 хувь гээд олгож байна. Гэтэл банкны хүү чинь 18 хувь байгаа. Тэгэхээр бид нар ипотекийн зээлийн хүү дээрээ анхаарах ёстой юм уу, эсвэл метр квадратын өртгийг бууруулах асуудал дээрээ анхаарах юм уу гэдэг дээрээ бас бодох ёстой. Жишээлбэл би зүгээр нэг жирийн тооцоолол хийж үзэхэд 8 хувийн хүүтэй зээл аваад 15 жил төлөхөд 1м2-ын өртөг нь 7 сая байхад 360 орчим сая төгрөг төлж байгаа юм. Хэрвээ бид нар энийг метр квадратын өртгийг нь 3,5 сая болгоод яг бусад нөхцөлүүдийг нь ижилхэн байлгахад бол 280 орчим сая төгрөг төлж байгаа юм. Тэгэхээр бид бол хүү дээрээ татаас өгөх дээрээ анхаарах ёстой юм уу эсвэл орон сууцын метр квадратынх нь өртгийг бууруулах дээрээ анхаарах ёстой юм уу гэдэг дээрээ бас бодох ёстой.

Тэгэхээр би бол энэ бүх ер нь бол энэ татаастай хүү чинь бас манай Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргүүдтэй зөрчилддөг учраас ер нь аль болох тэр арилжааны зарчим руу нь явуулах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байдаг.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Раднаасэдийн Даваадорж. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Р.Даваадорж: Ганбат гишүүний голлон асууж байгаа нэг асуултад нь хариулъя. Зээлийн хүү яагаад өндөр байна вэ гэж. Тэгэхээр энэ дээр бол бид нар яг системээр тогтолцоогоо харах ёстой. Монгол Улсын санхүүгийн системийн 90 хувь нь банк, арилжааны банканд оногддог. Цаана нь үлдэж байгаа 10 хувь нь бол Хөрөнгийн бирж, даатгал, бусад жижиг сангууд оногдож байна. Дэлхийн тэр хамгийн бага хүүтэй улс орнуудын санхүүгийн системийг харах юм бол 40 хувь нь банк. Банк бол богинохон хэмжээний зээлийг санхүүжүүлдэг. Урт хугацааны зээлийг хэн санхүүжүүлдэг вэ гэхээр хөрөнгийн бирж дээрээс компаниуд мөнгө босгож ингэж 40 хувь нь хөрөнгийн биржид оногддог. Цаад 20 хувь нь болохоор даатгалын компаниуд, бусад сангууд ингэж оногдсон ийм хэлбэр дүрстэй байдаг. Гэтэл манайх бол сүүлийн 30 жил хэт банкны үйл ажиллагаа давамгайлсан. Санхүүгийн системд нь бол банкны гаргаж байгаа шийдвэрүүд нөлөөлсөн ийм хэмжээтэй яваад, энэ арилжааны зээлийнх нь хүү нь ерөөсөө бууж өгөхгүй байна. Тэгэхээр бид нар бол зөвхөн цөөхөн хэдэн банкныхаа хүүг буулгая гэж ярихаасаа илүүтэй энэ хөрөнгийн бирж, бусад энэ санхүүгийнхээ байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, энийг тэр иргэдийн гар дээр байгаа мөнгө, аж ахуйн нэгжийн гар дээр байгаа мөнгийг бид нар хадгаламж хэлбэрээр банканд төвлөрүүлэхдээ хамгийн өндөр, дэлхийн хамгийн өндөр хадгаламжтай 5 улсын бараг 2-т нь байна уу 3-д нь явж байсан. Хэдэн жилийн өмнөхийг харахад. Тэгэхээр ийм өндөр хадгаламжтай нөхцөлд иргэд, аж ахуйн нэгж бол мэдээж өөрийнхөө ашгаа бодоод л банк руу мөнгөө өгнө. Тэгэхээр тэр өндөр хадгаламж авсан банк яадаг вэ гэхээр өөртөө ашиг гаргахын тулд өндөр хүүтэй зээл гаргадаг. Ингээд энд нь аж ахуйн нэгжүүд нь ингээд сүйрээд унаад байна. Ер нь бол зах зээлийн төгөлдөр болчихсон нийгэмд харахаар аж ахуйн нэгжийн зээл бол арилжааны зээл бол 10 хувиас хэтэрдэггүй юм байна лээ л дээ. 10 хувиас дээш бол юу гэдэг юм гэхээр тэр нөгөө зэвсгийн наймаа, наркотик, хууль бус тамхи, архи гэсэн ийм юмнууд дээр л 10 хувиас дээш зээл ашигтай ажилладаг. Өөрөөр хэлэх юм бол зөв зах зээлийн систем бүрэлдсэн нөхцөлд.

Тэгэхээр Монголд бол санхүүгийн зах зээл ний нуугүй хэлэхэд сүүлийн жил ийм хазайсан хэлбэртэй яваад байна. Энийг засах чиглэлд бас хэрвээ сонгогдох юм бол бас ажиллана гэсэн ийм бяцхан төлөвлөгөөтэй байгаагаа бас хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батбаатарын Мөнхзаяа нэр дэвшигч хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Мөнхзаяа: Ганбат гишүүний асуултад хариулъя. 3 асуулт асуусан гэж ойлгосон. Эхнийх нь хэдэн төрлийн ийм зээлийн хүү байна вэ. Яагаад ийм ялгаатай хүү байна вэ гэсэн асуулт байсан. Тэгэхээр тухайн улс зээлийн хүүгийн бүтцийг дотор нь задлах юм бол ямар ч эрсдэлгүй хүү, тэгээд үүн дээр инфляцын эрсдэл, төлбөрийн чадвар хугацаанаас хамаарсан гээд тухайн зээлийн төрөл нөхцөлөөсөө хамаараад зээлийн хүү бол ялгаатай тогтоогддог. Тэгэхээр Монгол Улсад эрсдэлгүй хүүгийн түвшнийг бол бодлогын хүүгээр буюу 10 хувиар бол ойлгож байгаа. Үүн дээр инфляцын эрсдэл нэмэгдээд, тухайн зээл нь ямар төрлийн зээл гэдгээсээ хамаараад энэ нь бол явж байгаа. Хамгийн эрсдэл багатай салбар гэхээр иргэдийн хэрэглээний зээл худалдааны салбарын зээлүүд бол харьцангуй бага хувийн хүүтэй авах боломжтой бол уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрийн салбарууд бол

чанаргүй зээл өндөртэй байдаг учраас энэ дээр зээлийн хүү бол өндрөөр тогтоогдохоос өөр аргагүй байдалд хүрдэг гэж ингэж хариулах гэсэн юм.

2 дугаарт яагаад гадаадын банк Монголд орж ирэхгүй байна вэ гэсэн. Энэ дээр бол 2017 онд бас гаднын банк орж ирвэл ямар аюулууд нь өрлөж болох вэ, яаж сэргийлэх вэ гэсэн ийм судалгааны ажлыг бол хийж байсан. Эндээс Гадаадын хөрөнгө оруулагчид бол тухайн улсаас өгөөж хүсэж орж ирж байгаа. Монгол Улсын зээлжих зэрэглэл бол В зэрэглэлтэй байгаа гэдгийг бид бүхэн мэдэж байгаа. Тэгэхээр В зэрэглэлтэй улсаас валютаар дор хаяж 15 орчим хувийн өгөөж хүртэх тохиолдолд гаднын банк манай Монгол Улс руу бол орж ирнэ. Тэгэхээр энэ хүртэх өгөөжийн хувь, хэмжээг бууруулахын тулд Монгол Улс зэрэглэлээ сайжруулах буюу үүндээ эдийн засаг, улс төр, санхүүгийн системийн тогтвортой байдлыг бий болгож байж, зэрэглэлээ сайжруулж байж тэгээд энэ тохиолдолд зээлийн хүү бас хөрөнгө оруулалтын өгөөж буурч байж гаднын банкнууд, хөрөнгө оруулагчид Монгол Улсыг сонирхох нөхцөл бүрдэнэ гэж харж байгаа.

Дараа нь яагаад ийм олон янзын төрлийн ханшууд байна вэ гэсэн ийм асуулт байсан. Төв банк бол албан ханшийг тогтоодог. Ханш бол өөрөө төгрөгийн валютын үнэ байдаг учраас эрэлт нийлүүлэлтээр зохицуулагдаж байгаа. Арилжааны банкнууд, тэгээд банк бус санхүүгийн байгууллагууд бол тухайн үеийн эрэлт нийлүүлэлтээсээ хамаарч энэ ханшаа тогтоож байгаа. Ийм хариулт өгье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одоо тэгээд энэ Мөнхзаяа нэр дэвшигчийн хариулт яг эсрэгээрээ байгаа юм биш үү. Сая өөрийн чинь хариултад жишээ нь уул уурхай том эрсдэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа хэсэгт өндөр хүүтэй зээл олгогдож байх ёстой. Эрсдэл багатай иргэдийн хэрэглээний зээл бага хүүтэй оногдож байх ёстой гэж өөрөө хариуллаа шүү дээ. Онолын хувьд гэж ярьж байна. Тийм ээ. Гэтэл өнөөдөр Монголын арилжааны банкнуудаас олгогдож байгаа зээл, тэтгэврийн зээл, малчны зээл, цалингийн зээл 21-24 хувь буюу хамгийн өндөр хувьтай. Харин аж ахуйн нэгжүүдийн зээл 16-18 хувьтай буюу хамгийн бага хувьтай болчихсон.

Банкны тухай хуулиараа эрсдэлтэй хэсгийг өөрөө энэ том аж ахуйн нэгжүүд гэж үздэг мөртөө тэр аж ахуйн нэгжүүдээс үүсэж болзошгүй эрсдэлийг иргэдийн хэрэглээний зээлийн хүүд шингээж аваад байна шүү дээ. Одоо яг тийм эсрэгээрээ нөхцөл үүсчихсэн байна. Жишээлбэл Ганбат гишүүн ийм байгаа юм. 24 хувийн хүүтэй хэрэглээний зээлийн бүтцийг аваад үзэхэд 11 хувь нь эх үүсвэрийн зардал буюу тэр хадгаламжийн хүү, үлдсэн 13 хувь нь 3-4 хувь нь банкны үйл ажиллагааны зардал, 4-5 хувь нь эрсдэлийн зардал, дахиад 4-5 хувь нь банкны ашиг гэж яваад байгаа байхгүй юу. Бүтэц нь.

Тэгэхээр хууль, эрх зүйн орчинд нь сайжруулалт хийж, зээлийн хүүг бууруулах боломжийг бид зоригтой хийж чадвал 4-8 хувиар зээлийн хүүг бууруулах бодит боломж байгаа гэдэг нь харагдаж байгаа. Тэгэхээр өнөөдөр энэ Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны Мөнгөний бодлогын хороо, Монгол банкны хяналтын зөвлөл зэргийг бүтнээр нь бүрэлдэхүүнээр нь хугацаа дууссантай холбогдуулж сольж байгаа зорилго бол эдгээр хууль, эрх зүйн орчны тодорхой өөрчлөлтүүдийг хийж, Улсын Их Хурлаас батлагдсан хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулахын төлөө ажиллахад асуудал оршино гэж ингэж үзэж байгаа. Манай нэр дэвшигчид ч гэсэн энэ дээр нэгдсэн тийм ойлголттой байх нь зөв байх гэж ингэж бодож байна. Мэдээж Улсын Их Хурлаас батлагдсан хууль хэрэгжиж байгаа учраас

өнөөдөр хэн нэгнийг буруутгахад эртэднэ гэж бодож байна. Тэгэхээр Улсын Их Хурал хууль, эрх зүйн орчныхоо энэ шинэтгэлийг бодлоготой хийх нь зөв юм гэсэн ийм байдлаар бас тодруулж хэлэх нь зөв байх.

Бямбажавын Энх-Амгалан нэр дэвшигч хариулт өгье.

Б.Энх-Амгалан: Зээлийн хүүтэй холбоотой асуудал дээр ер нь бол сая өмнө хэлсэн нэр дэвшигчидтэйгээ бол санал нэг байна. Энэ дээр бас нэмээд өөр бас нэг зээлийн хүү бас өндөр байгаад байгаа шалтгаанууд маань өмнө нь авсан нөгөө эрсдэлтэй зээлүүд байдаг. Шүүх дээр очоод асуудлууд гацдаг. Үүнтэй холбоотой бас нөгөө шүүхийн шийдвэр гарахгүй байгаатай холбоотой банкнууд эрсдэл хүлээдэг учраас энэ эрсдэлтэй холбоотой бас хүүнүүдээ дараа дараагийн зээлүүдээр шингээх гэдэг ийм нөхцөл байдлаас бас нэг шалтгаан нь байж байгаа. Тэгээд энэтэй холбоотойгоор бас зээлийн хүү дорвитой бас буухгүй байгаа гэдэг ийм асуудал бол бодогддог.

Гадаад банк орж ирэх тухай асуудлуудын хувьд бол мэдээж Монголбанкны хувьд бол хуулиараа гадаад банк оруулж ирэх бүх нөхцөл байдлыг бол хангасан. Гэхдээ орж ирэхгүй байгаагийн үндсэн нэг шалтгаан нь бол эдийн засгийн нөхцөл байдал маань бас гадныхны хүлээж байгаа түвшинд бас бүрэн хүрч чадахгүй байна уу даа гэдэг ийм нөхцөл байж байгаа. Яагаад гэхлээр манайх уул уурхайн бүтээгдэхүүнээс ихээхэн хамааралтай Үүний үнэ ханшийн өөрчлөлт нь хэлбэлзэл өндөр байдгаас шалтгаалаад эдийн засгийн өсөлт, бууралт маань шалтгаалж байдаг. Энэ нь эргээд манай зээлжих зэрэглэлдээ нөлөөлөөд явдаг учраас энэ нөхцөл байдлын улмаас бас гаднын банкнууд бас хүртэх өгөөжийн хувьд бол алдагдал хүлээх магадлалтай байх ийм учиртай байгаа учраас энэ шалтгааны улмаас бас орж ирэхгүй байна уу даа гэсэн ийм зүйлийг бол бодож байна.

Нөгөө талаас бас хүүтэй холбоотой асуудал дээр бол ер нь хүү маань бол зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн нөхцөл байдлаар тэнцвэржиж байх ёстой. Цаашдаа бол эдийн засаг төрөлжөөд, эдийн засгийн өсөлт маань харьцангуй тогтвортой болоод ирж байгаа тохиолдолд бол аяндаа өрсөлдөөний чанад чадвараар бас хүү буурах нөхцөл маань бүрдэнэ гэж ингэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Би нэг шалгалт авч байгаа юм шиг, та хэд маань тэгээд ер нь яах вэ гайгүй, хариулт бол гайгүй байна гэж үзэж байна. Ер нь эрсдэлээсээ болоод хүү янз бүр байж болно. Тэр бол ойлгомжтой.

Гэхдээ Хойд Солонгос, Монгол 2-т л гаднын банк алга байна шүү дээ. Тийм л орхигдсон улс орон болчхоод байна л даа бид нар. Тэгэхээр энэ Монголбанк бол Засгийн газрын янз бүрийн хөтөлбөрт оролцоод байхаа больё. Энэ янз бүрийн бүлэглэл Засгийн газрын тэр АТМ бэлэн мөнгөний машин тэд нарын бодлогод автдаг ийм байж болохгүй. Хараат бусаар ажиллах ёстой шүү. Тэрийг та бүхэн хянаж, цаашдаа ажиллах ёстой. Тэгээд манай ард түмэн маань ийм л өндөр хүүтэй зээлтэй 30 жил явлаа. Ахиад ч явах юм байлгүй дээ. Их л харамсалтай байна. Энэ улс орны эдийн засгийг үнэхээр өөрчлөхгүй..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох санал хураалтыг явуулна.

Намсрайн Батнасанг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 55 гишүүн буюу 59,1 хувиар дэмжигдлээ.

Раднаасэдийн Даваадоржийг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 47 гишүүн буюу 50,5 хувиар дэмжигдлээ.

Батбаатарын Мөнхзаяаг Монголбанкны бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 54 гишүүн буюу 58,1 хувиар санал дэмжигдлээ.

Бямбажавын Энх-Амгаланг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт. Санал хураалт. 49 гишүүн буюу 52,7 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Байнгын хорооны саналаар Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээс чөлөөлөх санал хураалт явуулна.

Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Цэрэндоржийн Батсүх, Цэвэгсүрэнгийн Мөнхбаяр, Чулуундоржийн Хашчулуун нарыг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 53 гишүүн буюу 57 хувиар санал дэмжигдлээ.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Томилогдсон Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүдэд ажлын өндөр амжилт хүсье. Улсын Их Хурлын гишүүдийн хэлсэн саналыг сайтар тэмдэглэж авч, бодитой ажил хэрэг болгож ажиллах ёстой. Ажиллаж байгаа талаарх тайлангаа эргэж Улсын Их Хурал, холбогдох Байнгын хороонд тогтмол тайлагнадаг хэлбэрээр ажиллах ёстой.

Монголбанканд бас үүнтэй зэрэгцүүлж, давхар чиглэл өгөх ёстой. Монголбанкны тухайд энэ Мөнгөний бодлогын хороо, Монголбанкны Хяналтын зөвлөл зэргийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж, Байнгын тогтвортой ажиллах нөхцөлөөр хангаж ажиллах шаардлагатай болсон юм байна лээ. Сая Ганбат гишүүн бас тодорхой хэлчихлээ. Ганбаатар гишүүн ч түрүүн хэлж байна. Өмнө нь нэр төдий хэлбэрээр ажиллах ийм байдал бол илтэд ажиглагдаж ирсэн байна. Цаг хугацаандаа хугацаа дууссан гишүүдийг өөрчлөх шинэчлэх ажил бас хийгдээгүй байна. Ингэхээр нэр зүүж, орон тоо бөглөж энэ олон улс эх орон, ард иргэдийн эрх ашгийн томоохон асуудлыг гацааж удаашруулдаг энэ байдлыг бол бүрэн таслан

зогсоохын төлөө энэ удаагийн томилгоо авч байгаа нөхдүүд та бүхэн онцгой анхаарч ажиллаарай гэдгийг хэлье. Тэгээд ажлын амжилт хүсье.

15.03 цаг.

Дараагийн асуудалд оръё. **Монгол банкны Хяналтын зөвлөлийн дарга гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Нэр дэвшигчдийн талаар гаргасан Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Индэрт урьж байна. Чуулганы танхимд чөлөөтэй сэлгүүцэхгүй Даваадорж дараа нь гар барь.

Б.Мөнхсоёл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн нэр дэвшигчийг бүртгэх тухай 5 дугаар тогтоолын дагуу зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад Нинжбатын Ууганбаатар, гишүүдэд Сугарын Лхагвадорж, Гэрэлтийн Тэлмэн, Данзанбалжирын Энхжаргал, Ундраагийн Хосжаргал, Тунсагийн Тэлмэн, Гомбын Эрдэнэбаяр нарын нэрийг дэвшүүлсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 3 дугаар тогтоолоор баталсан Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу нэр дэвшигчид нь өөрийн танилцуулга, холбогдох бусад баримт бичгээ бүрдүүлж, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай тогтоолыг баталж, 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддоржийг томилсон.

Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан нэр дэвшигчийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батшугар, Ганхуяг, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг, Цогтбаатар, Эрдэнэбат нарын гишүүд оролцсон болно.

Байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх сонсголын тайланг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гарган танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшигч нь өөрийн харилцаа, ёс зүй хандлагад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай нэр дэвшигч Монго банкны үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгах, Хяналтын зөвлөлийн дарга нь бие даасан, хараат бус байдлаа хадгалж, шинэлэг санаачилга гаргаж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл үйл ажиллагааны ил тод байдал, дотоод хяналтыг сайжруулах, бусад арилжааны банкнууд болон улс төрөөс хараат байдалд хяналт тавих, хамаарал бүхий албан тушаалтнууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд хувь эзэмшдэг нь зүйд нийцэж байгаа эсэх, Цаашид ёс зүй зарчмыг баримталж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн иргэдэд олгох хэрэглээний зээлийг хязгаарласнаас болж иргэд ББСБ-аас зээл авах нөхцөл байдал үүсэж, зээлийн хүүгийн зөрүүнээс санхүүгийн алдагдалд орж байгаа асуудлаар аудитын тайландаа тусгаж, Улсын Их Хуралд тайлагнах, Монголбанкны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах талаар үг хэлсэн болно.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргаар Нинжбатын Ууганбаатарыг, тус зөвлөлийн гишүүнээр Сугарын Лхагвадорж, Гэрэлтийн Тэлмэн, Данзанбалжирын Энхжаргал, Ундраагийн Хосжаргал, Тунсагийн Тэлмэн, Гомбын Эрдэнэбаяр нарыг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тухай бүр дэмжсэн болно.

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Далрайн Даваасамбууг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас, Лхагвадоржийн Ариунаа, Лувсан-Очирын Дондог, Баатаржавын Лхагважав, Бат-Очирын Цэрэнбалтав, Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Мишигийн Энх-Амгалан нарыг тус зөвлөлийн гишүүнээс чөлөөлүүлэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Нинжбатын Ууганбаатар, Сугарын Лхагвадорж, Гэрэлтийн Тэлмэн, Тунсагийн Тэлмэн, Ундраагийн Хосжаргал, Данзанбалжирын Энхжаргал, Гомбын Эрдэнэбаяр нар хүрэлцэн ирсэн байна., Байнгын хорооны санал дүгнэлт болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 12 гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Нэр дэвшигч нартаа амжилт хүсье. Түрүүн би бас Санхүүгийн зохицуулах хорооноос асууж байсан асуултаа асууя. ЖДҮ-лэл, жижиг, дунд бизнесийн хүрээнд дэмжих санхүүжилтийн бодлогыг Монголбанк хэрхэн чиглүүлж ажиллах ёстой вэ гэдгийг нэр дэвшигч нараасаа асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Бүх нэр дэвшигчээс хариулах уу. Нинжбатын Ууганбаатар нэр дэвшигч эхэлж хариулъя. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

Н.Ууганбаатар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. ЖДҮ-лэлийг дэмжих тухай асуудал бол хамгийн түрүүнд, нэн тэргүүнд мөнгөний бодлоготой илүү холбоотой болов уу гэж бодож байна. Хяналтын зөвлөл бол чиг үүргийн хувьд мөнгөний бодлогоос салангид байх ёстой ийм байгууллага. Тэгэхээр шууд мөнгөний бодлогод ямар нэгэн байдлаар нөлөөлөх ёсгүй ийм байгууллага байгаа.

Хувь эдийн засагчийнхаа зүгээс хандахад Монголын эдийн засгийн нэг номерын асуудал бол үндсэндээ нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд бодлогын олон арга хэмжээнүүдийг авах ёстой. Энэ дотор хамгийн түрүүнд мэдээж зээлийн хүүгийн асуудал тулгамддаг. Манай ЖДҮ-лэлийн бизнесменүүд дээр. Дахиад энэ бизнесүүдийн маань өсөлт бойжилтын талаар нарийн судалгаа хийх ийм шаардлага байдаг. Бүртгэлтэй их олон аж ахуйн нэгж байдаг. Гэхдээ идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд их цөөхөн. Арай гайгүй яваа салбарууд дээр төвлөрөл нэлээн нэмэгдсэн. Иймэрхүү ерөнхий эдийн засгийн нөхцөл байдал харагддаг. Тэгээд үүний толин тусгал болж хүү маань өндөр ийм санхүүгийн нөхцөл байдалтай, өндөр инфляцтай, бага нийлүүлэлттэй, өндөр эрэлттэй, импортоос нэлээн хамааралтай ийм эдийн засгийн нөхцөл байдал бол үүсчхээд байгаа. Тэгээд энэ дээр цаашид анхаарч ажиллах ийм шаардлага бүх эдийн засагчдад тулгарч байгаа.

Тэгээд эдийн засгийн бодлогыг нийт эрэлт нийлүүлэлт рүү чиглэсэн ийм эдийн засгийн бодлого хөдлөхөөс өөр ийм сонголтгүй болов уу гэж хувь эдийн засгийнхаа зүгээс харж байгаа юм.

Хяналтын зөвлөлийн хувьд бол ЖДҮ-лэлийг дэмжих чиглэлд ямар нэгэн арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалт бол байхгүй. Бид бол Монголбанк маань үйл ажиллагаагаа тогтвортой, зохистой явуулж байгаа эсэх дээр дүгнэлт гаргах, тэгээд Монголбанкны хөндлөнгийн аудит болон дотоод аудиттай хамтарч ажиллах ийм чиг үүргийн зохицуулалттай байгууллага байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Сугарын Лхагвадорж. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон. Урдах дугаараа өргөнө шүү нэр дэвшигчид. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

С.Лхагвадорж: Их хурлын эрхэм дарга Амарбаясгалан бол Их хурлын гишүүдэд энэхүү өдрийн мэнд хүргэе. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Эдийн засагчийн хувьд ЖДҮ-лэлийг дэмжих бодлого нь өнөөдрийн Монголбанкны хэрэгжүүлж байгаа мөнгөний бодлогоос бол тусдаа. Энийг цэвэр тусдаа урт хугацааны, хүү багатай тэгээд жижиг дунд бизнес эрхлэгч нарыг урт хугацааны 10-15 жилийн хэлбэртэй, өөрөөр хэлбэл үйлдвэрлэлд оруулсан эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалтад оруулсан зээлүүдээ нөхөх хэмжээнд нь дэмжих бодлогоор тусдаа сан байгуулж, энийг бас тэгж дэмжсэн бодлогоор зохицуулсан нь зөв гэж үздэг. Олон улсын туршлагаар бол энийг жишээ нь Япон улс бол Японы хамтын ажиллагааны банк буюу дээр үед бол Жайка гэдэг байсан Жайжибикийн банкны санхүүжилтээр бол нэлээн олон төслүүдийг дэмждэг. Энийг бол Монгол улс Ти Эс Эл 1, 2 гэдэг хөтөлбөрийн хүрээнд бол арилжааны банкнууд маш амжилттай хэрэгжүүлж, энэ төслөөр бол Монгол Улсын олон жижиг дунд бизнесүүд бол арилжааны банкнуудаас гүүрэн зээл авч босож ирсэн. Жилийн хүү нь 6-7 хувь, хугацаа нь 10 орчим жилийн хугацаатай байхаар жижиг, дунд үйлдвэрлэгч маань өөрсдөө энэ зээл дээрээсээ босож, дараагийн том үйлдвэрлэгч

компани болох, шилжих процессыг хэрэгжүүлж чаддаг. Одоогийн арилжааны зээл буюу жилийн 20-оос дээш хувийн хүүтэй, хугацаа богино 2-3 жилийн хугацаатай зээл өгчихлөөр ЖДҮ-лэгчид маань өөрсдөө энэ зээлээ дааж чадахгүй. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтаа нөхөж чадахгүй байдгаас болж жижиг дунд эс эм и чиглэл маань босож ирж чаддаггүй. Тэгэхээр Монгол Улсын Засгийн газар, төр маань өөрөө энэ олон улсын сангуудтай хөтөлбөртэй энэ гүрэн зээлүүдийн бодлогуудыг маш сайн дэмжиж, гаднын урт хугацааны, хүү багатай ийм зээлийн хөтөлбөрүүдийг оруулж ирж, жижиг, дунд бизнесүүдийг дэмжих бодлогыг хэрэгжүүлсэн нь зөв гэж боддог. Тэгэхгүй бол Монголд өөрөө мөнгө хомс, өөрөөр хэлбэл бид нар зах зээл дээрх өнөөдөр бодлогын хүү маань 10, үүн дээр нэмээд бид нар зээлийн хүү маань тогтоод явж байгаа учраас яг энэ дээр бид нар босговол бололцоо байхгүй. Дэлхий дээр бол Герман бол жишээ нь аж үйлдвэрлэлийн хамгийн том орон. 95 хувь нь дандаа ЖДҮ-лэгч орнууд байдаг. Ерөөсөө л санхүүжилтийн схем нь дандаа л урт хугацааны, бага хүүтэй зээлээр босдог учраас бид нар олон улсын зах зээл дээрээс ч эс эм и босгох тийм санхүүжилтийг л төрийн бодлогоор шийдүүлэх нь зүйтэй. Тэгэхээр энийг бол тусдаа сан хэлбэрээр, зарцуулалтыг нь шилэн болгож, яг одоо тэр зарцуулалтыг нь ил тод байлгаж, яг зарцуулалтыг зээлийн бус зарцуулалтаар ашиглаагүй бол тэрийг бас хариуцлагын хэлбэрийг нь чангатгах хэлбэрээр ингэж хуульчилж өгөх юм бол жижиг дунд бизнесийг томруулах бүрэн боломжтой гэж харж өөрөө үздэг байгаа.

Д.Амарбаясгалан: Гэрэлтийн Тэлмэн нэр дэвшигч. Ажлын хэсгийн 17 дугаар микрофон.

Г.Тэлмэн: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Гэрэлтийн Тэлмэн. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Дөнгөж сая нэр дэвшигч Лхагвадорж илүү нөгөө хөрөнгө оруулалт талаас нь бас хэлчихлээ. Миний хувьд болохоор жижиг дундыг санхүүгийн дэд бүтэц талаас нь бас саналаа хэлье гэж бодож байна.

Тэр дундаа бас яг энэ зах зээл дээр бас ажиллаж байсан хүний хувьд нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог бий болгох нэлээдгүй ийм чухал асуудал гэж би хувьдаа боддог. 2024 оны 10 сарын 27-нд Монгол Улсын Их Хурлаас баталсан Төрөөс 2025 онд мөнгөний бодлогын талаар баримтлах чиг баталсан байж байгаа. Үүний 3 хүрээний 3 дахь буюу санхүүгийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэл дээр нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх ажлыг эхэлнэ гээд оруулсан байсан. Энийг бол талархаж хүлээж авч байгаа. Яг өнөөдөр амьдрал дээр юу болдог вэ гэхээр жижиг, дунд бизнес эрхлэгчид санхүүжилт үйлдвэрлэгч болон нийлүүлэгчдээс бараа бүтээгдэхүүнээ аваад, эцсийн хэрэглэгч рүү нийлүүлж байгаа энэ мерчант гэж ярьдаг энэ жижиг дунд бизнес эрхлэгчид бол өөрсдийнхөө байрыг, үл хөдлөх хөрөнгөө барьцаалж байгаад, банкнаас өөрийн яг бизнесийн тэр циклтэй уялдахгүйгээр өндөр хүүтэй ийм мөнгө авч бизнесээ санхүүжүүлж явдаг. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд бол энэ эргэлтийн хөрөнгийн санхүүжилт бол богино хугацаатай санхүүжилтүүд маш их тийм шаардлагатай байдаг. Бүр цаашлаад ярих юм бол нийлүүлэгчид болон үйлдвэрлэгчдэдээ өөрсдийнхөө байрны ордерыг барьцаалуулж байгаад ингээд зээлээр бараа бүтээгдэхүүн авдаг. Энэ нь эргээд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт ингээд хөгжөөгүйтэй холбоотой. Бусад оронд энэ жижиг дунд бизнес эрхлэгчдийг ингээд дэмжих тал дээр нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт бол тухайн бизнес эрхлэгчийн орлого, мөнгөн урсгалын

бизнесийн циклд нь уялдуулаад энэ үйлдвэрлэгч, жижиг, дунд бизнес эрхлэгч, эцсийн хэрэглэгч 3-ын дунд нь ингээд мэдээлэл дээр үндэслэсэн ийм санхүүжилтийн тогтолцоог бий болгож өгсөн байдаг. Тэгээд Монголбанкны 2025 онд Улсын Их Хуралд өргөн барьж батлагдсан энэ бодлогод бол энэ орчихсон байгааг талархаж хүлээж авч байгаа. Тэгээд энэ нь ч гэсэн бас өргөн хүрээнд бас өнөөдөр бас яригдаж байгаа зээлийн хүүг бууруулахад энэ санхүүгийн байгууллагын дэд бүтэц талаасаа бас нэмэртэй юм байна гэж би хувьдаа саналаа хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Тунсагийн Тэлмэн нэр дэвшигч.

Т.Тэлмэн: Сайн байцгаана уу. Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Нэр дэвшигч Ууганбаатар бол ерөнхийдөө ойлгомжтой тодорхой хэлчих шиг боллоо. Тэгээд миний хувьд бол үүн дээр бас нэмэх зүйл алга.

Ер нь Хяналтын зөвлөл маань өөрөө Төв банкны мөнгөний бодлогын үйл ажиллагаанд бол оролцохгүй. Төв банкны тухай хуулийн 27^{1.2} дээр бол энийг тодорхой заачихсан байдаг. Тэгэхээр бид нарын чиг үүрэг дээр бол яг үүнтэй холбоотой ажил бол байдаггүй болохоор бид нар энэ дээр бол тодорхой үүрэг оролцоотой байхгүй юм байна лээ.

Д.Амарбаясгалан: Ундраагийн Хосжаргал нэр дэвшигч хариулт өгье. Ажлын хэсгийн 16 дугаар микрофон.

У.Хосжаргал: Ундраагийн Хосжаргал нэр дэвшигч. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Яг жижиг дунд салбарт бол би бас олон жил зээл өгч, яг хамтарч ажиллаж байсан. Тэгээд яг санхүүжилтээс гадна менежментийн болон олон зүйлүүд бас их чухал байдаг л даа. Тэгэхээр манай нэр дэвшигч нар бүгдээрээ ер нь олон талаас нь хариулсан учраас би эрсдэл талаас нь жоохон тодорхойлоод хэлдэг юм уу. Яг Монголбанк дээр байгаа энэ жижиг дундын зээлийн сан бол 20-22 хувийн чанаргүй зээлтэй байдаг. Энэ нь эргээд нөгөө жижиг, дунд бизнес хөгжихөд эрсдэлийн сан нь их өндөр болчихоод байдаг. Тэгээд эргээд зээлийнхээ хүүд нөлөөлдөг ийм байдал бол арилжааны банкнууд болон Монголбанкны зээлийн багц дээр нөлөөлдөг. Тэгэхээр энэ дээр бол арилжааны банк, бусад энэ эдийн засгийн эко системд байгаа байгууллагууд нэгдэж инкубатор маягаар бол энэ жижиг дунд бизнесийг хөгжүүлдэг бол олон улсын жишиг байдаг. Тэгээд энэ дээр бол санхүүжилтийн тогтолцоо нь их уян хатан. Экспорт, импорттойгоо холбоотой, эдийн засгийн салбартай холбоотойгоор нэлээд санхүүжилтийн схемүүд гардаг. Тэгээд энэ чиглэл рүүгээ манай Монголбанк бас түлхүү ажиллаж, энэ салбарыг бол санхүүжүүлэхэд схем нь зөв болох юм болов уу гэж эдийн засагч хүнийхээ хувьд бол бодож байгаа. Тэгээд нэмээд хариулахад бол ийм байна.

Д.Амарбаясгалан: Данзанбалжирын Энхжаргал нэр дэвшигч. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Д.Энхжаргал: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Асуулт бол Монголбанк өөрөө ЖДҮ-лэлийг хөгжүүлэхэд ямар бодлогын арга хэмжээг авах бололцоотой вэ гэсэн. Тэгэхээр Монголбанкны үндсэн чиг үүрэг бол инфляц, төгрөгийн тогтвортой байдал, макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангахад үндсэн үүргээ чиглүүлдэг учраас энэ ажлаа л маш сайн хийх юм бол инфляц бага, түүгээрээ бол зээлийн хүү буурах, эдийн засгийн тогтвортой буюу түрүүний манай гишүүдээс дэлгэрэнгүй тайлбарласан бүх

асуудлууд, бүх эрсдэлүүдийг зохицуулж ингээд дэмжих, банкуудаар дамжуулж дэмжих ийм боломж байгаа. Ерөнхийдөө жижиг, том ч гэлтгүй зээлийн хүү өндөр байна. Хугацаа богино байна. Барьцаа хөрөнгө хангалтгүй байна. Энэ бүгдээс үзээд ЖДҮ-лэл энэ 3 асуудал бүр илүү их нэрвэгддэг. Тэгэхээр энэ хүмүүст бол яаж туслах ёстой вэ гэвэл зээлийн батлан даалтын сан санхүүгийн зөвлөх үйлчилгээгээр дамжуулж, санхүүгийн төслөө зөв хийх, эх үүсвэрээ орлогоороо дамжуулж барьцаагаар биш, баталгаатай төлдөг bankable төслүүдийг бий болгоход нь Төв банк санхүүгийн боловсролынхоо төрийн мөнгөний бодлогод дурдсан Их Хурлаас баталсан төрийн мөнгөний бодлогын 2025 оны үндсэн чиглэлд заасан тэр чиглэлээрээ бол тусалж дэмжих ийм бололцоотой байгаа.

Мөн түүнчлэн Монголбанк бол өөрийн харилцдаг олон улсын банк санхүүгийн байгууллагууд, Европын сэргээн босголтын банк, IFC буюу Дэлхийн банкны дэргэдэх санхүүжилтийн байгууллагуудаар дамжуулж, ЖДҮ-лэлд зориулсан зээлийг санхүүжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх, холбож өгөх, банкнуудыг тэр зах зээл дээр илүү ажиллуулахад нь бодлогынхоо бичиг баримтууд зохицуулалтынхаа хяналтынхаа ажлуудыг хийх нь зүйтэй гэж үзэж байгаа. Ер нь бол одоо нийт арилжааны банкнууд бүгд санхүүгийн зөвлөх үйлчилгээ, тэр тусмаа бизнесийн төвүүдийг бол байгуулж, жижиг макро бизнесийг дунд болгох, дундыг том болгох, томыг корпорэйт болгох, корпорэйтийг дэлхийн хэмжээний компани болгохын төлөө бол бүгд ажиллаж байгаа. Тухайлбал энэ ЖДҮ-лэлийн дийлэнх нь 80, 90 хувь нь бол эмэгтэйчүүд байдаг. Эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээл дээр эрэгтэйчүүдийг бодвол 20 хувиар бага оролцдог. Яагаад гэвэл бол ахмад, өөрийнхийгөө гэрт байгаа нялх нойтон хүүхэд, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гишүүдээ харж хандах гээд хөдөлмөрийн зах зээл дээр орж чаддаггүй. Иймээс бол эмэгтэйчүүдийг дэмжсэн энэ зээлийг бий болгохын тулд эрх зүйн орчныг бий болгох саналыг Монголбанкнаас статистик мэдээлэл дээр үндэслэж, Их Хуралд танилцуулах зэргээр ажиллах боломж байна л гэж харж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гомбын Эрдэнэбаяр. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Г.Эрдэнэбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Би урд нэр дэвшигч нарын саналтай ерөнхийдөө нэгдэж байна. Гэхдээ энэ дээр зүгээр Монголбанкны зүгээс ямар бодлого явуулж шийдвэрлэж болох вэ гэдэг асуудал дээр Бат-Эрдэнэ гишүүний хариултад энэ дээр яах вэ, нэмээд бид харилцагчийн эрх ашгийг хамгаалах гэсэн Монголбанкны бас үндсэн үүргийн нэг. Тийм учраас харилцагчийн эрх ашгийг хамгаалах гэдэг чиглэлээр бас тодорхой ажил зохиох ч юм уу, эсвэл ийм байж болох юм.

Нөгөө талаас бас түрүүн ярьсан хүмүүсийн санхүүгийн боловсролыг сайжруулснаар жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бас боловсролыг дээшлүүлж хандив нэмэр оруулж болох юм гэж бодож байна. Ер нь бол яах вэ, санхүүгийн юуг бол арилжааны банканд хяналт тавьж байгаагийн хувьд бол хяналт шалгалтын чиглэлээр банкнуудад ажиллахад бас энэ дээр дамжуулан бас энэ талын хяналт тавьж туслалцаа үзүүлж болох юм гэсэн хариултыг өгөх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр асуулт асууж, үг хэлье.

У.Отгонбаяр: Өдрийн мэнд хүргэе. Эрхэм нэр дэвшигч нарт амжилт хүсье. Юуны түрүүнд. Би эхлээд үгээ хэлээд, араас нь асуултаа асуучихъя. Монголбанкны Хяналтын зөвлөл бол маш чухал үүрэг, функцтэй ийм газар. Хэрвээ та бүгд маань сонгогдоод очвол төрийн хүний эрхэм үүргийг тэнд гүйцэтгэх ёстой. Зөвд зөөлөн, буруд хатуу байх ёстой ийм л үндсэн чиг үүрэгтэй газар гэж би ойлгож байгаа юм. Тэгээд энэ зарчмыг та бүгд маань ямагт санаж, энэ зарчмыг барьж ажиллаарай гэдгийг бас хэлье.

Асуултаа асууя. Орчин цагт бол энэ дижитал технологи ашиглахгүйгээр тэр дундаа хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх газар бол дижитал технологигүйгээр хуучинсаг байдлаар бол ажил урагшаа явахгүй. Тийм учраас би маш товчхон та бүгдээс асуух гэж байгаа асуулт нь энэ тал дээр хяналтын зөвлөлийн гишүүд гэж байгаа шүү дарга гээгүй, гишүүд яг юу санаачилж юуг цааш нь хөгжүүлж ажиллах вэ гэдэг дээр та бүгд маань өөрсдийнхөө бодож байгаа, санаж байгаа зүйлийг бас маш товчхон бөгөөд тодорхой хариулаач гэдгийг хүсье.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч Нинжбатын Ууганбаатар. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

Н.Ууганбаатар: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Дижитал технологи нэг сайн талтай, нэг муу талтай. Бид юм болгоныг илүү хурдтайгаар хийж байгаа. Хяналтыг бол мэдээж гэхдээ давхар уламжлалт байдлаар бичиг заавал явж байх ийм ёстой байгаа. Тайлан баланс мөн ялгаагүй. Одоо жишээлбэл Монголбанкны одоогийн байгаа олон нийттэй харилцааны ихэнх нь өөрийнх нь веб сайтаар дамжиж явагддаг. Энэ бол нэг бодлын маш сайн. Яагаад гэхээр бид нар хурдтай мэдээлэл солилцож байна. Гэхдээ нөгөө бодлын тэр веб сайт руу хандалт ер нь хэр зэрэг их байдаг бол гэдэг дээр бас бодох ёстой. Хэр зэрэг олон хүнд хүрдэг бол энэ мэдээллүүд гэдгийг бас харах хэрэгтэй.

Нөгөө талаас бас хэтэрхий их мэдээлэл дижитал байдлаар түгэх ийм хандлага бол байдаг. Тэгэхээр энэ дээр хяналтын чиг үүрэг хэрэгжүүлж байгаа тохиолдолд бид нар уламжлалт болон дижиталыг заавал хослуулах нь зөв болов уу гэсэн ийм байр суурьтай байгаа.

Хяналт дээр дижитал мэдээж манайд би нөгөө дотоод аудитынх нь газар ямархуу технологийнх нь дэвшил ямар түвшинд байдаг талаар мэдээлэл надад байхгүй байгаа учраас одоогоор би дүгнэлт хийж чадахгүй байна. Гэхдээ ихэнхдээ нягтлан бодох бүртгэлийн систем бол сүүлийн 15-20 жил 15 жилийн дотор нэлээн их боловсронгуй болсон байх ёстой. Манай татварын алба бол тухайлбал харьцангуй боловсронгуй ийм мэдээллийн бааз суурьтай болсон байдаг. Тэгээд тэр утгаараа Монголбанк нэг их энэ төслүүдээс хоцроогүй болов уу гэсэн ийм хүлээлттэй байна. Тэгээд тэн дээр бид нар очоод анхаарч ажиллах нь зөв гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ээр дэвшигч Сугарын Лхагвадорж. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

С.Лхагвадорж: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Монголбанк бол өөрөө бас Монгол Улс дахь хамгийн том бие даасан институц. Энэ үүргээрээ бол санхүүгийн тайлагналын олон улсын стандартын зарчмуудыг бол бүгдийг нь мөрдөж ажилладаг. Энэ үүргээ бас олон улсын аудитын байгууллагуудаар

шалгуулж ажилладаг. Энэ үүргээрээ бол бид нар тэр ил тод, шилэн байх байдал нь мөрдөж ажиллаж байгаа гэж найдаж байна. Би бол бас Монголбанканд ажиллаж байгаагүй учраас бас доторх үүрэг функцүүд нь хэр цахимждаг, хэр дижитал байгаа талаар бас бас мэдээлэл байхгүй байна.

Мэдээж Хяналтын зөвлөлийн гишүүний үүргээр очих юм бол аль болох ил тод байх, олон нийтэд мэдээлэлтэй байх, мөн Улсын Их Хурал, Эдийн засгийн байнгын хороо, гишүүдэд илт тод мэдээлэлтэй байх, энэ цаасаар бус дижиталаар нэвтрүүлэлт ер систем, мөн энэ Кор банкиг хэр нэвтрүүлж байгаа байдал дээр Хяналтын зөвлөлийн гишүүний үүргээр хяналт тавьж ажиллана гэж бодож байгаа. Гэхдээ хэт их дижиталжуулах юм бол нөгөө төрийн мөнгөний бодлогыг хадгалах үүрэгтэй, бас энэ Эрдэнэсийн сан, валютын нөөцтэй холбоотой бас юм маань бас нөгөө гаднын сервер нууцлалтай холбоотой бас алдагдах магадлал өндөр байдаг учраас бас энэ Ууганбаатар даргатай бас санал нэг байна. Энэ хослуулах хэлбэрээр ажиллуулж явах нь зөв. Гэхдээ бүтээмжийн хувьд бол бид нар энэ Ки Пи Ай буюу энэ автоматжуулалтын процесс, мөн ажилтнуудын бүтээмж, энэ процессын дахин инженерчлэлийн чиглэлээр энийг бол дахин шинэчлэлийг хийж ажиллахыг бол шаардаж, хэрэгжүүлэлтийг нэхэж ажиллана гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гэрэлтийн Тэлмэн. Ажлын хэсгийн 17 дугаар микрофон.

Г.Тэлмэн: Отгонбаяр гишүүний асуултад товчхон хариулъя. Яах аргагүй асуулт бол дижитал технологийг ашиглаж хяналт шалгалт дээр яаж сайжруулах вэ гэдэг асуулт тавилаа гэж ойлгосон. Монголбанкны хувьд болохоор банкны үйл ажиллагаа эрхэлж байгаа 12 банкнаас гадна бас 25 банкнаас бусад этгээдүүд буюу финтекүүд инновац шингэсэн банкнаас бусад оролцогчид бас оролцогчдын үйл ажиллагааг бол зохицуулж байгаа. 2017 онд батлагдсан, 2018 оны 1 сарын 1-ээс мөрдөгдөж ирж байгаа Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар банкнаас бусад этгээдүүд энэ үндэсний төлбөрийн системд оролцдог болсон. Эдгээр финтекүүд оролцдог болсноороо 24 цагийн турш зээл олгодог. 24 цагийн турш төлбөр тооцоог гүйцэтгэдэг. Бага дүнтэй гүйлгээгээр хийдэг болсон. Өмнө бас энэ салбарт ажиллаж байсан хүний хувьд бол Монголбанкны Хяналт шалгалтын функц бол яг үүнийгээ дагаад бас нэлээн боломжийн бас сайхан технологиудыг ашиглаад явж байгаа юм байна гэж бодсон.

Түрүүн бас өмнөх нэр дэвшигчдийн яриа дээр гарч байсан зүйл дээр зээлийн мэдээллийн сантай холбоотой зүйл байгаад байгаа. 2025 оны төрөөс баримтлах мөнгөний бодлогод ч гэсэн орчихсон байж байгаа. Санхүүгийн дэд бүтцийг бэхжүүлэх тал дээрээ зээлийн мэдээллийн шинэ үйлчилгээг нэвтрүүлнэ гээд ингээд орчихсон байсан. Үүн дээр яг энэ финтекүүд зах зээлд орж ирснээрээ иргэд нөгөө үйлчилгээ үзүүлэгчид харилцан адилгүй цаг хугацаанд энэ зээлийн мэдээллийн санд мэдээллээ өгч байгаатай холбоотой нэг иргэн бол маш олон төрлийн байгууллагуудаас зээл авчих, өөрөө өрийн дарамтад ороод, сүүлд нь зээлээ төлж чадахгүй байх ийм асуудал байгаад байгаа. Тэгэхээр нэн яаралтай Монголбанкнаас энэ зээлийн мэдээллийн сангийн мэдээ нийлүүлэлтийг бодит горим буюу рийл тайм нийлүүлдэг болсноор бол үүнээс бас сэргийлж чадна гэж бол хувьдаа бодож байгаа. Энэ хүрээнд бол товчхон хариулмаар байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Тунсагийн Тэлмэн. Ажлын хэсгийн 15 дугаар микрофон.

Т.Тэлмэн: Отгонбаяр гишүүний асуултад товч хариулъя. Миний хувьд бол 3 зүйл дээр түлхүү анхаарч ажиллана гэж бодож байна. Монголбанкны төв банкны дотоод аудитын тогтолцоо өөрөө эрсдэлд суурилсан систем явж байгаа. Тэгээд тухайн тогтолцоо дээр технологийн шийдэл болон дижитал шийдлүүдийг хэрхэн ашиглаж байгаа тал дээр анхаарна. Олон улсын гаднын Төв банкнуудын дотоод аудитын тогтолцоо нь өөрөө энэ дээр ямар шинэлэг шийдлүүдийг ашиглаж байна, тэр туршлагыг бас цуглуулах, хуримтлуулах, тэн дээр бол бас судалж ажиллана.

2-т бол нөөцийн удирдлагын эрсдэлийн бодлого байгаа. Төв банк өөрөө Монгол Улсын гадаад валют болон үнэт металлын нөөцийг удирдан захиран зарцуулдаг. Тэгэхээр нөөцийн удирдлагын эрсдэлийн тогтолцоо нь өөрөө хэр технологийн шийдлүүдийг ашиглаж байна. Энэ дээрээ ямар шинэлэг, шинэ санаанууд байж болох вэ гэдэг дээр бас судалж анхаарч ажиллана.

3-д болохлоор Төв банк өөрөө санхүүгийн салбарын төлбөр тооцоо болон банкны салбарын төлбөр тооцооны бүх зүйлийг хариуцан ажиллаж байна. Тэгэхээр системийн цахим аюулгүй байдал, кибер аюулгүй байдлын асуудлууд яригдаж байгаа. Тэгэхээр энэ дээр технологийн болон бусад ямар дижитал шийдлүүд, эрсдэлийн удирдлагын тогтолцоо байж болох вэ. Энэ дээр бас анхаарна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Ундраагийн Хосжаргал. Ажлын хэсгийн 16 дугаар микрофон.

У.Хосжаргал: Отгонбаяр гишүүний асуултад товчхон хариулъя. Монгол Улс бол энэ банкны салбар яг дижитал шилжилтээр бол их түүчээлж явдаг гэж би үздэг. Тэгээд яг төлбөр тооцооны 98 хувь нь бол дан цахимаар явж байгаа. Энэ бол бас олон улсад их сайн үзүүлэлт болдог. Гэхдээ яг энэ хянан шалгах үйл ажиллагаа дээр бол технологийн шийдэл, орчин үеийн инновацыг ашиглалт бол харьцангуй сул байдаг гэж би боддог. Энэ олон талын оролцоог хангасан энэ блокчэйн ЕА гээд олон шинэ технологиудыг бид нар хянан шалгах үйл ажиллагаанд нэвтрүүлж чадах юм бол оролцогч талуудын тэгш оролцоог хангах, дата мэдээлэл дээр зөв, цаг алдалгүйгээр анализ хийх гээд ингээд маш олон боломжуудыг бий болгох боломжтой. Тэгээд яг энэ чиглэлээр буюу финтекийн чиглэлээр Англи улсад яг зэрэг хамгаалж байхад бол дэлхийн яг энэ Монголбанкны дэлхийн төв банкнуудын жишиг бол яг энэ дижитал шийдэл рүүгээ их түлхүү анхаарсан, хөрөнгө оруулалтуудаа хийсэн. Эргээд энэ нь бүх оролцогч талуудад тэгш боломжийг олгосон ийм загвар луу бол их түлхүү явж байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр бол бас яг энэ хянан шалгах үйл ажиллагаа бол нэлээн ахиц гаргах ёстой гэж үзэж байгаа. Ялангуяа энэ блокчэйнийг ашиглаад, тэн дээр хянан шалгах үйл ажиллагаа явагдах юм бол эргээд засах боломжгүй, өөрчлөх боломжгүй. Тэгээд түүх нь үлдээд явдаг. Оролцогч талуудад олон талаас зэрэг ажиллах боломжийг үүсгэдэг гээд ингээд олон давуу талууд байдаг гэдгийг бас нэмж хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Данзанбалжирын Энхжаргал. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Д.Энхжаргал: Хяналт шалгалтын ажилд дижитал, цахим хэлбэрийг ашиглах нь маш зүйтэй. Ийм саналыг бид нар зөвлөмж болгож хэлж байгаа нь бол их зүйтэй гэж үзэж байна. Ер нь бол Монголбанкны санхүүгийн үйл ажиллагаа хэрхэн зөв аудитлагдаж, олон улсын зарчмаар ажиллаж байгаа эсэх, дотоод хяналтын үйл ажиллагаа нь хэр зохистой, зөв зүйтэй байгааг бид нар цахим хэлбэрээр мөн

дижитал хэлбэрээр ингээд ашиглах энэ гарц гаргалгаа нь бас хангалттай байгаа эсэхийг бол мэдэхгүй байна. Яагаад гэвэл сүүлийн 8 орчим жил ажиллаагүй. Үүнээс өмнө Монголбанканд 30 гаруй жил нягтлан бодогч, эдийн засагч, Мөнгөний бодлогын газрын захирал, Хянан шалгалтын газрын захирал, Ерөнхийлөгчийн зөвлөх, туслах, Ерөнхий эдийн засагч Лондон дахь Монголбанкны төлөөлөгч, дэд ерөнхийлөгч, Европ дахь Монголбанкны төлөөлөгчийн газрын захирал гэсэн ажлуудыг хийж байх хугацаанд ер нь бол Монголбанк бол цахим шилжилтэд бол хангалттай сайн шилжсэн. Дэд ерөнхийлөгч байхдаа ер системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд үлдээсэн. Энэ ажил маань хэр зэрэг сайн хэрэгжсэн бол. Хэрвээ энэ сайн хэрэгжсэн бол бид нарт хяналт шалгалтын ажлыг цахим хэлбэрээр хийх бүрэн боломж гарна гэж найдаж байна.

Мэдээж цахим дижитал болгож байгаагийн нөгөө талд бол энэ цахим дижиталийн эрсдэл байгаа. Аюулгүй байдал байгаа. Ийм учраас энэ тал дээр бас анхаарч, энэ банкны дотоод хяналт, эрсдэлийг хэрхэн үнэлж, дүгнэж, тооцож, хянаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авдаг юм бэ гэдгийг нь бас хянаж шалгаж, тэгээд шаардлагатай Улсын Их Хурал, Эдийн засгийн байнгын хороонд бид нар тайлан тавихдаа илтгэх болно. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гомбын Эрдэнэбаяр. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Г.Эрдэнэбаяр: Асуултад хариулъя. Энэ урд нэр дэвшигч нар маань нэлээн тодорхой хэлчихсэн учраас би давт давхцуулахгүйгээр хэлье. Монголбанкны хувьд дижитал шилжилт бол нэлээн гайгүй хийгддэг. Мэдээллийн технологийн бас нэлээн хүчтэй албатай гэж бодож байна. Зүгээр ер нь одоо бол дэлхий нийтийн олон улсын хандлага бол жишээлбэл хуучин практикаас хуульчлагддаг байсан бол одоо хуульчлаад практик руу явж байгаа гэсэн хандлага байгаа учраас ер нь бол одоогийн шинжлэх ухаан, техник технологийн шинэ ололтуудыг цахим мөнгө гэдэг юм уу, тэр финтек дээр хэрэглэхэд бол бид түрүүлж хуульчлах асуудал бас гарах юм гарч ирж байгаа юм байна гэдгийг ойлгож байна. Тийм л санал хэлэх байна даа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа асуулт асууж, үг хэлье.

А.Ариунзаяа: 2 чиглэлээр дэмжиж үг хэлье. Нэмэлт 1 минутаа авъя. Мөнгөний бодлогыг бид нар түрүүн ярьсан. Одоо бол Монголбанкны Хяналтын зөвлөлийн талаар ярьж байгаа. Хяналтын зөвлөлийн дарга, удирдлагаар болон гишүүдээр нэр дэвшсэн бүх хүмүүсийг дэмжиж байна. Бүгдээрээ л өөр өөрийнхөө салбартаа танигдсан, амжилттай ажилладаг ийм мэргэжлийн хүмүүс орж ирж байна. Нэн ялангуяа Монголбанкны дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Энхжаргал, Монголбанканд ажиллаж байсан Тунсагийн Тэлмэн яг Монголбанкны үйл ажиллагааг бол маш сайн мэднэ. Даргад нэр дэвшиж байгаа Ууганбаатар. Туркт төсвийн санхүүгийн асуудлаар суралцсан, Шведэд Эдийн засгийн ухааны доктор хамгаалсан, МУИС-ийн Математик, эдийн засгийн тэнхимд дэд профессороор ажиллаж байгаа. Одоо бол бас өнгөрсөн жил Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилогдож, маш сайн ажиллаж байгаа. Яг энэ хэлбэрээрээ төсвийн болон мөнгөний бодлого хоорондоо холилдохгүй байх тал дээр та хэд маань бас анхаарч өгөөрэй гэж хүсэж байна. Сүүлийн 4, 5 жил нэн ялангуяа ковидын үед төсвийн бодлого, мөнгөний бодлого холилдсоноос болоод бас нэлээдгүй

асуудлуудыг үүсгэж байгаа учраас энэ тал дээрээ бас анхаарч, зоригтой ажиллаарай гэж хүсэж байна.

2 дахь асуудал нь болохоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байхдаа яг энэ банкны эрх хүлээн авагч буюу Капитал банкны эрх хүлээн авагч Монголбанкнаас томилогдож ажиллаж байгаа. Тэгэхээр яг энэ Монголбанкны чиг үүрэгт нь байгаа банкны эрхийг хүлээн авагчийн зүгээс проактив байж буюу өөрөө санаачилж бас энэ хөрөнгө хураагдсан байгаа хөрөнгийг борлуулах байдаг юм уу, шилжүүлэх байдаг юм уу энэ Капитал банкны хохирогчдын нэн ялангуяа нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын сангийн хохирлыг барагдуулах тал дээр бас шуурхай ажиллах хэрэгцээ шаардлага байгаа шүү гэдгийг хэлье.

Яагаад гэвэл эс үйлдэхүйгээрээ эргээд удаашруулж байна уу, ямар учир шалтгаан байна вэ. Энэ дээр яг энэ хяналтын зөвлөл бас сайн ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Мөн дээрээс нь яг энэ банкнуудын дампуурлын өмнөх үед нь ямар арга хэмжээнүүдийг авах ёстой вэ, ямар дохио гарч байна вэ гэдэг дээр яалт ч үгүй хяналтын зөвлөлийн чиг үүрэг бас байгаа шүү. Энэ дээр бас зоригтой ажиллаарай. Нэн ялангуяа манай Энхжаргал Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын зөвлөхөөр ажиллаж байхдаа бид нар хамтдаа яг энэ Капитал банкны эрх хүлээн авагчтай хамтарч хөрөнгийг борлуулах, шилжүүлэх замаар энэ авлагаа тодорхой хэмжээнд барагдуулж чадсан. Гэхдээ одоо бол цаана нь маш их хөрөнгө хэвээрээ байгаад байгаа учраас 1 дүгээрт үнэ цэн нь алдагдаж байна. 2 дугаарт ердөөсөө нөгөө алдагдал барагдуулахгүй байгаа нь тэтгэвэр төлөгчдийн, шимтгэл төлөгчдийн хөрөнгө нь алдагдсан байгаад бас их нөлөөлж байгаа учраас энэ дээр анхаараарай.

Үндэсний баялгийн сангийн хөрөнгө Монголбанк дээр байршихаар болж байгаа. Энэ дээр бол цаашдаа тэтгэврийн life insurance гэдэг шиг тийм ээ энэ тэтгэврийн сангийн зарчмаараа цаашдаа алсдаа явах болов уу. Тэгэхээр яг энэ дээр ч гэсэн манай нөгөө Тэлмэн ажиллаж байсан хүний хувьд бас анхаарч энэ баялгийн сангийн цаашдын энэ хөгжил дээр нь бас анхаарч энэ хяналтаа тавина байх гэсэн ийм чиглэлийн саналыг гэдэг юм уу захиасыг гэдэг юм уу хэлж байна. Баярлалаа. Та бүхнийг бүгдийг нь дэмжиж байна. Амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууж, үг хэлье.

Л.Соронзонболд: Нэр дэвшигчдийн сонсгол дээр нэлээн их асуулт асуугаад, хариултаа авчихсан учраас үг хэлье гэж цаг авсан юм. Тэгэхээр Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүд бол мөнгөний бодлогоос бусад Монголбанкны гаргаж байгаа шийдвэр, үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй, үүрэгтэй. Тэр утгаараа болохоор бол жишээлбэл Монголбанкнаас иргэдийг хэт өрийн дарамтад оруулахаас сэргийлж, өр орлогын харьцаа эд нар гээд олон үзүүлэлтүүд мөрдүүлдэг.

Нөгөө талдаа бас Монголбанк өөрийнх нь хариуцаж байгаа бас дэд бүтцийн ажлууд байдаг. Жишээлбэл зээлийн мэдээллийн сан байна. Өнөөдөр зээлийн мэдээллийн сан бодит цагийн горимоор бүх зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлж байгаа байгууллагуудаас авч чадахгүй байгаа улмаас бол олон иргэд өр орлогын харьцаагаа хэтрүүлж зээл авах, нөгөө талдаа банк болон банк бус санхүүгийн байгууллагууд нь эрсдэлд орох ийм асуудлууд гарч байгаа. Тэгэхээр энэ

бол бас Монголбанкны өөрийнх нь үйл ажиллагаагаа бас дутагдалтай явуулж байгаагийн нэг хэлбэр гэж үзэж байгаа. Тийм учраас ер нь бол хяналтын зөвлөлийн гишүүд хэрвээ сонгогдох юм бол энэ тал дээр бас нэлээн сайн анхаарч ажиллах ёстой байх гэж бодож байна.

2 дугаарт болохоор бол Монголбанкны Хяналтын зөвлөлийн өөрийнх нь журам бол 2003 онд батлагдсан ийм журмаар явж байгаа. Тэгэхээр энэ дээр бас нэр дэвшигчид бол бас өөрсдөө энэ дээр тодорхой хэмжээний эрх зүйн байдлыг сайжруулах ийм ажлуудыг бол хийнэ гэж бол ярьсан. Энэ ажлаа бас хэрэгжүүлээрэй. Энэ дээр чинь бол бас Улсын Их Хурлын гишүүд бас нэлээн дэмжиж ажиллана гэдгийг бол хэлмээр байна.

3 дугаарт нь болохоор бол энэ Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд бол салбар салбарын төлөөлөл Монголбанкандаа ажиллаж байсан, ББСБ хувийн секторт ажилласан ийм олон байгууллагын төлөөлөл орсон учраас бас та бүхэн энэ дээр нэлээн санаачилгатай ажиллаарай гэж хэлмээр байгаа. Зөвхөн одоогийн журам зааврын хүрээнд биш өмнө нь ажиллаж байсан Хяналтын зөвлөлийн ажлын арга барилд баригдахгүйгээр бас өөрсдөө их санаачилгатай ажиллаарай гэж захимаар байна.

Д.Амарбаясгалан: Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Хэрлэн: Тэгэхээр Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр нэр дэвшиж байгаа 7 нэр дэвшигчийн материалтай ерөнхийдөө танилцлаа. Тэгэхээр банк, санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэжил боловсрол эзэмшсэн, бас ажлын нэлээн туршлагатай хүмүүс орж ирж байгаа юм байна. Ялангуяа Монголбанканд ажиллаж байсан. Шат шатад нь ажиллаж байсан ийм ажлын туршлагатай Энхжаргал, Эрдэнэбаяр нарын хүмүүс Хяналтын зөвлөлийн энэ багт орж ирж байгаад би хувьдаа их олзуурхаж байна.

Монголбанкны үйл ажиллагаа, тэр тусмаа Монголбанкны дотоод хяналт, хөндлөнгийн хяналтын давуу, сул талыг, амьдралыг сайн мэдэх хүмүүс энэ багт орж ирж байгаагаараа энэ хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа бас өшөө илүү сайжрах, өшөө илүү үр дүнтэй болох болов уу гэж би бас найдаж байна. Сая хэлж байгаагаар ерөнхийдөө хяналтын зөвлөлийн журам бол 2003 онд батлагдсан ийм журмаар үйл ажиллагаагаа явуулж байгаа, энийгээ шинэчлэх гэж байгаа гэж ярьж байна. Тэгэхээр энийг шинэчлэх энэ үйл хэрэгт бол та бүхэн бас дорвитой хуримаар оруулж чадна байх гэж найдаж байна.

Ингээд миний асуулт энэ Монголбанканд ажиллаж байсан 2 эрхэм Энхжаргал, Эрдэнэбаяр 2-т би хандаж би бас зарим нэг зүйлийг тодруулж асууя гэж бодож байна. Ялангуяа Энхжаргал нэр дэвшигч бол бас Монголбанканд төдийгүй ер нь олон улсын банканд ажиллаж байсан ийм туршлагатайтай хүн юм байна.

Тэгэхээр энэ дотоод хяналт, хөндлөнгийн хяналтыг хараат бус, бие даасан болго, олон улсын дэлхийн энэ дэвшилтэт тэр банкны стандарт, шаардлагуудад нийцүүлэхийн тулд та бүхэн өөрийнхөө ажлын туршлага дээр тулгуурлаад яг ямар ажлыг хийе, ямар өөрчлөлтийг хийе гэж бодож яваа бол. Энийгээ бидэнтэй бас илэн далангүй хуваалцахгүй юу.

Д.Амарбаясгалан: Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асуулаа. Нэр дэвшигч Энхжаргал. Ажлын хэсгийн 20 дугаар микрофонд хариулт өгье.

Д.Энхжаргал: Би нийтдээ бол 38 жил банк санхүүгийн салбарт, үүнээс 30 жилийг Монгол банканд, 8 жилийг олон улсын банк санхүүгийн байгууллагууд, мөн түүнчлэн хувьцаат компаниудын ТУЗ-ийн хараат бус гишүүнээр бол ажиллаж, ингэхдээ дотоод хяналт, ялангуяа энэ хөндлөнгийн аудитын хийсэн дүгнэлтийн дагуу тухайн байгууллагууд зөвлөмжийг хэрхэн яаж мөрдүүлдэг ийм сайн практикууд байгаа. Өнөөдрийн өнцгөөс энэ гишүүнд нэр дэвших гэж байгаатай холбогдуулаад нэлээдгүй материалыг бол судалж үзсэн. Тэгээд өмнөх Хяналтын зөвлөлөөс хэд хэдэн ийм зөвлөмж, тайлан, дүгнэлтүүдийг гаргаснаа цахим хуудсан дээрээ тавьсан байсан. Тэгээд эндээс үзэхэд бол Монголбанкны санхүүгийн тайланг хөндлөнгийн ОУБ үнэлж дүгнээд, хязгаарлалттай гэсэн ийм дүгнэлтийг өгсөн. Сүүлийн нэлээдгүй олон жил ийм байдалтай байгаа. Үүнээс дүгнэж үзэхэд одоогийн энэ хяналтын зөвлөлийн эрх хэмжээ, зөвхөн зөвлөмж хэлбэрээр энэ өгсөн зөвлөмжөө хэрэгжүүлэх арга механизм нь сул байдаг юм байна. Энэ сул байгаа шалтгаан нь юу юм бэ гэдгийг судалж үзлээ. Ингэхэд Хяналтын зөвлөл зөвлөл нь дотоод хяналтынхаа газрын удирдлагыг шууд сонгодог олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлээгүй юм байна. Өөрөөр хэлбэл өнөөдрийн Монголбанкны Ерөнхийлөгчийн томилогдсон дотоод хяналтын удирдлага Монголбанкныхаа удирдлагаас цалин хөлсөө тодорхойлуулдаг энэ хараат байдал нь Монголбанкны төв банкны ялангуяа Хяналтын зөвлөлийг хараат бусаар ажиллах энэ бүх үйл ажиллагаа нь олон улсын жишгээс бол хоцрогдсон байна. Тэгэхээр энэ талаар бидний эрх сонгогдсон тохиолдолд хязгаарлагдмал учраас өнөөдөр Эдийн засгийн байнгын хороо, Улсын Их Хурал энэ хууль, эрх зүйн тааламжтай нь орчныг бүрдүүлж өгвөл хяналтын ажлын маань үр дүн илүү сайн гарах болов уу гэсэн ийм бодолтой байна.

2 дугаарт нь ер нь бол Монголбанкны засаглалын асуудал олон улсын түвшинд бас хүрээгүй байна. Өөрөөр хэлбэл Монголбанкны дотоод үйл ажиллагаа хэр зэрэг зөв засаглалтай байгаа талаар Говенин боод гэж олон улсын хэллэгт байгаа. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгчийн томилогдсон захирлуудын зөвлөл биш 3 ерөнхийлөгч дээр нэмээд өнөөдрийн энэ Улсын Их Хурлаар бас яг энэ сонгон шалгаруулж байгаа энэ арга хэлбэрээр захирлуудын зөвлөл, удирдах захирлуудын зөвлөл гэж байгууллагыг байгуулж, энэ нь бол тухайн Монголбанкны төсвийг баталдаг, Эрсдэл удирдлагын хороог нь бас байгуулдаг, эрсдэлийн дээд шалгуур үнэлэлтийг өгдөг, цалин урамшууллын хороог ажиллуулж бас ажиллуулдаг ийм сайн туршлагууд байгаа. Тэгээд энийг бас нэвтрүүлэх нь бол зүйтэй гэж хувь хүнийхээ хувьд бол үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гомбын Эрдэнэбаяр. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон. Аль болох товч хариулахыг хүсэж байна.

Г.Эрдэнэбаяр: Асуултад хариулъя. Энхжаргал нэр дэвшигчийн хэлсэн дээр нэмэхэд бол ер нь Монголбанкны дотоод засаглалыг сайжруулах асуудал бол нэлээн хурц болж байгаа. Яагаад гэвэл биднийг анх 2003 онд Монголбанкны Хяналтын зөвлөлийн асуудлыг хуульд оруулснаас хойш бас нэлээн хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд төв банкны хөгжил бол бас нэлээд хөгжилд ахиц гарсан учраас энэ дээр бас бид энэ хоцрогдлыг засан залруулах нь зүйтэй гэж үзэж байна. Ер нь бол яах вэ Монголбанкны дотоод хяналт, хөндлөнгийн аудитыг сайжруулах дээр бол гол нь Монголбанкны хараат бус байдлыг сайжруулах, хариуцлагатай

байдлыг сайжруулах, ил тод байдлыг сайжруулах гэсэн энэ үндсэн олон улсад барьдаг үндсэн зарчмуудыг барьж хөгжүүлэх нь зүйтэй юм болов уу гэж бодож байна. Тэгэхээр Энхжаргал нэр дэвшигчийн хэлснээр бид одоогийн хуулийн хүрээнд бол яах вэ, Төв банкны хуульд байгаа нэг зүйл болон Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос баталсан журмын дагуу явж байгаа учраас энэ журмыг сайжруулахад ер нь бид хэрвээ батлагдсан тохиолдолд манай нэр дэвшигчдийн саналаас гадна энэ бас парламентаас хүсэх зүйл бас байгаа юм.

Яагаад гэвэл энэ энэ хууль тогтоомжийг нь бас нэлээн өөрчлөх юм уу, сайжруулах шаардлага аргагүй эрх нь тавигдаж байгаа. Энд энэ дээр бас бодолцож ажиллах нь зүйтэй юм болов уу л гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Монголбанкны тодорхой албан тушаал дэвшиж байгаа хүмүүсийг бол дэмжиж байгаа. Сонсгол дээр бас өөр өөрсдийн чиглэлээрээ нэлээн сайн бэлдэж орж ирсэн ийм кандидатууд байсан гэдэг зүйлийг би бас цохон хэлмээр байгаа юм. Тэгээд энэ удаагийн бас Улсын Их Хурлын нэг онцлог бол энэ тодорхой албан тушаалууд дээр томилох асуудлыг бас нээлттэйгээр сонсгол хийдэг болсон. Энэ жишиг бас ХЭҮК, ШЕЗ, Сахилгын хороон дээр явж байсан бол цааш цаашдаа Улсын Их Хурлын бас томилгоо хийгддэг Монголбанк, СЗХ, ҮСХ зэрэг энэ байгууллагууд дээр бас нээлттэйгээр иргэдээс бас энэ нэр дэвшиж байгаа хүмүүсийн талаарх мэдээллийг авч, өөрийнх нь давуу болон, ер нь хийх гэж байгаа ажлын төлөвлөгөө ч байдаг юм уу, энэ байгууллагаа бас юу гэж харж байгаа юм гээд бас олон зүйлүүдийг олон нийтдээ хүргэх зорилгоор энэ сонсголдуудыг хийж байгаа. Тэгээд яах вэ, сонсгол бас 13 цаг үргэлжилсэн. Аль болохоор л бас Эдийн засгийн байнгын хорооны гишүүд бас асуулт асууж, нэр дэвшигчдийгээ бас олон нийтэд өөрсдийгөө танилцуулах боломж олгохын төлөө бас ажилласан гэдэг зүйлийг би бас энд нэг онцолж хэлмээр байна.

Тэгээд энэ бас Улсын Их Хурал дахь томилгооны жишиг юмнуудыг сайжруулаад явж байгаа нэг процессоо гэдэг зүйлийг би бас цохон тэмдэглэмээр байгаа юм. Тэгээд энэ нэр дэвшигчдийн дунд бас туршлагатай залуучууд гээд бас олон төлөөллүүд байгаа. Би зүгээр яах вэ тэгээд нийтлэг байдлаараа одоо мөнгөний бодлого ер нь төсвийн бодлоготойгоо ямархуу бас уялдаатай, бас хамааралтайгаар явах нь зүйтэй гэж бас та нөхөд харж байгаа. Дээрээс нь ер нь зүгээр энэ зээлийн хүүг бууруулахад ерөнхийдөө яг анхаарах ёстой 7 нэр дэвшигч бас олуулаа байгаа учраас яг 2, 2 зүйлийг хэлээч. Яг нэр дэвшигч хамгийн түрүүнд энэ ажлыг Улсын Их Хуралтайгаа хамтарч хийх ёстой гэсэн тэр банкны секторын түвшиндээ ч байдаг юм уу, Монголбанкны түвшиндээ хийх ажлуудыг орхиё. Ер нь Улсын Их Хурал бид бас юуг анхаарах ёстой юм. Энэ зээлийн хүүг бууруулах, энэ санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, энэ хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд яг энэ өрсөлдөөнийг дэмжих чиглэлд яг ямар ямар ажлуудыг Улсын Их Хурлын түвшинд хийх ёстой гээд 2 ажлыг хэлээч.

Би тэгээд энэ дундаас бас Энхжаргал гээд нэр дэвшигчийг бас онцолж хэлмээр байна. Бас хийх ажлын төлөвлөгөө маш детальчилж гаргаж ирсэн. Яг тодорхой ажлуудыг дурдаж гаргаж ирсэн. Бараг энэ хийх ажлын төлөвлөгөөгөөр нь Эдийн засгийн байнгын хороо болон магадгүй зүгээр Улсын Их Хурал дээрээ бас Монголбанкны үйл ажиллагааг сайжруулах ажилтай нь холбоотойгоор үйл

ажиллагааг ер нь бүхэлд нь сонсчихоод, авах арга хэмжээний тогтоолын төслийг ч гэсэн боловсруулаад бас энэ шинээр томилогдож байгаа хүмүүстээ бас үүрэг даалгавар өгөх хэмжээний мэдээлэлтэй, бас хийх ажлын төлөвлөгөөтэй орж ирсэн байсан юм болов уу. Бас эмэгтэйчүүдийн, бүсгүйчүүдийн төлөөллийг бас их өндөр түвшинд харуулахуйц бас ийм манлайлалтай орж ирж байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Нэр дэвшигчид хариулт өгье. Зээлийн хүүг бууруулах талаар 2 санал. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон. Нинжбатын Ууганбаатар.

Н.Ууганбаатар: Сайнзориг гишүүний асуултад товчхон хариулъя. Мөнгө ба төсвийн бодлогын талаар ямар байр суурьтай байдаг вэ гэж асууж байна. Монголбанкны тухай хууль дээр Монголбанкны зорилтуудынх нь үндсэн 2 зорилгоо биелүүлэх, хэрэгжүүлэх зорилтуудынх нь 1 нь бол энэ макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх гэж ийм заалт орсон. Олон улсын түвшинд энэ макро зохистой бодлого гэдгийн цаана үндсэндээ мөнгө ба төсвийн бодлогын хоорондын оновчтой уялдаа гэсэн ийм концепц явдаг. Монголбанк маань энийг энэ 2018 онд орсон болов уу гэж бодож байна. 2018 оноос хойш энэ чиглэлд тодорхой хэмжээний нэлээн судалгаанууд хийсэн байсан. Тэр судалгаануудтай бид нар өмнө нь танилцаж байсан. Энэ дээр ахиц дэвшил дэвшил гарах шаардлагатай яваандаа гарах хэрэгтэй болох байх байх. Ялангуяа Монголд өнөөдөр Монгол Улсын эдийн засагт энэ мега төслүүд яригдаж байгаа тохиолдолд мөнгө болон төсвийн бодлогын хоорондын зохистой оновчтой уялдааг хангаж ажиллахаас өөр ийм зам байхгүй.

Зээлийн хүүг бууруулах чиглэлд авч болох 2 арга хэмжээ юу байж болох вэ гэхээр үндсэндээ бид нар өнөөдрийг хүртэл дандаа эрэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлж ирсэн байгаа. Бүх эдийн засгийн бодлого маань бүгдээрээ нийт эрэлтийг дэмжих чиглэлд явж ирсэн. Үүний үр дүнд юу болж байгаа вэ гэхээр бид нар импортоос өндөр хамааралтай, өндөр инфляцтай, тэгээд дээрээс нь өндөр хүүтэй ийм эдийн засаг руу орчхож байгаа юм. Үүнээс гарах цорын ганц гарц бол одоо нийт нийлүүлэлтийг дэмжих чиглэл рүү бүх бодлогыг чиглүүлэх л байгаа. Нөгөө нэг гарц нь бол бид нэлээн үр ашиггүй ийм тогтолцоотой. Нийтээр нь харах юм монголчууд бид аягүй үр ашиггүй амьдардаг. Энэ үр ашгийг сайжруулахгүйгээр бид дахиад энэ эдийн засгийн олон сорилтуудыг давах ийм боломж гарахгүй болов уу л гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Сугарын Лхагвадорж. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

С.Лхагвадорж: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Төсөв, мөнгөний бодлого оновчтой уялдах ёстой. Сүүлийн жилүүдэд Монгол төгрөгийн ханш ам.долларын эсрэг өнөөдрийн байдлаар 3450 гартлаа нэлээн суларч байна. Энийг би бол энэ төсвийн хэт тэлэх бодлого явуулж, мөнгөний бодлогын орон зай багасаж байгаатай холбоотой гэж болдог. Өөрөөр хэлбэл Монголбанк өөрөө мөнгөний бодлогоо явуулах орон зайг нь төсвийн бодлогын хэт их том орон зай хаагаад байгаа. Тэгэхээр энэ Монголбанкны Хяналтын зөвлөлд би бас ажиллах юм бол энэ Монголбанкны бие даасан хараат бус бодлогоо хэрэгжүүлэхийг шаардана. Монголбанк мөнгөний бодлогоо оновчтой явуулж, энэ төсвийн хэт их бодлогын эсрэг, өөрөөр хэлбэл энэ зах зээлийн хүүгээс доогуур энэ янз бүрийн хөтөлбөртэй зээлүүд гаргаж энэ хэт их импортыг өдөөсөн энэ зээлүүд нь өөрөө эргээд төсвийн

хэт их бодолго нь энэ зах иргэд, аж ахуйн нэгжүүдийн дарамт болж очдог. Тэгээд энэ нь эргээд мөнгөний бодлогын орон зайг хумьдаг.

Тэгэхээр бид нар цаашдаа мөнгөний бодлогын орон зайгаа авч явъя гэвэл төсвийн хэт тэлсэн бодлогыг жоохон тэнцвэртэй, оновчтой авч явах нь зохистой болов уу гэж хувь эдийн засагчийнх нь зүгээс бол авч хардаг.

Зээлийн хүү бууруулах тал дээр бол яах вэ Улсын Их Хурлаас зээлийн хүүг бууруулах стратегийг бол өргөн барьсан байдаг. Би бол хувь бас арилжааны банкны салбарт ажиллаж байсан хувь туршлагаасаа үзэхэд бол түрүүн бас Ууганбаатар дарга хэлсэн. Энэ дээр давхцуулаад яах вэ. Миний хувийн байр суурь бол 1 дүгээрт энэ зээлийн хүүгийн энэ өртгийн 20 орчим хувийг эзэлдэг нь энэ зээл олгож байгаа байгууллага энэ хугацаа хэтэрсэн зээлүүдийг шүүхийн бус журмаар шийдүүлж чаддаггүй. Өөрөөр хэлбэл энэ барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулъя гэхээр Иргэний тухай хуулиар үйлчлэгчийн эрхэд халдана гээд шүүхийн шийдвэр дээр очоод улмаар ингээд шүүхийн шийдвэр гараад, хүү зогсдог ийм байдал байдаг. Энэ нь ингээд явсаар байгаад банкнууд дээр бараг 5 жил, заримдаа 7 жил, бүүр 12 жилийн кэйс байдаг. Нөгөө талдаа зээлийн хүү гэдэг чинь дандаа нөгөө хадгаламжийн өртөгтэй явж байдаг. Энэ маань ингээд зээлийн хүүгийн өртгийг нэмээд байдаг. Бид нар олон улсын практикт болохоор энэ актив удирдлагын компани гэж байгуулаад, өөрөөр хэлбэл банкнууд чанаргүй зээлээ хувийн хэвшилд суурилсан актив удирдлагын компанид дискаунтлаад шүүхийн бус журмаар шийдвэрлээд, энийг ингээд олон улсын практикаар хурдан хугацаанд чанаргүй зээлээ барагдуулдаг горимоор шийдүүлчих юм бол энэ банкнуудын зээлийн хүүгийн өртгийг бууруулах бас нэг боломж гэж би бол хувь эдийн засагчийн зүгээс хардаг.

2 дахь алхам нь болохлоороо энэ банкнуудын дунд энэ өрсөлдөөнийг дэмжсэн зарим нэг юмнууд байгаад байна л даа. Уг нь энийг би шэйред экономи буюу энэ банкнуудын дундаа клерингийн системүүдээ болгочихмоор байдаг юм. Одоо ингээд харахад энэ томоохон худалдааны төв олон иргэд дундаа явдаг энэ газруудад 5 банкны АТМ 1 дор байж байдаг. Их дэлгүүр, гээд томоохон дэлгүүрүүд дотор ингээд 5, 6 банкны пос машин байж байдаг. Энэ олон улсын практик дээр байх юм бол бид нар энийг цаанаа шимтгэлээ хуваагаад авчихдаг, цаад талдаа клерингийн систем нь нэг байж байдаг. Энийгээ хувийн хэвшилд суурилсан дундын компани байгуулаад явах юм бол уг нь өртөг зардал буураад явах боломж байгаад байгаа юм.

Тэгэхээр энийг нөгөө зах зээл дээр монопол түрүүлж орсон компаниуд нь энэ зах зээлийг аль хэдийн эзэлчхээд, тэгэхээр нөгөө компани бусад арилжааны банкнууд нь бас эндээс хоцрохгүйн тулд ингээд дагаж хөгжүүлэлт хийгээд байхаар нөгөө талдаа бас энэ технологийн хөрөнгө оруулалт нь бас энэ зээлийн хүүгийн өртгийг бас нэмж явдаг. Нэгэнт макро инфляц бодлогын хүүтэй холбоотой асуудлууд байгаа. Тэгэхээр яах вэ, би бол зүгээр бас тодорхой 2-3 хувиар бууруулах бол ../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гэрэлтийн Тэлмэн. Ажлын хэсгийн 17 дугаар микрофон.

Г.Тэлмэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Сонсголын үед бас энэ асуултыг тавьж байсан. Товчхон хариулахад бас амаргүй тийм өргөн хүрээний асуулт байгаад байгаа. Чадлаараа товчхон хариулахыг хичээе гэж бодож байна.

Мөнгөний бодлого болон төсвийн бодлогын хоорондын асуудлыг ярьсан. Улс орнууд хоршиж ажиллах тохиолдол байдаг. Гэхдээ бие даасан үйл ажиллагаагаа явуулдаг. Манай хууль дээр ч гэсэн мөнгөний бодлогод харшлах хэмжээний арга хэмжээг Засгийн газраас авч байвал Төв банкнаас сануулах ч байдаг юм уу ийм байдлаар хамтарч ажилладаг. Гэхдээ энэ 2 бол тусдаа бодлого гэдгийг бүгд мэдэж байгаа болов уу гэж бодож байна. Зээлийн хүү яах аргагүй өнөөдөр ч гэсэн ингээд хамгийн их яригдаж байгаа сэдвүүдийн 1 болоод байх шиг байна.

Өөрийнхөө байр суурийг илэрхийлье. Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүний Төв банкны тухай хуулийн 27.1, дээрээс нь Хяналтын зөвлөлийн гишүүний үйл ажиллагааны журам 2003 онд батлагдсан зүйл дээр бол бид нар мөнгөний бодлогын шийдвэрт ямар нэгэн байдлаар оролцохгүй. Бодлого боловсруулагч биш гэсэн хэдий ч ийм асуулт тавигдсан учраас өөрийнхөө хувийн бодлыг бол хариулъя гэж бодож байна. Ямар нэг байдлаар ийм радикал зээлийн хүүгийн таазыг тогтоох байдлаар бол хатуу ийм зохицуулалтын бодлогоор зээлийн хүүг тогтоохыг миний хувьд бол эсрэг байдаг. Энэ нь өөрөө эргээд нэг өдөр бол нэлээдгүй тэсэрдэг. Зүгээр жишээ болгоод үзүүлэхэд бид нар валютын ханш дээр тодорхой хэмжээний интервенц хийж, олон жил хосолмол байдлаар ингээд зохицуулах гэж үзсэн. Гэтэл нөгөө нэг валютын уян хатан ханшийн зохицуулалттай газруудтай харьцуулахад илүү савлагаатай байсан гэсэн ийм тооцооллууд гарч байсан ийм байдаг.

Зүгээр хэлэхэд эхний хувьд бол макро орчин өөрөө сайжрах ёстой. Макро орчин сайжирна гэдэг бол 2023 он, 2024 онд бол харьцангуй сайн байж байна. Манай төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл сайн гарч байна. Гадаад валют улсын албан нөөц сайн байж байна. Бид нар Засгийн газрынхаа гадаад өр төлбөрийг 300 саяар бууруулж чадлаа ч гэдэг юм уу. Энэ макро дохионууд сайжирснаараа гадаад зах зээл дээрээс санхүүждэг эх үүсвэрийн өртөг буурах юм байна гэж үзэж байгаа. Зээл бол үндсэндээ нэг талдаа эх үүсвэр, дунд нь санхүүгийн зуучлалын байгууллагын үйл ажиллагааны зардал гэсэн ийм хэдхэн зүйлүүдээс бүрдэж байгаа. Эх үүсвэр тал дээр бол макро орчин 1 дүгээрт сайжрах ёстой. 2 дугаарт нь дотооддоо гэх юм бол зөндөө олон удаа ярьж байгаа зүйл байгаад байгаа. Банк давамгайлсан санхүүгийн зах зээлээ бодлогын орчинд бол өөрчлөх ёстой. Тулганы 3 чулуу гэж ярьдаг. Банк, дээрээс нь хөрөнгийн зах зээл, дээрээс нь даатгалын болон даатгалын зах зээл маань хөгжих ёстой. Даатгалын зах зээл бол 1 их наяд хүрэхгүй хэмжээтэй байж байна. Хөрөнгийн зах зээл хөгжсөнөөр бол зөвхөн банкнаас бизнес эрхлэгчид санхүүжилт аваад зогсохгүй, өөрсдийнхөө хувьцааг гаргах, нэмэлт хувьцаа гаргах, бусад төрлийн санхүүгийн хөшүүргүүдийг ашиглаж бизнесээ тэтгэх боломжтой.

Дээрээс нь хөрөнгийн зах зээл хөгжихөд бол энэ институционал хөрөнгө оруулагчид маш чухал. Улсын Их Хурлын гишүүдийн энэ яаралтай батлах ёстой энэ хувийн тэтгэврийн тухай сангийн тухай хуулиа баталсан нөхцөлд хувийн тэтгэврийн сангууд бол энэ томоохон бизнесүүдийг урт хугацаанд санхүүжүүлэх, хөрөнгийн зах зээлээр дамжуулж ингэж санхүүжүүлж өгдөг ийм томоохон хөрөнгө оруулагч нар болж ирж гарч ирдэг. Тэгэхээр эдгээр цогц арга хэмжээнүүдийг авснаар бол сайжирна гэж үзэж байгаа. Санхүүгийн байгууллагын зуучлалын байгууллагын хувьд болохлоор үйл ажиллагаа бол мэдээж хэрэг мэдээлэл технологи, инновац шингэснээр зардал бол буураад ингээд нэлээдгүй явчихна. Дээрээс нь яах вэ яг зээл олгодог байгууллагуудын хувьд болохоор тодорхой нэг зардал гардаг нь чанаргүй зээл, тэр муудсан зээлтэй ажиллагаатай холбоотой энэ он дамжсан нэлээд илүү их зардлууд гардаг. Энийг хялбаршуулсан байдлаар шийдэх ийм

боломжийг нь бас эрх зүйн зохицуулалтуудыг нь хийж өгөх юм бол шат дараатай, цогц арга хэмжээ авч байж зээлийн хүү бол ерөнхийдөө буурна гэж би хувьдаа боддог. Ямар нэгэн байдлаар хууль гаргаад зээлийн хүүгийн тааз тогтоосноороо бол буурна гэж олон туршлага ч гэсэн харуулахгүй байх.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Тунсагийн Тэлмэн хариулт өгье.

Т.Тэлмэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Зээлийн хүүтэй холбоотой ерөөсөө маш товчхон хариулт өгье. Зээлийн хүүгийн бүтэц нь өөрөө бол ер нь 4 зүйлээс үүсэж байгаа. Эх үүсвэрийн зардал, тухайн санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зардал, эрсдэлийн зардал, дээр нь тухайн санхүүгийн байгууллагын маржин буюу ашигт ажиллагаа. Ашигт ажиллагааг орхичихъё. Ашигт ажиллагаа бол угаасаа санхүүгийн байгууллагуудын хоорондын өрсөлдөөнөөр энэ тодорхой түвшин рүү ингээд буураад явж байгаа.

Хамгийн гол асуудал бол эх үүсвэрийн зардал болон эрсдэлийн зардал байгаад байна. Эх үүсвэрийн зардал нь өөрөө нөгөө талдаа инфляцтай холбогддог. Зах зээл дээрх дундаж хүү өөрөө буух юм бол эх үүсвэрийн зардал дагаж бууна. Дээр нь гадаадын банк санхүүгийн байгууллагаас тодорхой хэмжээний зардал өртөг багатай санхүүжилт авч байж энэ эх үүсвэрийн зардал маань өөрөө буурна. Тэгэхээр зээлийн хүү бууруулахын тулд нөгөө талд нь эх үүсвэрийн зардал бол буухгүй бол энэ нь өөрөө бууж чаддаггүй.

2 дахь гол асуудал бол эрсдэлийн зардал байгаад байгаа. Эрсдэлийн зардал дээр 2 л асуудал байгаад байгаа. 1 нь болохоор зээлийн мэдээллийн сангийн энэ тогтолцоог маш сайн хөгжүүлэх хэрэгтэй. Эргээд санхүүгийн байгууллага харилцагчаа таньдаг, эрсдэлээ үнэлдэг тэр тогтолцоо нь сайн байх юм бол эрсдэлийн зардал нэлээн сайн буурна. Тухайн хувь хүн, байгууллагад чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн төрөлжөөд ингээд яваад өгчих юм.

2 дахь асуудал нь саяын Лхагвадорж нэр дэвшигчийн хэлж байгаа асуудал маш чухал. Ер нь эргэн төлөлт болон энэ хуулиар шийддэг хуулийн процесс болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процесс нь өөрөө маш төвөгтэй, урт хугацаа шаарддаг болохоор энэ нь өөрөө хүүгийн гол зардал болж орж ирээд байдаг. Тэгэхээр хуулийн хүрээнд энэ асуудлыг бас шийдэх хэрэгтэй.

Үйл ажиллагааны зардал бол ерөнхийдөө санхүүгийн байгууллагууд өөрсдөө өрсөлдөөний журмаар энийгээ буулгаад явж байгаа. Үйл ажиллагааны зардлыг бууруулах техник технологи, инновац, дижитал солюшн шийдлүүдийг бол байгууллагууд өөрөө зах зээл дээр нэвтрүүлээд явж байгаа болохоор энэ бол өрсөлдөөнийхөө жамаар ингээд буураад явах байх. Тэгэхээр үндсэн энэ 4 юман дээр л анхаараад л, төвлөрөөд л ажиллах юм бол хүүгийн зардал бол буурах бол боломжтой л гэж харж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Ундраагийн Хосжаргал. Ажлын хэсгийн 16 дугаар микрофон.

У.Хосжаргал: Сайнзориг гишүүний асуултад давхцахгүйгээр их товчхон хариулъя. Би яг олон улс талаас дотоод талаас нь 2 жишээ хэлмээр байна.

1 дүгээрт бол олон улсын мөнгөний зах гэж байдаг. Энэ дээр бол лайбер нэмэх, хасах гээд ингээд хүү явчихдаг. Эргээд Монгол Улсын эдийн засгийг бол үнэлээд, энэ үнэлгээ нь бол хүү дээр бол тусаж буудаг байгаа. Тийм болохоор олон улсын байгууллагуудын мүдиз сая манайхыг В+ болгож үнэлсэн. Энэ бол маш том нөлөөтэй. Эргээд энэ Монгол Улсын эдийн засаг өөрөө үнэлэгдээд хүү болоод ороод ирдэг учраас ямарваа нэгэн шууд зах зээлийн бус зохицуулалтаар бол шууд буулгах бас боломжгүй.

Нөгөө талаасаа эрх зүйн орчныг сайжруулснаар ямар боломж үүсэх юм бэ гэж асуусан. Энэ дээр бол яг саяын энэ актив пасивийн менежментийг сайжруулах зайлшгүй шаардлага байгаа. Ингэснээрээ энэ сангууд дээр үүсээд байгаа эм пи эл буюу чанаргүй зээлийн хувийг буулгах боломжтой. Энэ бол одоо яг Улсын Их Хурлын зүгээс хууль тогтоомжид өөрчлөлт оруулаад, Монголбанкны хамтын ажиллагааны үндсэн дээр бол хамгийн ойрхон гарах боломжтой ийм үр дүн байгаа. Ингэснээрээ бол арилжааны банк болон Монголбанкны хүү буурах бол бүрэн боломжтой байгаа гэж маш товчхон хариулъя.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Данзанбалжирын Энхжаргал. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Д.Энхжаргал: 2 асуулт асуусан гэж ойлгосон. 1 дүгээрт нь ер нь төсөв мөнгөний бодлогыг яаж уялдуулах тухай асуусан. Энэтэй холбогдуулаад хэрвээ Засгийн газар төсвийн ихээхэн тэлэлтийн үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд Монголбанк хатуухан мөнгөний бодлого явуулахаас өөр гарцаагүй байдалд ордог. Ийм учраас Төв банк нөгөө хараат бус байдлаар мөнгөний бодлогоо явуулах ёстой. Хойноос нь хөөж явуулдаг учраас инфляцыг бол хөөрөгдөж гүйцэж чаддаггүй. Энэ нь макро эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэдэг ийм байдлууд байгаа. Тэгэхээр энийг зогсоох ёстой. Ер нь бол мөчлөг дагах биш сөрөх энэ бодлогоо хараат бус байдлаар зохистой хэрэгжүүлэх ёстой. Энэ тал дээр мөнгөний бодлогын хороо сая томилогдлоо. Энэ хүмүүс үндсэн чиг үүргээ хараат бус байдлаар Засгийн газраас хараат бус байдлаар зохион байгуулах ёстой. Ингэвэл бол зөв зохистой.

2 дугаар асуудлын хувьд хүүг яаж бууруулах тухай ярилаа. Энэ дээр санал асууж байна. Ер нь бол Монгол Улсад бол эрэлт их байгаа. Нийлүүлэлт нь бага байгаа. Тэгэхлээр нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа. Тэгэхээр одоо байгаа банк, банк бус санхүүгийн байгууллагуудын хүү, зээл өндөр байгаа. Яагаад гэвэл эрэлт их учраас тэд нар хүүгээ бууруулах сонирхол байхгүй. Бууруулах ямар сонирхол нөхцөл бий болох вэ гэхээр хөрөнгө оруулалтын гадаадын ч юм уу дотоодын банкнуудыг байгуулах энэ ажлыг идэвхжүүлэх, эрх зүйн орчинд нь тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, ялангуяа олон улсын санхүүгийн чөлөөт бүсийг байгуулах сүүлийн 20 гаруй жил ярьж байгаа энэ асуудлыг бодит ажил хэргийг болгох ёстой.

3 дугаарт нь гэвэл ер нь энэ актив зээлийг чанаргүй зээлийг борлуулдаг энэ зах зээлийг бий болгохын тулд эрх зүйн орчныг бий болгох ёстой. Биржийг бий болгох ёстой. Энэ тал дээр бол гишүүн өөрөө санаачлаад хууль боловсруулж байгаа гэж сонсгол дээр хэлсэн. Энэ ажлыг сайн хийх юм бол хүү буурах бас нэг гарц боломж гай байгаа. Мэдээж бүх арилжааны банкнууд Монголбанк ч гэсэн хэмнэлтийнхээ горимыг бүх шатдаа хэрэгжүүлж, зээлийн хүүг аль болох бага байлгахын төлөө хамтдаа зүтгэж ажиллах ёстой гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гомбын Эрдэнэбаяр хариулт өгье.

Г.Эрдэнэбаяр: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Урд нэр дэвшигч нар тодорхой ярьчихсан учраас би зөвхөн зээлийн хүүгийн тухай асуудал дээр хууль зүйн хувьд ямар шийдэл байж болох юм бэ гэдэг нэг л санал гаргахыг хүсэж байна.

Чанаргүй зээлийг банкнаас шилжүүлэн авч удирдах тийм мэргэшсэн институтийг бий болгох. Тэгээд тэр зээлийн 2 дахь зах зээлээ хөгжүүлэх шинэ бүтцийг бий болгох шинэ байгууллага бий болох ёстой юм шиг байгаа юм. Яагаад гэвэл энэ дээр бусад улсуудын туршлагыг харахад Солонгост жишээлбэл Камко гэдэг юм уу, эсвэл Хятадад байдаг, Казахстан ойр хавийн орнуудад байдаг ийм төрлийн бүтцийг бид нар бас сонирхож судалж үзүүштэй юм болов уу гэж бодож байна. Энэ дээр бол яах вэ, Төрийн оролцоо зарим газар байдаг. Зарим нь хувийн байдаг. Ер нь эхний үүсгэл санаачилгууд бол Монголбанкны санаачилгаар Хадгаламж банкны эрх хүлээн авагчийн дэргэд ийм чанаргүй зээлийг бусад банкнуудаас аваад шилжүүлээд, 2 дахь зах зээлд арилжих тийм зорилго байгуулсан компани байгаа гэдгийг дурдахыг хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг асуулт асууя.

Х.Ганхуяг: Би 2 хоног бас сонсгол дээр нэлээн сайн шүүсэн шахсан юм. Гэхдээ саяын Сайнзориг гишүүний асууж байгаа асуултад хариулж байгаа байдлыг сонсохоор яг л арилжааны банкны гүйцэтгэх удирдлага шиг л хариулаад байна л даа. Зээлийн мэдээллийн сан ярьж байна. Улсын Их Хурал ийм хууль батлах ёстой гэж байна. Муу зээлийн арилжаа ярьж байна. Шүүхийн процессын асуудлууд ярьж байна. Өнөөдөр муу зээл бол муу зээлийн багц бол арилжааны банкнуудын зээлийн ерөөсөө 1-2 хувиас хэтрэхээ больсон. Тэгээд би юу хэлэх гээд байна гэхээр бид нар 2021 онд энэ банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор Банкны хуулийг батлуулсан юм. Тэр хуулийг батлуулснаас болж би чинь талбай дээр бас зургаа шатаалгаж байсан хүмүүсийн нэг л дээ. Тэр хуулийг батлуулах болсон үндсэн шалтгаануудыг нь хэлэх юм бол энэ олон жил дамнасан банк, Төв банк, улс төрчдийн мафи гэж юм байдаг юм, байсан юм. Олон янзын хулгай хийсэн. Тэгээд тэрийг таслан зогсоох зорилгоор банкиг банкнаас өөр төрлийн бизнес хийхийг нь хориглосон ийм хууль болсон. Тэгэхээр би энэ дээр та бүхнээс 1 дүгээр асуулт юу хэлэх гэж байна гэхээр өнөөдөр банкнууд ер нь банкнаас өөр төрлийн бизнес хийж байгаа юу. Хийхгүй байгаа юу. Та бүхэн очоод энийг таслан зогсоож чадах уу. Та бүхний үүрэг бол хуулийн хэрэгжилтийг хангах, Төв банкыг хуулийг хэрэгжүүлэхийг нь шаардах ажлын нэг хэсэг чинь тэр шүү дээ..

2 дугаарт энэ хувьцааны задралтай холбоотой асуудал байгаа юм. Эд нар бол үндсэндээ яагаад нээлттэй ХК болгосон бэ гэхээр тэр банкиг хувьцаа бусад жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ хяналтад оруулах ийм зорилгоор нээлттэй ХК болгосон юм. Тэгээд одоо бол 5, 10, 5, 10 хувиа гаргачхаад тэгээд ингээд гацчихсан байдалтай байгаа. 2026 оны 12 сарын 31 гэхэд хувьцааны задралаа хийх ёстой юм. Тэгж байж энэ салбарын өрсөлдөх тэр юу нь нэмэгдэх юм байгаа юм. Өрсөлдөөний зах зээл, зарчим нь нэмэгдэх юм байгаа юм. Энэ бүхнийг яагаад яриад байна гэхээр өнөөдөр банкны зээл бол ЖДҮ эрхлэгч нарт бол олдохоо больчихсон шүү дээ. Банкны зээлийн хүүгээр жижиг дундууд зээлээ авч чадаж байвал үгүй ээ мөн хэрэгтэй байгаа юм. Тэр 3 хувийн хүүтэйгээр тийм зээл чинь ер нь олдохгүй. 6 хувийн хүүтэй ЖДҮ-ийн зээл гэдэг юм чинь олдохгүй. Тэр бол жилд 100, 200 аж

ахуйн нэгжид л олддог. Дандаа энэ дарга нарын хүмүүс авдаг. Тэгээд л яадаг вэ гэхээр дандаа нэг банк бус юм уу, ломбард юм уу, ХЗХ руу л явдаг байхгүй юу. Өнөөдөр бид нар банкны зээлийн хүүг бууруул гээд байгаа. Үгүй банкны зээл нь олддог болоосой гээд тэр хүртээмж дээр нь та нар ажиллах ёстой шүү. Банкны зээлээрээ энэ аль болох олон хүн тэр зээлийг нь авах боломжийг нь хангаж өгөх ёстой шүү..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигчид хариулт өгье. Нэр дэвшигч Нинжбатын Ууганбаатар.

Н.Ууганбаатар: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Банкны тухай, Банкны эрх зүйн байдлын тухай, Банканд хийсэн реформын тухай ерөнхийдөө өөртэй чинь би санал нийлж байна. Банк, банкнаас өөр төрлийн бизнес хийхгүй байх нь зохистой. Бодит байдал дээр хийж байгаа эсэхийг би энд шууд дүгнэж хэлж мэдэхгүй байна. Зүгээр одоо надад байгаа тоон мэдээллээс харахад манай банкны пассивын бүтцийн хамгийн эхнийх нь үзүүлэлт бол хамгийн их жин дарж байгаа зүйл нь 29 хувьтайгаар харилцах үлдэгдэл байгаад байдаг. Дараа нь 23 хувьтайгаар хадгаламж байх жишээтэй. Нөгөө талд нь активынхаа бүтэц дотор зээлийнх нь эзэлж байгаа хувь бол үндсэндээ 30 хувь орчим ийм байгаа. Тэгээд энэ бол зөвхөн банкныхаа үйл ажиллагааг эрхэлж байгаа тохиолдолд ийм нөхцөл байдал, ийм дата, ийм өгөгдөл харагдах уу, үгүй юу гэдэг дээр би бол жоохон эргэлзэж байна. Тэгээд энд ямар нэгэн цаана нь өөр юм байхыг үгүйсгэхгүй. Тэгээд энэ дээр анхаарч ажиллах нь зүйтэй.

Зүгээр банканд хийсэн 2 том реформ байгаа сүүлийн хэдэн жилүүдэд. 1 нь активын үнэлгээ хийсэн. Үүнтэй холбоотойгоор дараа нь ХК нээлттэй болох ийм алхам хийгдсэн. Тэгэхдээ өөрийн чинь хэлснээр 5-10 хувиа гаргасан. Ер нь 20 хүртэл хувь гаргах ийм зорилт байгаа болов уу гэж бодож байна.

Нөгөө талаас энэ үзэгдлүүд маань хоорондоо холбоотой юм биш биз дээ гэсэн бас ийм нөхцөл байдлыг үүсгэж байна. Өөрөөр хэлбэл ХК болох, үүнд бэлтгэл хангаад активын үнэлгээ хийх, тэгээд энэнтэй холбоотойгоор саяын түрүүний миний дурдсан актив, пассивын бүтцэд гарсан энэ үндсэн үйл ажиллагаанд ажиллагаа нь харьцангуй бага хувь эзэлж байгаа ийм нөхцөл байдлууд хоорондоо холбоотой юм биш биз дээ гэсэн бас нэг ийм асуулт байна. Би шууд хариултыг нь бол мэдэхгүй. Энийг тодруулж судалж нягталж үзэх ёстой юм байна гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Сугарын Лхагвадорж.

С.Лхагвадорж: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Ганхуяг гишүүний байр суурьтай бол би санал нэг байна. Банкны реформ хийх нь бол зайлшгүй шаардлагатай байсан. 2017 онд Европын Төв банк буюу И Си Би-ийн стандартын дагуу Монгол Улсын арилжааны банкнуудад активын чанарын үнэлгээ хийсэн. Тэгээд үүний өмнө Монгол Улсын Төв банк өөрөө банкнууд дээрээ хяналт шалгалтын тогтолцоогоороо хийгээд, өөрийн хөрөнгийн дутагдал И Си Би-ийн Эй Кю арын өөрийн хөрөнгийн дутагдал 2-ын зөрүүг тухайн үед харж байхад 520 орчим тэрбумын зөрүүтэй гарч байсан. Тэгээд энэ бол том тухайн үедээ маш том тоо байсан л даа. Өөрөөр хэлбэл дэлхийн хараат бус бие даасан байдлын хамгийн том үлгэр жишээ болдог том банк бол Европын Төв банкнууд гэх И Си Би байдаг. Тэгээд Швед, Норвегийн банкнууд бол энэ хараат бус бие даасан байдлыг хэрэгжүүлэх байдлаар бол дэлхийд тэргүүлдэг. Тэгээд энэ 520 тэрбумын өөрийн хөрөнгийн

дутагдал гарсны дараа бол Монгол Улсад бол энэ банкны реформыг хийх зайлшгүй шаардлагатай юм байна гэж үзээд, 2021 онд бол банкны реформын тухай хууль хийгдсэн. Үүний дараа банкны хувьцаа эзэмшигчдийн бүтцийг бол задалсан. Энэ бүрэн хэмжээний реформ бол 2026 онд бол хийгдэж дуусна. Энийг бол би бүр олон улсын жишгийн хэмжээнд бол утгаараа ХК-уд олон нийтийн компаниудын хэмжээнд яваад, жижиг хувьцаа эзэмшигчид нь энэ арилжааны банкнуудаасаа шаардлага нэхдэг, өөрөөр хэлбэл энэ том хувьцаа эзэмшигчид нь банкнуудыг аж ахуйн нэгж эрхлэхийг хориглодог. Өөрөөр хэлбэл банкнаас бусад бизнес хийхгүй байхыг шаарддаг энэ тогтолцоо руу шилжих энэ тогтолцоо нь бол зөв юм гэж бодож байна. Одоо Банкны тухай хуулиар банкнуудыг бол өөр бизнес хийхийг хориглосон. Одоо би бол банкнуудыг бас өөр бизнес хийхгүй байгаа гэж ойлгож байгаа.

Зээлийн хүртээмжийн хувьд тантай санал нэг байна. Яах вэ, энэ нөгөө зээлийн хүртээмж нь өөрөө 3 хувьтай зээл жижиг дунд бизнесийнхэнд олдохгүй байгаа шалтгаан нь эргээд л нөгөө бодлогын хүү 10 хувьтай, тэгээд цаашаа яваад нөгөө нэг зээлийн өртөг, тэгээд энэ манай улсад мөнгө өөрөө хомс байна л даа. Тэгэхээр бид нар энэ макро эдийн засгийн орчин, гадаадын хөрөнгө оруулалт, энэ ажлын байр нэмүү өртөг шингээсэн энэ бодлогуудаа нэмэгдүүлэх юм бол манай улсын иргэд өөрөө хуримтлалаа нэмэгдүүлээд, энэ банкнуудын хадгаламжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг нь нэмэгдүүлэх юм. Тэгэхээр одоо яг банкнууд маань өөрөө мөнгөгүй байгаад байгаа учраас энэ зах зээл дээрээс мөнгийг өндөр өртөгтэйгөөр татах өрсөлдөөнд орчхоод яваад байгаа юм.

Тэгэхээр манай иргэд ерөнхийдөө илүү цалингаасаа илүү гарсан хэсгээ хадгалдаг болоод, иргэд маань өөрсдөө ингээд нөхцөл байдал нь сайжраад ирэх юм бол энэ банкнуудад маань хадгаламжийн хэмжээ нь нэмэгдээд ирэх юм бол өөрөө дагаад зээлийн хүү маань буугаад л явчихна. Одоогоор банкнууд маань олон улсын зах зээл дээрээс 10-12 хувийн хүүтэй бонд авчраад, энийгээ Монгол банктайгаа своп хийгээд, 15-аас дээш хувьтай төгрөгийн своп болгоод, энийгээ арилжааны банкнууд маань 18-аас дээш хувьтай төгрөг болгоод ингээд гарахлаараа эргээд зээлийн өртөг маань өндөр болдог. 3 хувьтай зээл гэдэг чинь өөрөө яг л нөгөө зах зээлийн бус механизм. Өөрөөр хэлбэл цэвэр татаасан хэлбэртэй төслийн ийм сангуудын зээл байдаг учраас энэ маань дахиад л хүртээмжийн хувьд асар богино болоод яваад байна. Энийг би түрүүн хамгийн эхний Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулчихсан байгаа. Ингээд л олон улсын зах зээл дээрээс л бид нар зээлжих зэрэглэлээ сайжруулж л гаднаас л урт хугацааны богино хугацаатай мөнгө оруулж ирж л шийдүүлэх бололцоотой гэж хардаг.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гэрэлтийн Тэлмэн.

Г.Тэлмэн: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Асуултад хариулахаасаа өмнө Ганхуяг гишүүний яах вэ санаа зовнилыг, дээрээс нь Монголбанкны Хяналтын зөвлөлд горилж байгаа магадгүй томилогдвол шаардаад байгаа зүйлүүдийг маш сайн ойлгож байгаа. Гэхдээ яг өнөөгийн хүчин төгөлдөр Төв банкны тухай хуулиар Монголбанкны хяналтын зөвлөл нь яг юу хийдэг юм бэ гэдгийг хэлье гэж бодож байна.

Монголбанкны хяналтын зөвлөл нь Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн байгууллагын аудитын зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц, Монголбанкнаас санхүүгийн тайлагналаа Улсын Их Хурал болон

олон нийтэд хэрхэн тайлагнаж байгаа байдал, Монгол банкны зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавина гээд ийм байж байгаа.

Бүрэн эрхийн хэмжээнд 4 чиглэл байж байгаа. Гол шийдвэр нь өөрөө зөвлөмжийн шинж чанартай байгаад байгаа юм. Зөвлөмжийн шинж чанартай. Дээрээс нь Улсын Их Хуралд Монголбанкнаас тайлангаа хүргэхэд нь Монголбанкны Хяналтын зөвлөлөөс ингээд тайлангаа хамт хүргүүлдэг ийм л юм байгаад байгаа юм. Тэгэхээр Ганхуяг гишүүний хүсэж байгаа зүйл дээр бол Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журмын бүрэн эрх дээр 1 бүрэн эрх байж байгаа. Хяналт шалгалт, дээрээс нь санхүүгийн тайлагналтай холбоотой эрх зүйн орчныг өөрчлөх санал гаргах эрх бол Монголбанкны Хяналтын зөвлөлд бол байгаа юм байна лээ. Тэр хүрээнд бол хамтарч ажиллаад, саяын хэлж байгаа зүйлүүд дээр бас тодорхой ажиллах нь зүйтэй болов уу гэж бодож байгаа. Мэдээж хэрэг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Банкны тухай хуулиар бол банкнууд өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй. Монголбанкнаас авсан тусгай зөвшөөрлийн хүрээнд, дээрээс нь СЗХ-оос авсан зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах эрхтэй. Гэсэн хэдий ч энэ хардлагууд байдаг. Өнөөдөр олон нийтэд нээлттэй байгаа мэдээллүүд дээр л бид нар дүн анализ хийж байгаа болохлоор бас тодорхой хэмжээгээр яг оролцож байна уу, үгүй юу гэдэг тал дээр нь бол хэлэхэд бол хэцүү.

2 дахь асуулт болох энэ жижиг хувьцаа эзэмшигчийн асуудал 2026 оны 12 сарын 31 хүртэл бол хойшлуулсан байж байгаа. Банкны хуулийн шинэчлэлээр энэ хувьцааг 20 хувь эцсийн нэг өмчлөгчийг 20 хувь хүртэл эзэмших энэ зохицуулалт. Ийм практик өөрөө бусад орнуудад бол байдаг. Монголоос хүн ам ихтэй, нэлээдгүй өндөр хөгжсөн орон дээр хүртэл, магадгүй нео банкны чиглэлд байгуулж байгаа бол эцсийн өмчлөгч нь 10 хувиас 1 өмчлөгч нь 10 хувиас хэтрэхгүй байна. Дээрээс нь нэг төрлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа этгээдүүд хамтарч болохгүй гээд категори хаадаг. Магадгүй нэг үүрэн телефоны оператор, магадгүй нэг томоохон сүлжээ эзэмшиж байгаа байгууллага монопол болохоос сэргийлж ингэж хамтралыг илүү үзсэн ийм зөв зохистой зохицуулалтуудыг бол хийж өгдөг юм байна лээ.

Зээлийн хүртээмжийн хувьд бол зүгээр зээл авах хүртээмж талаараа Монгол Улсын иргэд зээл авч чадаж байгааг. Гол нь өртгийн асуудлуудыг бол түрүүн зөндөө ярьчихсан учраас дахиж яриад яах вэ. Орон нутагт, тэр тусмаа энэ хөдө аж ахуй, мал аж ахуй тал дээр бол 2 банк ерөнхийдөө зонхилж байгаа. Малчдын зээл 1,2 их наядыг Төрийн банк, Хаан банк 2 олгож байгаа. Үндсэндээ хэрэглээний зээл шинжтэй 24 сарын хугацаатай, жилдээ 2 удаа төлөх тэр орон нутгийн энэ зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах нь зүйтэй гэж бодож байгаа. Бусад банкнуудын тийшээ нэвтрүүлэх энэ хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр ажиллах нь зүйтэй байх гэсэн тийм саналтай байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Тунсагийн Тэлмэн.

Т.Тэлмэн: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Таны 2 асуулт болон байр суурьтай бол санал нэг байна. Нэгд бол банкны томоохон хувьцаа эзэмшигч бол өөр төрлийн бизнес хийх нь зохимжгүй гэж үзэх нь бол зөв. Гол яах вэ, би өмнөх нэр дэвшигчдийн хувьд яригдаагүй зүйл гэх юм бол банк өөрөө мэдээлэлтэй байдаг. Өөрсдийн хэрэглэгч, харилцагчтайгаа өрсөлдөөд, тухайн мэдээллийн давуу байдлыг ашиглаад бизнес хийгээд байх нь зохимжгүй болов уу гэж хувьдаа би боддог. ХК болох асуудал нь болохоор банкны хувьд өөрөө тусгай зохицуулалттай

санхүүгийн байгууллага. Олон нийтэд нээлттэй ХК болсноор хэд хэдэн санхүүгийн салбарт хэд хэдэн давуу талыг авчирч байгаа болов уу гэж үзэж байгаа.

Засаглалын хувьд бол зөв, ил тод засаглалын зарчим нэвтэрч байгаа. Дээр нь тайлагналын хувьд болохоор олон нийтэд нээлттэй тайлагнаад явах, олон нийт түүнд нь хяналт тавих, тодорхой хэмжээний итгэлцэл үүсэх асуудал байгаа.

3-д болохлоор жижиг хувьцаа эзэмшигчдийн хяналтыг оруулж ирж байгаа. Үүгээрээ давуу талтай байгаа. Тэгэхээр үүн дээр бол хувь хүний хувьд би бол санал нэгтэй дэмжиж явдаг. Зүгээр хяналтын зөвлөлийн гишүүнээр томилогдон очих юм бол өөрийн хууль болон журмаар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд би тодорхой хяналтаа тавиад, Монголбанктайгаа ингээд ажиллах болов уу. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Ундраагийн Хосжаргал.

У.Хосжаргал: Яг бас хэлэлцүүлэг дээр бид нар нэлээн тодорхой ярьсан. Ганхуяг гишүүнтэй бол 100 хувь санал 1 байгаа. Банкны энэ шинэ хуульд өөрчлөлт орсон. 2021 онд өөрчлөлт орсон энэ хууль, эрх зүй Монголбанкны тухай хууль, Банкны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах дээр бол Хяналтын зөвлөлийн гол чиг үүрэг оршдог. Тэгэхээр энэ тал дээр бол хэрвээ сонгогдсон тохиолдолд анхаарч ажиллана.

Дээрээс нь энэ банкны төвлөрлийг сааруулах хувьцааг бол нэмж гаргах дээр бас хуулийн хэрэгжилт хугацаатай. Тэгэхээр энэ 12 сарын 30-аас өмнө бас энэ тал дээр банкнууд маань арга хэмжээ авч ажиллаж байгаа байх. Тэгээд энэ тал дээр бас бид нар багаараа ажиллах бүрэн боломжтой гэж үзэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Данзанбалжирын Энхжаргал.

Д.Энхжаргал: Ганхуяг гишүүний санаачилсан 2021 оны банкны хуулийн реформ бол үнэхээр бол банкны системийг олон нийтэд нээлттэй, хяналттай, хариуцлагатай болгоход маш чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж байгаа. Учир нь ганц Монголбанк хяналт тавихгүй. Одоо ХК нөлөө бүхий энэ банкнуудад СЗХ бас давхар хяналт тавих ийм боломж бүрдсэн. Мэдээж жижиг хувьцаа эзэмшигч нар орж ирсэн учраас хувьцаа эзэмшигчдийн хяналт сайжирч, үйл ажиллагаа нь ил тод болсон ийм давуу, сайн талтай байгаа. Тэгээд Ганхуяг гишүүн бас хэлж байгаа шүүмжлэлтэй байдал дээр хандаж байна. Энэ банкны үйл ажиллагаанаас өөр бусад харилцагчийнхаа бизнесийг хулгайлдаг, хэрэгжүүлдэг ийм ёс бус, ёс зүйгүй, хариуцлагагүй байдал байгаад байдаг гэж ярьж байна. Хэрвээ ийм байдаг бол банкны хариуцлагатай, ёс зүйтэй банкируудыг бүрдүүлэх тал дээр бол Монголбанк анхаарах ёстой. Монголбанкны Төв банкны тухай хууль дээр Хяналт шалгалтын хороо гэж байдаг. Энэ хороо эдгээр үйл ажиллагаа дээр илүү анхаарах ёстой. Хяналтын зөвлөлийн гишүүдийн хувьд энэ хяналтын хороо чиг үүргийнхээ дагуу зөв зохистой, авлигагүй, хэт банкнуудын нөгөө карманд ордог гэж яриад байсан. Ингэхгүйгээр ажиллаж байгаа эсэх дээр бид нар бол хяналт тавих бололцоотой гэж үзэж байгаа.

Ерөнхийдөө бол хувьцааны хувьд 5 том банк маань нэг зэрэг хувьцаагаа гаргаснаас болж Краудин Аутс гэдэг монголоор бол шахагдсан ийм байдал нөхцөл бүрдсэн. Яагаад гэвэл манай тогоо санхүүгийн энэ хуримтлалын чөлөөт эх үүсвэрийн хэмжээ бол хязгаартай байсан. Ийм учраас тэр ликүэтити буюу

хувьцаануудыг худалдан авах, зарах энэ байдал ганц банкны хувьцааны асуудал дээр биш, бусад хувьцааны, үнэт цаасны зах зээл дээр харагдаж байгаа. Энэ тал дээр бол СЗХ илүү анхаарч ажиллах ёстой байх. Энэ тохиолдолд институционал инвестор буюу мэргэшсэн хөрөнгө оруулагч нарыг бий болгох ёстой. Хувийн тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сангуудыг дэмжсэн үйл ажиллагаа явуулах ёстой. Эдгээр бүх асуултад хариулахдаа өөрийнхөө мэдлэг, банк санхүүгийн мэргэжил, мэдлэг өөрийнхөө туршлага дээр үндэслэж хариуллаа.

Гэхдээ зарим хариулж байгаа асуултууд маань бол Хяналт шалгалтын хорооны хяналтын ажлын чиг үүрэгтэй бол холбоогүй, зүгээр мэргэжлийнхээ хувьд хариулж байгаа гэдгийг онцолж хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гомбын Эрдэнэбаяр.

Г.Эрдэнэбаяр: Ганхуяг гишүүний 1 дүгээр асуултад бол яах вэ банкнуудын хувьд бол хуулиар тогтоосноор бол 12 үйл ажиллагаа явуулах ёстой. Тэрнээс илүү бусад үйл ажиллагааг хориглодог учраас энэ дээр Монголбанк хяналт тавьж ажиллаж байгаа гэсэн утгаар энд бол нэмэх юм алга. Зүгээр хувьцаа эзэмшигчдийн хувьд банкнуудыг нээлттэй хувьцаат компани болгосон давуу тал бол олон бий л дээ. Мэдээж энэ урьд ярьсан нэр дэвшигч нар дээр давхцуулахгүйгээр хэлэхэд ер нь засаглалын хувьд олон давуу талыг бий болгосон давуу тал олон. Хяналт шалгалтын явцад хэрвээ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хохирч байгаа бус хууль бус үйл ажиллагааг бол Монголбанк өөрийн хяналтын явцдаа шалгаад, хянаад, илрүүлээд засаад явчих бүрэн боломжтой гэж үзэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Очирбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгээд Төв банкны бас хяналтын зөвлөлийн гишүүнээр орж ирж байгаа бас нэр дэвшигч нартаа амжилт хүсьеб. Бүгдээрээ бас мэргэжлийн боловсон хүчин байна. Олон жилийн туршлагатай, гадаад, дотоодод мэргэжил, боловсрол эзэмшээд, салбартаа бас олон жил ажиллачихсан ийм хүмүүс байна. Тэгээд би бас энэ Эдийн засгийн байнгын хорооноос оруулж ирж байгаа, мэргэжлийн Байнгын хорооноос оруулж ирж байгаа саналыг дэмжиж ажилладаг хүн. Хувь гишүүнийхээ хувьд. Дээрээс нь Ёс зүй, дэгийн байнгын хороонд бас ажиллаж байгаа. Тэгээд яг энэ нэр дэвшиж байгаа дэвшигч нараас манай зөвлөлийн даргад нэр дэвшиж байгаа манай Ууганбаатар гээд нэр дэвшигч маань та Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр 2024 онд сонгогдоод ингээд ажиллаж байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэдэг бол Улсын Их Хурлын гишүүдийн нүд чих болж байдаг байгууллага. Ялангуяа 2025 оны төсвийг түрүүн батлахад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмжийг бол Их Хурлын гишүүд их эш татаж, ярьж, энийг ажил болгохын төлөө явсан. Мөн дээрээс нь Үндэсний аудитын газрын дүгнэлт, тайланг бас жишиг болгож явах ийм зорилт тавиад, 2025 оны төсөв бол ямар ч байсан алдагдалгүй батлагдаад, манай Тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмж хэрэгжээд явж байгаа гэж харж байгаа. Тэгээд өнөөдөр та өөрөө Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн мөртөө дахиад Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргаар нэр дэвшүүлээд өөрийгөө ингээд ороод ирж байна. Энд ямар амбиц, ямар эрх ашиг байна вэ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэдэг бол өөрөө Монгол Улсын хэмжээнд хамгийн бас өндөр нэр хүндтэй ийм газрын гишүүн хүн. Ингээд тэр асуултад хариулчхаарай.

2-т гэх юм бол хэрвээ та сонгогдох юм бол ажлаа өгөх үү. Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийхээ ажлыг. Яагаад гэхээр энэ чинь бас дараа дараагийн олон залуучууд байна. Энэ чиглэлээр олон жил явчихсан хүмүүс байгаа. Эд нарт бас боломжуудыг гаргаж өгөх ёстой юм гэсэн байр сууринаас асууж байгаа шүү.

Нийт гишүүдээсээ бас асууя. Монголбанкны Хяналтын зөвлөлийн чиг үүрэг байгаа. Түрүүн бас Тэлмэн нэр дэвшигч чиг үүргээ тодорхой хэлчихлээ. Яг энэ чиг үүргийнхээ хүрээнд Монголбанкны дотоод үйл ажиллагааг хянах ёстой. Ялангуяа энэ санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг компани, аж ахуйн нэгжүүд ярьдаг. Монголбанканд танил талтай, тэнд байгаа мэдээлэлд ойрхон байгаа хүмүүс бол валют дутагдсан байх үед мэдээлэлд ойрхон байж асар их хэмжээний мөнгө хүүлдэг гэдэг ийм юм ярьдаг. Тэгэхээр энэ дээр ямар байдлаар та хэд маань ажиллах вэ гэдэг асуултыг бүгдээс нь асуух гэсэн юм. Яагаад гэхээр энэ бол нээлттэй, ил тод байх ёстой. Бүгд харддаг сэрддэг. Тэгэхээр та хэд маань шинээр сонгогдох гэж байгаа зөвлөлийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн үг хэллээ. Асуулт уу. Нинжбатын Ууганбаатар нэр дэвшигч хариулъя.

Н.Ууганбаатар: Очирбат гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилогдоод бид нар 1 жилийн нүүр үзэж байгаа. Бидний өмнө байсан орон тооны бус төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга маань өнөөдөр одоо хүчинтэй байгаа Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын ажлыг давхар хашиж байсан ийм түүхтэй. Бас манай Тогтвортой байдлын зөвлөлийн 1 гишүүн маань өнөөдөр түрүүн тогтоолоор чөлөөлөгдсөн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргын албыг давхар хашиж байсан. Тэгэхээр Хяналтын зөвлөлийн ажил, Хяналтын зөвлөлийн дарга, энэ орон тооны бус ажлуудыг бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд давхар хашиж байсан ийм туршлагууд байгаад байгаа. Нөгөө талаас 2 хуультай хоёулантай нь харшлах ийм зүйл бол байхгүй. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маш чухал институц гэдэг үнэн. Монголбанк ч мөн ялгаагүй маш чухал институц. Тэгээд энэ 2 чухал Монгол Улсын банк санхүүгийн салбарын 2 ч төрийн оролцоотой байдаг хэсэг дээр нь байгаа энэ 2 чухал салбарт хоёуланд нь оролцож байгаа хүний хувьд хариуцлага маань 2 дахин нэмэгдэж байна гэж ингэж ойлгож байна. Сонгогдсон тохиолдолд ажлаа өгөх бодолгүй байгаа.

Дотоод хяналтын тухай болон мэдээлэлд ойр байгаад давуу талтай болох спекулятив маягаар валютын зах зээлд ялангуяа оролцох энэ асуудлыг бид нар зайлшгүй анхаарч үзэх шаардлагатай. Зүгээр надад байгаа урьдчилсан мэдээллээр манай валютын зах зээл бол харьцангуй идэвх муутай ийм зах зээл байдаг. Хэдийгээр бид байнга мэдээгээр валютын ханш гэж хардаг, магадгүй 8 шарга ч юм уу ингээд явахаар валютын арилжаа хийгдэж байгаа юм шиг харагддаг боловч валютын зах зээл маань харьцангуй хөшүүн ийм зах зээл байдаг. Тэгээд Монголбанк бол валютын зах зээл дээр оролцохдоо голцуу зах зээлийг хөдөлгөгч болох ийм байдлаар бол оролцдог. Яах вэ сүүлийн жилүүдэд манай нөгөө валютын бол нөөц маань нэлээн сайн өсөж байгаа. Энэ бас спекулятив хандлагын эсрэг хангалттай сайн хамгаалалт болох ийм зүйл байгаад байдаг. Яагаад гэхээр ямар нэгэн байдлаар ашиг хайж тэн дээр хөдөлгөөн орсон тохиолдолд энэ дээр Монголбанк зарчмын хувьд интервенц хийх бүрэн хүчин чадалтай байна гэдэг энэ дохиогоо бол зах зээл болон тэр спекулятын хандлагатай хүмүүст өгч явж байх нь зөв зүйтэй гэж ингэж бодож байгаа.

Мэдээлэлд ойр байгаа хүмүүс хэрэв давуу талтайгаар энэ мэдээллээ ашиглах ийм боломж бололцоо 1 дүгээрт байгаа эсэхийг хараад, ийм байгаа бол энийг зохицуулах хэрэгтэй. Эсвэл бүгдэд нь нээлттэй болгох хэрэгтэй. Одоогийн байдлаар бид нөөцийнхөө давуу талаар үндсэндээ спекулятын дайралтыг бол харьцангуй хааж ингэж ирсэн ийм түүхтэй байгаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гэрэлтийн Тэлмэн.

Г.Тэлмэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. Яг дотоод мэдээлэл ашиглаад ийм зүйл хийгээд байна уу гэдэг талаар бол яг мэдээлэл бол алга байна. Яагаад гэхээр олон нийтэд нээлттэй байгаа мэдээллүүд дээр л ерөнхийдөө үндэслэж явж байгаа учраас. Гэхдээ хуулиар заасан 4 бүрэн эрх байгаа. Монголбанкны зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих, дотоод аудитын газар хөндлөнгийн байгууллагын аудитын гаргасан дүгнэлт аудиторруудтай харилцах шууд ийм бүрэн эрхтэй байж байгаа. 3 дахь нь болохоор менежментийн багийн үйл ажиллагаа, дээрээс нь шаардлагатай гэж үзвэл тодорхой гүйлгээнүүд дээр шалгалт оруулах санал гаргах, 4 дэх нь болохлоор Улсын Их Хуралд мэдээлэх өөрсдийнхөө бүрэн эрхийн хамаарах асуудлаараа мэдээлэх ийм үүрэгтэй байгаа. Тэгэхээр энэ хуулиар олгогдсон ажлуудаа тултал нь максимум ингэж ашиглаж ажиллая гэж зорьж байна.

Цаашдаа нөгөө түрүүн хэлж байсан нөгөө үйл ажиллагааны бүрэн эрхэд орчихсон байж байгаа энэ дотоод хяналт болон санхүүгийн тайлагналтай холбоотой эрх зүйн орчныг сайжруулах талаар санаачилга хэрвээ томилогдвол баг хамт олныхоо хооронд бол гаргана. Манай Энхжаргал нэр дэвшигчийн хэлж байгаа шиг Говернэн борден байг гэхэд ядаж хяналтын зөвлөл энэ дотоод аудитын газрынхаа даргыг томилж, энэ дотоод хяналтаа хэрэгжүүлдэг энэ тогтолцоог бэхжүүлэхийн төлөө цаашдаа бас явна гэж хэлэхээр байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Тунсагийн Тэлмэн.

Т.Тэлмэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. Аливаа санхүүгийн байгууллагын ажиллагсад мэргэжилтнүүд өөрийн үйл ажиллагаа ажил мэргэжлээрээ олж авсан мэдээллээ ашиглан өөрт давуу байдал үүсгэх нь бол Монгол Улс болон олон улсад бол хуулиар болон ёс зүйн дүрмээр бол хориглодог. Монголбанкны хувьд бол дотоод аудитын тогтолцоо болон дүрэм журам нь эдгээр зүйлүүдийг илрүүлэх, илрүүлж хариуцлага тооцох ч юм уу тэр зүйлүүд байх ёстой болов уу. Тэгэхээр энэ зүйл байна уу гэдэг дээр одоогоор бол мэдээлэл алга. Тэгэхээр хэрвээ хяналтын зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллах юм бол дотоод аудитын дүрэм журамд эдгээр зүйлүүд тусаж уу, ийм зүйлийн хариуцлагын тогтолцоо нь байна уу гэдэг дээр бол түлхүү анхаарч ажиллах болно.

Д.Амарбаясгалан: Ундраагийн Хосжаргал нэр дэвшигч хариулт өгье.

У.Хосжаргал: Очирбат гишүүний асуултад хариулъя. Ер нь бол яг манай Хяналтын зөвлөлийн гишүүд яг базаад бүгдийг нь ер нь хэлчихсэн учраас нэмээд яг энэ хууль хэрэгжилт дээр Монголбанк бол өөрөө тусгай зохицуулалттай байгууллага гэж явдаг. Тэгэхээр тэнд ажиллаж байгаа хүмүүс бол ямарваа нэгэн эрх ашиг, мөн индипендент буюу тусдаа байдлыг бас их чухалчилж ажилладаг ийм байгууллага байгаа. Тэгэхээр яг энэ чиглэл рүү бол бид нар бас багаараа анхаарч ажиллана гэдгээ бас танд энэ ташрамд хэлье.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Данзанбалжирын Энхжаргал.

Д.Энхжаргал: Дотоод мэдээллийг ашиглаж хувьдаа ажилласан байх тухай яригдлаа. Хэрвээ Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилогдвол хамгийн түрүүнд хийх ажил бол энэ юм байна гэж ойлголоо. Дотоод хяналтын, дотоод аудитын газар маань энэ чиглэлээр ямар ажил хийсэн юм, ямар арга хэмжээнүүдийг авсан юм. Энэ нь үр дүнтэй байсан юм уу. Яагаад ийм үйл ажиллагаа гардаг юм. Энийг зогсох талаар ямар ажиллагаа явуулсан гэдэг дээр хамгийн эхний ээлжид дүгнэлт хийж, шалгах ёстой юм байна гэдгийг өнөөдрийн энэ мэдээллээс ойлгож авлаа.

Ер нь өчигдөр бас Эдийн засгийн байнгын хороонд орохоос өмнө Монголбанкны дэд ерөнхийлөгч Тайвантай бас бид тааралдаж асууж байсан. Ойрын хугацаанд хийсэн гол ажлуудаас юу байна гэхэд Ёс зүйн дүрмээ баталсан гэж байсан. Тэгэхээр энэ бүхэн цаашдаа гарахгүй байх гэж найдаж байна. Гаргахгүй байлгахын төлөө бол бид ажиллана. Ер нь мэдээллийн аюулгүй байдал талаас санаатай буюу санаагүйгээр алдагдсан бас байхыг үгүйсгэхгүй. Тэгэхээр ийм цоорхой байна уу гэдэг дээр, ийм эрсдэлүүд байна уу гэдэг дээр үнэлгээ дүгнэлт хийж, тэр нүх гарцыг хаахын төлөө бол зүтгэнэ.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гомбын Эрдэнэбаяр.

Г.Эрдэнэбаяр: Очирбат гишүүний асуултад хариулъя. Урьд нэр дэвшигчдийн юун дээр нэмж нэг санал хэлэхэд хуулийн хүрээнд хэрвээ шаардлагатай бол Монголбанкны Хяналтын зөвлөлийн журамд зааснаар хуульд зааснаар бол Монголбанкны дотоод менежментэд аливаа асуудалд тодорхой гүйлгээнд шалгалт хийх, аудит хийх санал гаргах гэсэн юуныхаа хүрээнд хэрвээ Монголбанкны ажилтны зүгээс хууль бус үйл ажиллагаа бол энэ ханштай холбоотой шударга бус үйлдэл гаргасан бол юуныхаа хүрээнд Монголбанктэй үйл ажиллагаанд нь хяналт тавих гэсэн утгаараа бол энд хамтран ажиллаж болох юм.

Ер нь бол Монголбанкны дотоод журмын тухай ярьж байна. Дотоод ёс зүйн журам энэ тэр гээд бас нэлээн тогтчихсон газар учраас энэ асуудал төдийлөн байдаггүй болов уу гэж би бодож байна. Сүүлийн жилүүдэд ер нь нэлээн хууль журамд нэлээд өөрчлөлт орчихсон учраас одоо бөс энэ асуудал дээр бол бас Монголбанкны дотоод боловсон хүчин, хүний нөөцийн ур чадварт би бол найдаж байна гэж хэлье дээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нэр дэвшигч нарыг ер нь дэмжиж байгаа. Тэгээд сая асуулт, хариултын үед бас нэг сонсогдож байгаа зүйл нь болохоор энэ хязгаарлагдмал дүрэм журмын хүрээнд ажиллана гэсэн үгнүүд бас сонсогдоод байна. Нэг тийм үүрэгтэй, тийм чигтэй гээд. Улсын Их Хурлаас томилоод байгаа шалтгаан чинь энийг ингээд та нар очоод сайжруулаад, өөрчлөөд, нэмэлт оруулаад, цэгцлээд өгөөч ээ л гэж та бүгдийг энэ Улсын Их Хурлаас нэр дэвшүүлж, томилоод байгаа гэдгийг бас нэг нэр дэвшигчид бүгдээрээ бас нэг ойлгож аваасай гэж бодож байгаа юм.

Тэгээд энэ Лхагвадорж байна. Хосжаргал байна. Бид нар бас нэг зорилгын төлөө сайндаж, муудаад хамтарч ажиллаад явж байсан. Өөрсдөө ч сайхан зорилготой залуучууд. Тэгээд бүгдийг нь бол ер нь дэмжиж байна.

Тэгэхдээ нийт нэр дэвшигчид бас Хяналтын зөвлөл гэж очих юм бол нийтдээ нэг Монгол төгрөгийн үнэ цэнийг бас нэг өсгөх чиглэлд анхаарч, бас нэг зорилгоо болгож ажиллаарай гэж.

Дээрээс нь арилжааны 5 банк IPO хийснээс хамгийн муу үзүүлэлттэй явж байгаа нь Төрийн банк. Үнэлгээ нь хамгийн муу байгаа. Удирдлага зохион байгуулалт нь хамгийн муу байгаа. Тэгээд ажиллах хүчин гэдэг юм уу, хүний нөөцийнх нь бодлого нь бас хаалттай. Тэгээд улс төрийн шалтгаанаар баахан хүн томилогддог. Үр дүн маш муу байдаг гэдэг энэ банкийг бас нэг анхааралдаа аваад цэгцлэх талаас нь ажиллах ёстой шүү гэж бас нэг санал хэлж байгаа.

Тэгээд араас нь бас нэг үйл ажиллагаа доголдоод байгаа 2 ч банкны асуудал бас яригдаж байгаа. Энэ дээр бас нэг тодорхой хэмжээнд анхаарлаа хандуулж Монголд үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны бүх банкнууд Монголбанкнаас тавигдаж байгаа зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдээ хангаад, яг хуулийн дагуу үйл ажиллагаа хэн нэгний нөлөөгүйгээр явдаг байхад бас анхаарч ажиллах, тэгээд энэ банкнуудын AQR-ын үнэлгээг тогтмолжуулах гэх мэт ийм мэргэжлийн ажлуудаа бас нэг сайн хийгээрэй гэж хэдэн санал хэлэх гэсэн юм.

Тэгээд Энхжаргал, Эрдэнэбаяр гээд 2 нэр дэвшигчээс асуух асуулт байгаа юм. Өнгөрсөн хугацаанд Монголбанканд ажиллаж байсан, туршлагатай хүмүүс байна аа. Дэд ерөнхийлөгч байсан байна. Лондонд дахь төлөөлөгч байсан байна. Монголбанкны Хуулийн газрын захирал байсан байна. Хэлтсийн захирал байсан байна. Ахлах мэргэжилтэн байсан байна. Тэгээд энэ хугацаандаа та хэд өөрсдийгөө ер нь хэр ажилласан гэж үнэлж байгаа вэ. Яг өнөөдрийн байдлаар харах юм бол дэлхийд хамгийн тааруу үнэтэй мөнгөн тэмдэгттэй улс нь бас яс юман дээр Монгол гэж орж ирэх гээд байна шүү дээ. Тэгээд яг энэ үеүдэд нь та 2 бас нэг Монголбанкийг удирдалцаад явж байсан хүмүүс байна. Өнөөдрийн төгрөгийн энэ үнэ цэний муу байгаа шалтгаан нь та хэдтэй холбоотой гэж үзэх үү. Эсвэл энэ сайн ажилласан учраас ийм байна гэж бодож байна уу гэж. Энэ дээр та 2 хариулт өгөөч.

Тэгээд ер нь томилогдоод сонгогдоод очиход бүгдэд нь ажлын .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Данзанбалжирын Энхжаргал хариулт өгье.

Д.Энхжаргал: Би Монголбанканд бол анх Эрхүүгийн Улс ардын аж ахуйн дээдийн Их сургуулийг банк санхүүгийн мэргэжлээр Монголбанкны нэр дээр төгсөж, нягтлан бодогчоор хоорондын тооцооны хяналт шалгалтыг хийх ажлыг гүйцэтгэж байсан. Тухайн үед тооцооны 1 дүгээр кассаас ихээхэн хэмжээний мөнгө алдагдаж, хоорондын тооцоогоор мөнгө иддэг ийм асуудал байсныг зогсох үүрэг даалгавартай ажилласан. Үүнээс хойш бол тооцооны кассууд хоорондоо мөнгө зувчуулдаг байдал бол зогссон. Энэ хяналтын шинэ тогтолцоог бол бүрдүүлсэн. Энэ ч чиглэлээрээ намайг бол Улсын Банкны Ерөнхий Хороонд нэр дэвшүүлж, би эдийн засагч болсон. Эдийн засагчаар ажиллаж байгаад Монгол Улсад 2 шаттай банкны тогтолцоо үүссэн учраас өнөөдрийн бид нарын яриад байгаа заавал байх нөөц, Төв банкны үнэт цаас, ингээд мөнгөний бодлогын статистик үзүүлэлтүүд болох суурь мөнгө, их мөнгө, бараг мөнгө гэсэн энэ статистик үзүүлэлтүүдийг бий болгох мөнгөний бодлогын суурь механизмуудыг нэвтрүүлэх ажлыг гардан хариуцаж, манлайлж хийж байсан.

Ийм ч учраас Мөнгөний бодлогын газрын захирлаар томилогдоод, удаагүйгээр Хяналт шалгалтын газрын захирлаар томилогдсон. Тухайн үед нэлээд олон банкнууд бол санхүүгийн маш их хүндрэлд орчихсон, татан буугдчихсан, заримд нь эрх хүлээн авагч томилогдчихсон байсан. Энэ үед банкны шинэчлэлт өөрчлөлтийг хийх ийм ажлыг хариуцсан. Маш хүнд ажил байсан. Эмэгтэй залуу, одоогийнхоор нөгөө Z gen гэдэг нь байсан л даа. Тэгээд англи хэлтэй боловсон хүчин Монголбанканд тэр бүр бол байгаагүй. Энэ үед АХБ, Дэлхийн банкттай бас хамтын ажиллагааг хөгжүүлж, 50 сая долларын зээлийг 1996 онд банкны салбарыг эрүүлжүүлэх гэсэн ийм томоохон хөтөлбөрийг Засгийн газартай хамтарч бол хэрэгжүүлэх ажлыг хийсэн. Ингээд 1996 оны 9 сарын 23-нд тухайн үеийн АН засаглаж байсан үед Банкны хууль, Төв банкны хуулийг зарчмын хувьд орчин үеийн тухайн үеийнхээ нөхцөл байдалд нийцүүлж, сайжруулж хяналт шалгалтын эрх мэдлийг бол Монголбанканд нэмэгдүүлсэн ийм бол шинэчлэлийг хийсэн.

Дараа нь би Дэлхийн банканд Банк санхүүгийн салбар хариуцсан салбарын ажилтнаар ажилласан. Ингээд 1999 онд аавын минь бие муудсан учраас Монгол Улсад буцаж ирээд, тухайн үед бол Үнэнбат Ерөнхийлөгч Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирлаар дахин томилох ийм санал тавьсныг бол хүлээн зөвшөөрч ажилласан. Тэр үед ХААН буюу одоогийн Хаан банк тэр үед бол бараг дампуурчихсан. Эрх хүлээн авагч нар томилогдчихсон, ХХБ дээрээ асар их хэмжээний өр зээл хуримтлагдсан, засаглалын хувьд хүндрэлтэй болчихсон ийм нөхцөлүүд бол үүссэн байсан. Энэ үед бол АНУ-ын ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гомбын Эрдэнэбаяр.

Г.Эрдэнэбаяр: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Миний хувьд 1991 онд Монгол Улсад банкны тогтолцоог 2 болгосон тогтолцооны үеэс эхэлж ажилласан. Анхны хууль дээр ажиллаж байсан юм. Тэрнээс хойш 1996 оны хууль дээр ажиллаж байсан. 2010 онд ажиллаж байсан. Ер нь 2016 он хүртэл бол Монголын банкны систем, Төв банкттай холбоотой хууль тогтоомжийн асуудалд ямар нэгэн хэмжээгээр оролцсон. Би өөрийгөө дүгнээд зохистой ажилласан. Тийм сайн ажилласан, муу ажилласан гэж дүгнэх нь зохисгүй байх. Зүгээр ер нь миний оролцоо бол яах вэ Монголд банкны хууль тогтоомжийг бий болгох гэдэг чиглэлийг л би төрд алба хаахдаа гол чиглэн ажилласан. Энэ чиглэлээр ч дагнаж тасралтгүй ажилласан. Энэ энэ хугацаанд зөвхөн Төв банкттай холбоотой хууль тогтоомжоос гадна банкны хууль тогтоомж, банкттай холбоотой хууль тогтоомжууд, мөнгөн хадгаламж, хадгаламжийн даатгалтай холбоотой асуудал, Монголын мөнгө угаах тогтолцооны асуудал гэсэн энэ хуулиудад бас голчлон ажиллаж өөрийн хувь нэмрээ бага хэмжээгээр ч болов оруулсан болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ч.Анар: Сайн байцгаана уу. Нийт нэр дэвшигчдэдээ амжилт хүсье. 1 юмыг ойлгохгүй юм. Гишүүд нь асуулт асуухдаа Монголбанкны удирдлага, Мөнгөний бодлогын хорооноос асууж байгаа юм шиг асуугаад, хариулж байгаа хүмүүс маань Монголбанкны бодлого яриад байх юм. Тэгээд нөгөө Мөнгөний бодлогын хороодын гишүүдээсээ мундаг мундаг юм яриад байх юм. Тэгээд нөгөө ханш, төгрөгийн бодлогын талаар Сугарын Лхагвадорж нэр дэвшигч ярьж байна. Тэгээд та бүхэн чинь Монголбанкны Хяналт шалгалтын хороонд нэр дэвшиж байгаа хүмүүс биз дээ. Тэгэхээр энэ бодлогын талаар мундаг юм ярьж байгаа болохоор танд энэ

ам.долларын эсрэг төгрөгийн ханш унаад байгаа. Тэр талаар та ямар бодлоготой байгаа вэ. Энэ талаар хяналт тавих юм уу. Эсвэл та хэд маань бараг бодлого гаргачих юм байна. Тэгэхээр тэр талаар хариулт авъя.

2 дугаарт Гэрэлтийн Тэлмэн технологийн чиглэлээр ажиллаж байсан. Өөрийнх нь хувьд мэдэхийн хувьд 1 асуулт асууя. Монгол Улс өнөөдөр эрчим хүч нефтийнхээ төлбөрийг хийж чадахгүй, хүндрэлтэй нөхцөл байдалд орсон байгаа улс. Олон улсууд үндэстний мөнгөн тэмдэгтэй крипто валют руу шилжээд туршилт нь эхэлчихсэн явж байгаа. 2 хөрш хоорондоо туршилтын гүйлгээнүүд хийгээд эхэлчихсэн. Монголбанк энд бэлэн эсэх. Энэ дээр ямар үзэл бодолтой байна. Нэг өдөр нефтээ та нар зөвхөн крипто рублиер төл, крипто юаниар төл гэхэд бид яах вэ. Та энэ дээр ямар үзэл бодолтой вэ. Энэ 2 асуултыг асуугаад, нийт нэр дэвшигчдэдээ амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гэрэлтийн Тэлмүүн хариулт өгье.

Г.Тэлмэн: Анар гишүүний асуултад хариулъя. Яах вэ, миний өнгөрсөн хугацаанд ажилласан чиглэл яг энэ крипто валют чиглэл бол биш. Ерөнхийдөө уламжлалт бас банкнаас бусад санхүүгийн байгууллагын чиглэлээр. Гэхдээ яах вэ дэлхийн улс орнууд дээр 70-аад улс орон энэ үндэстний мөнгөн тэмдэгтэй, цахим болгох Тэ Си Би Ди Си-ийн сонирхоод, 30-аад улс орон нь ингээд төсөл хэрэгжүүлээд явж байгаа юм байна лээ. Тэгэхээр Монголбанкны хуучин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд дээрээс нь Монголбанкнаас тусгай зөвшөөрөлтэй Финтек байгууллагын хувьд бас тодорхой санал солилцож байсан. Монголбанк 1 хэсэг энэ асуудлыг сонирхож байгаа. Төдийлөн одоогоор хойш нь тавьчихсан байгаа гэсэн. Тийм байр суурьтай байгаа юм байна лээ. Тэр асуудал нь яг өнөөдөртөө банкны салбар маань энэ төлбөр тооцоо, үйлчилгээний асуудал маань бол нэлээдгүй сайн байгаад байгаа ижил төрлийн орнуудаас нэлээд урд явж байгаа гэж ойлгож байгаа. Түрүүн бас манай нэр дэвшиж байгаа гишүүд хэлсэн төлбөр тооцооны нийт 96-аас дээш хувь нь бэлэн бусаар хийгдэж байна. Дөнгөж саяхан бас apple pay ингээд ороод ирчихсэн ийм явж байгаа. Зүгээр цаашдаа миний зүгээр байр суурь энэ Си Би Ди Си-ээ яаралтай бас сонирхоод хөгжүүлэх ёстой л гэсэн байр суурьтай бол байгаа. Нарийн юмыг нь би худлаа яриад яах вэ сайн мэдэхгүй байгаа шүү Анар гишүүн ээ.

Д.Амарбаясгалан: Анар гишүүний эхний асуултад нэр дэвшигч Сугарын Лхагвадорж хариулт өгье.

С.Лхагвадорж: Анар гишүүний асуултад хариулъя. Анар гишүүний асуулт бол зөв. Монголбанкны Хяналтын зөвлөлд нэр дэвшиж байгаа, Хяналтын зөвлөлийн ажиллах журам, ажиллах хүрээ бол уг нь бол 2003 оны энэ журмаар бол нэлээн хязгаарлагдмал байгаа. Өөрөөр хэлбэл Монголбанкны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит сонгох процессыг хяналт тавих, дотоод үйл ажиллагаанд хяналт тавихаас биш мөнгөний бодлогын аливаа шийдвэрт оролцохгүй. Гэхдээ өнөөдөр Улсын Их Хурлын чуулганд Их Хурлын эрхэм гишүүд өөрийн бүрэн эрхийнхээ хэмжээнд Хяналтын зөвлөлд нэр дэвшиж байгаа гишүүдээс асуулт асууж байгаа учраас бас эдийн засагч хүний хувьд бас хариулж байгаа.

Тэгээд таны асуултад бол хариулъя. Төгрөгийн ханшийг тогтвортой байх тал дээр ямар бодлого барих вэ гэж асуусан. Тэгээд ер нь төгрөгийн ханш бол төлбөрийн тэнцлийн тусгал байдаг. Тэгээд ер нь бол энэ төлбөрийн тэнцэл бол

ашигтай гарах үед бол энэ төгрөгийн ханш бол тогтвортой л байж байдаг. Алдагдалтай байх үед бол энэ зохих хэмжээнд бол жоохон суларч байдаг. Тэгэхгүй бол нөгөө нөөцөө алдаад, нөгөө ханш бүр огцом томоор сулрах эрсдэлтэй байж байдаг.

Тэгээд энэ ханшийг тогтвортой барихын тулд бол бид нар энэ худалдааны тэнцлийг бол сайжруулах шаардлагатай байдаг. 2024 оны балансаар бид нар 15 тэрбум долларын экспорт хийгээд, 11 тэрбум долларын импорт хийсэн байсан байсан. Тэгэхээр 4 тэрбум долларын худалдааны тэнцэл нэмэхтэй гарсан. Гадаад валютын албан нөөц нь 5,5 тэрбум долларын үлдэгдэлтэй байгаа. Тэгэхээр бид нар ер нь цаашид төгрөгийн ханшийг хүчтэй, ам.долларын эсрэг тогтвортой байлгахын тулд гадаад худалдааны бодлогыг бол тууштай дэмжих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл бид нар олон улс руу экспортолж байгаа бүтээгдэхүүнүүдийг гадаад худалдааг төрөөс олон чиглэлээр дэмжих хэрэгтэй. Нүүрснээс гадна бид нар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг, мөн гаднаас оруулж ирж байгаа аялал жуулчид болоод энэ бусад хөдөө аж ахуйн бизнесүүдийг тогтвортой дэмжих, мөн томоохон төслүүд сая бид нар ураны төслүүдээ хөдөлгөсөн шиг иймэрхүү гадаадын хөрөнгө оруулалтуудыг сайн явуулж чадах юм бол бид нар бол энэ төгрөгийн ханшуудыг бол тогтвортой барьж чадна.

Эсрэгээрээ бид нарын хийхгүй байх ёстой нэг зүйл нь бол энэ импортыг өгдөг байсан энэ бодлогуудыг хориглох ёстой гэж би боддог юм. Өөрөөр хэлбэл бид нар бас нөгөө өмнө нь саяхандаа нэг тогтворжуулах бодлого нэртэй ийм бодлогуудыг хийсэн. Өөрөөр хэлбэл энэ нөгөө зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлүүд гараад энэ импортыг дэгдээсэн, өдөөсөн ийм бодлогууд явуулснаараа эргээд ханшийг асар их хэмжээгээр сулруулдаг.

Энэ ипотекийн зээлийн хөтөлбөр чинь бас нэг талаараа ханшийг бас асар хэмжээгээр сулруулсан нэг томоохон бодлого болсон л доо. Яг уг нь бол нөгөө талдаа энэ орон сууцжуулах хэлбэрийг дэмжээд байгаа юм шиг хэр нь нөгөө талдаа бол зах зээлийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бусад нэр дэвшигчид шууд хариулах боломжгүй. Сая үндсэндээ Лхагвадорж нэр дэвшигч төлөөлөөд хэлчихлээ. Улсын Их Хурлын гишүүд асууж байгаа учраас мэргэжлийн эдийн засагчийн хувьд байр суурь бодлогоо бас илэрхийлэх байдлаар хариулж байна. Тэгэхээр Анар гишүүний хэлж байгаа зөв л дөө. Бас яг ямар чиг үүрэгтэй нэр дэвшигчээс яг юу асуух тал дээрээ бас бүх талдаа анхаарч байх ёстой гэсэн үг. Нэгэнт яах вэ эдийн засагчдын бас байр суурь Монголбанк дээр Хяналтын зөвлөлийн үүрэг гүйцэтгээд очих гэж байгаа учраас бас Улсын Их Хурлын гишүүд бас өргөн хүрээтэй асуулт асуусныг бас буруутгах зүйл бас байхгүй. Нөгөө талдаа. Тийм ээ. Энэ энэ асуудал дээр нэгэнт тэр гал тогоонд очиж ажиллаж хяналт тавьж ажиллах чиг үүрэг хүлээж байгаа учраас. Энхбаярын Батшугар гишүүн асуулт асууя.

Э.Батшугар: Баярлалаа. Нэр дэвшигчдээс бол мөнгөний бодлогын талаар хянан шалгалтын функцийн талаар асуухгүй. Харин яг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн болох гэж байгаа талаар асууя.

Монголбанк болон Төв банк 1 дүгээрт мэргэжлийн байх ёстой. 2-т нь хараат бус байх ёстой. 3 дугаарт ил тод байх ёстой. Тэгэхээр яг энэ тал дээр Хяналтын

зөвлөл гэсэн нэгж байдаг. Тэгээд өнөөдрийн хууль болон дүрэм журмын талаар яг энэ функцээ хийхэд бүрэн хангалттай байна уу, үгүй юү гэж асууя.

2-т нь зөвлөмжүүдийг нь хэрэгжүүлэх механизмыг хэр амжилттай ажиллаж байна. Илүү сайжруулах тийм санаа оноо байна уу гэж товчхон асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Нинжбатын Ууганбаатар.

Н.Ууганбаатар: Батшугар гишүүний асуултад товчхон хариулъя. Өнөөдрийн хууль бид нар өмнө зөндөө ярьсан. Энэ бол 2003 онд батлагдсан хууль байгаа. Энэнээс хойш нийгэм, эдийн засагт томоохон өөрчлөлтүүд гарсан. Төв банк өөрөө институцийнхээ хувьд бас нэлээн том өөрчлөлтүүд хийгдсэн. Төв банк бол магадгүй Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлаас болоод томоохон өөрчлөлтүүд хийж явдаг. 2008 оны хямрал, сая ковидын дараах нөхцөл байдал гээд гэх мэтчилэн Төв банкны тухай асуудал бол цаг үргэлж нэг бодлын хуучин, нэг бодлын шинэ ийм сэдэв болж ирсэн. Тэгээд энэнтэй холбоотойгоор тодорхой хэмжээний салбар нь институц нь нийгмийн шаардлага бүгд хөгжихсөн байгаа. Тэгээд энд эрх зүйн зохицуулалт дээр тодорхой хэмжээний өөрчлөлтүүд оруулах шаардлагатай гэж бол үзэж байгаа юм. Тэгэхээр хууль маань Төв банкны тухай хууль дээр, тэгээд Хяналтын зөвлөлийн ажиллах журам, Улсын Их Хурлын тогтоол дээр тодорхой өөрчлөлтүүд орох ийм цаг нь бол болчихож, нөхцөл нь бас бүрдчихжээ гэж ингэж харж байгаа.

Тэгэхдээ энэ дээр бид нар тодорхой нэлээн судалгаатай нарийн хандана. Олон удаа өөрчлөгдөхөөр ойр ойрхон өөрчлөгдөхөөр ийм зохистой ийм институц бас биш, сайн судалгаатайгаар, суурьтайгаар, тэгээд зохих ёсны реформыг нь хийх ёстой болов уу гэж бодож байна. Тэр суурьтайгаар зохих ёсны реформыг хийнэ гэдэг дээр таны өөрийн сая асуугаад байгаа тэр механизмуудыг нутагшуулах тухай ийм асуудал орж ирнэ. Түрүүн манай зарим нэр дэвшигч маань хэлсэн. Тухайлбал дотоод хяналтын газар одоогоор Монголбанкны Ерөнхийлөгчийн харьяалалд байгаа. Бүрэн эрхэд нь байгаа. Хяналтын зөвлөл үндсэндээ аудит хийсэн аудиторудтай аудитын дүгнэлтийг судалж үзэх, танилцах, тэгээд санал хүргүүлэх гэсэн иймэрхүү чиглэлттэй иймэрхүү эрх хүрээтэй байгаа. Тэгээд энэ бол бас хангалттай эрх хүрээ бас биш болов уу гэж бодож байна.

Нөгөө талаас төв банк маань хараат бус байх гэдэг зүйл бол хяналт сайтай байж байж л илүү сайн хараат бус болно. Тэгэхээр энэ 2 бол хоорондоо нэг зоосны 2 тал юм байна гэж ойлгосон. Тэгэхээр илүү сайн хяналттай, илүү нээлттэй болж чадах юм бол Төв банк маань бас тэр хэмжээндээ илүү хараат бус болох болов уу гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Сугарын Лхагвадорж.

С.Лхагвадорж: Батшугар гишүүний асуултад хариулъя. Монголбанкны Няналтын зөвлөлийн ажиллах журам 2003 оны Улсын Их Хурлын 39 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан юм байна лээ. Тэгээд энэ ажиллах хүрээ бол үнэхээрийн хумигдмал байсан. Тэгээд ОУВС-аас Монголбанканд ирүүлсэн зөвлөмжийг би бас харж байсан юм. Тэр артикл 4 гээд тэр дээр энэ хяналтын зөвлөлийнхөө эрх хүрээг нэмэгдүүлж, энэ хяналтын зөвлөлийнхөө хүчин чадлыг сайжруулаач ээ гэсэн тийм утга агуулгатай тийм зөвлөмжүүд байдаг юм байна лээ.

Өөрөөр бол энэ гадаадын олон улсын төв банкнууд чинь хяналтын зөвлөлөө яг энэ компанийн дэргэдэх ТУЗ-ийн аудиторуд шиг хараат бусаар шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл ийм маш өндөр хэмжээний говернс буюу энэ засаглалыг сайжруулах чиглэлээр ажилладаг байдлаар Хяналтын зөвлөлийг ажиллуулахыг шаарддаг юм байна лээ. Тэгээд манай энэ хяналтын зөвлөл болохоороо бас энэ хэмжээнд ерөөсөө огт ажиллаж чадахгүй байгаад байгаа учраас зөвхөн хөндлөнгийн аудитыг сонгох процессыг олгодог. Дотоод аудиторын тайлан мэдээллийг сонсдог. Түрүүн бас нэр дэвшигч маань хэлж байсан. Дотоод аудитын газрын даргаа хүртэл сонгох хэмжээний эрх мэдэлгүй ийм зөвлөл байж байсан.

Тэгэхээр бид нар хэрвээ энэ Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгогдож ажиллах юм энэ хяналтын зөвлөлийн ажиллах журмыг сайжруулна. Энэ Монголбанкны тухай хуулийн 27.1-д заасан энэ хяналтын зөвлөлийн ажиллах эрх, үүргийг нэмэгдүүлнэ. Ингэснээрээ Улсын Их Хурал болоод Эдийн засгийн байнгын хороо улмаар Төв банкныг олон нийтэд нээлттэй ил тод байлгах улмаар энэ Төв банкны өөрийн хөрөнгийн алдагдал гэхэд л 7,2 их наяд. Тэгээд баланс дээрх хуримтлагдсан алдагдал гэхэд бараг 1.7 их наядын алдагдал байгаа. Тэгэхээр энийг ингээд бууруулах чиглэл дээр бол хяналтын зөвлөл манлайлж, идэвхтэй ажиллана гэдгээ Улсын Их Хурлын танхимд бас илэрхийлж байна. Гишүүд дэмжиж ажиллана гэж найдаж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гэрэлтийн Тэлмэн.

Г.Тэлмэн: Батшугар гишүүний асуултад хариулъя. Тэрнээс өмнө бас Лхагвадорж нэр дэвшигчийн сая хариулт дээр бас арай өөр байр сууриар бас илэрхийлэхгүй бол яг эндээс ингээд хэлчихээр бас олон нийтэд бас төөрөгдөл үүсчхэж магадгүй. Тэр баланс дээр байж байгаа 7,4 их наядын алдагдал бас тийм айхтар санаа зовох зүйл бас биш байж магадгүй.

Яагаад вэ гэхээр Төв банкны үндсэн зорилт бол төгрөгийн тогтвортой байдлыг хангах, нөгөө талаараа санхүү банкны салбарын тогтвортой байдлыг хангаж, нийгэм, эдийн засгийн хөгжлийг тэнцвэртэй дэмжлэг үзүүлэх энэ зорилтоо хангах үүднээс мөнгөний бодлогын хэрэгслүүдийг ашиглаад, магадгүй тэр алдагдалтай байж ч магадгүй учраас тэрийг нь ч гэсэн хуулиараа хүлээн зөвшөөрөөд, хэрвээ алдагдалтай байх юм бол Засгийн газраас үнэт цаас гаргаж үүнийг нөхөж өгнө гээд хуулиараа хүлээн зөвшөөрчихсөн байдаг учраас энэ бол тийм айхтар санаа зовохгүй байж магадгүй.

Гэхдээ энийг нарийн мэдэхгүй учраас бас ингээд хэдүүлээ харах ёстой болов уу гэж бодож байна. Ийм ноцтой юм хэлчихвэл бас нөгөө нэг иргэдэд маш хэцүү оччих болов уу гэж бодоод, энэ дээр жоохон залруулга маягаар хэлчихье гэж бодлоо. Нөгөө талаас энэ зөвлөмжүүдийн хэрэгжилтийн хувь дээр яалт ч үгүй бид нарын хувьд олон нийтэд нээлттэй байгаа мэдээллүүдийг харахаас өөр аргагүй. Тэгэхээр өмнөх Хяналтын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлүүдийг бол харсан сүүлийн 2 жилийн. Улиралдаа 1 удаа хуралддаг байж байгаа. Тэр дээр зарим зөвлөмжүүдийн хэрэгжилт сайн байна гээд дараагийн хуралдаанаар дүгнэдэг. Заримдаа дараачийн хуралдааных нь тэмдэглэл дээр бол зөвлөмжийг биелүүлээгүй байна. Энэ дээр анхаарч ажиллана уу хэмээн зөвлөмж гаргав гээд л нэг ийм байдлаар яваад байгаа. Тэгэхээр энэ дээр түрүүнээс хойш тоть шиг бас бид хэд давтаад байгаа зүйл нь өөрөө эргүүлээд энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх тэр хяналтын мандатын бүтэц нь бол тодорхой хэмжээнд байхгүй байгаа юм байна гэж

ойлгож байгаа. Бид тэгэхдээ олгогдсон хуулийнхаа хэмжээнд Эдийн засгийн байнгын хороондоо мэдэгдэх, Улсын Их Хуралд хамаарах асуудлаараа мэдэгдэж, зарим асуудлуудыг шийдвэрлэх тал дээрээ явах болов уу л гэж хувьдаа бодож байна.

Төв банкны үйл ажиллагаа мэргэжлийн, хараат бус, ил тод гэдэг дээр бол би харьцангуй мэргэжлийн юм байгаа болов уу гэж зүгээр бодож байна. Өмнө бас тодорхой хэмжээгээр өөр талаас ажиллаж байсан учраас. Хараат бус тал дээр олон талын эргэлзээ таамгууд байдаг иргэдийн төдийгүй Их Хурлын гишүүд хүртэл хэлдэг зүйлүүд байгаад байгаа. Хуулиар бол хараат бус байх ёстой ийм байгаад байгаа. Тэгэхээр тодорхой мэдээллүүд байхгүй байгаад байгаа учраас сайн мэдэхгүй байна. Хэрвээ томилогдвол Улсын Их Хуралд мэдээлэх ёстой байгаа учраас энэ хараат бус байдалд халдсан зүйлүүд байх юм Их Хуралд бас мэдэгдэж явъя гэж хэлэхээр байна. Товчхон л ингээд хариулъя даа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Тунсагийн Тэлмэн.

Т.Тэлмэн: Монголбанкны Хяналтын зөвлөлийн бүтэц нь өөрөө хэр ойлгомжтой байна вэ гэсэн. Төв банкны тухай хуулийн 27¹ болон Их Хурлаас баталсан Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журмаар бол бүтэц болон чиг үүргийг бол маш тодорхой заагаад өгчихсөн. Төв банкны мөнгөний бодлогоос бусад үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн Улсын Их Хурлын чиг үүргийн байгууллага. Бүтэц болон эрхийг бол хэр нэмэх үү, хумих уу гэдэг асуудал бол би энэ дээр бол хэлж чадахгүй. Энэ бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн өөрсдийнх нь шийдэх асуудал. Бид нар бол хуулиар олгогдсон бүтэц, чиг үүргийн хүрээнд бол ажиллах ёстой. Одоо харж байгаа ажиллах журмаас бол маш ойлгомжтой байгаа.

Олон нийтэд нээлттэй байгаа. Өнгөрсөн хугацаанд Хяналтын зөвлөлийн гаргасан зөвлөмж болон зөвлөмжийн биелэлтүүдийг бол бид нар харсан. Хяналтын зөвлөлөөс гардаг зүйл бол зөвлөмж, санал гардаг. Зөвлөмжийн биелэлт бол тийм хангалттай бус харагдаж байна лээ. Тэгээд энэ дээр болохоор бас Байнгын хороо болон Монголбанкны удирдлага өөрөө бас анхаарч ажиллах ёстой болов уу.

Төв банк бол мэргэжлийн, хараат бус, ил тод байх ёстой. Энийг бол хуулиар Төв банкны тухай хуулиар бүр зааж өгсөн. Төв банк бол Монголбанк бол харьцангуй мэргэжлийн байгууллага гэж би хувьдаа үздэг. Би өөрөө тухайн байгууллагад 10 гаруй жил ажилласан. Тэгээд дотроосоо дэвшээд мэргэшээд явдаг төрийн байгууллага байгаа. Тэгэхээр харьцангуй мэргэжлийн байгаа болов уу, энэ байдлаа бол алдаагүй болов уу гэж би найдаж байгаа. Хараат бус байдал дээр бол уг нь хуулиар заасан байдаг. Тэгэхдээ энэ дээр үнэхээр яг тийм ажиллаж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр бол сайн мэдэхгүй байна.

Ил тод байдал дээр бол Хяналтын зөвлөлийн гол хийх ажил байгаа. Хуулиар Төв банк нь өөрөө санхүүгийн тайлан, мэдээллээ ил тод, олон нийтэд болон Их Хуралд тайлагнах ёстой. Тухайн тайлагнал нь хэр үнэн зөв, бодитой байгаа вэ гэдэг дээр бол хяналтын зөвлөл өөрөө зөвлөм, дүгнэлт гаргаж явна. Тэгэхлээр энэ бол яг Хяналтын зөвлөлийн гишүүн бид нарын ажил байгаа. Тэгэхээр үүн дээр бол түлхүү анхаарч ажиллана. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Ундраагийн Хосжаргал.

У.Хосжаргал: Батшугар гишүүний асуултад товчхон хариулъя. Яг нэр дэвшигч нартайгаа ижил саналтай байна. Түүрэн бас Цогтбаатар гишүүнээс бас үүрэг өгсөн байгаа. Ер нь бол их санаачилгатай ажиллахгүй бол их хязгаарлагдмал хүрээнд одоогийн дүрэм журам маань байж байгаа. Энийг бол илүү хяналтын тогтолцоог сайжруулах тал дээр анхаарах ёстой гэж бодож байна. Мөн бас гишүүдтэйгээ санал нэг байна. Монголбанк бол бас мэргэжлийн байж чаддаг гэж миний хувьд бол үздэг. Хараат бус, ил тод байдал дээр бол өшөө бас сайжруулах зүйлүүд байгаа гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Данзанбалжирын Энхжаргал.

Д.Энхжаргал: Батшугар гишүүн Хяналтын зөвлөл хэр зэрэг мэргэшсэн, хараат бус, ил тод ажиллах вэ, зөвлөмжүүдээ хэрэгжүүлж чаддаг болгохын тулд юу хийх вэ гэсэн асуулт асуулаа гэж ойлгосон. Миний хувьд бол банк санхүүгийн салбарт 38 жил, үүнээсээ 30 жилийг Монголбанканд нягтлан бодогчоос дэд ерөнхийлөгч хүртэл ажилласан энэ мэдлэг, мэргэжил, дадлага туршлага ОУБ-ын Хяналтын Удирдах зөвлөлд ажиллаж байсан. Энэ туршлагаа бүрэн дүүрэн дайчилж ажиллана гэж бодож байна. Хараат бус гишүүний хувьд бол бүрэн дүүрэн итгэж ажиллаж болно надад. Учир нь гэвэл миний ах, дүү, хамаатан саднаас Монголбанканд болон Монголбанкны салбар харьяа нэгжид бол 1 ч хүн ажилладаггүй ийм байгаа.

Ил тод байдлын хувьд бид нар хууль, зөвлөлийн журмын хүрээнд бол ажиллана. Ингэхдээ Монголбанкны маш нууцын зэрэглэлтэй ажлуудыг бол мэдээж ил тод, шууд нийтэд таниулах ийм боломжгүй байгаа. Ийм учраас энэ төрийн нууцтай холбогдолтой асуудалтай хэсэг дээр холбогдох журмын дагуу Улсын Их Хуралтайгаа зохих журмын хуульд нийцсэн хүрээнд бол ажиллана.

Зөвлөмжүүдийг бол хэрэгжүүлдэг болгохын тулд өнөөдрийн энэ дотоод аудитын хяналтын газрын чадамж, чадавх тэд нарын эрх зүйн орчинд бол тэргүүн ээлжид бол үнэлгээ, дүгнэлт өгнө. Тэгээд хэрвээ чадамжтай, чадавхтай хийж байгаа ажлын цар хүрээ шалгалтын үр дүн нь бүрэн дүүрэн хэрэгждэг байвал бас болж байна. Хэрвээ тийм биш бол зөвлөмжөөрөө дотоод аудитын хяналтын газарт л илүү их шаардлага тавина.

2 дахь хуулиар өгөгдсөн боломж нь бол Монголбанкны менежментийг шалгуулах, тодорхой асуудлаар хянуулах энэ саналыг Улсын Их Хурал, Эдийн засгийн байнгын хороонд гаргах эрхтэй учраас тэр чиглэлээр бол ажиллана гэж бодож байна. Цаашдаа хууль, эрх зүйн орчинд нэмэлт боломжууд гарвал тэр боломжуудыг бүрэн дүүрэн ашиглана.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Гомбын Эрдэнэбаяр.

Г.Эрдэнэбаяр: Батшугар гишүүний асуултад хариулъя. Өнөөгийн хууль тогтоомжийн хүрээнд бол бид ажиллах хэрэгтэй болох байх. Эхний ээлжид. Тийм учраас байгаа хуулийнхаа хүрээнд бид бас Монголбанкны дотоод аудитыг илүү комплайнс тал руу нь оруулах, хөгжүүлэх шаардлага ургаж байх шиг байна. Энэ зорилгынхоо хүрээнд бол бид одоо комплайнс бол нийцэл, санхүүгийн аудитыг банк дотроо хийчхээд, ер нь гүйцэтгэлийн аудит талыг нь харин Хяналтын зөвлөл хариуцах нь зохистой юм болов уу гэж бодогддог. Тийм учраас одоогийн хууль тогтоомжийн хүрээнд нэг ийм юм байхад ер нь явцын дунд мэдээж сайжруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал тулгарч таарах байх.

Монголбанкны ил тод байдал мэдээж ил тод, хараат бус байдлыг хөгжүүлэхэд энэ зөвлөмжийн ач холбогдол бол бас маш их байдаг. Зөвлөмжийн хуучин бид нарын нийтийн мэдээллээс авч байгаа эх үүсвэрээс авч үзэхэд бол зөвлөмжүүд бас төдийлөн хэрэгжихгүй байгаа гэсэн бас дүгнэлт, санал гарсан байна лээ. Бид цаашид хэрвээ сонгогдвол энэ асуудал дээр илүү тодорхой санаачилгатай ажиллах болох болно гэж мэдэгдэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат асуулт асууж, үг хэлье. Санал хураалттай гишүүдийг танхимд дуудъя.

С.Эрдэнэбат: Өмнө гишүүд бас нэлээн асуусан асуултыг асуучихлаа. Тэгээд тодруулаад бас хэдэн зүйлийг хэлчихье гэж бодож байна.

1 дүгээрт энэ журам бас шинээр өөрчлөх шаардлага бол харагдаж байна лээ. Энэ тал дээрээ бол та бүгд маань томилогдсон тохиолдолд энэ журмаа боловсронгуй болгож оруулж ирэх ийм шаардлагатай. Энэ саналаа бол оруулж ир гэдгийг хэлмээр байна.

Түрүүн бас гишүүд хэлчихсэн тэр банкнууд өөрсдөө бизнес хийгээд байдаг асуудал байдаг гэж. Бизнес эрхлэгчдийн санааг хулгайлдаг, өөрсдөө давхар, бусад этгээдүүдийн олж авсан нууцын зэрэглэлтэй мэдээллүүдийг өөр этгээдүүдэд нэгдмэл сонирхолтой этгээдүүддээ дамжуулдаг ийм бас асуудлууд гардаг байсан. Энд анхаарч бас Төв банкны хийж хэрэгжүүлж байгаа ажлуудыг нь хяналт шалгалт хийх үүргээ хэр зэрэг биелүүлж байгаа вэ гэдэг дээр бол анхаарч ажиллая гэдгийг бас хэлмээр байна.

Дээрээс нь төв банканд байгаа бас чухал мэргэжилтэй хүмүүс хуулиа өөрөө өөрсдөө тайлбарлаад байж байдаг бас асуудал тулгамдсан. Би Капитал банкныг дампуурч байхад маргааш өдөр нь очиж байсан. Яагаад гэхээр тэнд нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын сангийн асар их хэмжээний мөнгө байсан. Гэтэл энийг өр барагдуулах дарааллын төрийн мөнгө учраас бараг хамгийн сүүлд барагдуулах ёстой гэдэг ийм байр суурьтай бүрэн эрхт төлөөлөгч нь очоод тийм юм яриад сууж байсан. Тэгээд энийг бол бүр шүүхэд өгч байж, 1 жил алдаж байж ч гэсэн тэр авлага бол түүнтэй л холбоотой л доо. Нэг албан тушаалтны хуулийг өөрөө тайлбарлаад, тэгээд ийм чухал зүйл дээр тийм байр суурьтай байсан нь бол харамсалтай санагдаж байсан.

Цаашдаа ч гэсэн энэ олон төрийн сангийн хөрөнгүүд банкнууд дээр бас байдаг. Энийг бас энэ мэтээр ойлгоод, энэ чинь төрийн мөнгө биш, ард түмний төлсөн татварын мөнгө байхгүй юу. Тийм учраас бол энэ хууль, эрх зүйн хувьд ч гэсэн сайжруулах ийм шаардлагуудыг нь бас та бүгд маань давхар хянаарай гэдгийг бол хэлмээр байна.

Тэгээд том хадгаламж эзэмшигч нартаа илүү хүү төлдөг. Том банкнууд компаниуддаа бага хүүтэй зээл олгодог гээд энэ өөрөө бас асуудал юм байна лээ. Яг иргэдийн төлж байгаа тэр зээлийн хүүгийн асуудлууд нь бол илүү их төлөөд байдаг. Тэгсэн мөртөө хамгийн төлөлт чанар сайтай. Тийм учраас энэ нэг ийм цаагуураа бичигдээгүй хуулийн цоорхойг ашиглаад ингээд шийдээд байдаг энэ зүйл дээр бас давхар хяналтаа сайн тавьж ажиллаарай гэдгийг захиж хэлье. Үндсэндээ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр томилох санал хураалт явуулж эхэлнэ. Гишүүд суудлаа эзэлье. Ирц бүртгэлийн санал хураалт нэг явуулаадахъя. Ирц бүртгэлийн санал хураалт 54 гишүүн санал хураалтад оролцсон байна.

Нинжбатын Ууганбаатарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажилд томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт 56 гишүүн буюу 60,2 хувиар дэмжигдлээ.

Сугарын Лхагвадоржийг Монголбанкны хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна аа. Санал хураалт 62 гишүүн буюу 66,7 хувиар дэмжигдлээ.

Гэрэлтийн Тэлмэнг Монголбанкны хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна аа. Санал хураалт 57 гишүүн буюу 61,3 хувиар санал дэмжигдлээ.

Тунсагийн Тэлмэнг Монголбанкны хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 63 гишүүн буюу 67,7 хувиар санал дэмжигдлээ.

Ундраагийн Хосжаргалыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 62 гишүүн буюу 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Данзанбалжирын Энхжаргалыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт 60 гишүүн буюу 64,5 хувиар санал дэмжигдлээ.

Гомбын Эрдэнэбаярыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61 гишүүн буюу 65,6 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Монгол Банкны Хяналтын Зөвлөлийн дарга, гишүүнээс чөлөөлөх санал хураалтыг явуулна. Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Далрайн Даваасамбууг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас, Лхагвадоржийн Ариунаа, Лувсан-Очирын Дондог, Баатаржавын Лхагважав, Бат-Очирын Цэрэнбалтав, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Мишигийн Энх-Амгалан нарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалтыг явуулна. Санал хураалт. 65 гишүүн буюу 69,9 хувиар санал дэмжигдлээ.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Хяналтын зөвлөлийн гишүүдэд ажлын амжилт хүсье. Улсын Их Хурлын гишүүд Монголбанкны мөнгөний бодлого болон зээлийн хүүтэй холбоотой асуудал, Монголбанкны үйл ажиллагаа ил тод байдалтай холбоотой асуудал, Монголбанкны алдагдалтай холбоотой асуудлуудаар тус тус асуудал хөндөж ярьсан. Тэгэхээр Хяналтын зөвлөлийн гишүүд хуулийн хүрээнд чиг үүргээ нэр төртэй хариуцлагатай гүйцэтгээрэй гэдгийг бас Улсын Их Хурлын даргын хувьд та бүхэндээ захиж хэлье. Ажлын амжилт хүсье.

17.21 цаг.

Дараагийн асуудалд оръё. **Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүдийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Нэр дэвшигчдийн талаар гаргасан Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилуулахаар саналаа ирүүлсэн болон Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн нэр дэвшигчийг бүртгэх тухай 05 дугаар тогтоолын дагуу зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд Идэшийн Батхүү, Төмөрбаатарын Гарамжүгдэр, Авирмэдийн Даваасүрэн, Ганболдын Золбоо, Дамдиндоржийн Мягмарцэрэн, Дорждэрэмийн Цолмон нарын нэрийг дэвшүүлсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай хүсэлтийн загварын дагуу нэр дэвшигчид өөрийн танилцуулга, холбогдох бусад бичиг баримтаа бүрдүүлж, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу баталсан нэр дэвшигчдийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай 08 дугаар тогтоолоор 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддоржийг томилсон.

Эдийн засгийн байнгын хорооноос 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн зохион байгуулсан нэр дэвшигчийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, Да.Цогтбаатар, С.Эрдэнэбат нарын гишүүд оролцсон болно.

Байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонгол явуулсан талаарх сонголын тайланг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүд нэр дэвшигчээс асуулт асуугаагүй бөгөөд Идэшийн Батхүү, Төмөрбаатарын Гарамжүгдэр, Авирмэдийн Даваасүрэн, Ганболдын Золбоо, Дамдиндоржийн Мягмарцэрэн, Дорждэрэмийн Цолмон нарыг Үндэсний статистикийн хорооны гишүүн томилуулах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Төмөрбаатарын Гарамжүгдэр, Дорждэрэмийн Цолмон, Идэшийн Батхүү, Дамдиндоржийн Мягмарцэрэн, Авирмэдийн Даваасүрэн нар хүрэлцэн ирсэн байна. Нэр дэвшигч Ганболдын Золбоо хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө хүссэн тул чөлөө олгосон байгаа.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Өөр гишүүн байна уу. 3 гишүүнээр тасаллаа. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Нийт нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нартаа амжилт хүсэж байна. Ганцхан л асуулт байгаад байна. Манай улсын төлөвлөгөө, бодлогын бичиг баримт, төсвийн зарцуулалт энэ бүхний үр дүнг бид нар зөв хэмжиж чадахгүй байгаад байгаа. Сүүлийн 30 жил дандаа ийм алдаатай явж ирсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль дээр уг нь бол үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт байх ёстой. Шалгуур үзүүлэлт буюу кэй пи ай оновчтой байх ёстой. Гэтэл жишээлбэл төсвийн 1 дүгээр хавсралт дээр нийт шалгуур үзүүлэлтүүдийн бараг тал нь шахуу алдаатай. Товчхондоо дурдах юм бол агаарын бохирдлыг зөвхөн ПМ 2,5-аар хэмжээд байгаа. ПМ 10, азот, хүхэр гээд хүүхдийн эрүүл мэндэд маш хортой бодисуудыг бид нар хэмжиж чадахгүй байгаад байгаа. Тэгсэн мөртөө агаарын бохирдлыг бууруулна, тэмцэнэ гэсэн төсөл, арга хэмжээний төлөвлөгөө гаргаад, хэрэгжүүлээд байдаг. Үр дүнгээ хэмжиж чадахгүй байгаа бол бид нар хаана ч хүрч чадахгүй. Ер нь сүүлийн 10, 20 жилийн хугацаанд ихэнх улсууд яг энэ үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт гэдэг зүйл дээр анхаараад байгаа. Жишээлбэл Солонгос улс үндэстэн даяараа 200 Кэй Пи Ай буюу 200 шалгуур үзүүлэлт тавьж байгаад энэ нь олон улсын стандартын дагуу олон улсад ашиглагддаг шалгуур үзүүлэлтүүдийг ашиглаж байгаа. Тодхон жишээ хэлэх юм бол авлигатай тэмцэнэ гээд зорилго тавиад ороод ирсэн боловч авлигатай тэмцэж байгаа арга хэмжээнийхээ хэрэгжилтээр үр дүнгээ дүгнэнэ гээд байгаа юм. Гэтэл олон улс даяараа корропшн индекс буюу авлигын төсөөллийн индекс гэдэг зүйлийг ашиглаж байгаа шүү дээ. Хэзээнээс бид нар ийм зөв шалгуур үзүүлэлт буюу

кэй пи айг ашигладаг болох юм бэ. Энэ дата мэдээллүүд бүгд Үндэсний статистикийн хороо дээр цуглаад, түүнийгээ ашиглаад бид нар Засгийн газар, Улсын Их Хурлын үйл ажиллагааны хэрэгжилт, тайланг хараад байгаа юм. Энэ дээр ямар шинэчлэлт хийх вэ. Бодитоор ямар салбарын ямар шалгуур үзүүлэлтийг ямар болж шинэчлэх юм. Тийм зорилт төлөвлөгөө байна уу.

Та бүхэн багаараа хэрхэн ажиллах вэ гэдэг тодорхой асуулт байгаад байн. 1980, 1990-ээд оны залуу үе бол бид Их хурлаас, Засгийн газраас ерөөсөө үр дүн л хүсэж байгаа. Буруу төлөвлөгөө, буруу төсөвтэй явах юм бол бид нар хэзээ ч энэ үр дүнг өгч чадахгүй. Ийм асуулт байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигчид хариулт өгье. Төмөрбаатарын Гарамжүгдэр. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

Т.Гарамжүгдэр: Эрхэм гишүүддээ энэ оройн амар амгаланг айлтгая. Юуны түрүүнд би өөрийгөө танилцуулахад би бол иргэдийн төлөөлөл гэдэг утгаараа энэ зөвлөлийн гишүүдэд орж ирж байгаа. Тэгэхээр төрийн алба, нэгжүүдэд шийдвэр гаргахаас илүү төлөвлөгөө зохиохоос илүү гол нь иргэдийн энэ дата мэдээллийг хэрэглэж байгаа аж ахуйн нэгж, ялангуяа хувийн хэвшлийнхнийг төлөөлж уг датаг маш оновчтой гаргасан датад шийдвэр гаргахад маш оновчтой байх дата дээр хяналт тавих гэж л орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Саяын Лувсанжамц гишүүний асуултад хариулахад үр дүнд суурилсан төлөвлөгөөг гаргахын тулд бол анхдагч мэдээллийн чанар буюу дата маш үнэн, бодитой байх шаардлагатай гэж харж байгаа. Миний цахим мэдээллээс олсон судалгаагаар бол 2022 онд Үндэсний статистикийн хороо бол анхдагч мэдээллийн чанарыг сайжруулагч багц журам гэдэг гаргасан юм байна лээ. Энэ журмыг хэрхэн мөрдөж байна гэдэгт бид нар хяналт тавьж ажиллана гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Дорждэрэмийн Цолмон хариулт өгье. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

Д.Цолмон: Оройн мэнд хүргэе. Гишүүддээ Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Энэ Үндэсний статистикийн хорооны зөвлөл нь бол ерөнхийдөө Үндэсний статистикийн хороонд бол зөвлөн дэмжих ийм чиг үүрэгтэй институц юм байна лээ. Тэгэхлээр ерөнхийдөө бол яг энэ статистикийн үйл ажиллагаанд хамаардаг бүх үйл ажиллагаанд Үндэсний засгийн хорооны даргад нь бол дэмжлэг үзүүлээд явна. Энд таны тавьсан хөндсөн асуудал бол бас маш чухал асуудал. Энэ статистикийн үйл ажиллагааны үндсэн гол юу бол мэдээллийн үнэн зөв, бодитой байдал маш чухал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ төрийн байгууллагуудад байгаад байгаа энэ мэдээллүүд бол ер нь их зөрчилтэй, давхардалтай ийм асуудлууд үүсдэг учраас бас энэ төрийн бодлого шийдвэрүүд, төлөвлөлтүүд гарахдаа бас ийм үндэслэлгүй гарах ийм үндэслэл болоод байгаа юм. Тэгэхээр яг энэ төрийн байгууллага болон энэ захиргааны байгууллагууд дээр энэ төвлөрөөд байгаа энэ салангид мэдээллүүдийг нэгтгэх, уялдуулах, энэ давхардал хийдлийг нь арилгах 1 дүгээрт бол зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

2 дугаарт энэ мэдээллийг бас нэгтгэн боловсруулах энэ чиг үүрэг бол бас нэг том үндсэн чиг үүрэг байгаад байгаа энэ хорооны. Тэгэхээр энэ тал дээр бол Үндэсний статистикийн хорооны даргатай бид хамтраад ажиллах бол бүрэн боломжтой. Засгийн газрын түвшиндээ. Тиймэрхүү чиглэлтэй бол ажиллахад бол бэлэн байна.

Д.Амарбаясгалан: Идэшийн Батхүү нэр дэвшигч хариулт өгье. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарг Батхүү. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Монголын Үндэсний статистикийн хороо бол ер нь бас үйл ажиллагаа дата цуглуулалтад нээлттэй байдал талаараа бас олон нийтэд хүртээмжтэй хүргэх талаараа бас бусад орнуудтай харьцуулахад нэлээн дэвшилттэй сайн ажиллаж байгаа. Гэхдээ энэ ажлынх нь гарч байгаа үр дүн нь бол ер нь макро талын тоонууд дээр ер нь албан ёсны боловсруулалт хийж зарлах тал дээр илүү түлхүү анхаарч ажиллаж байгаа. Яг таны дурдсан энэ үр дүнд суурилсан төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, хяналтын тогтолцоонд нийцтэй тийм шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах тоон мэдээллийг нягталж гаргах тал дээр бол микро түвшний тоон мэдээллийг илүү задалж ажиллах тийм хэрэгцээ, хүчин чадал, чадавхыг бэхжүүлэх шаардлага бий. Үндэсний статистикийн хороонд бол өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийн судалгаа, ажиллах хүчний судалгаа зэрэг микро түвшний судалгаанууд бас нэлээн гайгүй явж байгаа. Тэгээд энэ микро түвшний судалгаанууд илүү өргөн дэлгэрэнгүй болгох, яг Монгол Улсын цахим хөгжлийн давуу талаар бий болоод байгаа и-монгол, гаалийн систем, Нөатын систем гээд энэ дээр байгаа, цаашдаа биг дата болж хөгжих боломжтой энэ мэдээллийг хиймэл оюун ухаан дата анализаар ашиглаад шинэ арга зүйгээр энэ микро тоон мэдээлэл боловсруулах чиглэл рүү илүү хөгжүүлж ажиллуулбал таны хүсэж байгаа үр дүнг гаргахад бас дөхөмтэй болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Дамдиндоржийн Мягмарцэрэн хариулт өгье. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Д.Мягмарцэрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ оройн амгаланг айлтгая. Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Мягмарцэрэн. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Үндэсний статистикийн хорооны зөвлөл бол 2017 оноос эхлээд Улсын Их Хурлаас зүгээр бүрэлдэхүүнийг төрийн байгууллагуудын албан тушаалаар бүрэлдэхүүнийг нь баталдаг байсан. Энэ хүрээнд миний бие Их Хурлыг төлөөлж, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албыг төлөөлж зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллаж байсан. Үндэсний статистикийн хорооны зөвлөл бол Статистикийн хорооны үйл ажиллагаанд зөвлөн туслах тийм л чиг үүрэгтэй зөвлөл байж байгаа. Лувсанжамц гишүүний асуулт. Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлттэй холбоотой асуудлыг бол Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлахын хувьд бол нэлээн сайн мэднэ. Яагаад гэхээр манай Байнгын хороогоор хөгжлийн бодлогын асуудлууд байнга хэлэлцэж байдаг. Өнгөрсөн онд гэхэд яг Лувсанжамц гишүүн орж ирээд, Байнгын хороо дээр бол яг энэ саналаа хэлж байсан. Төсөвлөлт, төлөвлөлт эд нар ерөөсөө уялдаа холбоо байхгүй байна. Шалгуур үзүүлэлт хангалтгүй байна гээд. Энэ бол үнэхээр үнэн. Тэгээд Лувсанжамц гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар тухайн үед төслүүдэд нэлээн их зарчмын шинжтэй өөрчлөлтүүд орж байсан. Ирэх жилийн төлөвлөгөө бол энэ 2025 оны хаврын ээлжит чуулганаар орж ирнэ. 5 сард. Хэлэлцэх хугацаа жоохон шахуу байдаг. 1 сарын хугацаан дотор хэлэлцээд батлах болдог. Тэр нь гишүүд нөгөө төсөл дээр ажиллах, шалгуур үзүүлэлтийг нягталж хянах энэ тэрд жоохон учир дутагдалтай байдаг тал үнэхээр байдаг.

Статистикийн хорооны зөвлөлийн гишүүний хувиар бол Байнгын хорооныхоо гишүүдэд Их Хурлыг байнга статистикийн мэдээллээр хангах, энэ хооронд нь холбох чиг үүргийг гүйцэтгэж, 7 хоног бүр гишүүдээ статистикийн мэдээллээр хангадаг байж байгаа. Гишүүн өөрөө мэдэж байгаа байх. Вайбер группүүдээр, утсаараа мэдээллүүдийг дор дор нь түгээгээд ингээд явж байгаа.

Хөгжлийн бодлогын хэлэлцэх үед бас яг энэ эрхлэх чиг үүргийнхээ хүрээнд гишүүдийн мэдээллээр хангана. Тэгээд магадгүй энэ жижигхэн ажил маань гишүүдэд мэдээлчхээд, тэгээд нөгөө бодлого төлөвлөлт шалгуур үзүүлэлтийг сайжруулахад нэлээн том тус болох байх л гэж найдаж байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Авирмэдийн Даваасүрэн хариулт өгье. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

А.Даваасүрэн: Эрхэм гишүүдийн энэ оройны амар амгаланг айлтгая. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Ер нь бол үр дүнд суурилсан төлөвлөлт манайд хэрэгжихдээ муу байна гэсэн ийм асуулт тавилаа гэж ойлгож байна. 1990 оноос өмнө бол манай улс бол деректив төлөвлөлт гэдэг хэлбэрээр байсан. 1990 оноос хойш бол үндсэндээ индикатив төлөвлөлт гэж ингэж үзэж болно. Ер нь төлөвлөлтийг арга зүй талаас нь ярих юм бол их удаан ярих байх. Төлөвлөлтийг бол 3 түвшинд хийдэг. Тэгээд төлөвлөлтийг урдаасаа хойш нь хойноосоо урагш нь дээрээсээ доош нь дороосоо дээшээ гэсэн ийм олон хэлбэрүүд байдаг л даа. Олон аргачлалууд байдаг. Зүгээр манай улс бол хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг юугүй явж ирсэн гэвэл худлаа. Энд бол би өөрөө оролцож байсныхаа хувьд бол Алсын хараа 2050 дээр ер нь бол Үндэсний хөгжлийн газар дээр бас хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бичиг баримтуудыг Монгол Улсын бичиг баримтуудыг дэлхийн тогтвортой хөгжлийн 2030-тай уялдуулах энэ судалгааг бас хийж, удирдаж байсныхаа хувьд бол ер нь хийж ирсэн байдаг. Гэхдээ нөгөө төлөвлөлтийнхөө арга зүй, хэрэгжүүлэлт дээр бол бид бас алдаж ирсэн байдаг. Тэгэхээр үр дүнд суурилна гэдэг маань ер нь ирээдүйд болох тэр зорилго, зорилт, алсын хараа, үнэт зүйлс тэрэндээ хүрэхэд ямар эдийн засгийн болон захиргааны ямар механизмуудаар тэр зорилгодоо хүрэх вэ. Зорилтуудаа хэрэгжүүлэх вэ. Тэр нь мэдээж 3 хувилбараар хийгдэх ёстой. Дунд, дээд бөгөөд оптимист гэдэг. Дунд нь байж болох түвшин доодох бол хамгийн писимист бөгөөд нэлээн хүнд үе гээд. Тэгээд төлөвлөлтийг хийхдээ бид нар шинжлэх ухааны судалгаа, тооцоо судалгаа, тэр норм норматив, ажил үүргийн тэр норм нормативыг тооцох тал дээр бас жоохон анхааралгүй, анзааралгүй ирсэн байдаг. Тэгээд ийм учраас ер нь бол төлөвлөлтийг хуучин 1990 оноос өмнөхтэй харьцуулах юм бол төлөвлөлтийг бид индикатив хэлбэрээр ингэж хийж байгаа.

Тэгэхдээ хийхдээ бид нар гол анхаарах юм бол ерөөсөө тэр механизмууд, хэрэгжүүлэх бодлогын механизм гэж их ярьдаг даа. Тэр бодлогын механизмуудыг аль шалгуурт хүрч аль үр дүндээ хүрэх вэ гэдгийг зорилтот түвшиндээ ингэж мэдээж урьдчилж тодорхойлж судалгаан дээр тодорхойлж ингэж гарах ёстой.

Үндэсний статистикийн ийн хорооны түвшинд энэ төлөвлөлт бол аливаа байгууллага төлөвлөлттэй байгаа байх гэж бодож байна. Микро, мезо, макро түвшний, ялангуяа энэ макро түвшний бөгөөд индикатив төлөвлөлтүүд бол манайд хийгдэж байгаа байх гэж бодож байна. Зүгээр ер нь бол үр дүнд суурилсан тийм төлөвлөлтийг хэрэгжүүлэх тэр механизмуудыг бол ашиглах, тэрийг нөгөө хосолсон болон дагнасан, дангаар нь далд ба ил гээд ийм олон аргаар бол хэрэглэж ашиглаж,

зорилтот түвшиндээ хүрэх тэр шалгууртаа хүрэхэд бололцоотой болов уу гэж би бодож байна.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Би асуулт асуухгүй. Би үг хэлнэ ээ дарга аа. 1 минут боломжтой бол нэмчхээрэй. Нэр дэвшигчдийг харахад статистикийн мэргэжлийн хүн байхгүй учраас би заавал ичээх гэж асуулт асуухгүй. Энэ статистикийн тухай хуулиараа холбогдох байгууллагуудаас орон тооны бус зөвлөлийг байгуулж байгаа учраас Улсын Их Хурлын Тамгын газар, Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, ШУА-аас тус бүр хүмүүсээ дэвшүүлдэг. Иргэний төлөөлөл бас орж ирж байгаа нь бол сайн хэрэг. Та бүхнийг 1 дүгээрт бүгдийг нь дэмжиж байна.

2 дугаарт болохоор Статистикийн байгууллага маань өөрөө маш мэргэжлийн байгууллага юм. 1924 оны 11 сарын 11-нд байгуулагдаж байсан. Өнгөрсөн оны 11 сарын 11-нд бид 100 жилийн ойгоо тэмдэглэсэн. Гэсэн мөртөөсөө хамгийн ашиглагддаггүй, хамгийн ойлгогддоггүй ийм салбар байгаад байгаа юм. Тэгээд манай Лувсанжамц гишүүний хэлээд байгаа зөв л дөө. Бид нарын тоо судалгаа мэдээлэл индикатор маш сайн ашигладаг байх ёстой гэж. Тэгээд та бүхний маань үүрэг даалгавар ер нь миний харж байгаагаар юу юм бэ гэхээр өөр өөрсдийнхөө байгууллагаасаа гадна ер нь энэ статистикийн мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх тал дээр, сайжруулах тал дээр өөрт буюу төр, Засгийн газрынхаа хэмжээндээ бусад байгууллагуудынхаа хэмжээнд бий болгож байгаа захиргааны мэдээллийг хэрхэн яаж хооронд нь уялдуулах вэ гэдэг дээр анхаарч сайжруулах, олон нийтэд таниулах, тухай бүр гарч байгаа бодлого шийдвэр маань яг статистикийн мэдээллээ ашигладаг байх тал дээр онцгойлон анхаараарай гэж захимаар байна.

Нэн ялангуяа Батхүү дарга сая и-баримтын мэдээллийг дурдлаа. И-баримтын мэдээлэл дээр өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ яг бодитоор цуглаж байгаа. Тэгэхээр яг энэ и-баримт дээрээ суурилад инфляцын мэдээллээ бүр өдөр тутам гаргах боломжтой. Тэгэхээр өмнөх аргачлал буюу зах худалдааны цэгүүдээр тогтсон лангуун дээр очиж байнга хүн очиж ажилладаг энэ байдлыг бол хэрэглээний сагсны 100 бүтээгдэхүүнээр бид авдаг шүү дээ. Тэгэхээр тэрийг шинэчлэх бүрэн боломжтой байгаа. Ингэхийн тулд бид нар Статистикийн хуулиа шинэчлэх ёстой. Тэгэхээр энэ статистикийн хуулиа бас хэдүүлээ хамтдаа шинэчлэх тал дээр анхааръя.

Хэрэг эрхлэх дээр жишээлбэл биг дата буюу энэ их өгөгдлийн дата санг байгуулах, и-Монгол академид хариуцуулах нэг тогтоомж гарч байсан шиг санаад байна. Эдгээр асуудлуудыг бид нар нэгтгээд Статистикийн байгууллагад бүрэн эрхийг нь өгөөд, мэдээллээ ашиглах тал дээр нь бид нар бас анхаарах ёстой юм. Ингэж байж бид нар бас энэ статистикийн мэдээллийг зөвхөн Статистикийн хуулиар батлагдсан албан ёсны статистикийн үзүүлэлтээр захиргааны мэдээллээ гаргахаас гадна цаг үе тутамдаа тулгамдаж байгаа асуудлуудыг төр өөрт байгаа мэдээлэл дээрээ суурилад гаргах боломж нь бүрдэх юм.

Тэгэхээр энэ дээр та бүхэн маань бас анхаарч, бид бүгдийг болон иргэд нийгэмд энэ статистикийн байгууллагын хэрэглээг нэмэгдүүлэх .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадарчийн Хэрлэн гишүүн үг хэлье.

Б.Хэрлэн: Үндэсний статистикийн хорооны зөвлөлд гишүүнээр нэр дэвшиж байгаа та бүхэнд амжилт хүсье. Тэгэхээр сая Лувсанжамц гишүүн, Ариунзаяа гишүүн 2 бас ерөнхийдөө хэллээ. Тэгэхээр статистикийн байгууллагын өгч байгаа боловсруулж гаргаж ирж байгаа тайлан мэдээллүүд аль болохоор амьдралд ойр байх хэрэгтэй байна. Аваад хэрэглэхэд хялбар дөхөм байдаг байх хэрэгтэй байна. Хэдий чинээ найдвартай мэдээллүүд бид нар тэндээс авна, төдий чинээ бодлого шийдвэрүүд бол оновчтой гарна гэсэн санааг бол хэлээд байна л даа.

Тэгэхээр сүүлийн үед ер нь бол байгууллагууд энэ статистик тоон мэдээллүүдийг гаргадаг. Яах аргагүй саяын манай 2 гишүүний хэлдэг зүйл хэлэгдэхээс арга байхгүй. Статистик мэдээллийг аваад тэр дээр шууд ингээд ашиглахад бол бид нар зайлшгүй ахиад дараа дараагийн боловсруулалтуудыг хийж байж ашигладаг. Тэгэхээр энэ хариуцлагатай Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүн хэрвээ болоод сонгогдоод гараад ирэх юм бол та бүхнийг салбар хоорондын уялдааг хангаж мэдээллийг боловсруулах, хэрэглэгчид аваад хэрэглэхэд их ойр дөхөм байдлаар мэдээллийг боловсруулж өгдөг байгаасай гэж хүсмээр байна. Тэгээд ингээд та бүхний бүрэлдэхүүн дотор бол Их Хурлын Тамгын газраас, Эдийн засаг, хөгжлийн яамнаас, ЗГХЭГ-аас тэр тусмаа шинжлэх ухааны доктор хүн, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор хүн ороод ирсэн байна гэдэг бол энэ бүх мэдээллийг эдийн засгийн талаас нь хараад хүнд хэрэглэхэд маш хялбар дөхөм байдлаар боловсруулахад бас энэ хорооны үйл ажиллагааг сайжруулахад нэмэр болно байх гэж бодож байна.

Ингээд та бүхэнд амжилт хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох санал хураалт явагдана. Гишүүдийг танхимд урья. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад ороогүй гишүүн байна уу. Гишүүд суудлаа эзэлье. Санал хураалт.

Идэшийн Батхүүг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явагдана. Жуковын Алдаржавхлан гишүүн үг өгье.

Ж.Алдаржавхлан: Хурууны хээ ажилласангүй. Тэгээд дахин санал гаргаж хураалгаж өгөөч ээ. Горимын санал.

Д.Амарбаясгалан: Тэгээд Алдаржавхлан гишүүн яаж байгаа юм. Санал гаргаж байгаа юм уу.

Ж.Алдаржавхлан: Тийм ээ. Горимын санал гаргаж байгаа юм. Дахин санал гаргаж өгөөч ээ гэж. Саналыг хүчингүй болгож өгөөд дахин санал гаргаж өгөөч ээ гэж.

Д.Амарбаясгалан: Алдаржавхлан гишүүний горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдсэн байна.

Тэгэхээр Идэшийн Батхүүг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

Төмөрбаатарын Гарамжүгдэрийг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 55,9 хувиар санал дэмжигдлээ.

Авирмэдийн Даваасүрэнг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

Дамдиндоржийн Мягмарцэрэнг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Нууц санал хураалт явуулъя. Санал хураалт. 50,5 хувиар санал дэмжигдлээ. Гишүүд саналаа анхааралтай өгье.

Дорждэрэмийн Цолмонг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт 55,9 хувиар санал дэмжигдлээ.

Ганболдын Золбоог Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт. 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүдийг томилох саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

17.54 цаг.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддоржид микрофон өгье.

Р.Сэддорж: Өнөөдрийн баталсан томилгооны тогтоолуудын эцсийн найруулгыг сонсох саналтай байна.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны даргын саналыг хүлээн авлаа. Тогтоол батлагдсан өдрөөс хүчинтэй болж байгаа учраас өнөөдөр томилогдсон хүмүүсийн ажил хүлээлцүүлэх ажил зохион байгуулагдах учраас эцсийн найруулгыг сонсьё.

Тэгвэл эцсийн найруулга уншиж танилцуулъя.

Нэг.“Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /17:54/

“Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо./17:54/

“Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /17:54/

“Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /17:54/

“Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, дарга гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Найруулгыг сонссонд тооцлоо./17:55/

“Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу алга байна эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /17:55/

Дараагийн асуудалд оръё. 18 цаг болж байна. Хэлэлцэх асуудал олон байгаа учраас өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг сунгаж хуралдуулах саналтай байна. Эсрэг саналтай гишүүн байна уу. Алга байна. Өнөөдрийн хурлыг сунгаж хуралдахаар боллоо.

17.55 цаг.

Дараагийн асуудалд оръё. **“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.14 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос зарчмын зөрүүтэй 1 санал ирүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг танилцуулъя. Сандагийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хүчитбаатарын Итгэлт Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Данзан-Яринпилийн Мөнхбат Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга, Сүхээгийн Мяндасмаа Зам, тээврийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Баасанхүүгийн Цэнд Зам, тээврийн яамны Хуулийн хэлтсийн ахлах шинжээч.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаг гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нэг гишүүний нэр ирсэн байна. Батын Батбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг намын эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүд нэр ирээгүй байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллын уншиж танилцуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал

Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт. Санал хураалт явагдана. Улсын Их Хурлын гишүүд танхимд орж ирье. Суудлаа эзэлье.У

Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтын гаргасан, Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат гишүүн горимын санал уу.

Г.Очирбат: Төхөөрөмжөө хоцроод дарчихлаа. Дахин санал хурааж өгнө үү гэж горимын санал гаргаж байна. Тэгээд хүчингүй болгож өгөөч.

Д.Амарбаясгалан: Хэд хэдэн гишүүд бас санал хураалтад оролцож чадсангүй гэж гар өргөж байгаа учраас горимын саналаар санал хураалт явуулъя.

Ганбатын Очирбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналаар дэмжье гэсэн саналын томъёоллоор дахиж санал хураалт явуулъя. Санал хураалт. 54,8 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

18.01 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Заяабал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хуралд 2024 оны 12 сарын 13-ны өдөр ирүүлснийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн хүлээн зөвшөөрч, Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай 57 дугаар тогтоолыг баталсан.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Татварын ерөнхий хуульд зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулах асуудлыг судлан, хуулийн төслийг боловсруулж, Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Төсвийн байнгын хорооны 2025 оны 2 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Заяабалаар ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Ганзориг, Мөнхсоёл нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Дээрх ажлын хэсгээс Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд нийцүүлэн иргэний халдашгүй, чөлөөтэй хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрхийг хязгаарлах зохицуулалтыг тодорхой нарийвчлан тусгасан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Төсвийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 дахь хэсэгт заасны дагуу Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед хуралдаанд оролцсон гишүүдээс төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Заяабал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг гишүүдийн олонх дэмжсэн болно.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Цэндийн Тогосмаа Татварын Ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга, Лхагвасүрэнгийн Мөнхтуул Татварын ерөнхий газрын Олон улсын татварын хэлтсийн дарга, Бат-Өлзийн Буяннэмэх Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газрын дарга, Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга. Энэ дээр нэр орж ирээгүй байна. Ажлын хэсгийн нэрс дээр. Анхаараарай.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Пүрэвжавын Сайнзориг гишүүнээр тасаллаа. Баасанжаргал, Идэрбат гэсэн 3 гишүүнээр тасаллаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Энэ Татварын хуультай холбоотой бас нэг асууж тодруулах зүйлүүд байна. Хэдхэн хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхий сайд ард түмэндээ хандаж шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлэхдээ, энэ 2025 он бол татварын мөн нийгмийн даатгалын шимтгэлийн асуудлууд дээр бас нэлээдгүй өөрчлөлт хийх ийм он болно гэдэг зүйлийг хэлсэн. Энэ үгэндээ бас онцлох нэг зүйлийг хэлсэн нь бол иргэд, аж ахуйн нэгжүүдийн санал дээр бас үндэслэнэ гэдэг ийм зүйлийг бас хэлсэн байгаа. Тэгэхээр энэ асуудал ер нь ямар шатдаа яваа вэ. Иргэд, олон нийт энэ хаврын чуулганаар Их Хурлын гишүүдээс энэ татварын хуулийн өөрчлөлт, нийгмийн даатгалын энэ шимтгэл гээд нийгэмд яригдаж байгаа энэ олон асуудлуудаар бас нэлээдгүй тодруулах байх. Тийм учраас энэ дээр бас албан ёсны хариултыг хэлээч гэж 1 дүгээрт.

2 дугаарт Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн байнгын хороо 2-ын хамтарсан 2 Байнгын хороогоор Монгол Улсад хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжийн хэрэгжилтийн асуудлаар бас хөдөө аж ахуйн салбар, байгаль орчны салбарын танилцуулгуудыг сонссон. Тэгээд байгаль орчны салбарын танилцуулга дээрээс ингээд аваад үзэхэд ер нь манай Монгол Улсад гадаадын зээл тусламжууд бас нэлээдгүй хэрэгждэг юм байна. Энэ томоохон дэд бүтцийн төслүүд бол бас баримжаатай, ТЭЗҮ юмнуудтай, бас дүгнэх эргэх бололцоотой байдаг юм байна.

Харин энэ салбарууд дээр хэрэгжиж байгаа 2, 3 сая, 5 сая гэсэн ийм долларын өртөгтэй энэ зээлүүд бол олон сөрөг үр дагаврууд бас байгаа юм байна. Тухайн салбарын яамнаас захиалаагүй байхад гаднын янз янзын байгууллагуудаас танайд энийг хэрэгжүүлнэ гээд хэрэгжүүлээд эхэлдэг юм байна. Эргүүлээд Монголын төрийн байгууллага нь үүнийхээ тайланг авъя гэхээр тайланг нь өгдөггүй юм байна.

Санхүүгийн задаргааг нь аваад үзэхээр Монголд төсөл хэрэгжүүлсэн хэр нь нэг судалгаа зөвлөмж, тэгээд баахан сургалтууд гэсэн иймэрхүү зардлууд руу дийлэнх нь яваад өгдөг. Зөвлөхийн зардал гээд ингээд яваад өгдөг гээд ийм зүйлүүд бас байна. Тэгэхээр энэ дээр ч гэсэн ер нь бид цаашдаа анхаарахгүй бол болохгүй юм байна. Тэгэхээр ер нь бол энэ дээр Монгол Улсын Засгийн газраас энэ гадаадын зээл тусламж энэ бүх зүйлүүд дээр ер нь ямар бодлого бас барьж байгаа юм бэ гэдэг дээр би бас энэ Татварын хуультай холбогдуулаад энэ 2 асуудал дээр тодруулга авъя гэж ингэж бас бодсон юм байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Төрийн байгуулалтын байнгын хороог төлөөлж Заяабал гишүүн хариулт өгье.

Б.Заяабал: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Ерөнхий сайд он гарах мөчид бас энэ ирэх 2025 онд хийгдэх гол ажлуудыгаа ард нийтдээ хандаж хэлэхдээ энэ Татварын хуулийн шинэчлэлийг хийнэ гэдэг ийм үгийг бас хэлсэн байгаа. Үүнтэй холбоотой бас Засгийн газрын зүгээс Засгийн газрын хурал дээрээ бас яригдаад Сангийн сайдын Засгийн газрын хуралдааны дараа хийсэн мэдэгдлийг үзэж байхад эхний ээлжид манай Сангийн яам, Татварын ерөнхий газар, нийт энэ ард иргэд, татвар төлөгчдийн дунд эхний ээлжид татварын шинэчлэлтэй холбоотой ямар асуудлуудыг та бүхэнд илүү анхаарал хандуулах шаардлагатай байна, энэ талаар та бүхэн саналаа өгөөч ээ гэсэн ийм хэлэлцүүлгүүдийг зохион байгуулна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа гэдгийгээ танилцуулсан.

Тэгээд энэ төлөвлөгөө дээр гарч ирсэн татвар төлөгчдийн ард иргэдийн, аж ахуйн нэгжүүдийн санал дээр үндэслээд, дараагийн хуулийн төслүүд нь бичигдэж боловсруулагдаж явна гэсэн ийм ойлголттой байгаа.

Улсын Их Хурал дээр яг энэ Татварын багц хуулийн шинэчлэл дээр дэмжлэг үзүүлэх бас ийм ажлын хэсгийг бас байгуулаад ажиллаж эхэлж байгааг та бүхэн, та бас мэдэж байгаа байх. Үндсэн хуулиараа энэ татварын асуудлыг бол Үндсэн хуульд орсон өөрчлөлтөөр Засгийн газар өргөн барих бас ийм хуулийн зохицуулалттай байгаа гэдгийг бас бид бүхэн мэдэж байгаа.

2 дугаарт нь энэ төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой асуудлууд дээр Монгол Улсад нийтдээ 90 орчим төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа юм байна лээ. 2025 оны төсвийг батлахад бид нар бас энэ төсвийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагаж Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн тогтоол гаргасан. Улсын Их Хурлын тогтоол. Энэ дээрээ энэ 90 төслийнхөө хэрэгжилтийг эргэж хараач ээ. Эргэж аудит хийгээд, ирэх оны 1, 2 дугаар улиралд багтааж, Улсын Их Хуралд танилцуулаач гэсэн ийм үүрэг өгчихсөн байгаа.

Байнгын хороо дээр Сангийн сайдаас энэ асуудлаар асуухад зайлшгүй 2 дугаар улирал гэж хүлээхгүйгээр 1 дүгээр улирал дээр энэ төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаарх танилцуулгуудаа оруулж ирж, Улсын Их Хуралд танилцуулна. Зарим үр дүнгүй ийм төсөл хөтөлбөрүүдийг зогсоох, үр дүнтэй, шаардлагатай дэд бүтцийн чиглэлтэй газрын тос гэх мэтчилэн ийм томоохон төслүүдийгээ урагшаа явуулахын тулд бас энэ төсөл хөтөлбөрүүд дээрээ өөрчлөлт хийнэ гэсэн ийм зүйлийг бас ярьсан гэдгийг та бүхэнд бас мэдээлэл болгож хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Би яах вэ, асуулт бол байхгүй байна. Зүгээр санал хэлэх гээд. Ерөнхийдөө бас Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн агуулгаар шийдвэрээ гаргасан. Улсын Их Хурал маань хүлээгээд авчихсан учраас энэ дээр зохих хэмжээний нэмэлт, өөрчлөлтийг оруулах ёстой. Тэгэхдээ нэмэлт, өөрчлөлтийг оруулахдаа нөгөө бусад хууль тогтоомжийг баталж байгаа юм шиг үзэл баримтлал баталдаггүй. Тэгээд тодорхой хэмжээний судалгаа харьцуулалт хийдэггүй нэг ийм зүйл байгаад байгаа юм. Тэгээд энийг зүгээр холбогдох Байнгын хороон дээрээ боловсруулчихдаг, тэгэхдээ яах вэ мэдээж холбогдох төрийн байгууллагууд оролцуулж байгаа, судлаачдаа оролцуулж байгаа. Тэгэхээр бид хэд Улсын Их Хурлын дарга энэ намрын чуулганы дараагаар бас Улсын Их Хурлын дэгийг бас сайжруулах ажил ярина гэсэн. Энэ хүрээндээ ажиллах ажлын хэсэг маань бас нэг анхаараач. Энэ өөрөө эргээд нөгөө татвар төлөгч буюу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зайлшгүй мэдэгдэх ёстой, тэдгээрийн саналыг сонсох ёстой ийм хуулиудын нэг байхгүй юу. Ер нь бүх хуулиуд тийм. Тэгэхээр ийм хуулиудыг яах вэ, Цэцийн шийдвэрийг хүлээж авахдаа тодорхой бас ийм цаг хугацааг Улсын Их Хуралд олгодог баймаар байна. Юу юугүй ингээд л 27 хоногийн дотор гээд ингэчихээр бас болж өгөхгүй. Энийгээ бид нар бас олон нийтэд тавьж саналыг нь авдаг. Дээрээс нь бизнес эрхлэгч ч байдаг юм уу, холбогдох эрх ашиг нь хөндөж байгаа этгээдүүдээр бас хэлэлцүүлэг хийчихдэг ийм байдлаар ингээд яваад, улам сайжруулаад ингээд Цэцийн дүгнэлтийг авч хуулиа баталдаг энэ дэгийг бас цаашдаа оруулж өгөөч ээ.

Маш их хэмжээний Цэцийн дүгнэлтийг хүлээж авч байгаа энэ шийдвэрүүд дээр ямар нэгэн үзэл баримтлал, танилцуулга, судалгаагүй ийм хуулиуд хувийн хэрэггүй хуулиуд батлагдаад байгаа юм. Тэгэхээр энийг нэг анхаараад, жоохон тавиу. Мэдээж Цэцийн шийдвэрийг авсан ч гэсэн 27 хоног иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ийм хуулийн төсөл санал авлаа, саналаа өгөөрэй гэдэг эсвэл яг мэргэжлийн холбоодоор нь хэлэлцүүлдэг ийм боломжийг бас дэгийн хуульд оруулж өгөөч ээ, оруулахад бас анхаарч өгөөч ээ гэдгийг би Хурлын даргаас хүсэж байгаа юм. Тэгээд мэдээж энэ дэгийн асуудлыг ажлын хэсэг гарах байх. Бас Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярбаатар даргад би бас хандаад энэ саналыг энэ цэцийн шийдвэрийг хүлээж авахтай холбоотой жоохон Улсын Их Хурлын ажиллах орон зай, тэр ажиллах орон зай нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаа мэдээлэлжүүлэх гээд байгаа, саналыг нь авах гээд байгаа энэ боломжийг олгож өгөх дэг дээр анхаарч өгөөч ээ л гэдэг санал хэлэх гэсэн юм. Тэгээд хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн гишүүд мэдээж Цэцийн тогтоол, шийдвэртэй бол танилцсан байх. Ялангуяа энэ Цэцийн шийдвэрийн үндэслэх хэсэг дээр бол нэлээн нарийн тодорхой шалгууруудыг заасан. Тэгээд яагаад одоо гэтэл яг энд Цэцийн дүгнэлт дээр заасан шалгуурыг бол бас тодорхой хэмжээгээр хангаж чадахгүй л энэ заалтууд бол орж ирлээ гэж бодож байна. Тийм учраас миний асуулт тийшийгээ чиглэнэ.

Тэгэхээр энэ Цэцийн хувьд үндсэндээ бол олон нийтийн мэдээлэл, татвар төлөгчийн мэдээллийг банкнаас аваад олон нийтэд зарлаж байгаа энэ нөхцөл байдал чинь өөрөө хууль ёсны байх, хүний халдашгүй байх эрхэд хэтэрхий бүдүүлгээр халдаад байна л гэдэг ийм дүгнэлтийг бол Үндсэн хуулийн цэц гаргасан.

Тэгээд үүнийгээ татварын байгууллага маш тодорхой заах ёстой гэж заасан. Хоног хугацаа нь ямар байх юм. Ямар хэмжээний татвар төлөөгүй бол ил болох юм. Ямар мэдээлэл нь ил болох юм. Ямар хүрээнд хязгаарлагдмал байх юм гэдгийг маш нарийн тодорхой заасан байх ёстой гэдэг. Тэгээд өөр болон бусад улс орны жишээ татаад энэ дүгнэлт дээр бол нэлээн тодорхой заалтууд байгаа шүү дээ. Гэтэл яг тэр шаардлагыг энэ заалт, хууль маань орж ирэхдээ бас хангасангүй орж ирлээ. Тэгээд бид нарт ч бас хангалттай мэдээлэл бас гишүүдийн хувьд бол дөнгөж сая ингээд л ширээ дээр тавиад л яг энэ асуудал хуулийн томъёолол нь орж ирж байгаа байхгүй юу. Хэрвээ хугацаа байвал мэдээж томъёолол дээр нь ажиллаад, нэг ийм асуудлыг ингэж оруулмаар байна гэдэг ийм саналыг бол тавих байлаа.

Тэгээд асуулт нь юу вэ гэвэл 10-аас доошгүй хоногийн өмнө гээд, энэ 10 хоногтоо тухайн татвар төлөгч тайлбараа өгөөгүй бол шууд мэдээллийг нь ил тод олгох юм уу. Энэ өгсөн тайлбар, мэдүүлэг нь өөрөө ямар тохиолдолд хангалттай гэж үзэх юм. Хэн хангалттай гэж үзэх юм. Тэгээд зөвхөн татварын албанд бүртгэлтэй шуудангийн хаяг, утас, цахим шуудангаар гэж байгаа байхгүй юу. Татварын алба ер нь утасны дугаараа авахад бол маш хүндрэлтэй байдаг шүү дээ. Буцаагаад утасдаад мэдээлэл өгөх гэхээр. Тэгэхээр яг ийм нарийвчилсан ийм процессын заалт энэ дээр чинь хэрэгтэй байна. Хүний үндсэн эрхийн зөрчил энд байгаад байна л гэдэг ийм Цэцийн дүгнэлт гараад байгаа. Тэгэхээр үүнд нь нийцүүлсэн байдлаар энэ хуулийн томъёоллыг илүү нарийвчлах боломж байна уу. Тэгээд холбогдох судалгаанууд нь байвал гишүүдэд бас хүргүүлж өгөөч ээ л гэж хүсэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Төсвийн байнгын хороог төлөөлж Заяабал гишүүн хариулт өгнө.

Б.Заяабал: Баасанжаргал гишүүний асуултад хариулт өгье. Хэрвээ Үндсэн хуулийн цэцэд Татварын ерөнхий хуультай холбоотой ийм 2 асуудлаар гомдол маргаан, мэдээлэл гаргасан байдаг. Одоо Улсын Их Хурлын гишүүн хийж байгаа Лодойсамбуу, мөн Эрхэмбаяр гэсэн ийм 2 иргэн бол мэдээлэл өгсөн байдаг.

Энэ дээр бол 2 асуудлыг хөндсөн байдаг. Нэг нь энэ 13.4 буюу татвар төлөгч Татварын хууль тогтоомжийг зөрчсөн. Зөрчлөө арилгаагүй удаа дараа бас энэ зөрчлөө давтсан, эрэн сурвалжлагдаж байгаа гэсэн ийм нөхцөлүүдийг хангасан бол татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлээд байна. Энэ нь хүний эрх халдашгүй байх эрхэд бас халдаж байна гэсэн ийм асуудал байгаа.

2 дахь нь таны ярьдаг саяын арилжааны банк, ББСБ, ХЗХ, бусад санхүүгийн эрх бүхий байгууллага, татварын алба нь хуулийн дагуу татварын албаны шаардсан мэдээллийг гаргаж өгөх ёстой. Энэ мэдээллийг бас энэ мэдээлэл гаргаж өгч байгаа, авч байгаа процесс нь өөрөө бас хүний эрхийг зөрчиж байна гэсэн ийм 2 асуудлаар тавьсан. Үүний тэр таны яг яриад байгаа арилжааны банк, банкны мэдээллүүдийг авч байгаа энэ асуудал нь бол Үндсэн хуульд нийцсэн байна. Хүний эрх зөрчөөгүй байна гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа.

2 дахь асуудал нь болох дээр татвар төлөгчийн гаргаж байгаа зөрчлөө удаа дараа гаргаж байгаа 1 буюу 3-аас дээш удаа зөрчил гаргасан, эрэн сурвалжлагдаж байгаа гэсэн энэ татвар төлөгчийн мэдээллийг нийтэд мэдээлж байгаа нь бол бас хүний эрхийг зөрчсөн байна гэж ингэж томъёолсон байгаа. Тэгээд үүнийхээ дагуу ингэж томъёолохдоо бол яг энэ нь агуулгын хувьд энэ бол зөрчил биш, гэхдээ энийг

хуульд нь өөрөө тодорхой зааж өгөөгүй учраас энэ нь зөрчил үүсэх хэмжээнд байна гэж ингэж Үндсэн хуулийн дүгнэлт гарсан. Ингээд Үндсэн хуулийн дүгнэлтийн үндэслэх хэсэгт байгаа 7 үндэслэх хэсгийг зааж өгсөн байдаг.

Зөрчил тодорхой байх ёстой гэдэг. Зөрчил нь ямар зөрчил вэ, ямар төрлийн зөрчил вэ гэдэг нь тодорхойгүй байна. Ямар мэдээллийг агуулах ёстой юм бэ?. Мэдээллийн хүрээ нь тодорхойгүй байна. Яаж нийтэд мэдээлэх вэ гэдэг нь бас тодорхойгүй байна. Урьдчилан тэр татвар төлөөгчид нь мэдэгдсэн байх ёстой гэдэг нь бас тодорхойгүй байна. Зөрчил арилгасан тохиолдолд мэдээллийг жагсаалтаас хасах эсэх, зөрчлөө арилгасан бол мэдээллийг хасах эсэх энэ асуудал нь бас тодорхойгүй байна. Хэн ямар албан тушаалтан нийтэд мэдээлэх юм бэ гэдэг нь бас тодорхой гаргаж өгөөгүй байна. Нийтэд яаж мэдээлэх вэ гэдэг асуудал нь бас тодорхойгүй байна гэсэн ийм 7 үндсэн асуудлаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт хэсэгтээ бол оруулж ирж өгсөн байгаа.

Тэгээд манай ажлын хэсэг яг энэ Үндсэн хуулийн гаргаж ирсэн энэ зөрчиж байна гэсэн энэ заалтыг Үндсэн хуулийн цэцийн гаргасан энэ 7 дүгнэлтийн хүрээнд хянан үзээд, энэ яг Үндсэн хуулийн цэцийн гаргаж ирсэн энэ 7 үндсэн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье. Гүйцээж хариулъя.

Б.Заяабал: Үндэслэх хэсгийн дагуу энийг бол тодорхой буруулж оруулж ирж өгсөн. ингэхдээ бид нар яг юуг нь голлосон бэ гэвэл өнөөдөр Татварын алба яг энэ заалтыг хэрэглэхдээ татвар төлөгчийг, бусад татвар төлөгчийг яг энэ санхүүгийн баримтыг хуурамчаар үйлдсэнтэй холбоотойгоор бусад татвар төлөгчдөд эрсдэл үүсгэх, татвар төлөгч хуурамч санхүүгийн баримтыг үүсгэж байгаа аж ахуйн нэгжүүд цаашдаа татварын харилцаанд орохдоо эрсдэл үүсэхээс нь хамгаалах үүднээс зөвхөн санхүүгийн баримтыг хуурамчаар үйлдэж байгаа гэдэг нь татварын систем дээр илэрсэн нөхцөлд хууль хяналтын байгууллагад мэдэгдээд, хууль хяналтын байгууллага тэрийг нь хүлээж авч шалгаж үзээд, энэ нь хууль зөрчсөн байна, Цаашдаа шалгах шаардлагатай байна гэж хэрэг үүсгээд, Татварын албанд мэдэгдсэний дагуу яг энэ цагдаагийн газраас ирсэн хууль хяналтын байгууллагаас ирсэн мэдэгдлийг үндэслэж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 54,2 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн. Тэгэхээр Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явагдахаар байгаа. Гишүүдийг танхимд урьж байна. 64 гишүүнээр санал дэмжигдэх учиртай. Тэгэхээр гишүүдийг бас ирцээ бүрдүүлж байх хооронд дараагийн асуудлыг хэлэлцэж байя. Дараачийн асуудалтай хамт санал хураалтыг хамт явуулъя.

Дараагийн асуудал. **“Засгийн газарт чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлж, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тогтоолын төсөлд нэмж тусган “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг тогтоолын төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Уянгахишиг гишүүнд баярлалаа. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. 3 гишүүний нэр ирсэн байна. Батын Батбаатар гишүүн асуулт асууж.

Б.Батбаатар: Асуултыг татаад авчихъя.

Д.Амарбаясгалан: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн алга байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Батлуулах тогтоолын төслийн хувилбарыг Төрийн байгуулалтын байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 63 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүддээ талархал дэвшүүлье.

18.25 цаг.

Хэлэлцэх асуудал 10. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

С.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 01/1009 тоот, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2113 тоот хүсэлт уламжлах тухай, Шүүхийн сахилгын хорооноос Хууль зүйн байнгын хороонд 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 01/40 тоот, 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 01/88 тоот хүсэлт Уламжлал тухай албан бичиг ирүүлснийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасныг баримтлан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр баталсан бөгөөд уг хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг Ерөнхий зөвлөл шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож, нэмэгдэл олгох журмыг батална гэж өөрчлөн найруулсан.

Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр “Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоох, олгох журам батлах тухай” 273 дугаар тогтоол, “Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай” 274 дүгээр тогтоолыг тус тус баталсан тул Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 4 дүгээр тогтоолыг хүчингүй болгох хэрэгцээ шаардлага үүссэн. Иймд хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Хууль зүйн байнгын хороо уг тогтоолын төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хэргийн ачаалал багатай нийслэлийн давж заалдах шатын шүүхийн шүүгчийн орон тоог нэмэгдүүлсэн үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат шүүгчдийн цалингийн нэмэгдлийн талаар болон докторын зэргийн нэмэгдлийн талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хэргийн ачаалал ихтэй эрүү, иргэний хэргийн анхан шатын шүүхийн шүүгчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагын талаар

болон нийт шүүгчийн цалингийн нэмэгдлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат шүүгчийн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан тогтоох, цалин хөлстэй холбоотой амьдралын баталгаагаар хангагдаж байх ёстой талаар саналаа хэлсэн болно.

“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Соронзонболд гишүүнд талархал дэвшүүлье. Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна.

Байнгын хорооны саналаар “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 55,7 хувиар санал дэмжигдлээ.

Гишүүдийн олонх дэмжсэн тул тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

18.30 цаг.

Дараагийн асуудалд оръё. **“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг уншиж танилцуулна. Индэрт урьж байна

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 01/1009 тоот, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2113 тоот хүсэлт уламжлах тухай, Шүүхийн сахилгын хорооноос Хууль зүйн байнгын хороонд 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 01/40 тоот, 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/88 тоот хүсэлт уламжлах тухай албан бичгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасныг баримтлан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 117 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг, мөн тогтоолын 4 дүгээр хавсралтаар Шүүхийн сахилгын хорооны дарга шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг, 5 дугаар хавсралтаар бүх шатны шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг тус тус тогтоосон.

Монгол Улсын Их Хурал 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Шүүх байгуулах тухай хуулийг шинэчлэн батлахдаа Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож, нэмэгдэл олгох журмыг батална гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр “Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоох, олгох журам батлах тухай” 273 дугаар тогтоол, “Шүүгчийн албан тушаалын цалин нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай” 274 дүгээр тогтоолыг тус тус баталсан байна.

Иймд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.10, 95 дугаар зүйлийн 95.10 дахь хэсэгт нийцүүлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга шүүгч бус гишүүн, Сахилгын хорооны дарга шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг тогтоосон Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоол, түүний 3, 4 дүгээр хавсралтад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах, 5 дугаар хавсралтыг хүчингүй болгох хэрэгцээ шаардлага үүслээ.

Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцсэн уг тогтоолын төсөлд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны дарга шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээтэй уялдуулан шинэчлэн тогтоохоор, мөн бүх шатын шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгох зохицуулалтыг тусгасан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг тогтоолын төслийн хүчин төгөлдөр болох хугацааны талаар, мөн Шүүгчийн докторын зэргийн нэмэгдлийг 20 хувиар тооцож боловсруулан үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал тогтоолын төсөлд тусгасан цалингийн хэмжээг тоогоор тогтоохоос илүү дүйцүүлэх албан тушаалын нэрийг тодорхой зааж өгөх зарчмын хувьд зөв талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Шүүгчийн цалингийн нэмэгдлийн хувь, хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат шүүгчийн цалинг инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлж байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар цалингийн асуудлыг тоон дүнгээр биш дүйцүүлэх байдлаар уян хатан тогтоох шаардлагын талаар асуулт асууж, хариулт авч, үг хэлсэн болно.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналын томъёоллыг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүгдэд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүгдээсээ хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгье. Алга байна.

Одоо Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

18.35 цаг.

Дараагийн асуудалд оръё. **“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын тайланг Монголбанкны дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Энхтайван: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3 дугаар заалтын дагуу Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барьж байна.

Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

1.2024 онд сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2 тэрбум төгрөгийг түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлс, байгалийн төр заалт худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, археологи, түүх судалгааны байгууллагатай хамтран ажиллахад зарцуулахаар төсөвлөсөн билээ. Эрдэнэсийн санд 2024 онд нийт 7 иргэнээс эд зүйл худалдах тухай өргөдөл ирүүлсэн бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар эдгээр эд зүйлс нь Монголбанкны Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг баяжуулахад тавигдах үндсэн шаардлагыг хангахгүй тул худалдан авах боломжгүй гэж шийдвэрлэсэн бөгөөд иймд төсвийн гүйцэтгэл 0 төгрөг байна.

2.2024 онд Эрдэнэсийн сангийн үндсэн санд орлогоор бүртгэсэн чингис хааны алтадсан хүрэл баримлын холбогдох зардлын төсөв 1,5 тэрбум төгрөгөөр батлагдсан. Их эзэн Чингис хааны хүрэл баримлын ажлын гүйцэтгэл 747,4 сая төгрөгтэй байна.

3.Монголбанк нийт 100 ширхэг дурсгалын зоосны дээж үндсэн санд орлогод авахаар төсөвлөснөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 116 ширхгийн гүйцэтгэлтэй байна.

4.Эрдэнэсийн сангийн 2024 оны төсвийн 1.4-1.7-д заасан 2018 оны 5 мянган төгрөгийн загвар 2 ширхэг, 1938 оны 2 төгрөг 50 мөнгөний вексель 1 ширхэг, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Банкны мөнгөний чек 1 ширхэг, 20 мянгатын мөнгөний мөнгөн тэмдэгтийн хэв 1 ширхгийг үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэгдсэн билээ.

5.Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангаас 24550 ширхэг дурсгалын зоос болон алтан, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө зарлагдахаар тусгагдсанаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зочин төлөөлөгчийн зардлаар 200 ширхэг дурсгалын зоос, 5840 ширхэг дурсгалын зоос, алтан, мөнгөн гулдмай, мөнгөн үрлийг худалдаалсан байна.

6.Үзэсгэлэн зохион байгуулах ажлын хүрээнд 2024 онд төсөвт 2,9 тэрбум төгрөг төсөвлөснөөс Монголбанк Чингис хаан музейтэй байгуулсан 0523244 тоот Чингис Хаан музейд үзэсгэлэн зохион байгуулахад хамтран ажиллах гэрээний дагуу Чингис Хаан Үндэсний музейн 9 давхрын хүндэтгэлийн өргөөнд дэглэм байршуулах засварын ажилд 2,3 тэрбум төгрөг зарцуулсан.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

2025 оны Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн гүйлгээ сангийн орлого, зарлагын төсвийн төслийг та бүхэнд танилцуулъя.

Монголбанкнаас эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг 2025 онд дараах байдлаар нэмэгдүүлж, үндсэн санд орлогоор бүртгэхээр төлөвлөж байна.

1.Үндсэн сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхээр түүх, соёлын дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, сэргээн засварлалт, байгалийн төр заалт худалдан авах, археологи, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллахад 2 тэрбум төгрөг зарцуулах.

2.Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээжийг орлогод бүртгэх.

3.1945 оны зоосон мөнгө 2000 ширхгийг Эрдэнэсийн сангийн тэнцлийн гадуурх данснаас үндсэн санд орлогоор бүртгэх.

4.Монголбанкны хүндэт банкер жижиг тэмдэг хайрцаг нийт 3 ширхгийг тэнцлийн гадуурх данснаас үндсэн сангийн байнгын бус хэсэгт бүртгэх болно.

Мөн 2025 онд үйлдвэрлэгдэх дурсгалын зоос болон бусад эд зүйлийг гүйлгээ санд орлогоор бүртгэнэ. Гүйлгээ сангаас 24500 ширхэг дурсгалын зоос болон гулдмай, үрлэн мөнгө зарлагдахаар тусгаснаас худалдах зориулалтаар 24300 ширхгийг, зочин төлөөлөгчийн зардлаар 200 ширхэг, мөнгө, зэс дурсгалын зоост зарцуулахаар тусгалаа.

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8-д сэргээн засварлах, арчлах гэж заасны дагуу Чингис хааны алтадсан хүрэл баримал болон Эрдэнэсийн сангийн хөмрөг дэх эд зүйлсийн арчилгаанд 200 сая төгрөг зарцуулахаар төсөвлөж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хорооны хурлаар Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны төсвийн тайлан, 2025 оны төсвийн төслийг өргөн барьсан бөгөөд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2025 оны төсвийн төслийг хэлэлцэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг болон Монголбанкнаас ирүүлсэн саналыг тус тус үндэслэн “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо боловсруулж, уг тогтоолын төслийг 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Эрдэнэсийн сангийн музейн үйл ажиллагааны хадгалалт, хамгаалалт, баяжуулалт, орлого, зарлагын байдал, хөндлөнгийн аудитын дүгнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний асуудлын талаар, Монголбанк банкны салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай байгаа талаар, Монголбанканд ажиллаж байгаа албан хаагчдын ёс зүйн талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Монголбанк Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг баяжуулах зорилгоор 2024 онд хосгүй үнэт зүйл худалдан авсан эсэх талаар, Бэлэн мөнгөний заавал байлгах нөөц нэмэгдсэнтэй холбогдуулан банкны салбарын хөрвөх чадварт хэрхэн нөлөөлөх талаар, зээлийн хүүд үзүүлэх нөлөөллийн талаар, ОХУ-аас нийлүүлэх цахилгаан, нефтийн бүтээгдэхүүний импортын төлбөр тооцооны талаар, Инфляц, үнийн өөрчлөлтийн талаар, Банкнуудын бизнесийн зээлийн өсөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэлд аудит хийсэн эсэх талаар, тайланд тусгагдсан Чингис хаан баримлын зардал уг баримлын жижгэрүүлсэн хувилбар болон төсвийн талаар, мөн 2025 оны төсвийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн талаар, мөн түүнчлэн Эрдэнэсийн сангийн үзэсгэлэн зохион байгуулах зардлын талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Тогтоолын төслийг хэлэлцэж санал хураахад гишүүдээс тодорхой санал гараагүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг дэмжиж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэгт заасныг баримтлан чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол банкнаас ирүүлсэн санал болон тус саналыг үндэслэн Байнгын хорооноос Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Соронзонболд гишүүнд талархал дэвшүүлье. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар Эрдэнэсийн сангийн танилцуулгыг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд Монголбанкны Ерөнхийлөгч танилцуулна гэсэн дэгийн хуулийн заалттай. Тэгээд өнөөдөр Улсын Их Хурлаар Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүд сонгогдсон учраас тэр ажил хүлээлцэхтэй холбоотой асуудал үүсээд Монголбанкны Ерөнхийлөгч ирж чадаагүй. Монголбанкны тухай хуулиараа дэд ерөнхийлөгч орлох чиг үүрэгтэй учраас Энхтайван дэд ерөнхийлөгч ирж, асуудал танилцуулж байгаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ганболдын Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Түмэнжаргалын Тэлмэн Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Эрсдэлийн сангийн ахлах эдийн засагч.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна. Монголбанкны Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Гишүүд суудлаа эзэлье. Санал хураалт явагдана.

“Монгол банкны эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийнхэнд талархал дэвшүүлье.

18.47 цаг.

Дараагийн асуудалд орёе. **Хархорум хотын бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 1 дүгээр захирамжаар дээрх тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгээр ахлуулж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заяабал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-Parliament.mn цахим системээр дамжуулан олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан санал авахад нэр бүхий иргэдээс 30 санал ирүүлснийг ажлын хэсэгт танилцуулсан болно.

Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн үед гишүүдийн асуулт, санал, Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал, хууль зүйн дүгнэлтийн хүрээнд Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан 55 зарчмын зөрүүтэй санал, 2 найруулгын санал, хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан 3 зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэн Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан болно.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллын үндэслэл, шаардлага, хамрах хүрээ, хуулийн төслийн нэршилд хот төлөвлөлтийн агуулгыг нэмэх, зорилго, зарчмыг тодруулах, суурь шинжтэй үндсэн зарчмыг эрэмбэлэн тусгах, Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон Хот байгуулалтын тухай хуулийн зохицуулалттай хуулийн төслийн зарим хэсгийг нийцүүлэх, Хотын зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд хотын удирдлагыг хэрэгжүүлэх зөвлөл, захирагчийг Засгийн газар томилох, чөлөөлөх зохицуулалтад өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын хэлбэр нь Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгагдсан байгаа тул тухайн хуулиар зохицуулах татварын болон татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг орон нутгийн дэмжлэгийн хэсгийг төслөөс хасах, хуулийн үйлчлэх хугацааг тухайн хотын оршин суугчийн тоо 10 мянгад хүрч, хуулийн дагуу хотын зөвлөл, захирагч сонгогдох хүртэл хугацаанд үйлчлэх зэргийг хамарсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Ж.Бат-Эрдэнэ нар ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын талаар асуулт асууж, саналаа илэрхийлсэн болно.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан 58 зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулсан бөгөөд ажлын хэсэг Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуулиудад нэмэлт оруулах, мөн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх үед боловсруулж, хэлэлцүүлэх талаар санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжсэн болно.

Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хархорин хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцууллаа. Сандаг-Очир гишүүнд талархал дэвшүүлье. Ажлын хэсгийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Батаагийн Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт, Сумъяасүрэнгийн Энхжаргал Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын Хуулийн мэргэжилтэн, Нэргүйн Нацагдорж Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Баасанхүүгийн Энхсайхан Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх, Гомбосүрэнгийн Дарханчулуун Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Ганболдын Хосбаяр Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга, Баярсайханы Амарсанаа Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, Мягмаржавын Отгонбат Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Мэдээлэл, харилцаа холбооны инженер, Мөнхуягийн Мөнх-Эрдэнэ Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хуулийн мэргэжилтэн.

Ингээд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд асуулт асууж, хариулт авна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Ажлын хэсэгт орж ажиллаад 2, 3 хоног бараг шөнө 12 хүртэл ажилласан. Та бүхний өргөсөн хуулийн төсөл дээр мэргэжлийн хүний хувьд бол маш чухал заалтуудыг өөрчилж, засья, хотыг байгуулах гэж байгаа бол бодитой байя гэдэг саналуудыг маш олон гаргаж өгсөн.

Зарим дээр нь санал нийлсэн, зарим дээр нь зөрчилдсөн байх. Яг нэг зүйлийг л ойлгох хэрэгтэй байгаад байгаа. Төр дангаараа хот байгуулах боломжгүй, ямар ч боломжгүй. Хотын хөгжлийн төлөвлөгөө зохиоходоо жоохон бодитой байх ёстой. Хятад, Солонгос, Индонез гээд хотуудыг ингээд жишээ болгож авч байгаад Шинэ Хархорум байгуулна гээд бараг 180 мянган га газар дээр 2, 3 мянган талбай дээр байшин барина. Барилга байгууламж барина гээд ороод ирсэн. Өмнө нь бас хэлэлцэх эсэх дээр би асууж байсан. Тэгээд тодорхой хариулт авч чадаагүй. Хувийн хэвшил байхгүй энэ хотыг байгуулж чадахгүй ээ. Бид нар бариад, бариад 10 жилд 100 га-г л барилгажуулж чадна. 2, 3 мянга бол бүтэшгүй тоо. Би асууж байсан. Яармаг бол ингээд тод жишээ. 10 гаруй жилийн дотор хувийн хэвшил босгосон тэр хэсгийг. Шинэ Хархорум хотын хуулийн төслөө хэлэлцэхдээ хувийн хэвшилтэйгээ ярилцсан уу. Худалдаа Аж Үйлдвэрийн танхимтай ярилцсан уу. Монголын барилгын компаниуд үйлдвэрлэгч нартай ярилцсан уу. Та бүхний хөрөнгө оруулалтыг авъя гэсэн тийм бодитой зүйл хэрэгжсэн үү. Ярилцсан уу гэдэг зүйлийг асуумаар байна.

2 дахь асуулт нь болохоор олон улсын уралдаан зарлаад 36 гадаад, дотоодод ийм баг орж ирээд, маш олон концепт, үзэл баримтлал загвар зургуудыг гаргаж өгсөн. Сарын өмнө бас би энийгээ асуусан. Хариултаа авч чадаагүй байгаад байгаа юм. Уг нь ингээд төсвийн хөрөнгө мөнгө зарцуулаад ч байдаг юм уу, гаднын ийм том туршлагатай багийг урьж оролцуулаад уралдаан зарласан. Тэрнийхээ тайланг гаргах ёстой. Тэндээсээ бид нар гаднын туршлагыг суралцаад, юу нь хэрэгтэй, юу нь хэрэггүй гэдгийгээ тусгаад явах ёстой. Гаднын оруулж ирсэн энэ мундаг туршлагатай хүмүүсийн оруулж ирж байгаа юмыг манай үндэснийхэн уг нь хийж чадна. Тэр дээрээсээ суралцах л хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Тэр дээрээсээ юуг суралцаад, энэ хуулийн төсөл дээр оруулж ирсэн юм бэ. Ийм 2 дахь асуулт байна.

3 дахь асуулт. Би хэлсэн анх үнэхээр бодитоор энэ хотыг байгуулахыг дэмжээд байна. Гол нь зөв мэргэжлийн зарчимтай байх ёстой гэж хэлсэн. Хаан шиг эрх мэдэл олгох гээд байна гэж хэлсэн. Тэрийг нь би сая энэ ажлын хэсэг дээр ороод засаж өгсөн. Тэгсэн чинь нэг өмнө нь Улсын Их Хурлын гишүүн байсан гэдэг хүн ерөөнд орж ирээд, чи ийм юм ярьж болохгүй гээд загнаад гараад явж байгаа байхгүй юу. Би мэргэжлийн зарчимтай ажиллах гэж Их Хурлын гишүүн болсон. Тиймээрээ л ажиллаж байгаа. Эхний 2 асуултдаа хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Хэн хариулт өгөх вэ. Учрал сайд хаана байна. Байнгын хороо, ажлын хэсэг хариулт өгөх үү. Тэмүүлэн гишүүн хариулт өгөх үү. Лувсанжамц гишүүний асуултад.

Тэгээд энэ Улсын Их Хурлын гишүүний хараат бусаар ажиллах асуудалд хэн нөлөөлж байна. Ганзориг гишүүн энэтэй холбоотой асуудлаа Улсын Их Хурлын Тамгын газарт хандаарай. Энэ чинь Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлж ажиллаж байхад хөндлөнгөөс дарамт шахалт үзүүлж байгаа бол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын асуудал хөндөгдөнө. Зохисгүй. Өнөөдөр бас энэ Улсын Их Хурлын гишүүдэд цаас тараачихсан. Байнгын хороо, ажлын хэсэг дээр

унасан саналыг бас янз янзын байдалд оруулах гээд явж байгаа сураг сонсогдсон. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэг, Байнгын хорооны түвшинд шийдчихсэн асуудлын араас элдэв янзын лобби хийж явдаг байдал байж болохгүй. Энэ дээр ямар ч хуулийн төсөл хэлэлцэж байгаа үйл явц дээр анхаарч байх ёстой шүү. Бид удаа дараа мэдэгдэж байгаа шүү дээ. Янз бүрийн лоббины шинж чанартай хууль энэ Улсын Их Хурлын босгыг давахгүй шүү гэдгийг байнга хэлж байгаа. Энд тэнд гишүүдийг аваачиж хоол унданд оруулаад л, худлаа, үнэн мэдээллээр хангаад л, янз янзын хуулийн төсөл өргөн барьчхаад, тэрийгээ авч гарах гэж ажилладаг ийм байдлыг бол цаашид явуулж болохгүй. Энэ хуулийн төсөлтэй холбож хэлж байгаа юм биш шүү. Зарим хуулийн төсөл дээр тийм мэдээллүүд ирж байгаа учраас би хэлж байгаа юм. Ганзоригийн Тэмүүлэн ажлын хэсгийн дарга хариулт өгье.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Тэгээд Улсын Их Хуралд Засгийн газраас 12 сард Хархорин хотын бүтээн байгуулалтыг дэмжих тухай хуулийн төслийг өргөн барьсан. Ингээд Улсын Их Хурлын даргын захирамжаар бас сая сүүлийн 10 гаруй хоногийн хугацаанд, 27 хоногийн хугацаанд ажлын хэсэг бас ажиллалаа. Бид бүхний хувьд бас энэ гол Монгол Улсын түүхэн нийслэл болсон Хархорин хотыг бүтээн байгуулах, түүнд шаардлагатай байгаа эрх зүйн орчныг бүрдүүлэх гол суурь асуудал бол байгаад байгаа. Энэ хүрээндээ бид бүхний хувьд сая энэ өнгөрсөн 10 хоногийн хугацаанд үндсэндээ бас одоогийн эрх зүйн орчин дээр, тэр дундаа Хот байгуулалтын тухай хууль дээр, Хот, тосгоны тухай хуулиуд дээр, мөн холбогдох Газрын тухай хууль болон бусад хуулиуд дээр бас дутагдалтай байгаа зүйл, заалтуудыг хотыг төлөвлөхтэй холбоотой эрх зүйн орчинд хэрэгтэй байгаа зохицуулалтуудыг бас нэмж тусгаж бас оруулж өгсөн байгаад байгаа.

Нөгөө талдаа бас онцолж хэлэхэд үндсэндээ өргөн баригдсан хууль дээрээс эдгээр хуулиудтай нийцүүлэх зайлшгүй шаардлагууд бол байсан. Тодорхой хэмжээнд давтсан байдлаар тухайн хуулиуд дээр зохицуулагдсан байсан харилцаануудыг хасаж, ингээд үндсэндээ энэ хууль дээрээ бас хэрэгцээтэй байгаа гол зохицуулалтуудыг бол хийж өгсөн гэдэг зүйлийг хэлэх байна.

Манай Лувсанжамц гишүүн маань бол энэ ажлын хэсэгт ажиллаж гол саяын тэр хотын үндсэн үзэл баримтлал, концепц болон төлөвлөлттэй холбоотой суурь зарчмуудыг бас үндсэндээ шинээр оруулж өгсөн. Тэгэхээр энэ бол үндсэндээ манай Хот байгуулалтын тухай хууль болон Хот, тосгоны тухай хууль дээр байхгүй ийм шинэ практик, шинэ зохицуулалтууд бас хуульчлагдсанаараа онцлогтой ийм хууль болж байна гэж бас харж байгаа. Үндсэндээ одоо байгаа хуулийн хүрээнд бид нар бас нэгдсэн байдлаар энэ хотыг төлөвлөдөг, дээрээс нь тэр төлөвлөлтийнхөө дагуу хэсэгчилсэн байдлаар дараагийн холбогдох баримт бичгүүдээ боловсруулж гаргадаг, түүндээ нийцүүлсэн үндсэн суурь бодлогынхоо баримт бичигтэй нийцүүлж, дараа дараагийнхаа тэр барилгажилтын төсөл байна уу, тухайн жилийнх нь газар зохиолтын төлөвлөгөө байна уу, энэ болгоныгоо нийцүүлдэггүй байсан зүйл маань бол өнөөдөр Улаанбаатар хот дээр алдаа болж гарч ирсэн. Тэгэхээр бид нар нэг талдаа шулуухан хэлэхэд Улаанбаатар хотод бий болж байсан алдаа дутагдлуудыг залруулах энэ бодлогын зохицуулалтыг төлөвлөлтийнхөө хүрээнд бол бий болгож өгснөөр онцлогтой гэж хэлэх байна.

Энэ хүрээ хэн ч гэсэн манай Лувсанжамц гишүүн бас яг өөрийнхөө мэргэжлийн хүний хувьд хэрэгцээтэй гол чухал зохицуулалт, заалтуудыг бас оруулж өгсөн. Бид нар ч гэсэн ажлын хэсгийн хүрээнд бас ярьсан. Ер нь бол цаашдаа үндсэндээ 189 мянган га газрыг хотын төлөвлөлтөд авч байна. Энэ хүрээндээ бол одоо нэг талдаа

яг суурь бодлогын баримт бичиг буюу концепц төлөвлөлт нь албан ёсоор гараагүй байгаад байгаа учраас суурь ерөнхийдөө хязгаарлалт хийж ингээд ямар нэг байдлаар газрын ил болон далд наймаанууд явагдахаас сэргийлсэн энэ тусгай хамгаалалтад авах зохицуулалтуудыг хийж байгаагаараа онцлогтой.

Харин цаашдаа яг энэ хотынх нь төлөвлөлт нь бодлогын баримт бичгүүд нь зураг төсвүүд нь батлагдсаны дараагаас бид нар хэсэгчлээд чөлөөлөөд явах үндсэн суурь төлөвлөлтөө бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгэхээр Хархорин хотыг сэргээн байгуулах, бүтээн байгуулах асуудал орж ирж байгаа явдалд бол хувь хүний хувьд, гишүүний хувьд баяртай байгаа юм. Тэгэхээр манай Монгол Улс бол хот байгуулах туршлага ихтэй, түүхэн аспект талаар нь аваад үзсэн ч гэсэн ер нь сүүлийн 60 гаруй жилийнхээ түүхэнд 2 хот байгуулчихсан ийм улс байгаа юм. Энэ дэлхийд бас тийм элбэг биш байх. Тэгээд одоо 3 дахь хотоо 21 дүгээр зуунд байгуулах гэж байгаа явдал бол зүгээр нэг цаасан дээр явж байгаа ажил биш гэж ингэж ойлгож байгаа юм. Тэгэхээр энэ хуулийг оруулж ирэхийн өмнө өмнөх Их Хурал ажлын хэсэг байгуулж байсан. Тогтохсүрэн даргатай ажлын хэсэг бол 2 жил гаруй ажиллаад, энэ ажлын хэсгийн ажил нэлээн маргаан дагуулсан саатсан ажил бол хаана байгуулах вэ, хилийн цэсийг нь яаж тогтоох вэ гэдэг асуудал байсан. Тэгээд энэ дээр Орхоны хөндийн дэлхийн өвд бүртгэгдсэн газар дээр байгуулах талаар нэлээн хүчтэй лобби явсан боловч ажлын хэсэг бас зөв шийдвэр гаргаж, өнөөгийн энэ 189,3 мянган га газрыг бол тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг бас тийм тэмдэглэн хэлэх нь зүйтэй байгаа юм.

Хуулийн төсөлтэй танилцлаа. Тэгээд боловсруулж ирсэн материал нэг л гологдоод л байх юм. Би яагаад ингэж хэлж байна вэ гэхээр энэ хуулийн үзэл баримтлал гэдэг хэсэг дээр та бүхэн үзээрэй дээ. Энэ хууль 7 бүлэгтэй байна гээд бүлэг болгоны товч агуулга байж байгаа. Танилцуулга дээр товч болоод дэлгэрэнгүй 2 танилцуулга дээр энэ хууль маань 8 бүлэгтэй байна гээд ингээд танилцуулаад байгаа юм. Тэгээд энэ чинь бид нарт худлаа танилцуулга өгч байгаа юм уу. Хууль 8 бүлэгтэй байхыг үзэл баримтлалаас зөрүүлээд хийчихсэн юм уу гээд гайхаад, хуулийн төслийг нь аваад үзэхээр 7 бүлгээр хийчихсэн байгаад байгаа юм. Тэгэхээр яаруу сандруу, хам хум хандсан ийм байдал ингээд харагдаад байгаа юм. Тэр хуулийн заалтуудаар ч гэсэн иймэрхүү юм бол бас нэлээн байгаа. Ганцхан жишээ хэлье. Бичлэг найрлагыг бол аваад л үзэхэд тэр 4 дүгээр зүйлийн 4.1.13 гэдэг заалт байгаа юм. Олон төрөлт нийтийн тээвэр, явган алхалт, унадаг дугуй зэрэг цахилгаан хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг дэмжсэн байна гээд байгаа юм. Тэгэхээр энэ чинь олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нь цахилгаан хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл гэж ойлгогдож байгаа. Явган алхалт нь бас цахилгаан хөдөлгүүр тээврийн хэрэгсэл гэж ойлгогдоно. Унадаг дугуй гэдэг нь бас тэгж ойлгогдоно. Тэгэхээр ийм ойлгомжгүй томъёололтой зүйл заалт бас байж мэднэ. Зүгээр ингээд миний уншихад л энэ харагдаад байгаа. Тэгээд энийгээ дэлгэрэнгүй танилцуулах дээрээ бүр тэгэхээс тэг гэсэн юм шиг 2 дахиад давтаад оруулчихсан байгаа. Та бүхэн сайн үзээрэй. Өөр ийм заалтууд бий. Тэр болгоныг дурдаад яах вэ. Зүгээр жишээлбэл энэ хот төлөвлөлт, бүтээн байгуулалт гээд 2 дугаар бүлэг байж байгаа юм. Энэ 2 дугаар бүлэгтээ 8.1.3 дээр 1 га газар олгоно. Тэр орон сууцнаас бусад нийтийн орон сууцаас бусад тохиолдолд. 8.1.4 дээрээ бас энэнтэй

холбоотой 0.2 га-аас багагүй байна гэсэн заалттай. Танилцуулга дээрээ энэ 1 га, 1,5 га, энэ 0.2 га нь 0,5 га танилцуулга дээрээ яваад байгаа юм. Тэгэхээр дахиад л энэ танилцуулга гэдэг юмаа Их Хурлын гишүүдэд худлаа танилцуулга өгч байгаа юм уу, үгүй юу гэж ингэж энийг асуумаар байгаа юм.

Тэгээд цааш нь жаахан явбал энэ зарим хуулийн заалт нь төгс биш, дутуу орхичихсон юм их байгаа юм. Өмнөх практик дээрээ үндэслээд хийвэл зөв хийчихмээр юм байгаад байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Рэгдэл гишүүний 1 минутыг нэмж өгье.

Д.Рэгдэл: 16.1 дээр хотын захирагчийг нийт иргэд сонгоно гэхээд Ерөнхий сайд батламжилна гэж байгаа юм. Тэгээд цааш нь уг нь энэ хуулийнхаа баримталдаг уламжлалаараа Ерөнхий сайд батламжлахгүй тохиолдолд яах вэ гэдэг ийм заалт бол заавал байх ёстой. Энэ зарим юман дээр Ерөнхий сайд батламжлахгүй явчихсан. Зарим юман дээр Ерөнхийлөгч батламжлахгүй өнгөрчихсөн амьд тохиолдол би л лав амьдрал дээрээ 1, 2-ын зэргийг үзсэн. Ингээд зохицуулалт байхгүй бол болдоггүй. Дандаа Ерөнхий сайдад сонгосон даргаа батлаад байхгүй бол яах вэ. Эсвэл зүгээр соёрхон батална гэх юм уу гэх мэтчилний юмнуудыг бас нэг оруулж өгвөл зүгээр байгаа юм.

Тэгээд дараагийн нэг асуудал бол ингээд үйл явцыг хараад байхад бол Ерөнхийлөгч Хархорин хотод Ерөнхий сайд Төв аймгийн нутаг дэвсгэрт Ломботын хөндийд, Улсын Их Хурлын дарга.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн хариулт өгье.

Г.Тэмүүлэн: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Рэгдэл гишүүний сая асууж байгаа асуултууд бол яг цэвэр Засгийн газраас өргөн баригдсан, бид бүхний нөгөө хэлэлцэх эсэх хийхэд яригдаж байсан гол хуулийн төсөл дээр ярьж саяын саналуудыг хэлж байна. Ингээд сая Засгийн газрын таны сая шүүмжилж хэлж байсан тэр заалттай тэр хуулийн төсөл дээр сая ажлын хэсэг бол үндсэндээ 2 7 хоногийн хугацаанд ажиллаад, бид нар бас сая суурь голлох техникийн болон найруулгын шинж чанартай, алдаатай, мөн бусад хуулиуд дээр зохицуулагдсан энэ харилцаануудыг бас нэлээн хасаж янзалж, найруулгын өөрчлөлтүүдийг хийж ингэсэн байгаа. Үндсэндээ ингээд Улсын Их Хурлаар та бүхнээр бас дэмжүүлэхээр орж ирж байгаа зарчмын зөрүүтэй нийтдээ 58 санал бас орж ирсэн. Үүний нэг нь таны бас яг хэлж байгаа хотын бүтээн байгуулах, хөгжлийг дэмжихэд баримтлах суурь зарчимтай холбоотой асуудлууд байгаа. Тэр дээр яг л яалт ч үгүй л саяын тэр нийтийн тээвэртэй холбоотой, тэдгээрийн юу гэдэг юм тээврийн суурь зарчмуудыг заасан гэдэг юм уу, тэдгээрийн дэд бүтэцтэй холбоотой зарчмыг тусгасан байсан юм. Энэ асуудлуудыг бол бид нар ерөнхийдөө нийт 14 ийм суурь зарчим орж ирснийг нь гол давтсан болон онцын шаардлагагүй бусад хуулиудад зохицуулагдсан байгаад байгаа заалтуудыг бол үндсэндээ хот төлөвлөх болон бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд баримтлах 10 зарчим болгож оруулж ирсэн. Саяын тэр дэд бүтэцтэй холбоотой асуудлыг жишээ нь ингэж оруулж ирсэн байгаа. Дэвшилтэт технологи, инновацад суурилсан, ухаалаг дэд бүтцийг хөгжүүлэх, мөн дээрээс нь тусдаа 1 заалтаар бол хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, оршин суугчийн нийтлэг эрх ашиг, сонирхолд нийцсэн,

нийгмийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, олон төвт хотын тогтолцоог хөгжүүлэх гэдэг юм уу энэ зохицуулалтуудыг бас нэлээн оруулж өгсөн байгаа юм.

Мөн сая ерөнхийдөө бас энэ Хархорин хот дээр бол бид бүхний хувьд онцолж үзэх ёстой зүйл бол нэг талдаа энэ хот илүү бас түүхэн өв соёл, энэ бол нэг талдаа бас Монголчуудын хувьд түүх нийслэл. Тэгэхээр бид нар энэ түүх нийслэлээ сэргээх гэдэг асуудал маань бас үндсэн гол суурь зарчмын асуудал, түүн дээрээ суурилж бид бүхний хувьд бас энэ аялал жуулчлалыг хөгжүүлэх, түүнд суурилсан эдийн засгийг хөгжүүлэх, бий болгох, дэд бүтцийг бий болгох ийм боломж бололцоо байна гэж үзэж энэ дээр гол онцлох фокусуудыг хийсэн.

Таны хувьд бас түрүүн онцолж асуусан зүйл бол ерөөсөө энэ түүх өв соёлыг хадгалах сэргээн засварлах ажил бол зайлшгүй номер нэг байх ёстой асуудлууд байгаад байгаа юм. Бид нар илүү хот байгуулах гэхээсээ илүүтэй 1 дүгээрт тэр газар нутаг дээр байгаа, тэр газрын доор байгаа тэр түүх, өв соёлын археологийн өв соёлуудыг хадгалж хамгаалж авч үлдэх, сэргээх нь бол бид нарын 1 дүгээр асуудал байгаад байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг бас хуульд тусгайлан энэ өвийг сэргээх, эдгээрийг хадгалж хамгаалах зохицуулалтууд бол нэг талдаа бас орж ирсэн гэдэг зүйлийг бас танд онцолж хэлэх байна.д

Дараагийнх нь төлөвлөлттэй холбоотойгоор .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Мөн хот төлөвлөлтөд тавигдах шаардлага гэдэг зүйл бол бас энэ хууль дээр орж ирж байгаа. Бид бүхний хувьд ерөнхийдөө бас л энэ одоогийн өнөөгийн Улаанбаатар хотод алдсан, оносон зүйлүүд, тэр дундаа бас хүнд ээлгүй, нөгөө талдаа илүү бас нийгмийн харилцааг зохицуулах боломжгүйгээр төлөвлөлттэйгөөр хийгдсэн энэ алдаа дутагдлуудыг залруулж, зохицуулалтуудыг хийсэн. Энэ хүрээндээ гол саяын таны тэр хэлж байгаа нөгөө төлөвлөх газрын доод хэмжээ 1 га газар байх гэдэг асуудлыг Засгийн газраас оруулж ирсэн юм. Энэ ямар нэг байдлаар газар олгоно гэсэн асуудал биш. Ерөөсөө хотыг төлөвлөхдөө газрыг нэгдсэн том байдлаар нь төлөвлөлтийг хийж, эргээд тэр юу гэдэг юм нийтийн орон сууцын зориулалтаар ашиглах тохиолдолд, томоороо төлөвлөлттэйгөөр хийгдэж, тэндээ хэрэгцээтэй байгаа сургууль, цэцэрлэг, соёлынх нь зохицуулалтууд нь цуг төлөвлөчихсөн байх ёстой л гэдэг ийм ерөнхий төлөвлөлт байдалтайгаар орж ирснийг бид нар бас зарчмын зөрүүтэй саналын хүрээнд тодорхой өөрчлөлтүүдийг бас оруулж тусгаж хийж өгсөн байгаа гэдгийг бас хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн тодруулж асуух юм уу. Хосбаяр гишүүн хурууныхаа хээг уншуулчхаарай. Нэр чинь гарахгүй байна.

Г.Хосбаяр: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Ажлын хэсэгт орж ажилласан. 2 асуудлыг л яриад байгаа юм.

1 дүгээрт нь бид нар энэ Хархорин хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль гээд улсын зэрэглэлтэй хотын асуудал, улсын зэрэглэлтэй хот бүтээн босгох тухай ийм хуулийн төсөл ярьж байгаа. Гэтэл Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар одоо тэнд байгаа 10 гаруй мянган хүн амтай Хархорин сум маань орон нутгийн зэрэглэлтэй ийм хот болно. Хот болно. Тэгэхээр зэрэг хоорондоо 8км зайтай улсын зэрэглэлтэй 1 хот, мөн орон нутгийн зэрэглэлтэй 1 хот ингээд бий

болох гээд байна. Нэр томъёоны хувьд ч ойрхон. Одоо ингээд хуучин орон нутгийн зэрэглэлтэй Хархорин хот, мөн улсын зэрэглэлтэй шинэ Хархорум хот гээд. Тэгэхээр энэ дээр нэгдсэн ойлголтод хүрч, энэ 2 хотоо нэгтгэх юм уу. Ер нь нэр томъёоны хувьд ямар байх юм. Тэнд оршин суугаа уугуул иргэдийн эрх ашиг оролцоог яаж хангах юм гээд олон асуудлууд байгаа. Тийм учраас энэ нэр томъёоны асуудлаа нэг тийш нь цэгцэлмээр байгаа юм.

2 дугаарт нь энэ хотын бүтээн босголтын 70 хувийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт оролцоогоор бүтээн босгоно гээд бид нар томъёолчихсон байгаа. Ерөнхий агуулгаа ч ингэж гаргасан байгаа. Гэтэл хувийн хэвшилд ээлтэй, хувийн хэвшлийг тийш нь хөрөнгө оруулалт хийх бололцоогоор хангах, хувийн хэвшлийг татах ийм нөхцөлүүд дээр бас илүү их тааламжтай нөхцөлийг оруулж өгмөөр байгаа юм. Тэгэхгүй бол бид нар ажлын хэсэг дээр ярьж байсан. Жишээ нь, газар эзэмших ашиглах гэдэг байснаас газар эзэмших гэдэг үгийг нь аваад хаячхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр тэнд газар эзэмшихгүйгээр хувийн хэвшил гадаадын ч бай, дотоодын ч бай хувийн хэвшил хөрөнгө оруулж ажиллана гэж бол байхгүй. Хэрвээ энэ газар эзэмших заалтыг хасах юм бол зүгээр ашиглах газар дээр бол хөрөнгө оруулалт хийх гадаадын байтугай, дотоодын хөрөнгө оруулагч ч цөөхөн байх болов уу гэж бодож байна. Тэгээд энэ 2 асуудал дээр онцгой анхаарч, дараагийн хэлэлцүүлгийн шатад бас хууль дээр өөрчлөлт оруулах ийм саналтай байгаа. Тэгээд ажлын хэсгийн гишүүн ажлын хэсэгт орж ажилласан болохоор бусад асуудал дээр бол бас байр сууриа илэрхийлчихсэн байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Үндсэндээ санал хэлчихлээ. Тийм ээ Хасбаяр гишүүн. Асуулт байгаа юм уу. Тэмүүлэн гишүүн хариулт өгье.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Тэгээд бас бид нарын хувьд ажлын хэсэг дээр гол бас ярьсан энэ асуудал маань бол ерөнхийдөө бас одоо байгаа сумын төлөвлөлтийг нэгтгэх асуудал байгаа. Тэр дундаа одоо бол яах вэ нэг талдаа мэдээлэл болгоод бас нийгэмд өгөхөд бол үндсэндээ улсын тусгай хэрэгцээнд авах газар маань 189 мянган га газар байгаа юм. Тэгээд энэ дотроо үүний 133 мянган га газар нь бас Архангай аймгийн нутаг дэвсгэр буюу Өгий нуур Хашаатынх. Ингээд 55 мянган га газар нутаг нь Өвөрхангай аймаг буюу Хархорин сумын газар нутаг байгаад байгаа юм. Тэгэхээр одоо бол сая бас энэ асуудлын хүрээнд бид нар нэг талдаа үндсэндээ энэ төлөвлөлтөд хамрагдаж байгаа аймаг сумууд, эдгээрийг бол нэг талдаа бас нэгтгэх, төлөвлөлтдөө нэгтгэж хамтад нь хөгжүүлэх зохицуулалтуудыг бас хууль дээрээ тусгаж оруулж өгсөн байгаад байгаа. Тэгэхээр нэг талдаа одоо юу гэдэг юм орон нутгийн тэр сум Хархорин ч гэдэг юм уу, шинээр байгуулагдах Хархорум хот ч гэдэг юм уу энэ 2 бол тусдаа байдлаар хөгжинө гэсэн зүйл бол байхгүй ээ. Тийм зүйл огт байж болохгүй.

Үндсэндээ төлөвлөлтдөө бүгд хамт нэгтгэж ороод, үндсэн энэ Өвөрхангай, Архангай, мөн Булган аймгийн энэ тусгай хамгаалалтад хамрагдаж байгаа газар нутгууд нэгдсэн 1 төлөвлөлтөд ороод хийгдээд явах боломж бололцоо бүрдэнэ. Цаашдаа бид бүхэн энэ хот төлөвлөлт болоод нөгөө талдаа суурь дэд бүтцийн асуудлууд ч гэсэн ерөөсөө хамтдаа зохицуулагдаад явна.

Нэршлийн хувьд харин энэ асуудлыг бас гаргаж ирж тавьж байгаа асуудлууд байгаа. Одоо яригдаж байгаа Хархорин болон Хархорин сумтай холбоотой нэршлүүдийг цаашдаа бид нар нэгтгээд угаасаа нэгтгэх тодорхой цаг хугацааны

нэршил засаглалын нэгтгэх асуудал бас явна. Энэ хууль бол зөвхөн түр хугацааны буюу шилжилтийн үеийн зохицуулалтуудыг хийж өгч байгаа, тэгээд энэ төслийг төлөвлөлтийг хийх, хот байгуулалтын шаардлагатай төлөвлөлтийн бүтээн байгуулалт болон бичиг баримтыг боловсруулж, зураг төсө, в техник эдийн эдийн засгийн үндэслэлийг хийх ийм үндсэн зорилготойгоор байгуулагдаж байгаа. 1 талаараа бид бүхний хамгийн ойлгодог юу нөгөө ашиглалтын өмнөх захиргаа гэдэг юм уу. Тэрийг нь энэ хуулийн хүрээнд бий болгож өгөөд, эрхийг нь олгоод энэ шаардлагатай бичиг баримт, бодлогынхоо зураг төсөв, төсөл юмнуудаа боловсруул гэсэн зохицуулалтыг хийж өгч байгаа. Хөрөнгө оруулалтын асуудал бол үндсэндээ бид бүхэн бусад юу гэдэг юм. Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр тусгачихсан зохицуулалтууд бас хөрөнгө оруулалтынхаа хуулиар зохицуулагдахаар ингээд явж байгаа.

Засгийн газраас орж ирсэн зүйл дээр 2, 3 бас нэг тийм хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагч талд илүү давуу байдал олгосон зохицуулалтууд байсныг ажлын хэсэг онцын шаардлагагүй хасах, одоогийн байдлын Хөрөнгө оруулалтын тухай хуулиар явах нь зүйтэй гэсэн байдлаар бас оруулж өгсөн.

Цаашдаа Засгийн газрын энэ хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтыг татахтай холбоотой, хот байгуулалтад олон улсын болон дотоодын аж ахуйн нэгжүүдийг татах хөшүүрэг болсон эдийн засгийн механизмыг тусдаа оруулж ирэх зайлшгүй шаардлага байна гэж үзээд энийг одоогийн Засгийн газрын ажлын хэсэгт чиглэл өгөөд, шуурхай хэмжээнд ажиллаад энийгээ бас оруулж ирээрэй гэсэн чиглэлийг өгсөн байгаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Хотыг шилжүүлэхдээ 2, 3 үндэслэлээр хотыг шилжүүлэх, шинээр байгуулах гэсэн нэг ийм юм олон улсад байгаад байх шиг байгаа юм.

1 дүгээрт эдийн засгийн хот байгуулахаар, 2 дугаарт улс төрийн буюу геополитикийн төв рүү шилжих гэсэн энэ чиглэлээр хотууд бас шинээр үүсэж байгаа. Энэ хот төлөвлөлттэй холбоотойгоор бас шинээр зарим улс орнууд энэ хотуудаа шилжүүлсэн, шинээр барьсан ийм тохиолдлууд байгаа юм. Тэгээд олон улсууд хотоо шинээр барих, шилжүүлэхдээ алдаа гарч байсан. Эзэнгүй хот болж байсан. Тэгээд энэ Хархорум хот маань яг эдийн засгийн хот байна уу, аялал жуулчлалын чиглэл рүү байх юм уу. Одоо бол ойлгож байгаагаар ийм түүхэн дурсгалт, эртний нийслэл рүүгээ шилжих гэсэн нэг ийм концепц явж байх шиг байна.

2 дугаарт гишүүд бас давхцаж яригдаж байна. Хархорин орон нутгийн чанартай Хархорин хот, улсын зэрэглэлтэй Хархорум хот гээд ийм 2 нэршилтэй байгаа. Яг энэ төлөвлөлт дээр тухайн Хархорин сумын газар нутаг орж давхцаж байгаа байх. Энийг нэгтгэх тал дээр нь арай уян хатан байдлаар шийдэхгүй бол 2 зэрэгцсэн ийм том, жижиг ийм хот шиг ийм болчихож байгаа юм.

Дараачийнх нь хууль, эрх зүйн орчны дэд бүтцийг нь яг уялдуулж явахгүй бол төлөвлөлт дээр алдаа гарах юм бол яг Улаанбаатар 2 гэсэн ийм л хот болж хувирна. Хууль, эрх зүйн орчноо энэ дэд бүтэц, бүтээн байгуулалт хийх ажилтай яг уялдуулж явахгүй бол яг энэ Улаанбаатарын газар олголт шиг ийм 1 дүгээрт, 2 дугаарт ийм төлөвлөлтийн алдаатай хот болчихвол энэ дээр хөрөнгө оруулалт ч байхгүй, тэгээд

тал дээр хэдэн балгас үлдэхийг үгүйсгэхгүй. Тэгэхээр энийгээ маш сайн уялдуулж өгөөч гэж байгаа юм. Бусад аймгийн газар нутгийн давхцал байгаа юм байна. Архангай аймаг, Өвөрхангай, Булганы бас зарим хэсэг орж байна. Өгийнуур сум орж байна. Энэ маань яаж зохицуулагдах юм. Хархорум хотынхоо газар нутагт орж явах юм уу. Одоо байгаа энэ Улаанбаатар хотын Богд уул шиг болоод явчихвал хэцүү шүү дээ. Хархорум хот үүсчихдэг, хажуугаар нь нөгөө бусад аймгийнхан шавуулаад 2 метрийн зайтай газар өгөөд замбараагүй болговол ингээд л энэ чинь хот төлөвлөлт үндсэндээ нурна гэсэн үг. Тэгэхээр энэ Үндсэн хуульд ч бараг л өөрчлөлт орж мэдэхээр ийм асуудал үүсэж болох юм уу гэж байгаа. Ийм асуултыг асууж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Тэгээд үндсэндээ бид бүхний бас хот байгуулах гэж байгаа Хархорин хот маань бол монголчуудын хувьд өөрөө энэ түүхэн нийслэл. Бид бүхэн бас энэ түүхэн нийслэлээ сэргээн босгох, Хархорин хотыг сэргээн байгуулах энэ суурь үндсэн зарчмын хүрээнд хийж өгсөн. Таны саяын асуусан асуулттай уялдуулаад ер нь яг эдийн засгийн хувьд энэ хот маань өөрөө яг ямар хот байх юм бэ гэдэг асуудлыг бол асууж байгаа юм.

Тэгэхээр бид бүхний хувьд гол бодож төлөвлөж юу гэдэг юм Засгийн газраас оруулж ирсэн хуулийн төсөл дээр нэмж тусгаж, оруулж шигтгэж өгсөн, онцолж өгсөн гол асуудлууд маань бол өөрөө юу юм бэ гэхээр ерөөсөө энэ хот байгуулагдсанаараа бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангасан, тэгээд одоогийн энэ бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалтай уялдсан, эдийн засгийн хувьд бие даан хөгжих ийм боломжтой хот байх ёстой л гэдэг суурь зарчмыг хийж өгч байгаа. Яг энэ асуудлыг сая Улсын Их Хурлын ажлын хэсгээс бол бид нар хот төлөвлөх, бүтээн байгуулах түүний хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим гэдэг энэ зарчмын зөрүүтэй санал дээрээ бүр онцолж, онцгойлж бас оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр энэ хүрээндээ бид нар эдийн засгийн хувьд бие даан хөгжих, тэр дундаа саяын түрүүний хэлсэн аялал жуулчлал болон тухайн эдийн засгийн өөрийнх нь бүс нутгийн онцлогт нийцсэн энэ бүс нутгийнхаа хөгжилтэй уялдсан ийм хотыг байгуулах ёстой гэдэг зарчмыг бас гаргаж тавьж гарч ирж байгаа.

Хот төлөвлөлттэй холбоотойгоор алдаа оноотой зүйлүүд гарах вий дээ. Хууль, эрх зүйн орчин болоод дэд бүтцийн асуудлуудыг уялдуулж хийх ёстой гэдэг асуудлууд байгаад байгаа юм. Үндсэндээ Улаанбаатар хотод бид бүхний хувьд бас том алдсан гол алдаа маань бас эндээ байгаад байгаа. Тэгэхээр эндээ бид нар уялдуулах гэсэн гол асуудлууд маань ерөөсөө бүх цааш цаашид хийгдэх энэ төлөвлөлт болоод дэд бүтцийн ажлууд бол үндсэн энэ Засгийн газраар орж батлагдах хотынхоо хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнийхөө үзэл баримтлалтай нийцдэг байх ёстой. Мөн дээрээс нь хотынхоо хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэйгөө нийцдэг байх ёстой. Хуучин магадгүй ямар нэг байдлаар хэн нэгэн гэдэг юм уу тэр барилгачдынхаа төслийг ч гэдэг юм уу дураараа хийчихдэг, тэрийгээ дүрмээ зөрчөөд явчихдаг ч гэдэг юм уу, тухайн эсвэл газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөө өөрөөр гаргадаг энэ асуудлууд байж болохгүй гэдэг асуудлыг хатуу тусгаж оруулж өгч, заавал ч үгүй тэрэндээ нийцүүлж эдгээр юу гэдэг юм энэ асуудлуудаа хийнэ гэсэн асуудлуудыг бол тусгайлж оруулж өгсөн байгаа. Нөгөө талдаа ч гэсэн саяын тэр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн

ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, барилгажилтын төсөл болон эдгээр асуудлуудыг батлах субъектүүдийг бас нэлээн статусыг нь нэлээн дээшлүүлж, Засгийн газар болон яамнуудын түвшинд батлуулахаар бас энэ зохицуулалтууд хийж өгснөөрөө ийм онцлогтой байгаад байгаа.

Тэгэхээр энэ хүрээндээ бол харьцангуй бас бид нар өмнөх алдаа оноонуудыг бас алдахгүйгээр байх ёстой. Тэгээд эргээд төлөвлөлтөд байх ёстой суурь зарчмын асуудлууд. Нөгөө хүнд ээлтэй хот, байгальдаа илүү ойрхон, илүү хүмүүнлэг гэдэг ийм хотуудыг байгуулах энэ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чинбаатарын Анар. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн тодруулж асууя.

Н.Алтаншагай: Энэ нөгөө бусад хил залгаа аймгуудынхаа орж байгаа газар нутгийг яаж зохицуулалт хийх юм. Тэр чинь нөгөө хотын иргэн болоод явчих юм уу. Тэр чинь мэдээж нөгөө малчид байгаа шүү дээ. Тойроод. Тэгэхээр хотын иргэн болоод явах юм уу, тухайн нутаг нэршлээрээ үлдэх юм уу. Энэ бас маргаан дагуулж мэдэхээр л зохицуулалт асуудал болох байх. Энэ дээр нэг тайлбар өгөөч.

Д.Амарбаясгалан: Тэмүүлэн гишүүн нэмж хариулъя.

Г.Тэмүүлэн: Сая ерөнхийдөө бас хэлсэн. Энэ 3 аймгийн 4, 5 сумыг хамарсан ийм газар нутаг байгаад байгаа. 189 мянган га газар. Энэ бол өөрөө асар том газар. Өнөөдөр Улаанбаатар хот маань бол үндсэндээ 9 мянган га газар байгаа гэж байгаа. Тэгэхээр бид бүхний үндсэн том шинэ хот төлөвлөгдөх газар маань бол 189 мянган га газраасаа яг үндсэн шинэ хот маань багцаагаар үзэл баримтлал, зураг төсөв, төлөвлөгөө нь гараагүй. Гэхдээ одоогоор энэ захиргааны захиргааны зүгээс, Засгийн газрын зүгээс тооцоож үзэж байгаагаар бол 25 мянган га төлөвлөх болов уу гэж хараад байгаа юм. Тэгэхдээ 25 мянган га ч гэсэн ер нь үндсэндээ том болчхоод байгаа юм. Улаанбаатар хотоос 3 дахин том. Тэгэхээр бид нар үндсэндээ яг хотыгоо төлөвлөөд, зураг төсөв нь батлагдаад ингээд явах юм бол энэ үндсэндээ магадгүй 5-10 мянган га төлөвлөгдөх ч гэдэг юм уу ийм хот болох болов уу гэсэн ерөнхий төлөвлөгөөтэй байгаа.

Бид бүхний хувьд энэ хууль дээр онцолж өгсөн гол бас ажлын хэсгийн гишүүдийн зүгээс гаргаж байсан санал бол хот төлөвлөлтөө яг бодитоор хийгээч. Яг үндсэндээ яг хэт томоор аваад, энэ тэнчээнээсээ хамгаалалтад 189 мянган га-д авсан газраасаа хэсэг хэсгээр нь зураг нь батлагдсаныхаа дагуу чөлөөлөөд чөлөөлөөд явах зохицуулалтууд бол бас энэ хууль дээр хийгдэж өгсөн байгаа юм. Тэгэхээр 189 мянган га газар буюу энэ 4, 5 сумын газар нутаг дээр хот төлөвлөгдөнө нь гэж ойлгож бас болохгүй. Ерөнхийдөө тусгай хамгаалалтад аваад тэндээсээ зураг төсөв нь батлагдсаны дараагаас ингээд нөгөө чөлөөлөгдөх газруудаа хэсэгчлэн чөлөөлөөд явахаар зохицуулалтууд бол хийгдэж байгаа. Бодитоор ажил хэрэг болоод 10, 20 жилийн дараа хийгдлээ гэхэд магадгүй Засгийн газрын зүгээс хэлж байгаагаар 5-10 мянган га газар ч гэдэг юм уу Ерөнхий хот маань босох ийм дүр зурагтай байгаа болов уу гэж ярьж байна. Энэ дээр үндсэндээ хотын суурь концепц төлөвлөлт, энийг хийх зураг төсвийн суурь бас нэг төлөвлөлтүүд бол бас эхэндээ хийгдээд явж байгаа. Ингээд цааш цаашдаа энэ нь тодорхой болоод ирэхээр Засгийн газраараа батлагдаад, магадгүй Улсын Их Хуралд бас танилцуулагдаад явна гэж бид нар бас ойлгож байгаа

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Энэ дээр энэ хууль бол ер нь нэлээн анхааралтай хандахгүй бол болохгүй. Энэ маш их яаравчлалтай орж ирсэн. Би ажлын хэсэгт байсан. Ажлын хэсгийн гишүүд бол хэдэн шөнө суусан. Зарчмын хувьд Их Хурлын ажлын хэсэг бол нэг юман дээр тогтсон юм. Тэгэхээр улсын нийслэл цаашдаа шилжих, улсын зэрэглэлтэй хол болох төсөл учраас хотын зөвлөл, хотын Захирагчдын эрх зүйн хувьд ажлаа явуулах чадамжтай болгох хуулийн төслийг л өргөн барья гэдэг зарчим дээр бид нар тогтож хийсэн. Тэрнээс биш гадна дотнын хөрөнгө оруулалт, энд яг үнэхээр бодит хот болохын тулд түрүүн Хосбаяр гишүүний ярьж байгаа шиг энд маш их олон зүйл дутуу байгаа. Гадна, дотнын төр, хувийн хэвшил, гадна дотнын компаниудын туслалцаа дэмжлэгийн хамтралыг авахын тулд энэ хууль бол өшөө илүү хөнгөлөлттэй нөхцөлтэй, өшөө илүү дэлгэрэнгүй судалгаатай. Гэхдээ тэрэнд бол маш их цаг хугацаа хэрэгтэй. Тэгэхээр цаг хугацаа алдахгүй ажиллуулахын тулд энэ хотын зөвлөл, захирагчид нь эрх зүйн статусыг нь өгөөд ажлыг нь хийх боломжийг нь олгоё гэж орж ирсэн боловч эндээс үүдээд 2 асуудал гарч ирж байгаа юм.

1 дүгээрт би Засгийн газраас хуулийг өргөн мэдүүлсэн ажлын хэсгээс асуумаар байгаа юм. Их Хурлын ажлын хэсэг бол энийг эрх зүйн хувьд чадамжтай, ажлаа хийх боломжийг нь хангая гэсэн боловч одоо энэ дээр газрын наймааны завхралын суурь тавигдах гээд байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл 189 мянга мянган га газрыг ашиглах, эзэмших, өмчлөх буюу Газрын өмчийн тухай хуулийн эрхийг нь нээчхэж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ нь цаашлаад хот баригдахгүй баахан газар зарагдчихдаг, тэгээд хөрөнгө оруулагчид нь ч орохгүй баахан газар нь танил тал хүрээгээрээ авчихсан Улаанбаатар хот шиг, дээрээс нь Улаанбаатар хот байтугай орон нутаг ийм болчихсон юм шүү дээ. Тойргоос сонгогдсон бүх гишүүд мэдэж байгаа. Аймгийн төв, сум орон нутгийн эргэн тойрон нь хоосон газар байгаад байдаг. Бүгдээрээ олгогдоод зарагдчихсан. Тэгээд ингээд авч болдоггүй, бүтээн байгуулалт хийгддэггүй. Тэгэхээр яг тийм эрх нээх гээд байгаа болохоор Их Хурлын ажлын хэсгийн бид нарын баримталсан зарчим буюу төслийн судалгаагаа хийх, хөрөнгө оруулалтын судалгаа хийх зарчим алдагдах гээд байгаа юм. Энийг бол нөгөө Төрийн байгуулалтын байнгын хороо дээр Их Хурлын ажлын хэсгийн саналыг дэмжээгүй байна лээ. Тэгэхээр тийм эрхийг бид нар нээж өгөх гэж байгаа шүү. Тэгэхээр энэ яагаад Шинэзуун мод хотын хуулийн ажил хуулийн төсөл дээр зөвхөн ашиглах гэж орж ирсэн. 2021 оны Чөлөөт бүсийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр бас яг адилхан зөвхөн ашиглах гэж орж ирчхээд, одоо энэ хууль дээрээ болохоороо эзэмших өмчлүүлэх эрхээ авах гээд байгаа юм бэ гэдгийг Засгийн газрын ажлын хэсгээс асууя.

2 дугаарт Их Хурлын ажлын хэсгийн ахлагчаас асуух юм байгаа юм. Хууль өөрөө Хот байгуулалтын тухай хууль юм бол яагаад Эдийн засгийн байнгын хороогоор орохгүй байгаа юм. Олон хуультай уялдаж байгаа учраас Хууль зүйн байнгын хороогоор яагаад ороод, дүгнэлт гарахгүй байгаа юм бэ. Яагаад бид нар ингэж их яаравчилж энэ хуулийг батлах шаардлагатай байгаа вэ гэдэг 2 асуултыг асууна.

Зарчмын зөрүүтэй санал дээрээ би энэ дээрээ дахиад байр сууриа илэрхийлнэ.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс 19 номерын микрофон хариулъя.

Н.Нацагдорж: Анар гишүүний асуултад хариулъя. Энэ Хархорум хот маань бол Монгол Улсын засаг захиргааны нэгж дэх хот. Тэгэхээр энэ нэгжийн нутаг дэвсгэрт бол өөрчлөлт орохгүй. Тэгээд тухайн газар дээр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд бол захирагчийн эрхэд бол газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх нь бол олгогдчихсон. Ингээд дараа дараагийн хотууд бол яг энэ үйл ажиллагаагаа явуулаад л явна. Зүгээр энэ дээр нэг эмзэглэж байгаа асуудал нь бол мэдээж газар эзэмших эрх нь ингээд захирагчид нь олгогдоод явахаар энэ зөвхөн 189 мянган га-даа хэлж байгаа шүү дээ. Ингээд явахаар нөгөө газрын наймаа болчих вий гэдэг энэ асуудал бол иргэдээс ч тэр янз янзын уулзалт зөвлөгөөнүүд дээр ч гэсэн ирдэг асуудал. Энэ хуулийн үндсэн зарчим бол тэрнээс хамгаалах. Тэр нь юу вэ гэвэл нэгдсэн төлөвлөлттэй. Тэр газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагаа бол яг төлөвлөлтийн дагуу явна гээд хуульчлаад заагаад өгчихсөн байгаа. Тэр газар зохион байгуулалтын төлөвлөгөө тухайн жилийн төлөвлөгөө бол хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээрээсээ үүдэж гарч ирсэн төлөвлөгөөний дагуу тэр эзэмших, ашиглах үйл ажиллагаа нь бол хуулийн дагуу зохицуулагдаад явна л гэсэн ийм зүйлтэй байгаа.

Тэгэхээр энэ бол одоогийн практик шиг өмнө нь ингээд газраа өгчхөөд, дараа нь тэр дээр барилга байшин барих асуудал нь шийдэгддэг биш, газрынх нь зориулалт нь өмнө нь ерөнхий төлөвлөгөөгөөрөө тодорхойлогдчихсон, тэр зориулалтаар л шийдэл нь гарна гэсэн энэ хуульчилж өгч байгаа гол зорилго нь бол энэ.

Х.Булгантуяа: Тэмүүлэн дарга нэмж хариулах уу.

Г.Тэмүүлэн: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яг манай Анар гишүүн ч гэсэн бас манай Их Хурлын ажлын хэсэгт бас орж ажилласан. Ерөөсөө Их Хурлын ажлын хэсэг бол үндсэндээ энэ хууль дээрээс эзэмшүүлэх харилцаануудыг бас авч хасья гэсэн саналтай байсан. Ингээд ажлын хэсэг дээр ажиллаад бүх эзэмшихтэй холбоотой зохицуулалт, заалтуудыг бол хассан. Гол энэ үндсэн суурь зарчим асуудал маань бол өөрөө юу юм бэ гэхээр ерөнхийдөө Хот, тосгоны тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Газрын тухай хуулиараа энэ газар өмчлөх, эзэмшүүлэх болон ашиглуулах харилцаанууд бол угаасаа зохицуулагдаж байгаа харилцаа байгаад байгаа юм. Энэ удаагийн Хархорины тухай хууль бол нэг талдаа өөрөө шилжилтийн үеийн буюу харилцааг зохицуулсан суурь бусад хуульд тусгагдсан энэ зохицуулалтуудыг давхардуулж оруулах шаардлага байхгүй байна гэж үзээд, үндсэндээ шилжилтийн үеийн энэ ашиглалтын өмнөх захиргаа маань үндсэндээ хот төлөвлөлттэй холбоотой суурь энэ бодлогынхоо ажлуудыг хийгээд, дараагийн юунууд дээр бас ../минут дуусав/

Х.Булгантуяа: Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Их Хурлын ажлын хэсэг, Засгийн газрын ажлын хэсгээс асуусан 2 асуулт магадгүй би ойлгомжгүй асуусан байх. Шинэ Зуунмод хотын тухай хууль дээрээ яагаад ашиглуулах гэдгийг оруулаад, эзэмшүүлэх гэдгээ хасаад, ямар зарчим баримталсан юм. Чөлөөт бүсийн тухай хуулийн 2021 оны нэмэлт тодотголоороо бас зөвхөн ашиглуулах гэж орж ирсэн. Зарчмын хувьд яг адилхан хууль. Дээрээс нь энэ бүр шилжилтийн хууль. Тэгээд энэ дээрээ яагаад заавал эзэмшүүлэхийгээ оруулж ирнэ гээд зүтгээд байгаа юм бэ. Ямар зарчим юугаараа

ялгаатай юм. Тэгэхээр эргээд тэр хуулиа өөрчлөх юм уу. Тэрийг Засгийн газрын ажлын хэсгээс асуугаад байгаа юм.

Тэмүүлэн даргаас Их Хурлын манай ажлын хэсгээс нь асуугаад байгаа нь энэ хууль яагаад Эдийн засгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороогоор орохгүй чиг үүргийн дагуу заавал орох ёстой байж байтал яагаад зөвхөн Төрийн байгуулалтын байнгын хороогоор ороод шийдэх гээд байгаа юм бэ.

Х.Булгантуяа: 19 номерын микрофон эхлээд хариулъя.

Н.Нацагдорж: Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол энд тэр эзэмших, ашиглах асуудал нь Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийнхаа тэр захирагчийн, хотын тэр заалт дээрээ тэрийгээ үндэслээд л явж байгаа. Дээрээс нь энэ Хархорум хотод бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжүүдийн газар эзэмших эрхийг хязгаарлаж болохгүй л гэсэн үндсэн зарчим байгаа. Одоо ч энэ газар дээр 2 мянга гаруй эзэмшигч байгаа. Газар эзэмшигч байгаа. Тэгэхээр одоо энэ бол тусгай хэрэгцээнд авчихсан учраас эзэмшигчийн газрын харилцаа зогсчихсон.

Цаашаагаа ингээд хот болоод явахаар энэ эзэмшигчид маань өөрөө тэр газрын харилцаанд орох гэхээр ашиглах гэсэн ийм ганц заалтаар бол явж болохгүй. Ашиглах зориулалт бол Монгол Улсын иргэнд бол хотын бүсэд бол байдаггүй. Энэ бол ерөөсөө тусгай хэрэгцээний газар, тусгай хамгаалалттай газар дээр байдаг. Ашиглах эрх бол газрынхаа хуулиар гадаадын иргэн, аж ахуйн нэгжид байдаг юм.

Тэгэхээр энэ ашиглах гэдэг үгийг оруулах юм бол Монгол Улсын иргэн Хархорин хотод бол тэр бүс нутагт нь бол боломжгүй болно л гэсэн үг байгаа юм.

Тэгээд Шинэ Зүүнмод .../минут дуусав/

Х.Булгантуяа: Тэмүүлэн дарга нэмж хариулъя. Яагаад Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалагдаад байгаа юм бэ гэж байх шиг байна.

Г.Тэмүүлэн: 12 сарын 26-нд Улсын Их Хурлаар энэ Хархорины бүтээн байгуулалтыг дэмжих тухай хуулийн төсөл орж ирээд, ингээд Улсын Их Хурлын чуулган дээрээс бол угаасаа Төрийн байгуулалтын байнгын хороонд цохогдсон. Яагаад вэ гэхээр угаасаа энэ Улсын Их Хурлынхаа тухай хуулиараа засаг захиргааны шинэтгэл болоод төвлөрлийг сааруулах бодлого, нөгөө талдаа энэ засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж болоод түүний удирдлага зохион байгуулалттай холбоотой, үйл ажиллагаатай холбоотой, нөгөө талдаа бүүр томоор нь ярих юм бол бүсчилсэн хөгжилтэй холбоотой энэ бодлого бол угаасаа Төрийн байгуулалтын байнгын хороондоо хамаардаг. Ингээд Төрийн байгуулалтын байнгын хороонд цохогдоод, Улсын Их Хурал дээрээс ингээд бид бүхнээр ахлуулсан болон бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулаад ажилласан гэдгийг бас хэлэх байна.

Улсын Их Хурлын ажлын хэсэг бол та ч гэсэн бид бүхний хувьд анзаарсан юу бол энэ шилжилтийнхээ үедээ гол суурь бодлогынхоо баримт бичгүүдийг хийж өг. Тэрний дараа энэ газар.../минут дуусав/

Х.Булгантуяа: Анар гишүүн 1 минут тодруулъя.

Ч.Анар: Нацагдорж архитектур та ингээд гөлөг төөрүүлж байгаа юм шиг. Урьд шөнөжингөө л ярьсан шүү дээ. Бүгдээрээ тэр Газрын харилцааны тухай хуулиа мэдэж байгаа. Тэрийг би хариултыг нь асуугаагүй шүү дээ. Засгийн газрын ажлын хэсэг яагаад Шинэ Зуунмод хотын хуулийн төсөл дээрээ ашиглуулах гэж оруулаад, адилхан л шинэ хот шүү дээ. Дахиад Чөлөөт бүсийн тухай хуулийн тодотгол 2015 онд батлагдсан хуулийг 2021 онд яагаад бас яг энэ зарчмаар, тэгээд энэ дээрээ яагаад эсрэг зарчим бариад байгаа юм бэ. Тэрийг л хариулт авахыг хүсээд байгаа юм.

Тэгвэл би магадгүй энэ Төрийн байгуулалтын байнгын хороо дээр бид нарын оруулсан саналыг дэмжээгүйг ойлгох гээд байна.

Х.Булгантуяа: Байнгын хороо дээрээс нэлээн асуусан юм байна шүү дээ. 19 номер нэг сайн хариулаадхаач.

Н.Нацагдорж: Шинэ Зуунмод хотын хувьд бол ер нь бол статус нь бол нийслэлийн дагуул хот гэж байгаа. Тэгээд нийслэлийн дагуул хот. Нийслэл бол бас өөртөө бол нөгөө нэг тусгай хамгаалалттай бас газартай, хот орчмын газартай. Шинэ хот дээрээ болохоор тусгай хамгаалалттай газар дээрх хэрэгжүүлэх энэ зарчмыг л барьсан байх гэж бодож байгаа. Ер нь бол. Энэ шинэ Хархорин бол энэ чинь тусдаа бие даасан улсын зэрэглэлтэй хот байгаа юм. Чөлөөт бүсийн хувьд бол бид нар сайн мэдэхгүй. Чөлөөт бүсийн өөрийн дэглэм бол бас хуульчлагдсан байдаг.

Х.Булгантуяа: Анар гишүүн болохгүй бол бичгээр асуултыг нь тавиад 1 сайн хариулт аваадхаач. Та бүхэн өчигдөр Байнгын хороо дээр ч гэсэн бас асуусан юм байна шүү дээ Анар гишүүн. Ажлын хэсэг дээр. Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан.

Ж.Алдаржавхлан: Би ч ер нь бол хариултыг мэдэж байгаа болохоор ер нь Их Хурлын индэр дээрээс 1 зүйлийг хэлье гэж бодоод байгаа юм. Одоо тэнд чинь 2 хот байгуулагдах гээд байгаа байхгүй юу. Түрүүн Хосбаяр гишүүн маань хэлсэн. Алтаншагай гишүүн ч хэлнэ лээ. Хархорин гээд нэг хот байгаа. Одоо энэ 2024 оны 5 сард батлагдсан хуулиар хот болчихсон. Тэгээд дахиад Хархорум гэж хот 8км-ийн зайтай баригдах гэж байгаа. Тэгээд 1 рүү нь асар их хөрөнгө оруулалт ороод байдаг. Бүр ингээд Ерөнхийлөгчийн өргөө энэ тэр очих гээд ерөөсөө хөгжлийн бүх хөрөнгө оруулалт хийгдэх гээд байдаг. Нөгөө нь ингээд хэвээрээ үлдэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр миний хувьд энийг нэгтгэчихвэл яасан юм бэ. Тэр Хархоринд амьдарч байгаа 12 мянган иргэн чинь бас гомдоно шүү дээ. Нөгөө хот руу нь баахан хөрөнгө оруулалт цутгаад байдаг, цутгаад байдаг. Нөгөөх нь хэвээрээ байгаад байдаг. Тэгэхээр эрх зүйн хувьд энийг нэгтгэх тийм зүйлийг хэдүүлээ хийхгүй бол болохгүй нь гэсэн нэг тийм бодол байгаа.

2-т нь саяын тэр Анар гишүүний яриад байгаа асуудлууд бол бид нар ажлын хэсгийнхээ хүрээнд ярьсан. Энэ Хархорин хотод захирагчаар болох гэж байгаа хүмүүсийг хамгаалаад л байгаа юм. Янз бүрийн газрын наймаа эзэмших зүйлүүд нь хэрээс хэтэрчих вий, ашиглуулж байгаад хотоо барьчхаасай. Одоогийн байгаа хууль, эрх зүйн орчиндоо тохируулаад шилжилтийн ажлуудыг хийчхээсэй л гэж бодсон юм. Тэгээд 1 мэдсэн чинь ингээд газар эзэмших эрхийг нь өгчихдөг. Тэгээд 2, 3 жилийн дараа яанаа өө уучлаарай гээд сууж байх вий дээ л гэдэг зүйл байгаа юм. Өө энэ чинь бүр ингээд тараад олгочихсон байна шүү дээ гээд. Тэр чинь эрхийг

нь өгчихсөн юм чинь олгож л таараа. Бид нар хорьж чадахгүй л байхгүй юу. Энэ танхимаас гараад л бид нар хорьж чадахгүй болчихно. Тэгэхээр яах вэ л гэдэг асуулт байгаа юм. Тэгээд сүүлд нь эд нарыгаа загнах уу, Шинэ Хархорин хотынхоо захирагчийг барьж шоронд хийх үү. Тийм учраас хэдүүлээ энэ асуудал дээр маш зөв хандахгүй бол болохгүй юм л гэж би бодож байгаа юм.

Тийм учраас манай их хурлын гишүүд маань Улсын Их Хурлын ажлын хэсгийнхээ саналуудыг дэмжээд явна гэж би итгэж байгаа юм. Ер нь бол бид нар энэ хүмүүсээ л хамгаалъя л гэж зорьж байгаа юм. Тэгээд тэр 2 Хархорин хотын асуудал бүр сүүлд онигоо шиг юм болох байх даа. Нэг нь ингээд тосгон шиг байгаад байдаг. Нөгөөх нь жигтэйхэн хөрөнгө оруулалт хийгдээд байдаг. Энийг нэгтгэчих арга чарга байхгүй юм болов уу даа. Би хэнээс асуух юм бэ. Энэ чинь тийм л зүйл. Нэгтгэчихмээр л байгаа юм. Бат-Эрдэнэ дарга хариулах юм уу, яах вэ.

Х.Булгантуяа: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Бат-Эрдэнэ дарга хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь ажлын хэсгийнхний энэ логик, зарчмыг уг нь дэмжиж байгаа юм. Бид Улаанбаатар хот дээр асар том алдаанууд хийсэн. Газар олголт замбараагүй олгосон. Тэгээд буцаад эргээд харсан чинь ерөөсөө энэ хот байгуулалт, хот төлөвлөлт энэ бүх зүйлүүд чинь эвдэрчихсэн. Энийг бүх хүн ярьж байгаа шүү дээ. Бүгд л мэдэж байгаа. Тэгэхээр та бүхэн яг энэнтэйгээ уялдуулаад алдаа гаргахгүй гээд л ингээд л бас ажлын хэсэг дээр нэлээн ярьсан. Ажлын хэсэг дээр их ч ажилласан байх. Энийг бол хүндэлж байгаа, энийг ойлгож байгаа.

Гэхдээ нэг зүйл байгаа юм. Бид бүхэл бүтэн том хот улсынхаа нийслэлийг 1 дүгээрт барих гэж байна. Үүсгэн байгуулж байна. Алдаа гаргаж болохгүй. Гэхдээ энэ хүмүүсийн гарыг бас боож болохгүй байхгүй юу. Тэнд хөрөнгө оруулах гэж байгаа дотоодын бүтээн байгуулагч, дотоодын аж ахуйн нэгжүүд, эд нар чинь бас өөрсдийн гэсэн хөрөнгөө босгох, өөрсдийн гэсэн бүтээн байгуулалтаа хийхэд бас газар эзэмших эрхтэй байж байж үйл ажиллагаа чинь нээгдэнэ шүү дээ. Тийм болохоор ер нь бид нарын нэг ийм зүйл яриад байгаа нь дандаа гаднын хөрөнгө оруулалт, гаднын хөрөнгө оруулалт гээд байгаа юм.

1 дүгээрт гаднын хөрөнгө оруулалт оруулна. Гаднын хөрөнгө оруулалт чинь өөрсдөө газраа эзэмшээд ингээд явах юм бол нэг мэдэхэд тэр Хархорины хот чинь гаднын хот болоод хувирчихна. Тэгэхээр яг энэнтэй уялдуулаад эд нарын тэр харамлаад байгаа эзэмшихгүй гэсэн зүйл чинь нэг талдаа бол гаднынхантай барьцалдуулаад бид нар эзэмшүүлэхгүй гээд байгаа ч нөгөө талдаа бол дотоодын хөрөнгө оруулалт, дотоодын аж ахуйн нэгүүдээ бол бид нар бас ингэж гарыг нь татаж ингэж харамлаж бас болохгүй л болчхоод байгаа юм л даа. Энэ утгаараа бол миний хувьд ажлын албанд, бас Хот байгуулалтын яаманд ажиллаж байсны хувьд ерөнхийд нь энэ эзэмших эрхийг нь нээчихье гэж байгаа юм.

2 дугаарт, өнөөдөр бид нар Хот байгуулалтын тухай хуульдаа юу заасан гэхээр энэ замбараагүй байдлыг бий болгохгүйн тулд Улаанбаатар хотынхоо энэ нөгөө нэг алдсан алдаа дээр түшиглээд, 2011 он байх Хот байгуулалтын хуульд миний бие тэр яаманд ажиллаж байхад бид нар оруулж ирээд, Хот байгуулалтын хуульд Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Их Хурлаар баталдаг байя гэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ бол хууль болъё гэж байгаа. Хууль болсон тохиолдолд хэн нэгэн албан тушаалтан очоод газар олгоод байхгүй. Энэ

төлөвлөлтийг эвдээд байхгүй. Хэн нэгэн архитектур очоод 2, 3 жил ажиллахдаа энэ төлөвлөлтийг эвдээд байхгүй. Энэ нь бүхэл бүтэн Улсын Их Хурлаар батлагдсан хууль байхын тулд Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг өнөөдөр бид нар Улсын Их Хурлаар оруулж баталж байгаа юм. Яг энэ зарчмыг энэ Хархорин хот дээр авъя гэсэн ийм бодлого байгаад байгаа юм. Тийм болохоор Улсын Их Хурлын даргад өнөөдөр би бас санал гаргая гэж бодож байгаа. Дахин боловсруулах асуудал дээр оруулж ирээд, энэ Хархориныхоо ерөнхий төлөвлөгөөг Улсын Их Хурлаар баталдаг. Энэ нь хууль болдог. Үзэл баримтлалыг Улсын Их Хурлаар орж ирж батлуулдаг. Энэ баталсан төлөвлөгөөгөө яг энэ чигээр нь аваад явдаг хэн нэгэн .../минут дуусав/

Х.Булгантуяа: Харин тэгээд Алдаржавхлан гишүүн 2 хотыг нэгтгэж болдоггүй юм уу. Аль нэг нь хөрөнгө оруулалтаа татаад ингээд нөгөөдөх нь юу ч үгүй үлдчих юм биш үү л гээд байх асуугаад байна л даа. Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаас. Ажлын хэсгийн дарга хариулах уу. Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Одоо байгаа Хархорин болоод шинэ байгуулагдах Хархорин гэдэг 2 асуудлыг бол тусдаа ялгаж ойлгох боломж бололцоо бол байхгүй. Тэгэхээр энэ дээр ямар нэг байдлаар юу гэдэг юм нэг нь илүү хөгжөөд, нөгөөх нь дутуу хоцорно гэсэн зүйл байхгүй. Энэ бол яагаад вэ гэхээр ерөөсөө үндсэндээ бид бүхний зүйл бол ерөөсөө төлөвлөлтдөө бүгдийг нь нэгтгэж байгаа. Бүгдийг нь хамт нь хөгжүүлнэ гэсэн суурь зарчмыг энэ хууль дээр оруулж өгч байгаа. Засгийн газар ч гэсэн ерөнхийдөө цаашид нь боловсруулж оруулж ирэх гэж байгаа хөгжлийнхөө ерөнхий төлөвлөгөө болоод үзэл баримтлал дотроо бүгдийг нь нэгдсэн байдлаар хамтарч нэгтгэж хийх энэ зохицуулалтууд бол ингээд хийгдээд явна гэж харж байгаа. Тэгэхээр нэг талдаа дэд бүтэц болоод энэ бүх хотын бүтээн байгуулалтууд бол эндээ хамрагдаад явна гэж бас харж байгаа.

Харин цаг хугацааны хувьд цаашдаа бид нар харин энэ 2 нэршлийг бол тодорхой хугацааны дараа нэгтгэх, 1 болгох, засаглалыг нь бас нэгтгэх асуудлууд бол хийгдэж чадна. Одоогийн байгаа засаглал бол үндсэндээ яг төслийн менежментийн баг гэх юм уу, яг ашиглалтын өмнөх захиргааг хэрэгжүүлэх л ийм баг байна гэж бас ... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл.

Н.Батсүмбэрэл: Мэнд хүргэе. Би ажлын хэсэгт байгаа учраас асуулт асуухгүй, дэмжээд үг хэлчихье.

Монголчууд бол олон 100 жилийн өмнөөс хот байгуулж ирсэн ийм түүхтэй ард түмэн. 21 дүгээр зуунд шинэ хот байгуулах эрмэлзлийг тээж, үүнтэй холбоотой шийдвэр гарч, Улсын Их Хуралдаа хууль өргөн барьж байна. Ажлын хэсэг ч бас нэлээн завсаргүй ажилласан. Ажлын хэсэг дээр зарчмын зөрүүтэй, байр суурийн зөрүүтэй олон саналууд гарсан. Гэсэн хэдий ч санал хураалт хийгдээд олонхын санал саналаараа явж байгаа. Парламентын дэгийн дагуу холбогдох Байнгын хороогоор санал хураалт нь явагдаад, энд орж ирж байгаа юм байна. Ер нь Улаанбаатар хотын хүчин чадал бодит амьдрал дээрээ гүйцэгдчихсэн үнэнд. Бид нар цэвэр усны нөөц, дэд бүтцийн хангамж, газар зүйн тогтоц гээд олон зүйлүүдийг бид нар Улаанбаатар хот маань өнөөдөр бодит амьдралд гүйцэгдсэн учраас бид нар шинэ хотын тухай байнга ярьж байгаа. Улаанбаатар хотыг Богд уулынхаа урд нүүлгэж гаргах тухай, Богд уулаа нүхлэх тухай, мөн Дархан болон бусад хот руу

Улаанбаатар хотыг шилжүүлэх тухай байнга ярьж ирсэн. Олон ч жил нүүх үү, үлдэх үү гэж ярьцгааж ирсэн ийм түүхтэй.

Тийм учраас энэ ажлыг эхлүүлж байгаа явдалд бол нэн тааламжтай бөгөөд дэмжиж байгаа. Тийм учраас энэ ажил урагшаа явах ёстой. Энэ ажлыг түүхэн талаас нь авч харах юм бол аль хэдэн 100 жилийн өмнө 1220 онд анх Хархоринд хот байгуулж байсан байна. Одоо энэ түүх давтагдаж, 2024 оны луу жилд энэ түүхэн ажил үргэлжлээд явж байна. Алдаа дутагдал гарч ирж болзошгүй. Алдаа дутагдлыг аль болох бага гаргах, түүнийг Улаанбаатар хотод бий болсон алдааг давтахгүй байх тал дээр энэ төлөвлөлт хариуцаж байгаа хүмүүс нь анхаарч ажиллах ёстой. Саяын яригдаад байгаачлан одоо байгаа Хархорин сумыг холбогдох ойрхон байгаа тэр 4, 5 сумыг яах вэ. Тэр бүсийг цааш нь яаж хөгжүүлэх вэ. Мөн Хархорин хот маань бүсийн төв болох уу, цаашлаад уд Монгол Улсын нийслэл болох уу гэдэг асуудлууд ч ард нь хөндөгдөж байгаа юм. Үүнийг шийдэхийн тулд энэ эрх зүйн асуудлыг нээж өгөхийн тулд энэ хууль явж байна гэж ойлгоод байгаа юм. Тэгээд энэ асуудлыг нэлээн ултай, суурьтай хандах үүднээс эдийн засгийн тооцооллын энэ гарах үүднээс бас тус бүс нутгаас сонгогдсон хүний хувьд Тэмүүлэн гишүүн ч нэлээн сүрхий ахлаад ажиллаж байгаа. Энэ ажил тэгээд парламент дээр нэлээн хүчтэй, шуурхай явах байх гэж бодож байна. Тэгээд энэ санаачилгыг бид нар дэмжих хэрэгтэй. Их хурлын гишүүд маань. Бид чинь бас олон ажил хийж амжаагүй байна шүү дээ. Эхний энэ 126 гишүүнтэй парламент төсвийн хууль нэг баталлаа. Одоо бие даасан хууль бол энэ Хархорин хотын хууль шүү. Өөр бид нар бүтэн хууль баталж хараахан амжаагүй байгаа. Тэгэхээр энэ анхны хуулиа бол нэлээн сайн шүүгээд, дэмжээд явах нь бол зүйтэй байна. Холбогдох энэ захиргааны хүмүүс маань бас энэ Их Хурлын гишүүдийн хэлээд байгаа саналуудыг хүлээж авах, ялангуяа энэ төлөвлөлтийн асуудал, хот төлөвлөлтийн асуудал, газар олголт, зохион байгуулалттай холбоотой асуудлууд дээрээ алдаа мадаг гаргахгүй байх. Улаанбаатар хотын энэ төлөвлөлтийн алдаа, Улаанбаатар хотын газрын наймааны алдааг давтахгүй байх тал дээр онцгой анхаарч ажиллаарай гэдгийг зориуд захиж хэлье. Энэ ажил цаашаа урагшлаад явах ёстой. Тийм учраас намрын чуулган дээрээ бодвол батлаад дуусах байлгүй гэж бодож байна.

Тийм учраас Улаанбаатар хотын ачааллыг бууруулах, хот, хөдөөгийн ялгааг багасгах, Шинэ хот байгуулах энэ ажлыг дэмжиж байна. Цаашдаа Монгол Улсын нийслэл, Монгол Улсынхаа төв цэгт Хархорин хотод нүүж очих асуудал ч хөндөгдөж болзошгүй. Ийм учраас энэ асуудлыг дэмжиж байна. Их Хурлын гишүүдийгээ дэмжиж, асуудалд шинжлэх ухаанч, шударгаар хандаж саналаа өгөхийг уриалж байна.

Д.Амарбаясгалан: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн хариулт өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Алдаржавхлан гишүүний яриад байгаа тэр 2 Хархорин байх уу гээд байгаа асуудлууд ер нь бол бас бид нар бодох ёстой юм. Түрүүн Тэмүүлэн гишүүн ч бас хэллээ шүү дээ. Энийг салгаж бодож болохгүй юм гэж. Заавал бид нар хов хоосон газар цоо шинэ хот байгуулах эд нар гэсэн ийм зорилго бас тавиагүй шүү дээ. Нөгөөтээгүүр бол Алдаржавхлан гишүүний хэлдэг зөв. Одоо амьдарч байгаа хүмүүс чинь Хархоринчууд байхгүй юу. Тэгэхээр одоо байгаа Хархорин сум, нөгөө улсын чанартай Хархорин хоттойгоо нэг дор байна гэсэн ойлголт байгаа шүү. Нацагдорж архитектур та энэ дээр бас нэг хариулт хэлчихмээр байна. Яг бид нар газар дээр нь энэ бүтээн байгуулалт, ТЭЗҮ гээд энэ бүх төлөвлөлт хийхдээ энийгээ

хамтатгаад хийх нь зүйтэй гэсэн ийм л ойлголт байгаа. Урьд өмнө бид нар хуучин Дархан, Шинэ Дархан гэж байсан. Одоо бол хуучин шинэ гээд байх юм байхгүй. Тэгээд л том Дархан болчихсон л байж байгаа шүү дээ. Тэрэнтэй адилхан Хархорин гэдэг нэг том нийслэл том хот бий болно гэсэн бид нар ийм ойлголттой байж байгаа. Тэгэхээр энэ хуучин сумаа бол уялдсан ийм төлөвлөлт ийм зураг төлөвлөлт гарах байх л гэж найдаж байгаа шүү. Ингэж л бодож байгаа шүү. Төсөөлж байгаа шүү. Тэгээд уг нь бас газар дээр нь Нацагдоржоос шууд асуучихмаар л байгаа юм.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 55 санал байна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулж эхэлье.

Хархорум хотын бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал

1.Төслийн гарчгийг “ХОТЫН” гэсний дараа “ТӨЛӨВЛӨЛТ” гэж нэмж, үүнтэй холбогдуулан төслийн 6 дугаар бүлгийн 26 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 26.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот төлөвлөлт” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заяабал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдлаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Даваагийн Цогтбаатар, Мэнхцэцэг, С.Эрдэнэболд цаашид ажлын хэсэг. Санал хураалт 55,7 хувиар байнгын хорооны дэмжсэн санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь түүхэн нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулж, Монгол үндэстний түүх, язгуур өв, нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжих, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан ажлын хэсэг. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор. Даваасүрэн гишүүнд үг өгье.

Ц.Даваасүрэн: Би яах вэ. Нөгөө яг эхнээс нь Үндэсний хороог нь удирдаж явсан хүний хувьд л 1 асуулт асуух гээд байна л даа. Энэ дээр нэг ийм асуудал гараад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Асуулт байхгүй. Саналтай холбоотой санал. Даваасүрэн гишүүнд тэгвэл микрофон өгье. Зарчмын зөрүүтэй саналтай холбоотой асуудал дэмжсэн, эсрэг байр суурьтай.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр энэ дээр нэг ийм асуудал байна. Одоо сая нөгөө хуучин Хархорин шинэ, Хархорин ч гэнэ үү. Эхнээсээ ер нь үүсээд байгаа юм ийм байгаа байхгүй юу. Яг энэ аялал жуулчлалын түүхэн хот гэдэг дээр нь сэргээн босох юм уу аль эсвэл нийслэлд шилжүүлсэн шинэ Монголын хөгжлийн төв бий болгох юм уу гэдэг асуудал. Ийм 2 юм дээр эхнээсээ яригдсан. Одоо ингээд саяын томьёоллыг харахаар тэр түүхэн уламжлал энэ тэрээ сэргээсэн аялал жуулчлалын хот босгох гэсэн агуулга орчхож байна шүү дээ. Би тэгж ойлгож болох уу. Тэгж л ойлголоо. Тэгэхээр энэ эхнээсээ тодорхой байх ёстой юм байгаа юм. Тийм учраас одоо хийж байгаа төлөвлөлт бол бид нар шинэ хотоор хийчихсэн байгаа. Яг тэр хуучин Хархорин хотын хэсэг рүү ороогүй. Тэр Юнескогийн газар нутагт авсан хэсэг рүү ороогүй. Нийслэлээ ер нь шилжүүлэе. Монгол Улсын төвд бас энэ улс төр, нийгэм, эдийн засгийн гол төвөө байгуулъя гэдэг ийм концепцыг бол уг нь баримтлах нь зүйтэй юм гээд л ингээд шийдсэн. Тэгэхээр энэнээсээ жоохон зөрчсөн томьёолол болчхов уу л гэж би бодоод байх юм.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан ажлын хэсгийг төлөөлж ажлын хэсгийн дарга Тэмүүлэн.

Г.Тэмүүлэн: Би бас яг энэ заалттай холбогдуулаад бас та бүхэндээ саяын асуудал дээр тайлбарыг өгье. Тэгэхээр энэ яалт ч үгүй бас Монголчуудын хувьд түүхэн нийслэл. Тэгэхээр бид бүхний хувьд энд гол оруулж байгаа зүйл маань бас энэ түүхэн нийслэл болсон энэ Хархорин хотыг сэргээн байгуулах гэдэг асуудлыг бас оруулж өгч байгаа.

Даваасүрэн гишүүн бас ярьж байгаа гол асуудал маань бол үндсэндээ бид бүхний хувьд энэ улсын маань дараагийн нийслэл болох ёстой шинэ газар. Тэгээд энэ өөрөө нэг талдаа бас Монгол хүн бүрийн хувьд ч гэсэн байгаа ийм амбиц байна гэж харж байгаа. Тэгэхээр энийг бид нар бас нэг талдаа эрэмбэ дараалтайгаар хийх ёстой байгаа. Одоо бол цоо шинэ газар, цоо шинэ хот дээр бид нар ерөнхий төлөвлөлт, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлээ хийх гээд л бэлтгэл ажлаа хангах гээд явж байгаа. Тэгэхээр магадгүй цааш цаашдаа энэ бэлтгэл ажлууд хангагдаад, хотын өнгө төрхтэй болоод ирсний дараагаас бид нар нийслэлийн баримжаатай хотын статустай болгох энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг ч гэсэн хийгдэх тэр боломж бололцоо цаашдаа бүрдэх болов уу гэж хараад байгаа юм.

Хэрэв бид нар ямар нэг байдлаар энэ хууль дээр энэ бол цаашдын Монгол Улсын нийслэл байна гэж оруулж хийх тохиолдолд ийм юу гэдэг юм хуулийн томьёолол оруулах юм бол нэг талдаа энэ өөрөө бас Үндсэн хуультай зөрчилдөх зөрчил үүсгэх ийм асуудал байгаа. Үндсэн хууль дээрээ 13 дугаар зүйл дээр улсын маань нийслэл Улаанбаатар хот байна гэдэг зүйл байгаа. Тэгэхээр бид бүхний алсын баримжаа ийм амбиц бол бид бүхэн бүгдэд нь байна. Цааш цаашдаа энэ бэлтгэл ажлууд хот төлөвлөлтөө хийсний дараагаас ийм суурь нөхцөл бүрдээд явна гэж бас харж байгаа.

Д.Амарбаясгалан: Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор. Үгүй ээ, энэ саналтай холбоотой 2 хүртэл гишүүн шүү дээ. Тэгэхээр чинь 2 гишүүн болчихлоо. Зөвхөн зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн болон дэмжээгүй байр сууриа илэрхийлээд, 2 хүртэл гишүүн үг хэлнэ гэсэн дэгтэй. Тэгэхээр 2 гишүүн үг хэлчхэж байгаа. Намын бүлэг тус бүрээс. Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Тэр үзэл баримтлал юуны төлөө хот байгуулах гэж байгаа вэ гэдэг томъёололтой Даваасүрэн гишүүний хэлсэнтэй давхцах санаа байгаа. Ер нь бол түүхэн нийслэл монголчуудын өвөг дээдсийн эртний Хүн гүрнээс хойш ингээд хэд хэдэн нүүдэлчдийн угсааны нийслэл хотод байсан ариун газар гэж хэлж болохоор Орхоны хөндий, Өвөрхангай, Архангайн тэр хавийн ай сав нута. Тэгэхээр энд ийм сайхан юм байгуулна гэдэг нь ингээд гоё сонсогдож байгаа.

Гэхдээ зорилго нь эдийн засгийн бие даасан байдалтай байна. Тээврийн зангилаа, тэгээд хотын төлөвлөлтийг нь ч гэсэн ингээд харахаар нөгөө түүхэн аялал жуулчлал яг юу нь мэдэгдэхгүй байна. Нэг л том мега полис ирээдүйдээ болох юм шиг харагдаж байгаа юм. Тэгэхээр ямар зүйлд санаа зовж байна вэ гэхээр нөгөө эвэртэй тэмээ шиг юм байгаад байгаа байхгүй юу. Хоорондоо давхцахгүй зорилтууд. Түүхэн аялал жуулчлал юм уу, эдийн засгийн том ирээдүй нийслэл юм уу. Тэгэхээр нөгөө Улаанбаатар чинь ингээд Яармаг дээр их гоё байна гэж байгаад тэгээд байхгүй болчихсон юм шүү дээ. Тэгээд л нэг био шиг ийм асуудал болчих вий. Тийм болохоор түүх, аялал жуулчлалыг сэргээх гээд яг тэр нэг түүхэн утгаар нь археологийн түүхээр нь сэргээж байгуулдаг ийм зорилгын хүрээнд бүр үзэл баримтлал дээр нь хотын зорилго нь бол түүхэн байна. Аялал жуулчлал байна гэж ингэж тусгая л гэсэн ийм л саналтай байна. Одоо зүгээр төвлөрлийг бууруулах гэж байгаа, эсвэл шилжих гэж байгаа гэх юм бол энэ Багануур байна шүү дээ. Дархан байна шүү дээ. 2 цаг яваад хүрнэ. Шившгийн хөндийн шинэ хотууд байна. Тэгэхээр энэ үзэл баримтлал, зорилгоо ялгаж салгаж тавимаар байна. Тэр сайхан газрыг нэг баахан шаваалдсан юм болгочих вий гэж болгоомжилж байгаа.

Д.Амарбаясгалан: Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль” гэсний дараа “Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” гэж нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,3 хувиар санал дэмжигдлээ.

Чинбаатарын Анар гишүүнийг дэмжсэнээр, Хосбаяр гишүүнийг дэмжсэнээр протоколд бүртгүүлье.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,5 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хотыг төлөвлөх бүтээн байгуулах түүний хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим

4.1.Хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-д зааснаас гадна дараах зарчмыг баримтална.

4.1.1.монгол үндэстэн, угсаатны уламжлалт үнэт зүйл, түүх, соёлын, биет болон биет бус өвийг сэргээх, хадгалан хамгаалах;

4.1.2.түүх, соёлын дурсгалт газар, археологи, соёлын, биет болон биет бус өв, байгалийн онцлог, нүүдлийн соёл иргэншилд түшиглэн олон төрөлт, тогтвортой аялал жуулчлалыг дэмжих

4.1.3.бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан, эдийн засгийн хувьд Хангайн бүсийн хөгжлийг дэмжиж, бие даан хөгжих боломжтой байх;

4.1.4.тогтвортой хөгжлийн зорилгыг хангах хөрөнгө оруулалтыг дэмжих;

4.1.5.хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, оршин суугчийн нийтлэг эрх, хууль, ёсны, ашиг сонирхолд нийцсэн, нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, хүмүүнлэг олон төвт хотын тогтолцоог хөгжүүлэх;

4.1.6.Дэвшилтэт технологи, инновацад суурилсан, ухаалаг дэд бүтцийг хөгжүүлэх;

4.1.7.эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийг дэмжих;

4.1.8.сэргээгдэх эрчим хүчний олон төрлийг дэмжих;

4.1.9.орчны аюулгүй байдлыг хангаж, гамшгаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.10.Улаанбаатар хот болон бусад бүс нутагтай холбогдох зорчигч болон ачаа тээврийн сүлжээг хөгжүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,5 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хотын эрх зүйн үндэс

5.1.хот нь улсын зэрэглэлтэй байна.

5.2.Хотын захирагч хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хотыг төлөөлнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох, түүнийг өөрчлөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэх бөгөөд Газрын тухай хуульд заасан эдэлбэр газрын хэмжээ, заагийг баталж, тогтоохтой холбогдох зохицуулалт хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,3 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Хот нь” гэсний дараа “Хот байгуулалтын тухай хуулийн 11.1-д зааснаас гадна” гэж нэмэх. Санал гаргасан

ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,3 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “асуудлыг” гэснийг “асуудал болон хэрэгжүүлэх дэд бүтцийн төслүүдийн жагсаалтыг” гэж өөрчилж, 7.4 дэх хэсгийг 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр хамт боловсруулах бөгөөд хотын Зөвлөл батална.

7.5.Төсөл, төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.” Санал гаргасан ажлын хэсэг.

Зарчмын зөрүүтэй саналтай холбоотойгоор Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнд үг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Би түрүүн хэлж байсан. Хот байгуулалтын тухай хуульд Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг оруулж байж баталж байгаа. Яг үүнтэй адилаар бид нар Улаанбаатар хот дээр гаргасан алдаагаа гаргахгүйн тулд Хархорин хотын ерөнхий төлөвлөгөөг үзэл баримтлалын хүрээнд Улсын Их Хурлаар оруулж ирж баталъя гэсэн ийм саналтай байгаа юм. Тийм болохоор энэ 9 дүгээр заалт дээр гүйцээн боловсруулах авъя гэсэн ийм саналтай байгаа.

Одоо бол 20.40 орж ирчихсэн байж байгаа шүү дээ. Энэнтэй адилхан Хот байгуулалтын тухай хуульд заалт оруулаад, бидний Улаанбаатар хотод алдсан алдаагаа гаргахгүйн тулд Хот байгуулалтын тухай хуульдаа оруулаад Улсын Их Хурлаар хэлэлцдэг болъё гэсэн. Гүйцээн боловсруулах авъя гэж байгаа.

Д.Амарбаясгалан: Тэгье. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

10.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “зориулалтаас” гэснийг “зориулалт, хүн амын нягтаршлаас” гэж, 8.1.2 дахь заалтын “ногоон хот байгуулах зорилтын хүрээнд” гэснийг “хотын” гэж, 8.1.3 дахь заалтын “1 га” гэснийг “0.1 га” гэж, 8.1.5 дахь заалтын “нягтралыг” гэснийг “нягтаршлыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө барилгажилтын төслийн түвшинд” гэж, 8.1.6 дахь заалтын “төлөвлөгөөний шийдэл, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай” гэснийг “баримт бичигтэй” гэж, 8.1.8 дахь заалтын “байгууламжийн хамт цогцоор нь төлөвлөсөн” гэснийг “байгууламж, инженерийн дэд бүтцийн зурвасыг багтаасан цогц төлөвлөлтөөр шийдсэн” гэж, 8.2 дахь хэсгийн “ухаалаг шийдэл нэвтрүүлнэ” гэснийг “олон улсын ухаалаг хотын стандартад заасан ухаалаг шийдлийг нэвтрүүлж болно” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55.7 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “орон сууцнаас” гэсний өмнө “нийтийн” гэж, 8.1.7 дахь заалтын “шийдэл нь” гэсний дараа “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан гудамжны нийтлэг өнгө, барилгын өндөржилт, загварын

дагуу” гэж, 8.1.9 дэх заалтын “саарал усыг” гэсний өмнө “хотын олон нийтийн барилга байгууламж нь” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ Нацагдорж дарга аа, энэ заалт нөгөө хотын чинь ерөнхий төлөвлөгөө нөгөө олон улсын түвшинд зарлаад байсан уралдаантай чинь зөрчилдөх юм гарах уу, үгүй юу. Гарахгүй гэж байна. Тэгвэл дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 57 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.15 дахь заалтыг хасаж, мөн зүйл зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.18, 8.1.19 дэх заалт нэмэх:

“8.1.18.байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, соёл, нутгийн иргэдийн ахуй амьдралд түшиглэсэн, төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх;

8.1.19.түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээлд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээж, биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмэх:

“8.3.Хотын ерөнхий төлөвлөгөөг 20 жил, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 5 жилийн хугацаатайгаар төлөвлөх бөгөөд оршин суугч болон аж ахуйн нэгжийн санал, барилгажилтын түвшин, хотын Зөвлөлийн олонхын шийдвэрийг үндэслэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье гэж байна.

14.Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хотын нутаг дэвсгэрийн бүсчлэл

9.1.Хотын нутаг дэвсгэр Хот байгуулалтын тухай хуулийн 13.1-д зааснаас гадна дараах бүсчлэлтэй байх бөгөөд эдгээр бүс нь тусгайлан баталсан бүсчлэлийн дүрэмтэй байна:

- 9.1.1.археологи судалгааны бүс ;
- 9.1.2.нийгмийн дэд бүтцийн бүс;
- 9.1.3.тээвэр логистикийн бүс;
- 9.1.4.инженерийн дэд бүтцийн бүс;
- 9.1.5.хамгаалалтын бүс;
- 9.1.6.холимог ашиглалтын бүс;
- 9.1.7.нөөц бүс /цагаан газар/

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан бүсчлэлийн дүрмийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр нарийвчлан тодорхойлно.

9.3.Бүсчлэлийн дүрэм тухайн бүсэд зөвшөөрөгдөх үйл ажиллагааны төрөл, барилга байгууламжийн хэмжээ, байршил, барьж болох барилгын зориулалтыг

тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “төсөл сонгон шалгаруулах журмаар шийдвэрлэнэ.” гэснийг “дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.” гэж өөрчлөх санал гаргасан. Ажлын хэсэг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,2 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 10 дугаар зүйлийн 10.5.1 дэх хэсгийн “заасан бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээс” гэснийг “зааснаас” гэж, 10.5.2 дахь заалтын “бүтээн байгуулалтын төслийг” гэснийг “газар ашиглах” гэж, 10.7 дахь хэсгийн “төлөвлөгөөнд” гэснийг “төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар бүлгийн гарчгийг “ХОТЫН ЧИГ ҮҮРЭГ, УДИРДЛАГА” гэж өөрчилж, 12 дугаар зүйлийн 12.1.12 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,8 хувийн санал дэмжигдлээ.

18.Төслийн 13 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 35 дугаар зүйлийг хасах:

“14 дүгээр зүйл.Хотын удирдлага

14.1.Хотын удирдлагыг хотын Зөвлөл, Захирагч хэрэгжүүлнэ.

14.2.Хотын байнгын оршин суугчийн тоо 10000 хүрснээр хотын Зөвлөл, Захирагчийн сонгуулийг зохион байгуулна.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан Зөвлөл, Захирагчийн бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч, хотын удирдлагыг хэрэгжүүлнэ.

14.4.Энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.5.Зөвлөл нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах төлөөллөөс бүрдэнэ:

14.5.1.Засгийн газрын санал болгосон гурван төлөөлөл;

14.5.2.энэ хуулийн 14.7-д заасан Захирагч;

14.5.3.Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас санал болгосон гурван төлөөлөл;

14.5.4.хот байршиж байгаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;

14.5.5.барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон мэргэжлийн холбоодын хоёр төлөөлөл;

14.6.Энэ хуулийн 14.5.3-д заасан төлөөллийг нээлттэй нэр дэвшүүлж, тэдгээрээс сонгогдсон гишүүдийг энэ хуулийн 14.5-д заасан бусад гишүүдийн хамт Засгийн газар томилж, чөлөөлнө.

14.7 Энэ хуулийн 14.3-т заасан Захирагчийг Засгийн газар томилж, чөлөөлнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтын төхөөрөмж гацсан. шууд цуцалж болох билүү. Болно. Тийм ээ, дүн зарлаагүй юм чинь санал хураалтыг цуцалъя. Дахин санал хураалт явуулъя. Дахин санал хураалт 54,4 хувиар санал дэмжигдлээ. Жуковын Алдаржавхлан гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

20.Төслийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3, 15.4, 15.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,3 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,7 хувиар санал дэмжигдлээ. Тэмүүлэн гишүүн үг авах гээд байна уу.

22.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,2 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.13 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.4 дэх заалтын “батлах” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаа эсэхийг шалгах” гэж, 16.7.6 дахь заалтын “бүсчлэл” гэснийг “бүсчлэлийн дүрэм” гэж, 16.7.7 дахь заалтын “төлөвлөлтийн даалгаврыг батлах” гэснийг “төлөвлөлтийг хянан зөвшилцөх” гэж, 16.7.9 дэх заалтын “барилга байгууламжийн” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилга байгууламжийн” гэж, мөн заалтын “уялдуулан батлах” гэснийг “уялдаж байгаа эсэхийг хянах” гэж, 16.7.11 дэх хэсгийн “батлах” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагын дүгнэлтийн дагуу олгох” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,3 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.3, 16.7.15 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,4 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,3 хувиар санал дэмжигдлээ.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

27.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “төлөвлөгөө” гэсний дараа “бүсчлэлийн дүрэм” гэж, 17.1.7 дахь заалтын “хот хөгжүүлэх” гэсний дараа “болон хотын дэд бүтцийн” гэж нэмж, 17.1.8 дахь заалтын “энэ хуулийн 29.1.2-т заасан”

гэснийг “хотын өмчит болон хотын өмчийн оролцоотой” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.6 дахь заалтын “бүтээн байгуулалтын” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Цуцалъя. Ажлын хэсгээс үг авъя гэж байна. Тэмүүлэн гишүүнд үг өгье.

Г.Тэмүүлэн: Сая энэ 28 дахь заалт дээр дарга аа, энэ бичвэр нөгөө найруулга талаас дахиад нэг анхаарах шаардлагатай байгаад байгаа. Тэгэхээр бид нар бас энэ дээр ажиллаад, эргэж оруулж ирье л гэсэн саналтай байгаа юм. Гүйцээн боловсруулах авъя.

Д.Амарбаясгалан: 28 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгье.

29.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Энэ хуулийн 18.2-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэлдүүлэхтэй холбоотой харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анарт микрофон өгье.

Ч.Анар: Энэ дээр нөгөө хуулийг хойноос нь шилжсэн засвар оруулъя гэж хүссэн байгаа. Тэгээд гүйцээн боловсруулахаар чиглэл авъя.

Д.Амарбаясгалан: 29 дэх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

30.Төслийн 18 дугаар зүйлийн 18.2.5, 18.2.6, 18.2.14 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “хот хөгжүүлэх” гэсний дараа “сан, хотын дэд бүтцийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62 хувиар санал дэмжигдлээ. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

32.Төслийн 20 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт 40 10-ны 50 9,5 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,3 хувиар санал дэмжигдлээ. Батбаярын Жаргалан гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

34.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “паркийг” гэснийг “парк, гаалийн тусгай бүсийг” гэж, мөн хэсгийн “заасан журмын дагуу” гэснийг “заасны дагуу” гэж өөрчилж, 23.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,3 хувиар санал дэмжигдлээ. Гомбын Ганбаатар гишүүн санал хураалтад оролцохыг хүсэж байна.

35.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “Зөвлөлийн шийдвэрээр” гэснийг “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.8-д заасны дагуу” гэж

өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.1.3.хотын өмчит болон хотын өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хотод ноогдох ноогдол ашгийн 10 хүртэлх хувь;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62 хувиар санал дэмжигдлээ.

37.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.4, 25.1.5, 25.1.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн 25 дугаар зүйлийн 25.2.1 дэх заалтын “инженерийн болон” гэснийг хасаж, 25.2.2 дахь заалтын “түүх, соёлын” гэсний дараа “өвийг хадгалан хамгаалах” гэж, 25.3 дахь хэсгийн “санг бууруулах” гэсний дараа “түүний удирдлага, зохион байгуулалт” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “эх үүсвэрээр” гэсний дараа “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,3 хувиар санал дэмжигдлээ.

39.Төслийн 24, 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.5 дахь хэсэг нэмэх:

“27.5.хөрөнгө оруулалтын хэлбэр татварын болон татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67,1 хувиар санал дэмжигдлээ.

40.Төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийг “28.1.Хотод хэрэгжүүлэх төсөл нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-д заасан шалгуур хангасан тохиолдолд дараах хугацаагаар тогтворжуулах гэрчилгээ олгоно:” гэж, 28.6 дахь хэсгийн “өөрөөр заагаагүй” гэснийг “заасан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,3 хувиар санал дэмжигдлээ.

41.Төслийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.7 дахь хэсэг нэмэх:

“28.7.Хотод үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээртэй хамтран ажиллах зорилгоор хөрөнгө оруулагч оруулагчдын төлөөллөөс бүрдсэн Хөрөнгө оруулагчдын зөвлөлийг хотын Захирагчийн дэргэд байгуулах ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хотын Зөвлөл батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,8 хувиар санал дэмжигдлээ.

42.Төслийн 29 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

43.Төслийн 30 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Ажлын хэсэг санал хураалт 63,3 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,3 хувиар санал дэмжигдлээ.

45.Төслийн 33 дугаар зүйлийн гарчгийн “этгээдийн” гэсний дараа “эрх,” гэж, нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.1 дэх хэсэг нэмэх:

“33.1.Хот төлөвлөлтийн баримт бичгээр зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр бүсчлэлийн дүрмийн дагуу хэрэгжүүлэх эрхтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62 хувиар санал дэмжигдлээ.

46.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Иргэний хуульд” гэснийг, мөн зүйлийн 34.3, 34.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

47.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.Энэ хуулийг 2025 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн энэ хуулийн 14.2-т заасан нөхцөл бүрдэж, хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.” Санал гаргасан Ажлын хэсэг санал хураалт 65,8 хувиар санал дэмжигдлээ.

48.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “бүтээн байгуулах” гэсний өмнө “төлөвлөх” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалтын “нийтийн” гэсний өмнө “олон” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “бүтээн байгуулалт” гэсний өмнө “төлөвлөлт” гэж, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.6 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь хэсгийн “хөгжлийн” гэсний дараа “ерөнхий төлөвлөгөө” гэж, 10 дугаар зүйлийн 10.5.2 дахь заалтын “хэрэгжүүлж” гэсний өмнө “төслийг” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “чиг үүргээс” гэсний өмнө “нийтлэг” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Засгийн хуралдаанд” гэснийг “Засгийн газарт” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтын “нийтийн үйлчилгээний” гэснийг “олон нийтийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “гүйцэтгэнэ” гэснийг “хэрэгжүүлнэ” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “зөвлөл, түүний” гэснийг “зөвлөлийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “эрх, үүргийг” гэж, 18 дугаар зүйлийн 18.2,3, 18.2.4 дэх хэсгийн “байгууламж” гэснийг “байгууламжийн” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “үйлдвэр” гэснийг “үйлдвэрлэл” гэж, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “тогтворжуулалтын” гэснийг “тогтворжуулах” гэж, мөн хэсгийн “зохицуулаагүйгээс” гэснийг “зохицуулснаас” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,2 хувиар санал дэмжигдлээ.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Сэддорж гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Бадарчийн Хэрлэн, Долгорсүрэнгийн Үүрийнтуяа гишүүдийг дэмжсэнээр протокол тэмдэглүүлье.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал

Дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Гишүүд анхааралтай байя. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2., 10.5 дахь хэсгийн “эзэмших,” гэснийг тус тус, 10.3 дахь хэсгийн “ашиглуулахаас” гэсний өмнөх, мөн хэсгийн “ашиглуулах” гэсний өмнөх, 16 дугаар зүйлийн 16.7.6 дахь заалтын “эзэмшүүлэх,” гэснийг тус тус хасаж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анарт микрофон өгье.

Ч.Анар: Их Хурлын ажлын хэсгийн баримталж байгаа зарчим бол энэ Хархорум хотын хуулийн төслийг хотын Зөвлөл, Захирагчид нь эрх зүйн баримт үндэслэлийг нь бүрдүүлж, ажлыг явуулахыг дэмжиж ажиллаж байгаа. Тэгээд бид нар бол 2024 оны 6 сарын 4-нд батлагдсан Шинэ Зуунмод хотын хуулийн үзэл баримтлал, мөн цаашлаад энэ эзэмших эрхийг олгох нь өөрөө газрын наймаанаас, эрсдэлээс хамгаалах, цаашлаад нөгөө хот бүтээн байгуулахад баахан худалдан авчихсан төрийн бүтээн байгуулалт, төсвийн бүтээн байгуулалт, төр, хувийн хэвшлийн бүтээн байгуулалтад саад болох эрсдэлийг үүсгэж байгаа гэж үзэж байгаа.

Нөгөө талдаа Засгийн газрын хуулийг өргөн мэдүүлсэн ажлын хэсэг бол хөрөнгө оруулалтын орчныг хүндрүүлнэ гэж үзэж байгаа. Тэр бол үндэслэлтэй.

Гэхдээ хотын Зөвлөл, хотын Захирагчид бол тогтворжуулах байдлын гэрчилгээ болон гэрээгээр энэ асуудлыг зохицуулах бүрэн боломжтой. Тэгэхээрээ нөгөө хуучин батлагдсан хуулийн зарчимд нийцүүлээд энэ эзэмших гэдэг маань өөрөө Хархорин хот баригдахгүй байх суурь нөхцөлийг бүрдүүлэх вий гэдэг эрсдэлээс сэргийлж байгаа юм. Нөгөө талаасаа энэ маань өөрөө шилжилтийн үеийн тухай хууль учраас гишүүдийг энэ төхөөрөмждөө гар хүрээд дэмжихгүй байж энэ саналыг босгож өгөхийг хүсье.

Мөн Их Хурлын ажлын хэсгийн гишүүд энэ саналыг дэмжээгүй гэдгийг бол албан ёсоор мөн протоколд тэмдэглүүлэхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүнд үг өгье.

Б.Баярбаатар: Энэ Хархорин хотын төсөл Засгийн газраас санаачилж орж ирсэн заалт нь бол одоо энэ яг саяын уншдаг заалт байгаа юм. Тэгээд өнөөдөр энэ “ашиглуулах” гэсний өмнөх “эзэмшүүлэх” гэснийг нь хасчхаж байгаа юм. Тэгээд уг нь эзэмшүүлэх л ёстой байхгүй юу. Тэгээд энэ үг хасагдсанаар энэ хотын төсөл чинь бараг зогсох хэмжээ рүү оччихож байгаа юм. Ямар ч хэрэггүй болох юм. Тэгээд яах вэ, энэ ажлын хэсэг бол саналаа оруулаад явсан. Сая энэ чинь бид нар 50 саналыг нь дэмжээд явчихсан юм. 2 саналыг нь бол Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй юм. Тэгээд энэ дэмжээгүй саналыг дэмжиж санал өгөх ёстой л доо. Бид нар энэ хуулийг амилуулах ёстой. Бид нар энэ хот босгоё гэж байгаа бол энэ дээр дэмжсэн санал өгч, Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжиж санал өгч байж энэ санал босно. Үргэлжлэх юм. Яг энэ хэвээрээ явах юм шүү. Дараагийн санал нь ч гэсэн мөн адилхан.

Д.Амарбаясгалан: Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Би ажлын хэсэгт орж ажилласан гишүүн. Тэгээд мөн яг ажлын хэсэг дээр энэ дээр бол Анар гишүүнтэй санал зөрсөн. Эзэмших эрхтэй байж байж газрыг эзэмшүүлж байж хөрөнгө оруулалт татна. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт. Ашиглах газар дээр хөрөнгө оруулах хүн олдохгүй. Тийм учраас энийг Засгийн газраас оруулж ирсэн төслөөр нь “эзэмших” гэдэг үг нь байж байх юм. Тийм учраас одоо саналын томъёолол нь энэ саналыг дэмжиж байж энэ санал босох юм гэж ойлгож байна. Тэгэхээр гишүүдийг бас дэмжиж өгч энэ саналыг босгож өгөөч гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Ямар ч байсан дэмжвэл хууль нь босох юм байна. Дэмжихгүй бол заалт нь босох юм байна. Бүлгийг төлөөлж 2 хэлэх ёстой Баярбаатар, Анар 2 хэлчихсэн. 1 бүлгийг төлөөлж 2 гишүүн үг хэлэх эрхтэй. Дэгээрээ.

Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 30,4 хувиар санал дэмжигдсэнгүй. Нэг ёсондоо дэмжээгүй санал боссон гэсэн үг. Тийм бослоо гэсэн үг.

2.Төслийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг хасаж, 16.6 дахь хэсгийн “алба болон харьяа газрын” гэснийг “албаны” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 35,4 хувиар санал дэмжигдсэнгүй. Үндсэн санал бослоо.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Нэг.Улсын зэрэглэлтэй хот” гэсэн хэсгийн 4 дэх заалтыг бүхэлд нь хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

““Хархорум” хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн гарчгийг “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” гэж өөрчилж, тогтоолын төслийн тэмдэглэх хэсгийн “хэсэг, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг” гэснийг “хэсгийг” гэж өөрчилж, төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1.“Хархорум” хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт

бичиг, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн зохион байгуулах;

2.“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны төсөв, хөрөнгө, эрх, үүрэг, бүтэц бүрэлдэхүүнийг Хархорум хотын Захирагчийн ажлын албанд шилжүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,3 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дэх заалтыг хасаж, үүнтэй холбогдуулан тус заалтын агуулгыг алдагдуулахгүйгээр “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах. Санал гаргасан ажлын хэсэг Санал хураалт. 62 хувиар Байнгын хорооны дэмжсэн санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

19.48 цаг.

Дараагийн асуудалд оръё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тогтоолын төсөлд нэмж тусган, төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргэсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуух дэгтэй. Нэр ирээгүй байгаа эцсийн хэлэлцүүлэг учраас. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууссанд тооцно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Одоо “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна.

Батлуулах тогтоолын төслийн хувилбарыг Төрийн байгуулалтын байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт 55,7 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Татварын хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг эцэслэн батлахад бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Ингээд 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

20.52 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ